

МОНГОЛ УЛСЫН АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БУЮУ 2019 ОНЫ ТАЙЛАН

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН
САНААЧИЛГА

Улаанбаатар хот
2020 он



АГУУЛГА

1	Танилцуулга	8
1.1	Холбогдох мэдээлэл	8
1.2	Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг хариуцлага	9
1.3	Оролцогчид	9
1.4	Хүндрэл бэрхшээл	9
1.5	Талархал.....	10
2	Хураангуй.....	12
2.1	Салбарын тойм	12
2.2	ОУИТБС-ын оролцоо.....	12
2.3	Тайлангийн цар хүрээ	12
2.4	Засгийн газрын нийт орлого	14
2.5	Нэгтгэлийн үр дүнгийн хураангуй.....	15
2.6	Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдал.....	17
2.7	Гол дүгнэлт.....	19
3	Тохируулгын аргачлал болон цар хүрээг тодорхойлох нь	24
3.1	Танилцуулга	24
3.2	Цар хүрээг тодорхойлох нь	24
3.3	Аргачлал	28
3.4	Баталгаажуулалт.....	30
4	Тохируулгын үр дүн.....	33
4.1	Анхлан тайлагнасан урсгалуудын хураангуй	33
4.2	Анхны тохируулаагүй зөрүү болон тайлагнаагүй компаниуд	33
4.3	Тохируулаагүй үлдсэн зөрүү	35
4.4	Тайлагнаагүй компаниуд	36
4.5	Нэгтгэлийн үр дүн.....	37
5	Монголын олборлох салбар.....	40
5.1	Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого (шаардлага 2.1)	40
5.2	Уул уурхай.....	49
5.3	Ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэл, экспорт (шаардлага 3.1).....	71
5.4	Газрын тос болон байгалийн хий	78
5.5	Олборлох салбарын зүгээс эдийн засагт оруулсан хувь нэмэр	90
5.6	Засгийн газрын байгууллагууд	95
5.7	Олборлох салбар дахь төрийн оролцоо.....	97
5.8	Төсвийн үйл явц болон орлогын хуваарилалт	123
6	Бусад асуудлууд	130
6.1	Бенефициар эзэд (Шаардлага 2.5).....	130
6.2	Гэрээний ил тод байдал.....	132
6.3	Бэлэн бус орлого (Шаардлага 4.2)	135
6.4	Дэд бүтцэд хөрөнгө оруулах ба бартерын солилцоо (шаардлага 4.3).....	136
6.5	Тээвэрлэлтийн орлого (шаардлага 4.4)	137
6.6	Нийгмийн зарцуулалт (Шаардлага 6.1)	139
6.7	Нөхөн сэргээлтийн мэдээлэл	140
6.8	Цахим тайлагналын систем	151
6.9	Ашигласан усны мэдээлэл	153
6.10	Хог хаягдлын мэдээлэл.....	154
6.11	ОУИТБС-ын тайлангийн задаргааны түвшин, хэлбэр (шаардлага 4.7)	155
7	Зөвлөмж.....	158
7.1	Өмнөх жилийн нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	158
7.2	Баталгаажуулалтын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт.....	160
7.3	ОУИТБС-ын тайлагнал, түүний хэрэгжилтэд өгөх зөвлөмж	165
8	Хавсралтууд.....	171

Энэхүү Тайлан болон Хавсралтуудыг Монголын ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын албаны хүсэлтээр, санаачилгын зорилгын үүднээс Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл болон Ажлын хэсгийн оролцогч талуудын хэрэгцээнд зориулсан болно.

Хавсралтууд нь их хэмжээний мэдээлэл агуулсан тул ОУИТБС-ын Засаглалыг дэмжих төслийн www.eitmongolia.mn вебсайтад Microsoft Excel форматаар ил тод тавьсан бөгөөд Тайланг эдгээр Хавсралтуудын хамт уншина.

Хараат бус Хянагч-Нэгтгэгч

Грант Торнтон Аудит ХХК

Нэгтгэн бэлтгэсэн

Б.Осоргарав

О.Идшинринжин

Н.Эрдэнэцог

Л.Цэвэлмаа

Б.Дэлгэрмаа

Б.Эрдэнэбат

Орчуулагч

М.Билгүүн

О.Энх-Ариунаа

Хариуцах байгууллага

Монголын ОУИТБС-ын Ажлын алба

Фото

Грант Торнтон

Хэвлэсэн

2020 оны 12 сар

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж Ахуйн Нэгж
ААНОАТ	Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар
АМГТГ	Ашигт Малтмал Газрын Тосны Газар
АМНАТ	Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
БО	Байгаль Орчин
БОАЖЯ	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
БОНХАЖЯ	Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яам
БОХТ	Байгаль Орчныг Хамгаалах Төлөвлөгөө
БӨ	Бенефициар Өмчлөгч
БУУ	Бичил Уул Уурхай
БХГ	Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ГТГ	Газрын Тосны Газар
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны Цахилгаан Станц
ЗГ	Засгийн Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МОУИТБС	Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга
МУ	Монгол Улс
МУУУА	Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
НББ	Нягтлан Бодох Бүртгэл
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДС	Нийгмийн Даатгалын Сан
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар
ОНХНС	Орон Нутгийн Хөгжлийн Нэгдсэн Сан
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан
ОТАХ	Олон Талт Оролцогчдын Ажлын Аэсэг
ОУИТБС	Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга
ОХУ	Оросын Холбооны Улс
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
СЯ	Сангийн Яам
ТАН	Төлсөн Авсанаа Нийтэл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТБУ	Тогтвортой Бичил Уурхай
ТЕГ	Татварын Ерөнхий Газар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ТЕХ	Татварын Ерөнхий Хууль
ТӨААН	Төрийн Өмчит Аж Ахуйн Нэгж
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого, Зохицуулалтын Газар
ТӨК	Төрийн Өмчит Компани
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ТЭЗҮ	Техник Эдийн Засгийн Үндэслэл

УИХ	Улсын Их Хурал
УУХҮЯ	Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ҮАҮТ	Үйл Ажиллагааны Үндэсний Төлөвлөгөө
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХБ	Хөрөнгийн Бирж
ХК	Хувьцаат Компани
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
ЭБМЗ	Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөл

Тэмдэглэгээ

Ам.доллар	Америкийн нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт (доллар)
Мян.тн	Мянган тонн
%	Хувь

**Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод
Байдлын Санаачилгын Ажлын Хэсэг**
Монгол Улсын ОУИТБС-ын Засаглалыг дэмжих төсөл
Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж
Туушин компанийн байр, 314 тоот

2020 оны 12 сарын 21-ний өдөр

"Грант Торнтон аудит" ХХК нь Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын 14 дүгээр тайлан буюу 2019 оны Нэгтгэлийн ажлыг ("Гэрээт ажил") хийхээр сонгогдон, гэрээ байгуулсан билээ.

Монголын олборлох салбарын аж ахуйн нэгжүүдээс 2019 онд Засгийн газарт төлсөн материаллаг төлбөр хийгээд Засгийн газрын хүлээн авсан материаллаг орлогын урсгалыг нэгтгэх, ОУИТБС-ын 2019 оны стандартын дагуу орлогын бус мэдээллийг ил тод болгох гэрээт ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ноос 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Бид энэхүү Гэрээт ажлыг Холбогдох үйлчилгээний олон улсын стандарт 4400 буюу Санхүүгийн мэдээлэлд тохиролцсон горимуудыг гүйцэтгэх гэрээт ажлын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.

Бид Ажлын даалгавар болон ОУИТБС-ын стандартаар ил тод болгохыг шаардсан олборлох салбарын мэдээллүүдийг нэгтгэн, энэхүү тайлан, түүний хавсралтуудаар тайлагнаж байна. Учир нь гүйцэтгэсэн горимууд нь нэгтгэлийн болон шалгах ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС) буюу Шалгах ажлын олон улсын стандартын дагуу гүйцэтгэх зорилго агуулаагүй бөгөөд бидний зүгээс энэхүү тайланд харуулсан тодорхой мэдээллүүд, тэдгээртэй холбогдох аливаа гүйлгээнүүдэд ямар нэгэн баталгаа өгөх үүрэггүй юм.

Энэхүү тайлан нь Ажлын даалгаварт заагдсан зүйлсийн хүрээнд Олон талт ажлын хэсэгт болон Үндэсний Зөвлөлд мэдээлэхэд зориулагдсан бөгөөд аливаа нэгэн нэгжийг бүхлээр нь хамарсан санхүүгийн тайлангуудын хүрээнд хийгдээгүй болно.

Грант Торнтон Аудит ХХК

1

ТАНИЛЦУУЛГА



1 ТАНИЛЦУУЛГА

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) гэдэг нь байгалийн баялгаас (ашигт малтмал, газрын тос, байгалийн хий) олж буй орлогыг олон нийтэд ил тод болгосноор түүнийг нийтийн сайн сайхны төлөө зөв захиран зарцуулахад нь оролцогч талуудын хариуцлагыг өндөржүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий дэлхий нийтийн түншлэл юм.

ОУИТБС нь нэг талаас олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниуд төлсөн төлбөрөө, нөгөө талаас Засгийн газар тэдгээр компаниудаас хүлээн авсан орлогоо тайлагнадаг ба хоёр талаас ирүүлсэн тайланг Хараат бус хянагч-нэгтгэгч хянан нэгтгэж, ОУИТБС-ын стандартад заасан шаардлагуудын дагуу орлогын бус мэдээллийг хамруулан, олборлох салбарын тайлан гаргаж, түүнийг олон нийтэд ил тод болгоно. Энэхүү үйл явцыг төр, компани, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий олон талт оролцогчдын бүлэг удирдан явуулж, хянан зохицуулна.

1.1 ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

ОУИТБС бол газрын тос, байгалийн хий, олборлох салбарт ил тод байдал, тайлагналыг сайжруулахад зориулсан глобал стандарт юм. Монгол улсын Засгийн газар ОУИТБС-ыг хүлээн авч байгаа тухайгаа 2006 онд зарласан бөгөөд дагалдан хийгдэх ажлуудыг хэрэгжүүлж, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зорилгоор ОУИТБС-ын Үндэсний зөвлөл болон Олон талт оролцогчдын ажлын хэсэг (ОТАХ)-ийг Засгийн газар, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн төлөөлөл оролцуулан байгуулсан юм.

ОУИТБС-д нэгдсэнээс эхлэн ОУИТБС-ын 13 удаагийн тайланг Монгол улс бэлтгэн гаргасан бөгөөд энэхүү арван дөрөв дэх удаагийн тайлангийн Хараат бус хянагч-нэгтгэгчээр “Грант Торнтон Аудит” ХХК томилогдсон юм.

2016 оны 2-р сарын 24-25-нд Лима хотод хуралдсан ОУИТБС-ын олон улсын хуралдаанаар баталсан ОУИТБС-ын Стандарт (Стандарт) нь түүнийг хэрэгжүүлэх зарчмууд болон шаардлагуудыг агуулдаг ба 2016, 2019 онуудад 2 удаа шинэчилэн баталсан.

Стандарт нь ОУИТБС-ын мэдээллийг цуглуулахад улс орнуудын тайлан гаргалтын одоогийн системүүдийг ашиглах, үр дүнг ил тод байлгахыг хөхиүлэн дэмждэг. Энэ Стандарт нь олборлох үйл ажиллагааг эзэмшиж, ашиг хүртэж байгаа хувь хүмүүсийн тухай мэдээллийг ил болгохыг шаарддаг. Олборлох төслүүдийн тендерт оролцож, ажиллаж, хөрөнгө оруулж байгаа компаниуд өөрсдийн бенефициар өмчлөгчид буюу ашиг хүртэгч эзэд нь хэн бэ гэдгийг улс орнууд мэдээлж, баталгаажуулах шаардлагатай юм.

ОУИТБС-ын чанарыг баталгаажуулах механизм буюу ОУИТБС-ын шаардлагуудыг улс орнууд баримталж байгаа эсэхийг шалгаж тогтоодог “баталгаажуулалт”-ыг 2016 оны ОУИТБС-ын Стандартын хүрээнд улам боловсронгуй болгосон юм. Энэ Стандартыг дагаж мөрдөх журмыг өөрчлөөгүй боловч гишүүнчлэл бүхий улс орнуудын харилцан адилгүй байдал, минимум шаардлагуудыг давуулан биелүүлэх чармайлтууд, хэрэгжүүлэх явцаа үргэлжлүүлэн сайжруулж байгаа зэргийг үнэлгээ дүгнэлтэд өргөн хүрээнд харгалзах юм.

ОУИТБС-ын 2019 оны Стандартад өнөөдөр дэлхийн хэмжээний асуудал болоод буй байгаль орчин, нийгэм, жендерийн тэгш байдлын үр нөлөөг хамруулсан ба өмнө ил тод болоогүй ашигт малтмалын борлуулалт, төслөөрх тайлагнал болон 2021 оноос хойш байгуулагдах бүх гэрээнүүдийг ил тод болгохыг санаачилгад нэгдсэн орнуудад үүрэг болгожээ.

Энэхүү тайлан нь ОУИТБС-ын 2019 онд шинэчлэгдсэн Стандартын дагуу Монгол улсад хийгдэж байгаа ОУИТБС-ын анхны тайлан юм.

1.2 ХАРААТ БУС ХЯНАГЧ-НЭГТГЭГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Монгол улсын ОУИТБС-ын арван дөрөв дэх удаагийн нэгтгэл тайланг гүйцэтгэгч Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг, хариуцлагыг Ажлын даалгаварт тодорхойлсон бөгөөд үндсэн асуудлууд нь дараах байдалтай байна. Үүнд:

- Тайланд тусган нэгтгэхээр ОТАХ-ийн санал болгосон хамрах хүрээг шалган нягталж, санал дүгнэлт гаргах,
- Тайланд оруулах мэдээллийг цуглуулахын тулд мэдээлэл авах загвар маягтууд боловсруулж бэлтгэх, ОТАХ-ийн шийдсэний дагуу тайлан гаргахад шаардагдах төрийн болон хувийн байгууллагуудад тэдгээр маягыг хүргүүлэх,
- Тайлан гаргах байгууллага, иргэдээс мэдээлэл авахдаа цахим тайлагналын систем, мэдээлэл авах маягтууд, бусад хэрэгслүүдийг ашиглах,
- Хүлээж авсан мэдээллийг харьцуулж, аль болох өргөн хүрээг хамруулан нэгтгэх,
- Тайланд тусгасан санхүүгийн мэдээллийн хамрах хүрээний талаар дүгнэх, шаардлагатай бол, тайлан гаргах процессыг ирээдүйд сайжруулахын тулд санал дэвшүүлэх,
- Тайланд тусгасан орлого, төлбөрийн мэдээлэл болон Монгол улсын олборлох салбарт холбогдох бусад мэдээллийг нэгтгэж, ОТАХ-ийн хэвлэн нийтлүүлэх тайланг боловсруулж бэлтгэх.

Бидний бэлтгэсэн энэхүү тайлангийн зорилго бол Нэгтгэл тайланг бэлтгэх зорилгын хүрээнд Ажлын даалгаварт тодорхойлсон асуудлуудын талаар ОТАХ болон Үндэсний Зөвлөлд мэдээлэл өгөх явдал юм.

Тус тайланг Монгол, Англи хэлээр бэлтгэсэн бөгөөд хэрэв Монгол, Англи хувилбарын хооронд аливаа зөрчил, тохирохгүй зүйлс гарвал Монгол хэл дээрх хувилбарыг баримтална.

1.3 ОРОЛЦОГЧИД

Тайлан, мэдээллийг нэгтгэхэд оролцсон талууд нь:

- Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас материаллаг хэмжээний орлого хүлээн авч байгаа төрийн болон орон нутгийн төрийн байгууллагууд,
- Олборлох салбарыг хянах, зохицуулах, тайлан гаргуулах хариуцлага бүхий Засгийн газрын яамд, агентлагууд (5.6 бүлгийг үзнэ үү),
- Олборлох салбарт ажиллаж байгаа төрийн өмчийн компаниуд (5.7.1 бүлгийг үзнэ үү),
- Холбогдох эрх зүйн зохицуулалтын дагуу төрийн байгууллагуудад материаллаг төлбөр төлж байгаа, олборлох салбарын компаниуд (3.2.7 бүлгийг үзнэ үү) зэрэг юм.

Нэгтгэл тайланд оролцож байгаа төрийн байгууллагууд, компаниудын тухай мэдээллийг 3.2 бүлэг болон Хавсралт 1,2 болон 3-аас үзнэ үү.

1.4 ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

“Грант Торнтон Аудит” ХХК нь ОУИТБС-ын нэгтгэл тайлангийн Хараат бус хянагч-нэгтгэгчээр 2020 оны 10 дугаар сарын сүүлээр сонгогдон, 2020 оны 11 дүгээр сарын 2-ноос ажлаа эхэлж, олон жилийн ажлын туршлагадаа тулгуурлан эрчимтэй, шаргуу ажиллаж, эхлэлийн тайланг 5 хоногийн дотор бэлтгэн 11 дүгээр сарын 06-нд ОТАХ-ийн өргөн бүрэлдэхүүнтэй хуралд танилцуулж, нэгтгэл ажлын цар хүрээг батлуулсан. Гэтэл Ковид-19 цар тахал Монгол улсад тархсанаас шалтгаалан МУЗГ-аас 11 дүгээр сарын 11-нээс Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг зарлаж, “хатуу хөл хорио” тогтоосноор төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагууд ажиллахгүй, эсвэл гэрээс онлайн ажиллах болсноор ОУИТБС-ын нэгтгэл тайлантай холбоотой мэдээ, мэдээлэл гаргаж ирүүлэх боломжгүй болсон. Гэвч яамдын сайд, төрийн байгууллагын холбогдох нэгжийн удирдах албан тушаалтнууд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн захирал, удирдлагуудтай тодорхой түвшинд харилцаж, олж авсан мэдээллийн хүрээнд энэхүү тайланг бэлтгэсэн болно.

1.5 ТАЛАРХАЛ

“Грант Торнтон Аудит” ХХК-ийг төрийн байгууллагууд, агентлагууд болон олборлох салбарын компаниудаас зөвшөөрөл, албан бичиг, баримтууд авах, хүргүүлэхэд тусалж, шаардлагатай бусад ажлуудад дэмжлэг үзүүлсэн МОУИТБС-ын Засаглалыг дэмжих төслийн зохицуулагч З.Баярхүү, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Мэдээллийн технологийн мэргэжилтэн О.Мөнхбат нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Энэхүү зөвлөх үйлчилгээний эхлэлийн уулзалт болон тайлангийн төслийг танилцуулан хэлэлцүүлэх үед оролцож үнэтэй зөвлөмж, чиглэл өгсөн ОУИТБС-ын Үндэсний зөвлөл болон Олон талт оролцогчдын ажлын хэсэг (ОТАХ)-ийн гишүүд болох Засгийн газар, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн төлөөлөлд гүн талархал илэрхийлье.

2

ХУРААНГУЙ



2 ХУРААНГУЙ

2.1 САЛБАРЫН ТОЙМ

Олборлох үйлдвэрлэл нь Монгол улсын эдийн засгийн голлох салбар бөгөөд эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж болсоор ирсэн. 2019 онд олборлох салбар ДНБ-ий 23.7 хувийг эзэлж, 6.7 тэрбум ам.долларын орлого экспортоос олсон нь нийт экспортын 83.7 хувийг эзэлж байна. Уул уурхайн салбар мөн онд аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 57.5 хувь, нийт хөрөнгө оруулалтын (оны үнээр) 49.9 хувийг эзэлж байна.

Засгийн газар (ЗГ) олборлох салбараас орлогынхоо томоохон хэсгийг бүрдүүлдэг бөгөөд 2019 онд олборлох салбараас **3.8 их наяд төгрөг** хүлээн авсан байна. Түүнчлэн төрөөс уул уурхайн компаниудад хувь эзэмших байдлаар, тухайлбал Эрдэнэс Монгол компаниар дамжуулан түүний салбар компаниудыг эзэмшиж, олборлох үйл ажиллагаанд шууд оролцож байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2019 оны гүйцэтгэлээр 11.9 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1.9 их наяд төгрөг буюу 18.6 хувиар өссөн байна. Үүнээс, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 2.9 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 590.7 тэрбум төгрөг буюу 25.4 хувиар өссөн гэж ҮСХ-ны мэдээлэлд дурдсан. Бидний баталгаажуулсан олборлох салбарын орлого нь ҮСХ-ны мэдээллээс 900 орчим тэрбум төгрөгөөр их байгаа нь төсвөөс гадуурх хэд хэдэн төлбөр, орлого энэхүү нэгтгэлд хамрагдсантай холбоотой юм.

2.2 ОУИТБС-ЫН ОРОЛЦОО

Монгол улсын Засгийн газар нь 2005 оны 12 сард ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр шийдэж, 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс ОУИТБС-ын нэр дэвшигчээр элссэн. Баталгаажуулалтыг амжилттай давснаар 2010 оны 10 дугаар сарын 19-ний өдөр бүрэн нийцсэнд тооцогдсон.

ОУИТБС-ыг хэрэгжүүлж эхэлснээс хойш Монгол улс нь 13 удаагийн тайлан гаргасан. Энэхүү тайлан нь ОУИТБС-ын 14 дэх удаагийн тайлан бөгөөд ОУИТБС-ын 2019 онд батлагдсан шинэ Стандартын дагуу толилуулж буй анхны тайлан юм.

ОУИТБС-ын Удирдах хорооноос 2017 оны 1 дүгээр сард Монгол Улсын 2016 оны ОУИТБС-ын баталгаажуулалтын дүнг баталж, засаж сайжруулах 8 зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 1 дүгээр сард хянан хэлэлцэж, 2 дугаар сард Монгол Улсыг ОУИТБС-ын Стандартын шаардлагыг хангасан орноор хүлээн зөвшөөрсөн нь ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй 50 гаруй орноос шаардлага хангасан хоёр дахь орон болсон нь томоохон амжилт гэж үзэж байна.

2.3 ТАЙЛАНГИЙН ЦАР ХҮРЭЭ

Энэхүү тайлан нь олборлох салбар дахь дараах сэдвүүдийг хамарсан. Үүнд:

- Олборлох салбарын төлбөр, орлого
- Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого
- Олборлох салбарын зүгээс эдийн засагт оруулсан хувь нэмэр
- Ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэл болон экспорт
- Олборлох салбар дахь төрийн оролцоо
- Тусгай зөвшөөрөл болон гэрээний ил тод байдал
- Ашигт малтмал, газрын тосны нөөцийн тойм
- Нийгмийн зардал болон байгаль орчны нөхөн сэргээлт
- Ашиг хүртэгч жинхэнэ эзэд зэрэг хамаарна.

ОУИТБС-ын Стандартад 2019 онд орсон өөрчлөлтийн дагуу энэхүү тайланд дараах сэдвүүдийн хүрээнд илүү дэлгэрэнгүй мэдээллүүд орсон.

Зөвхөн ОУИТБС-ын тайланд төвлөрөхөөс илүүтэй тайлагнагч байгууллагууд олон талт, найдвартай ил тод байдлыг системтэйгээр, хэвийн үйл ажиллагааныхаа хүрээнд ил тод болгохыг Стандарт шаардсан ба заавал ОУИТБС-д зориулан мэдээлэл гаргахгүйгээр Стандартын дагуу

холбогдох мэдээллээ өөрсдөө боловсруулан ил тод болгосон байдлыг төрийн байгууллага, компаниудын нэгэнт байгаа цахим сүлжээг ашиглан үнэлж, үр дүнг Хавсралт 42-д харуулсан.

ОУИТБС-ын тайлангийн маягыг 2020 оны эхээр шинэчилсэн ба, шинэчлэгдсэн маягтаар төслийн түвшинд тайлагнахыг компаниудаас шаардсан. Төсөл бүрээр харуулахад хамгийн тохиромжтой төлбөр, орлогын урсгалуудыг харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 24-өөс харна уу.

ОУИТБС-ын шаардлага нь ТӨААН-үүдийн хувьд тодорхойгүй байна гэж Баталгаажуулалт хийсэн шинжээчид дүгнэдэг байсан ба, шинэ Стандартаар нилээд шаардлагууд нэмэгдсэн. Энэхүү шаардлагын хүрээнд ОУИТБС-ын өмнөх тайлангуудтай харьцуулахад дараах сэдвийн хүрээнд илүү дэлгэрэнгүй мэдээллүүдийг энэхүү тайлангаар ил тод болгож байна. Үүнд:

- Эрдэнэс Монгол ХХК, түүний охин компаниудын үүрэг хариуцлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг тайланд тусгасан.
- ЗГ болон ТӨААН хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан дүрэм, журам, практикийн талаар тодорхой тусгасан. Үүнд: ТӨААН-үүдийн хуримтлагдсан ашиг, дахин хийсэн хөрөнгө оруулалт, ногдол ашиг, гуравдагч талын санхүүжилт зэргийг багтаасан.
- Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан болон санхүүгийн гол үзүүлэлтийг нийтэд ил тод болгосон ТӨААН-үүдийн холбогдох мэдээллийн эх сурвалжийн холбоос (линк)-ыг тайланд тусгасан.
- ТӨААН-үүдийн үйл ажиллагаа, хөрөнгийн болон урсгал зардал, худалдан авалт, туслан гүйцэтгэгч ажиллуулах болон Компанийн засаглалтай холбоотой дүрэм, журам болон практик үйл ажиллагааг тайлбарлан оруулсан.
- Олборлох компаниудаас ТӨААН-д хийсэн төлбөр, ТӨААН-ээс төрийн байгууллагуудад, төрийн байгууллагаас ТӨААН хооронд хийгдсэн материаллаг төлбөрийг ил болгосон.

Стандартад ОТАХ нь жендерийн эрх тэгш тэнцвэртэй байдал болон нийгмийн оролцоог сайжруулахад хүчин чармайлт гаргаж, баримтжуулах шаардлагатай гэж заасны дагуу эрдэс баялгийн салбарт ажиллаж буй ажиллах хүчний мэдээлэлд жендерийн мэдээллийг оруулж, эмэгтэйчүүдийн оролцоо эрдэс баялагийн салбарт хэр байгааг харуулсан.

Байгаль орчны асуудал нь байгалийн нөөцийн засаглалын чухал хэсэг тул олборлох салбарын байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа, байгаль орчны нөлөөллийн мониторинг, үнэлгээг Монгол улс хэрхэн хийж байгаа талаар энэхүү тайланд дараах байдлаар тусгасан. Үүнд:

- Байгаль орчны хүрээнд төрөөс баримталж байгаа хууль, эрх зүйн зохицуулалтууд
- Байгаль орчны хүрээнд төрөөс баримталж байгаа бодлого, хөтөлбөрүүд, авч хэрэгжүүлж байгаа ажлууд
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үе шат, хэрхэн авч хэрэгжүүлж байгаа байдал
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний үе шатууд
- Байгаль орчныг хамгаалах тусгай дансны бүртгэл
- Уул уурхайн салбарын нөхөн сэргээлтийн гүйцэтгэл
- Нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд, тэдгээрийн байршил.

Ашиг хүртэгч жинхэнэ эздийн мэдээллийг Ажлын даалгаварт заасны дагуу оруулсан ба дэлгэрэнгүйг Хавсралт 21-ээс харна уу.

МОУИТБС-ын Ажлын хэсэг нь 171 компани (10 ТӨААН-ийг оруулаад)-ийн улсын болон орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийг тайлагнахаар баталсан бөгөөд, Засгийн газрын 43 байгууллага (28 орон нутгийн байгууллагыг оруулаад) хүлээн авсан орлогоо тайлагнасан.

Төлбөр, орлогыг харьцуулж, тохируулсан бөгөөд дэлгэрэнгүй үр дүнг энэхүү тайлангийн Бүлэг 4 болон Хавсралт 10-д тусгасан.

2.4 ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ОРЛОГО

2.4.1. Нийт олборлох үйлдвэрлэлийн салбараас 2019 онд Засгийн газрын хүлээн авсан орлого

Монгол улсад 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 3,266 тусгай зөвшөөрлийг 2,093 компанид олгоод байна.

Улсын болон орон нутгийн төвшний төрийн байгууллагууд нь олборлох үйлдвэрлэлийн бүх компаниудаас хүлээн авсан орлогоо МОУИТБС-ын цахим тайлагналын системд тайлагнасан. Харин уул уурхайн бус үйл ажиллагаа явуулдаг 40 компаниас хүлээн авсан орлогыг нэгэнт тусгай зөвшөөрөл эзэмшдэг учраас ЗГ цахим тайлагналын системд тайлагнасан ба нийтдээ 2,093 компаниас төлбөр, орлого хүлээн авсан гэж тайлагнажээ. Энэ талаар Бүлэг 2.7.4-т дэлгэрэнгүй тайлбарласан.

Эдгээр 2,093 компаниас олборлох үйлдвэрлэлийн бус 40 компанийг хасаад олборлох үйлдвэрлэлийн нийт 2,053 компанийн төлбөр орлогыг нэгтгэвэл нийт 3,748,081 сая төгрөгийн төлбөр, орлогыг хүлээн авсан байна. Хүлээн авсан төрийн байгууллага тус бүрээр харуулсан дүнг Хүснэгт 2.1-ээс харна уу.

Энэхүү ОУИТБС-ын тайлангийн цар хүрээнд нийцсэн төлбөр, орлогын урсгал бүрээс олсон нийт орлогын дэлгэрэнгүйг, баталсан материаллаг¹-ийн төвшнөөс доогуур орлогыг хамруулаад Хавсралт 6-д харуулав.

2.4.2. Тохируулгын цар хүрээ

Цар хүрээг тодорхойлох шатанд ЗГ-ын ба компаниудын зүгээс тайлагнасан урсгалуудыг тохируулах зорилгоор ОТАХ-ээс 171 компанийг сонгож авсан. Сонголтыг хэрхэн хийсэн талаар 3.2-р бүлэгт тайлбарласан. Эдгээр сонгосон компаниудаас ЗГ-ын хүлээж авсан орлогыг тохируулгын дараах байдлаар, мөн салбарын хэмжээний нийт урсгалтай харьцуулж, цар хүрээг Хүснэгт 2.1-д харуулсан болно.

Хүснэгт 2.1 Засгийн газрын хүлээн авсан орлого, байгууллагаар, сая төгрөгөөр

Засгийн газрын байгууллага	Засгийн газрын орлого		Хувиар
	Олборлох салбарын бүх компани	Нэгтгэлд хамруулсан компаниуд	
	Тохируулгын дараа	Тохируулгын дараа	
Татварын ерөнхий газар	2,477,732	2,453,715	99.03%
Ашигт малтмал газрын тосны газар	314,711	293,597	93.29%
Нийгмийн даатгалын ерөнхий газар	290,944	269,162	92.51%
Гаалийн ерөнхий газар	317,521	245,285	77.25%
Сангийн яам	152,940	152,940	100.00%
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	1,467	1,467	100.00%
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	21,533	21,533	100.00%
Орон нутгийн түвшин	135,863	132,087	97.22%
Тохируулсан урсгалын дүн	3,712,711	3,569,786	96.15%
Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	34,545	33,121	95.88%
Бусад	51,192	50,868	99.37%
Дүн	3,798,448	3,653,775	96.19%

¹ ОУИТБС-ын Стандарт 2019, Шаардлага 4.1.г

2.4.3. Засгийн газрын тайлагнасан орлогын тохируулга

Нэгтгэлийн явцад сонгогдсон компаниудтай холбоотойгоор ЗГ-ын анх тайлагнасан дүнгүүдийг тохируулж, тохируулгын дараах дүнтэй харьцуулж Хүснэгт 2.2-д харуулав. Үүнд:

Хүснэгт 2.2 Засгийн газрын тайлагнасан орлогын тохируулга, сая төгрөгөөр

Засгийн газрын байгууллага	Засгийн газрын орлого			Өөрчлөлт
	Нэгтгэлд хамрагдсан компаниуд			
	Тохируулгын өмнө	Тохируулга	Тохируулгын дараах	%-иар
Татварын ерөнхий газар	2,386,773	66,942	2,453,715	2.80%
Ашигт малтмал газрын тосны газар	293,197	400	293,597	0.14%
Нийгмийн даатгалын ерөнхий газар	273,174	(4,012)	269,162	-1.47%
Гаалийн ерөнхий газар	236,255	9,030	245,285	3.82%
Сангийн яам	-	152,940	152,940	-
Орон нутгийн түвшин	85,354	46,733	132,087	54.75%
Бусад	1,136	49,732	50,868	4377.82%
Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	6,835	26,286	33,121	384.58%
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	-	21,533	21,533	-
Байгаль орчин аялал жуулчлалын яам	-	1,467	1,467	-
Нийт дүн	3,282,724	371,051	3,653,775	11.30%

Нэгтгэлийн үр дүнд ЗГ-ын төлбөр, орлогын хэмжээнд хийсэн томоохон тохируулгуудыг дурдвал:

- ТЕГ нь анхны тайлангаа 66,942 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- ГЕГ нь “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-иар дамжуулан төлсөн “Оюу Толгой” ХХК-ийн НӨАТ, гаалийн албан татвар 9,030 сая төгрөгийг орхигдуулсан,
- ТӨААН-үүдээс улсын төсөвт төлсөн 152,940 сая төгрөгийн ногдол ашгийг төрийн ямар байгууллага тайлагнах нь тодорхойгүйгээс жил бүр зөрүү үүсч байна.
- Орон нутгийн засаг захиргаа нь уул уурхайн компаниудаас хүлээн авсан 46,733 сая төгрөгийн төлбөр, орлогоо дутуу тайлагнасан.
- Төрийн байгууллагууд хүлээн авсан хандив, тусламжаа тайлагнадаггүй, дутуу тайлагнадаг асуудлаас шалтгаалан 26,286 сая төгрөгийн орлогыг орхигдуулсан. Тухайлбал: Өмнөговь аймгийн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д өгсөн “Оюу Толгой” ХХК-ийн 13,163 сая төгрөгийн хандивыг орхигдуулсан байна.
- ХНХЯ, БОАЖЯ цахим тайлангийн системд анхны тайлангаа оруулаагүй.

Тохируулгын дэлгэрэнгүйг Бүлэг 4.2-оос үзнэ үү.

2.5 НЭГТГЭЛИЙН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

2.5.1. Засгийн газар ба компанийн урсгалуудын харьцуулалт, тохируулгын дараах байдлаар

ЗГ болон компаниудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэн, зохих тохируулгуудыг хийснээр тохируулгын дараах үр дүнг Хүснэгт 2.3-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 2.3 Засгийн газар, компанийн орлогын урсгалын тохируулга, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Дүн
ЗГ-ын дүн (тохируулгын дараа)	3,653,775
Компанийн дүн (тохируулгын дараа)	3,617,536
Нийт зөрүү	36,239
Тохируулгын хүсэлтэд хариу ирүүлээгүй компаниуд	(36,263)
Тайлбарлагдаагүй цэвэр зөрүү	(24)
ЗГ компаниудаас илүү тайлагнасан	15,138
ЗГ компаниудаас дутуу тайлагнасан	(15,162)

Төлбөр, орлогын анхны нэгтгэлээр нийт 41,762 сая төгрөгийн цэвэр зөрүү үүссэн ба Хараат бус хянагч-нэгтгэгч нь ЗГ-ын тайланд 371,051 сая төгрөгийн нэмэгдэх тохируулга, компанийн дүнд 293,050 сая төгрөгийн нэмэгдэх тохируулгыг хийснээр нийт зөрүүг 24 сая төгрөг хүртэл буурууллаа. Нэгтгэлийн явцад тохируулгын хүсэлтэд хариу ирүүлээгүй компаниудаас шалтгаалсан 36,263 сая төгрөгийн зөрүүний ихэнх хувь (98 хувь)-ийг “Ачит ихт” ХХК-ийн 35,548 сая төгрөгийн зөрүү эзэлж байна.

Хүснэгт 2.4 Нэгтгэлд тайлбарлагдаагүй зөрүү, компаниар, сая төгрөгөөр

№	Регистр	Компанийн нэр	ЗГ-ын тайлагнасан орлого	Компанийн тайлагнасан орлого	Тайлбар
1	2788705	Ачит-Ихт	35,548	-	Хариу өгөхөөс татгалзсан.
2	5175933	Мэжик бридж	715	-	Холбогдож чадаагүй.
Нийт			36,263	-	

2.5.2. Олборлох салбарын орлогын хураангуй

Компанийн тайлагнасан төлбөрийн мэдээг ЗГ-ын тайлагнасан орлогын дүнтэй тохируулсны дараа шинжилж үзэхэд 2019 онд олборлох үйлдвэрлэлийн компаниудын нийт төлбөрийн 85 хувийг топ 10 компаниас төлсөн бол, харин топ 20 компанийн төлсөн төлбөрийн дүн нь олборлох үйлдвэрлэлийн компаниудаас ЗГ-ын хүлээж авсан нийт орлогын 92.8 хувийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 2.5 Олборлох үйлдвэрлэлийн топ 20 компанийн төлбөр, сая төгрөгөөр, хувиар

№	Компанийн нэр	Компанийн мэдээгээр	Нийт дүнд эзлэх % (дангаар)	Нийт дүнд эзлэх % (өссөн дүнгээр)
1	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	949,590	25.99%	25.99%
2	Эрдэнэс Таван толгой ХК	710,293	19.44%	45.43%
3	Оюу Толгой ХХК	526,114	14.40%	59.83%
4	Петрочайна Дачин Тамсаг ХХК	281,682	7.71%	67.54%
5	Энержи Ресурс ХХК	225,646	6.18%	73.71%
6	Тавантолгой ХК	120,048	3.29%	77.00%
7	Монголын Алт МАК ХХК	101,472	2.78%	79.78%
8	Цайртминерал ХХК	70,212	1.92%	81.70%
9	Саусгоби Сэндс ХХК	54,209	1.48%	83.18%
10	ӨСӨХ ЗООС ХХК	43,268	1.18%	84.37%
11	Шинь Шинь ХХК	39,736	1.09%	85.45%
12	Монголросцветмет ТӨҮГ	38,516	1.05%	86.51%
13	Ачит-Ихт ХХК	35,548	0.97%	87.48%
14	Доншен газрын тос (Монгол) ХХК	32,152	0.88%	88.36%

15	МоЭнКо ХХК	29,621	0.81%	89.17%
16	Болдтөмөр Ерөө гол ХХК	27,329	0.75%	89.92%
17	Си Өү Эй Эл ХХК	25,324	0.69%	90.61%
18	Хангад Эксплорейшн ХХК	24,559	0.67%	91.28%
19	Цагаан Өвөлжөө ХХК	19,879	0.54%	91.83%
20	Хишиг арвин индустриал ХХК	16,072	0.44%	92.27%
21	Бусад компаниуд	282,505	7.73%	
	Бүх компаниудын дүн	3,653,775		

Компаниудаас ирүүлсэн төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 10-д харуулав.

2.6 МЭДЭЭЛЛИЙН ИЖ БҮРЭН, ҮНЭН ЗӨВ БАЙДАЛ

ОУИТБС-ын тайлан гаргаж буй төрийн байгууллагууд, төрийн болон хувийн компаниудын тайлангаа баталгаажуулсан байдал, олон улсын стандартын дагуу хариуцлагатай хараат бус аудитораар баталгаажуулсан эсэхэд үнэлгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.

2.6.1. Засгийн газар

БОАЖЯ, ХНХЯ-наас бусад төрийн байгууллагууд тайлангаа МОУИТБС-ын Цахим тайлагналын системд шивж оруулсан.

ОУИТБС-ын шаардлага 4.9.а, ОТАХ-ээс тавьсан шаардлагын дагуу ОУИТБС-ын нэгтгэл тайлангийн өгөгдөл мэдээллийг хангалттай хэмжээнд баталгаажуулсан байх ёстой. Өөрөөр хэлбэл, тайлагнагч төрийн байгууллага болон компанийн ахлах төвшний удирдлагаас бичгэн баталгаа авах юм.

Иймд “хараат бус хянагч-нэгтгэгчид ирүүлсэн мэдээллүүд нь үнэн зөв” гэсэн Удирдлагын хариуцлагын захидлыг баталгаажуулж ирүүлнэ үү гэж төрийн 14 яам, агентлаг руу хүсэлт явуулсан.

ОУИТБС-ын тайланг тушааж буй ЗГ-ын байгууллагуудын тайланг Үндэсний аудитын газар (ҮАГ) баталгаажуулах ёстой. ҮАГ-аас баталсан Санхүүгийн тайланд аудит хийх журмын 15.4.2-д “Олборлох үйлдвэрлэл эрхэлдэг ААН-дийн төсөвт төвлөрүүлсэн төлбөрийг ОУИТБС-ын Ажлын алба болон орлого хүлээн авсан ЗГ-ын байгууллагуудтай тулган баталгаажуулж, дүгнэлт гаргах” гэж заасан байна. Энэ аудитын ажил өнөөдрийг хүртэл хийгдэхгүй байна.

2.6.2. Төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨААН)

МОУИТБС-ын Ажлын хэсгээс шаардсан мэдээллүүдийг гаргаж өгөх нь ОУИТБС-ын тайлагналын үйл явц дахь ЗГ-ын хүчин чармайлтыг харуулах чухал хэсэг юм.

МОУИТБС-ын цахим тайлангийн системд нэгтгэлд хамрагдсан 10 ТӨААН-үүд бүгд тайлагнасан боловч, 3 компани нь ил тод байдлын тайлангаа Удирдлагын хариуцлагын захидлаар баталгаажуулсан, 7 компани баталгаажуулаагүй байна. Мөн Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК, Могойн гол ХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан нь нийтэд ил тод болоогүй байна.

ҮАГ-аас 2019 онд ТӨААН-үүдэд хийсэн аудитын дүгнэлтээр Эрдэнэт үйлдвэр ТӨХХК нь “хязгаарлалттай” дүгнэлт авсан, харин аудитын тайлангаа ил болгосон бусад ТӨААН-үүд “зөрчилгүй” дүгнэлт авсан байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайланд дараах асуудлаар аудитын дүгнэлтийг хязгаарласан байна. Тухайлбал, “Санхүүгийн тайлан дахь бараа материал дансанд 3-аас дээш жил ашиглаагүй 41,229.6 сая төгрөгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг ямар хөрөнгөнд хийсэн нь тодорхойгүй, үндсэн хөрөнгөнд 2014 оноос хойш дахин үнэлгээ хийгдээгүй буюу 1,200,867.6 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр илэрхийлээгүй зэрэг нь санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Үнэн зөв” гэсэн батламж мэдэгдлийг

хангаагүй бөгөөд холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй тул буруу илэрхийлсэн” гэж үзсэн байна.

ҮАГ-ын болон ТӨААН-ийн цахим хуудас, шилэн дансны цахим хуудсанд нийтэлсэн ТӨААН-дийн аудитлагдсан санхүүгийн тайлангууд нь УСНББОУС болон НББОУС/ СТОУС-ын дагуу шаардлага хангасан хавсралт тодруулгуудыг иж бүрнээр нь ил тод болгон нийтлэхгүй байгаа нь олон нийтийн зүгээс ТӨААН-үүдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны талаар цогц мэдээллийг авч чадахгүйд хүргэж байна.

2.6.3. Хувийн компаниуд

Нэгтгэлд хамрагдсан хувийн 161 компаниас 140 нь ил тод байдлын тайланг баталгаажуулж Удирдлагын хариуцлагын захидал илгээсэн, харин 21 компани илгээгээгүй байна. Нийт 21 компани МОУИТБС-ын цахим тайлагналын системд тайлан мэдээ тушаагаагүй бөгөөд эдгээр компаниудаас нэмэлт маягтаар мэдээллийг цуглуулсан.

Эдгээр компанийн тайлагнасан орлого нийтдээ 62,952 сая төгрөг байгаа нь нийт орлогын 2 хувийг эзэлж байна. Цахим тайлангийн системд анхны тайлангаа тушаагаагүй компаниудын төлбөр, орлого ЗГ-ын оруулсан мэдээллээр 73,138 сая төгрөг байна.

Нийт 161 компаниас 58 компани нь санхүүгийн тайланг АОУС-ын дагуу хариуцлагатай, хараат бус аудитораар баталгаажуулсан эсэх тухай мэдээлэл ирүүлсэн ба, үүнээс нэг аудиторын тайлан нь хязгаарлалттай дүгнэлттэй, үлдсэн нь зөрчилгүй дүгнэлттэй байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлангийн мэдээллээ оруулаагүй компаниудын тайлагнасан төлбөр, орлогын дүн 3,345,935 сая төгрөг болсон ба нийт тайлагнасан орлогын 93 хувьтай тэнцэж байна.

Удирдлагын хариуцлагын захидлын шаардлагыг биелүүлээгүй эдгээр компаниудын мэдээллийг Хавсралт 7-с үзнэ үү.

Хүснэгт 2.6 ТОП 10 компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан

Компанийн нэр	Аудитын дүгнэлтийн мэдээ ирүүлсэн	Удирдлагын хариуцлагын захидал ирүүлсэн байдал	Тайлагнасан дүн (тэрбум төгрөг)	Нийт төлбөрт эзлэх хувь	Нийт дүнд эзлэх % (өссөн дүнгээр)
Эрдэнэт үйлдвэр	×	√	948,633	26.3%	26.3%
Эрдэнэс Таван толгой	×	√	710,879	19.7%	45.9%
Оюу Толгой	×	√	525,033	14.5%	60.5%
Петрочайна Дачин Тамсаг	×	√	283,629	7.8%	68.3%
Энержи Ресурс	×	√	226,592	6.3%	74.6%
Тавантолгой	×	√	119,966	3.3%	77.9%
Монголын Алт МАК	×	√	101,210	2.8%	80.7%
Цайртминерал	×	√	70,073	1.9%	82.6%
Саусгоби Сэндс	√	√	54,768	1.5%	84.2%
ӨСӨХ ЗООС	×	√	43,384	1.2%	85.4%

Өмнөх нэгтгэлүүдийн үед компаниудаас аудитлагдсан санхүүгийн тайланг шаардаж авдаг байсан боловч компаниудын аудитлагдсан санхүүгийн тайлангаас ОУИТБС-д тайлагнасан мэдээллийн чанарыг дүгнэх мэдээлэл бараг олддоггүй, учир нь санхүүгийн тайлан аккруэл суурийн дагуу бэлтгэгддэг бол ОУИТБС-ын тайлан мөнгөн сууриар бэлтгэгддэг. Хамгийн их татвар төлсөн топ 10 компанийн санхүүгийн тайлан нь аудитлагдсан эсэх, аудитын ямар дүгнэлт авсан талаар цахим тайлангийн системээс судалж үзэхэд дараах байдалтай байна.

Эндээс үзэхэд зөвхөн Удирдлагын хариуцлагын захидал болон Аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлтэд үндэслэн компаниудын ирүүлсэн ил тодын тайланг үнэн зөв гэж итгэх

бололцоогүй нь харагдаж байгаа ба төрийн байгууллагууд болон компаниуд нь тушаасан ил тодын тайлангаа хараат бус аудитын байгууллагаар баталгаажуулж байх шаардлагатай.

2.7 ГОЛ ДҮГНЭЛТ

2.7.1. Боловсруулах компаниудыг тайланд хамруулахад үүсч буй хүндрэл

Олборлох салбараас Монгол улсад оруулж буй орлогын хувьд зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшдэг компаниудаас гадна боловсруулах үйлдвэр, уул уурхайн туслан гүйцэтгэгчид томоохон хувь нэмрийг оруулж байдаг. Эхлэлийн семинарийн үед ОТАХ-ээс боловсруулах салбарын 6 компанийг нэгтгэлд нэмж хамруулахаар шийдвэрлэсэн. Гэвч эдгээр компаниуд нь тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй тул цахим тайлангийн системд мэдээлэл нь ороогүй, ОУИТБС-ын талаар ямар ч ойлголтгүй бөгөөд, мэдээлэл гаргаж ирүүлэхийг хүсэхэд эрх зүйн ямар зохицуулалт байгааг лавлан асууж байна. Тухайлбал:

- Ачит ихт ХХК нь “манай компанийг eitimongolia.mn-д тайлагнах үүрэг хүлээсэн гэдгийг нотлох албан ёсны бичиг баримт, хуулийн заалт байгаа эсэх, нэгтгэгч нь төрийн байгууллага биш тул ААН-ээс шаардах эрхгүй, санаачилга гэхээр сайн дурын гэж ойлгогдож байна, хуулийн заалт болон эрх бүхий холбогдох байгууллагын шийдвэр ирүүлбэл мэдээллээ нууцлалын гэрээ байгуулсны үндсэн дээр өгнө” гэсэн хариу ирүүлсэн.
- Арева Монгол ХХК нь ураны чиглэлийн хайгуулын Кожеговь ХХК-ийн толгой компани бөгөөд тус компани нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй, зөвхөн төлөөлөгчийн газрын шинжтэй, улсад маш бага хэмжээний татвар төлдөг байна.

Иймд боловсруулах салбарын томоохон үйлдвэрлэгч болон туслан гүйцэтгэгч нарыг ОТАХ урьдчилан сонгож, тэдэнд албан ёсоор мэдэгдэж, цахим тайлангийн системд үндсэн мэдээллийг оруулах замаар ил тод байдлын тайланг тушаах нөхцөлийг бүрдүүлж, улмаар ОУИТБС-ын нэгтгэлд хамруулж байх нь зүйтэй байна.

2.7.2. Тайлан тушаалт, хариу ирүүлэлтийн байдал

ОУИТБС-ын 2019 оны тайланг нийт 2,093 компани илгээх ёстой боловч 1,472 компани тайлангаа илгээж, 621 компани тайлан илгээгээгүй байна. Төрийн байгууллагуудаас БОАЖЯ нь Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээг тайлагнаагүй бол, ХНХЯ нь Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийн мэдээг оруулаагүй байна.

Нэгтгэлийн явцад тайланд хамрагдсан төрийн байгууллагууд болон компаниудын хариу ирүүлэлт дараах байдалтай байна. Тухайлбал:

- Нийт сонгогдсон 171 компаниас Ачит Ихт ХХК, Баян айраг эксплорэйшн ХХК гэсэн 2 компани хариу ирүүлэхээс татгалзсан бол Мэжик бридж, Империаг гоулд Майнинг, Монголчех металл зэрэг компаниудтай огт холбогдож чадаагүй.
- Нийт 14 яамд, төрийн байгууллага руу албан бичиг явуулснаас УУХҮЯ албан ёсоор хариу ирүүлээгүй, СЯ-ны хувьд ирүүлсэн мэдээлэл нь албажуулаагүй төсөл хэлбэртэй байна.
- Зөрүү үүссэн 20 аймаг, 8 дүүрэг рүү зөрүүг тодруулах албан бичиг явуулснаас Сүхбаатар дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Орхон аймаг хариу огт ирүүлээгүй бол Ховд, Дорнод, Дорноговь, Баянхонгор аймгууд, Чингэлтэй дүүрэг мэдээллээ дутуу ирүүлсэн.

Компаниуд болон төрийн байгууллагуудын ОУИТБС-ын тайланг тушааж хэвшүүлэх, тушаасан тайлангийн үнэн зөв байдлыг хангуулах талаар жил бүрийн нэгтгэлийн тайланд зөвлөмж өгдөг боловч томоохон ахиц харагдахгүй байгаа нь Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг баталж мөрдүүлэх нь чухал болохыг харуулж байна.

2.7.3. Төрийн байгууллагын тайлан мэдээний үнэн зөв байдал

Нэгтгэлээс харахад ТЕГ нь 28 алтны компаниас хүлээн авсан 18.1 тэрбум төгрөгийн АМНАТ-ийг анхны тайландаа орхигдуулан тайлагнасан боловч, нэгтгэлийн явцад нэмэлт мэдээлэл гаргаж ирүүлээгүй. Учир нь 2019 онд Ашигт малтмалын тухай хуулийн 47.12-д орсон өөрчлөлтөд *“Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 47.3.2-т заасан хувь хэмжээгээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тушаасан алтны борлуулалтын үнэлгээнээс суутган авч, улсын төсөвт шилжүүлнэ”* гэж заасан тул Монголбанк алтны компаниудын тушаасан алтнаас АМНАТ-ыг шууд ногдуулан, бөөн дүнгээр нь ТЕГ-т шилжүүлдэг болсон байна.

Хуулийн өөрчлөлт нь ТЕГ-ын алтны компаниудын АМНАТ-ын ногдуулалт, төлөлтийн горимд нөлөөлсөн боловч, ОУИТБС-ын тайланг зөв дүнгээр тайлагнах, АМНАТ-ын ногдуулалт, төлөлтийн байдалд тавих хяналтад нөлөөлөхгүй тул ТЕГ нь мэдээллийн системээ сайжруулж, ОУИТБС-ын тайланг үнэн зөв тайлагнах талаар цаашид анхаарч ажиллана гэж найдаж байна.

2.7.4. Мэдээллийн чанар, тайлангийн баталгаажуулалтын талаар

ОУИТБС-ын стандартад өгөгдөл мэдээллийн чанарын асуудлыг чухлаар авч үздэг ба цаашид ЗГ болон компаниуд мэдээллээ системтэйгээр тайлагнах, Хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс хийх тохируулгын хэрэгцээг багасгах, мэдээллийн араас шалгах аас зайлсхийх олон улсын жишгийг дагаж мөрдөхийг зорьж байгаа юм.

Төрийн байгууллагууд, ТӨААН-үүд болон компаниуд нь цахим тайланд тайлагнасан төлбөр орлогын мэдээлэл болон нэмэлтээр ирүүлсэн мэдээллээ үнэн зөв гэдгийг баталгаажуулж, Удирдлагын хариуцлагын захидал ирүүлж байгаа боловч тайлангууд аль аль талдаа алдаатай байгаа нь Хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс оролцогч талуудын төлбөр, орлогын дүнд 541 тэрбум төгрөгийн буюу материаллаг хэмжээний тохируулга хийж байгаагаас тодорхой байна.

Иймд ОУИТБС-ийн тайланг буруу тайлагнасан оролцогч талуудын хариуцлагыг дээшлүүлэх, шаардлага 4.9-д заасны дагуу төрийн болон хөндлөнгийн аудитын байгууллагаар тайланг баталгаажуулахад анхаарч ажиллах хэрэгтэй байна.

2.7.5. Цахим тайлангийн иж бүрдэл

ОУИТБС-ын 2019 оны тайлан тушаалтыг 2020 оны 4 дүгээр сарын 30-наар хаасан ба тухайн өдрөөрх өгөгдөлд үндэслэн мэдээллийн иж бүрэн байдлыг шалгасан.

Цахим тайлангийн системд ЗГ нь 2,422 компаниас хүлээн авсан орлогыг тайлагнасан ба Хараат бус хянагч-нэгтгэгч нь эдгээр компаниудын жагсаалтыг АМГТГ-ын систем дэх тусгай зөвшөөрөл эзэмшигч (ТЗЭ) компаниудын жагсаалттай тулган шалгахад 329 компани илүү тайлагнасан гэж харагдаж байна (Хүснэгт 2.7).

Зөрүүгийн шалтгааныг тодруулахад дараах асуудлаас үүдэлтэй байна. Үүнд:

- Орон нутгийн захиргаанаас цахим тайланд мэдээлэл шивэхдээ шинэ нэр оруулах эрхтэй байдаг. Гэвч орон нутаг дахь төрийн байгууллагын хариуцсан ажилтан компаниудаас хүлээн авсан орон нутгийн татварыг цахим тайланд оруулахдаа уг системд нэгэнт бүртгэгдсэн компанийн нэр, регистрийн дугаарыг шалган мэдээг оруулалгүй, харин өөрсдөө шинээр нэр, регистр үүсгэснээр 70 компанийн хувьд давхардуулан тайлагнасан байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын лицензийг орон нутгаас бие даан олгодог ба эдгээр компаниудын мэдээллийг орон нутгийн захиргаа өөрсдөө нэмж оруулсан байх магадлалтай бөгөөд ийм 259 компани байна.
- 1-6 оронтой тоо бүхий алдаатай регистрийн дугаартай 106 компани бүртгэгдсэн байна.

- АМГТГ-ын кадастрын системд Голден грэвэл, Даян эрчис, Дүүрэн-Ёндой, Сова, Хишигтхөндий, Эрдэсплазм, Эрдэс плазм, Эрдэс плазм ХХК гэсэн 8 компани 2-6 орон бүхий буруу регистрийн дугаартай бүртгэгдсэн байна.

Хүснэгт 2.7 Цахим тайлан илгээх компаниуд, орлогод эзлэх дүн, сая төгрөгөөр

Утга	Компанийн тоо	ЗГ-ын орлогын дүн (сая төгрөгөөр)
Цахим тайлангийн системд бүртгэлтэй нийт компанийн тоо	2,422	3,452,974
Үүнээс: АМГТГ-аас оруулсан ТЗЭ компанийн тоо	2,093	3,405,508
Зөрүү	329	47,466
Цахим тайлагналын системд адилхан нэртэй мөртлөө өөр регистрийн дугаартай бүртгүүлж, тайлан тушаасан компанийн тоо	70	25,991
Бусад шалтгаантай компанийн тоо	259	21,475

2.7.6. ОУИТБС-ын шинэ маягтаар цуглуулсан мэдээллийн чанар байдал болон нэгтгэлийн тохируулга хийхтэй холбоотой хүндрэл бэрхшээл

2019 оны ил тод байдлын тайланг компаниудаас цахим тайлангийн системээр шинэ, хуучин 2 маягтаар авсан байна. Хуучин маягтаар 2020 оны 4 дүгээр сарын 30-ныг хүртэл, шинэ маягтаар 10 дугаар сарын 30-ныг хүртэл тайлан хүлээн авсан гэж Ажлын албанаас мэдэгдсэн.

Хуучин маягтаар нийт 1472 компани тайлан илгээсэн бол, 881 компани тайлангаа илгээгээгүй, харин 633 компани шинэ маягтаар тайлангаа гаргажээ. Төрийн 2 яам, 4 агентлаг болон орон нутгийн 19 аймаг, 8 дүүргийн захиргаа хүлээн авсан төлбөр, орлогоо цахимаар тайлагнасан байна.

Шинэ маягтуудыг гараар байршуулж байгаа бөгөөд, өмнө хэрэглэж байсан програм ба шинээр хөгжүүлсэн програм хоорондын нийлэмжийг шинэчлэх ажил хийгдэж дуусаагүйн улмаас шинэчилсэн маягтаар ирүүлсэн мэдээлэлд доорх алдаа илэрч байна. Үүнд:

- Мэдээлэл давхардсан,
- Олон сонголтот мэдээллийг тодорхойлох боломжгүй,
- Мэдээлэл бөглөөгүй орхисон

зэрэг нь дутуу боловсруулагдсан мэдээллийг олон нийтэд хүргэх, цаашлаад тайлан хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах эрсдэлтэй байна.

Иймээс дээрх бүх мэдээллийг олон нийтэд ил болгох, эсвэл сонгогдсон компаниудын мэдээллийг хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс үнэлж, сайжруулан олон нийтэд ил тод болгох талаар хэлэлцэх нь зүйтэй.

2.7.7. ТӨААН-ийн санхүүгийн тайланг ил тод болгох

ҮАГ-ын, шилэн дансны цахим хуудас болон ТӨААН-үүдийн цахим хуудсанд ТӨААН-үүдийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дараах мэдээллүүд нийтлэгдсэн байна.

- Санхүүгийн байдлын тайлан,
- Дэлгэрэнгүй орлогын тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Аудитын дүгнэлт.

Олборлох салбарын бүх ТӨААН-ийн аудитлагдсан иж бүрэн санхүүгийн тайланг цахимаар нийтэд мэдээлэх, тодруулбал тухайн ТӨААН-ийн вэб хуудсанд төдийгүй ҮАГ, ОУИТБС эсвэл АМГТГ-ын вэб хуудсанд тус тус нийтлэх нь зүйтэй байна.

2.7.8. Төрийн оролцоо, шаардлагыг ил тод болгох

ОУИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын 2018 оны баталгаажуулалтын тайлан, Мэдээллийг системтэйгээр ил тод болгоход Монгол улс бэлэн эсэхэд хийсэн үнэлгээний тайлан зэрэгт нийтлэг тусгагдсан зүйл нь төрийн оролцоог стандартын шаардлагын дагуу ил тод болгох асуудал хангалттай бус байгаа талаар онцлон тэмдэглэсэн байна.

Ялангуяа ТӨААН-ийн хуримтлагдсан ашиг, дахин хийсэн хөрөнгө оруулалт, гуравдагч талын санхүүжилт, зээл, ТӨААН-ээс төрийн байгууллагууд, төрийн байгууллагаас ТӨААН хоорондын гүйлгээ зэрэгт хамаарах мэдээллийг нийтэд ил тод болгох нь дутагдалтай байна. Түүнчлэн ОУИТБС-ын 2019 оны стандартын дагуу ТӨААН-үүд нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаа ил болгох, хөрөнгийн болон урсгал зардал, худалдан авалт, туслан гүйцэтгэгч ажиллуулах, компанийн засаглалтай холбоотой дүрэм, журам болон практик үйл ажиллагааг ил тод болгох асуудал хангалтгүй байна.

Хэрэв ТӨААН-үүд шилэн дансны мэдээллийг иж бүрэн бөглөвөл дээрх шаардлагуудаас заримыг ил тод болгох боломж нээлттэй байна. Үүнд:

- хуримтлагдсан ашиг (шилэн дансны цахим хуудасны санхүүгийн тайлан мэдээллээс харж болно),
- дахин хийсэн хөрөнгө оруулалт (бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр-хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр),
- хөрөнгийн болон урсгал зардал (шилэн дансны цахим хуудасны Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (бүтэн жилээр, сар бүр), хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (тухай бүр)),
- худалдан авалт (шилэн дансны цахим хуудасны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр), Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр), Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн).

Гэвч ТӨААН-үүд нь шилэн дансны цахим хуудсанд 2019 оны худалдан авалттай холбоотой зарим маягтуудыг л бөглөж, Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет, Эрдэнэс тавантолгой ХК-даас бусад ТӨААН зарим мэдээллийг шилэн дансанд дутуу, хангалтгүй байршуулсан байна.

ОТАХ нь жил тутам гаргаж буй ОУИТБС-ын тайлангийн хүрээнд төрийн өмчит компаниудын ЗГ-тай хамаарах санхүүгийн харилцааны журам, дүрэм болон бодит практик хоорондын ялгаатай/ зөрүүтэй байдалд үнэлэлт өгөхөд анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай. Илүү тогтвортой болгохын тулд ОУИТБС нь ЗГХЭГ, Эрдэнэс Монгол ХХК болон ТӨБЗГ-тай хамтран ажиллаж уул уурхайн салбарт ажиллаж буй төрийн өмчит компаниудын санхүүгийн мэдээллийг ил тод болгох системийг боловсруулан гаргах шаардлагатай.

ТӨААН-үүдийг Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ ил тод нийтлэх, ТӨБЗГ-ын цахим хуудсаар ТӨААН-ээс хүлээн авсан ногдол ашиг, эсвэл хамаарах төрийн байгууллагын вебсайтаар дамжуулан ил тод болгон нийтэлж байх тогтолцоог бий болгох хэрэгтэй.

3

ТОХИРУУЛГЫН АРГАЧЛАЛ, ЦАР ХҮРЭЭ



3 ТОХИРУУЛГЫН АРГАЧЛАЛ БОЛОН ЦАР ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

3.1 ТАНИЛЦУУЛГА

“Грант Торнтон Аудит” ХХК нь нэгтгэл тайланг гэрээт ажлын даалгаварт тодорхойлсон шаардлагын дагуу гүйцэтгэх үүрэгтэй. Энэхүү нэгтгэлээр олборлох салбарын компаниудын төлсөн төлбөрийг, ЗГ-ын хүлээн авсан орлоготой тохируулах ажил хийдэг бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг энэ бүлэгт оруулсан болно.

Тохируулгыг хийхдээ мөнгөн суурьт нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтална.

Хэрэв цахим тайлагналын системд төлсөн болон хүлээн авсан байгууллагуудын аль аль нь материаллаг хэмжээний төлбөр эсвэл орлого орхигдуулсан бол бидний ажил эдгээрийг шийдэх бололцоогүй бөгөөд энэ нь тайланд орохгүй байх эрсдэлтэй юм. Харин ЗГ болон Компанийн аль нэг нь тайлагнасан бол нөгөө талын орхигдсон мэдээллийг олж авч, нэгтгэлд хамруулах бүрэн боломжтой. Үүнээс бусад тохиолдолд тэдгээр орхигдсон төлбөр, орлогын мэдээллүүд бидний тайланд багтаагүй болно.

Бид тайлагнагч байгууллагуудаас бөглөж ирүүлсэн маягт, мэдээлэл ба тэднээс өгсөн тайлбарт үндэслэн нэгтгэлийн ажлыг гүйцэтгэсэн ба тоо мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдалд аудит хийгээгүй болно.

Энэхүү ажлыг гүйцэтгэх явцад тайлагнагч байгууллагуудаас хүлээн авсан тайлбар, мэдээлэл үнэн зөв гэдэгт бид найдаж байна.

3.2 ЦАР ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

3.2.1. Танилцуулга

Монгол Улсын ОУИТБС-ын 2019 оны нэгтгэл тайланд хамрагдах цар хүрээг тодорхойлохдоо ОТАХ-тэй хамтран дараах асуудлуудыг харгалзаж үзсэн. Үүнд:

- Тайланд хамрагдах уул уурхайн салбарын үндсэн мэдээллүүдийн хүрээг тогтоох,
- Тайланд хамрагдсан компаниудаас авах нэмэлт мэдээллүүдийн хүрээг тогтоох,
- Тайланд хамрагдах материаллаг төлбөр төлсөн компаниудыг тодорхойлох,
- Тайланд хамрагдах материаллаг төлбөр хүлээж авсан төрийн байгууллагуудыг тодорхойлох,
- Тайлан хамрагдах материаллаг төлбөр бүхий санхүүгийн урсгалуудыг тодорхойлох,
- Тайлагнасан тоо мэдээлэл нь үнэн зөв гэдгээ баталгаажуулах хувилбарууд.

3.2.2. Цар хүрээ тодорхойлох ба Эхлэлийн семинар

Эхлэлийн үе шатанд бид ОУИТБС-ын 2019 оны тайланд шаардагдах агуулгын талаарх мэдээлэл, үүнд Ажлын даалгаврын Хавсралт 4-т орсон шаардлагууд, цахим тайлагналын иж бүрэн байдлыг хянаж, тайланд хамрагдах компани, төрийн байгууллагууд, төлбөр орлогын урсгалуудыг тодорхойлох, оролцогч талуудын системтэйгээр ил тод болгосон байдал зэргийг шалгах, мэдээллийг тодруулах зэргээр ажилласан.

Эхлэлийн үе шатны зорилго нь ОУИТБС-ын тайлагналын үйл явцын хамрах хүрээг зөв тодорхойлж, үүнд тайлагнах маягууд, мэдээлэл цуглуулах горим, ОУИТБС-ын тайланг хэвлэх хуваарь зэргийг баталгаажуулах явдал юм.

Бид 2020 оны 11 дүгээр сарын 6-нд зохион байгуулсан ОТАХ-ийн гишүүдийг хамруулсан эхлэлийн семинарт оролцож, 2019 оны ОУИТБС-ын тайлангийн агуулга, шинэ стандартын шаардлагууд, холбогдох тодорхойлолтууд болон материаллаг хэмжээний төлбөр, орлогын босго үзүүлэлтүүдийг авч хэлэлцсэн бөгөөд, энэхүү тайланд семинарын үеэр авсан саналыг тусгаж, ОУИТБС-ын 2019 оны тайлангийн хамрах хүрээг ОТАХ-ийн гишүүд баталсан.

3.2.3. ОУИТБС-ын стандартад орсон өөрчлөлт

ОУИТБС-ын Зөвлөл нь 2 бүлэг, 12 шаардлага бүхий стандартыг 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс хэрэгжүүлэх шийдвэр гаргасан.

2019 оны 12 дугаар сарын 31-нээс өмнө хэвлэгдсэн ОУИТБС-ын тайлангуудын хувьд ОУИТБС Стандарт 2016 болон 2019 аль алийг нь мөрдөж болно. Харин 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн зөвхөн ОУИТБС-ын Стандарт 2019-ийг мөрдөнө.

ОУИТБС-ын Стандартад дараах гол өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- **Гэрээний ил тод байдал.** ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч олон улс оронд хэр их хэмжээний татвар олборлох салбараас эх үүсвэртэй байгааг тодорхойлох нөхцөл бүхий ЗГ болон компани хоорондын гэрээ байгуулдаг. Эдгээр гэрээ нь ихэвчлэн нууц, олон нийтэд ил тод бус байдаг нь бодит орлогыг хүлээж авч байгаа эсэхэд эргэлзээ үүсгэдэг. 2013 оны ОУИТБС-ын стандартаар гэрээг ил тод болгохыг сайшаан дэмжиж, гэрээг ил тод болгох тодорхой бодлоготой болох, үндэсний хэмжээнд гэрээг ил тод болгох асуудлыг хэлэлцэх талаар тусгасан. ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч ихэнх улс орон гэрээг ил тод болгох алхмуудыг авч хэрэгжүүлсэн байна. 2019 оны стандартаар 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш гарын үсэг зурагдаж, баталгаажсан гэрээг ил тод болгохыг шаардсан.
- **Төрийн оролцоо болон барааны арилжаа.** ОУИТБС-ын Удирдах хороо нь төрийн оролцоо, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй холбоотой ажил гүйлгээ, төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй шинжтэй төлбөр зэргийн талаар шаардлагуудыг ил тод болгохыг сайжруулахаар баталсан. Үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого зэргийг худалдан авагч нэг бүрээр задаргаатай ил тод болгохыг шаардсан.
- **Байгаль орчин.** Олборлох үйлдвэрлэлийн салбараас байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл нь олон нийтэд маргаан дагуулдаг гол асуудлуудын нэг юм. 2019 оны стандартаар ОУИТБС нь компаниудаас ЗГ-т төлсөн материаллаг хэмжээний байгаль орчны төлбөрийг ил тод болгож, байгаль орчны мониторингтой холбогдох суурь мэдээллүүдийг ил тод болгохыг шаардсан.
- **Жендер.** ОТАХ нь жендерийн эрх тэгш оролцоо болон компаниудын ажлын байрны мэдээллийг хүйсийн задаргаатай, түвшингээр нь ил тод болгохыг шаардсан.
- **Системтэй ил тод байдал.** Стандарт нь ОУИТБС-ын тайлан гаргах үйл явцаас системтэй ил тод байдалд шилжих явцыг үргэлжлүүлэн ОТАХ-т шинэ боломжуудыг нээсэн.

Стандартын өөрчлөгдсөн заалт, товч утгыг хураангуйлан доорх Хүснэгт 3.1-д харуулбал:

Хүснэгт 3.1 Стандартын өөрчлөлт

Төрөл	Шаардлагын дугаар, гарчиг	Нэмэгдсэн/ өөрчлөгдсөн шаардлагын тоо
Шинэ шаардлага	Жендер (#1.4, #6.3), Гэрээ (#2.4), Таваарын борлуулалт (#4.2), Байгаль орчны нөлөөллийн тайлагнал (#6.1)	5
Шинэ заалт нэмэгдсэн	Компани болон ТӨААН-н тодруулга (#4.9, #2.6), Гэрээ (#2.4)	3
Өөрчлөлт орсон шаардлага – шинэ /сайшаах/	Лиценз олголт (#2.2), ТӨААН (#2.6), Үйлдвэрлэл болон экспорт (#3.2, #3.3), Таваарын борлуулалт (#4.2), Орон нутаг дахь шилжүүлэг (#5.2), Байгаль орчны тайлагнал (#6.4), Жендер (#7.1, #7.4), Зөвлөмж (#7.3)	10
Уян хатан байдлыг нэмэгдүүлсэн	Тохируулга (#4.9), Жилийн явцын тайлагнал (#7.4)	2
Илүү тодорхой болгосон	Гэрээ (#2.4), Бенефициар өмчлөгч (#2.5), ТӨААН (#2.6, #6.2), Мэдээллийг задлах түвшин (#4.7), Олон нийтийн хэлэлцүүлэг, нээлттэй мэдээлэл (#7.1, #7.2)	7

3.2.4. Материаллаг байдал

Бид олборлох салбараас Засгийн газрын хүлээн авсан төлбөр, орлогын урсгалыг харгалзан үзэж, материаллагийн түвшин тодорхойлохын тулд ОУИТБС-ын Ажлын албанаас 2020 оны 11-р сарын 2-нд бидэнд ирүүлсэн Засгийн газрын мэдээллийг ашигласан. Энэхүү мэдээллийг шинжилж үзэхэд дараах байдалтай байна (Хүснэгт 3.2). Үүнд:

Хүснэгт 3.2 Засгийн газрын тайлагнасан орлого болон компанийн тоо, сая төгрөгөөр

№	Ангилал	Компанийн тоо	ЗГ-ын тайлагнасан дүн (сая төгрөгөөр)	Эзлэх хувь	Эзлэх хувь өссөн дүнгээр
1	100 тэрбум дээш	6	2,529,940	73.27%	73.27%
2	1 тэрбум-100 тэрбум	71	810,302	23.47%	96.74%
3	500 сая-1 тэрбум	40	28,711	0.83%	97.57%
4	300 сая-500 сая	70	26,636	0.77%	98.34%
5	300 сая хүртэл	2,235	57,385	1.66%	100.00%
Нийт		2,422	3,452,974	100%	

Бид Засгийн газрын ирүүлсэн компаниудын жагсаалтад өөрсдийн үнэлэмжээр судалгаа хийж, зарим компаниудын вебсайтын мэдээлэл болон утсаар холбогдож зохих мэдээллийг авснаар улсад их хэмжээний татвар, төлбөр, хураамж төлсөн боловч үндсэн үйл ажиллагаа нь уул уурхайн бус 40 компанийг тодорхойлсон (Хүснэгт 3.3).

Хүснэгт 3.3 Уул уурхайн бүс үйл ажиллагаатай компани

№	Компанийн регистр	Компанийн нэр	Дүн сая.төг	№	Компанийн регистр	Компанийн нэр	Дүн сая.төг
1	2082489	Магнай трейд	57,130	21	5467446	Нутгийн буян групп	388
2	5860091	Нппетролиум	7,030	22	2579634	МЕС	364
3	2659603	ОЧИР УНДРАА	4,123	23	2070251	Геосан	354
4	2054701	Гацуурт	2,670	24	2034719	Хөвсгөл зам	346
5	2577127	ГБТ Трейдинг	1,923	25	2685841	Коммод	338
6	2293463	ТЭСО	1,607	26	2068508	Реактив	310
7	2027194	Эрэл	1,053	27	5191823	Ремикон	299
8	5186552	Төмөрт өргөө	1,041	28	2096102	Ди Эйч Эл	298
9	2861224	Эсто	971	29	3615243	Өгөөмөр Гавилууд	296
10	2571889	Молор-Трейд	892	30	2095092	Гангар инвест	294
11	2072947	Шижир алт	837	31	5272378	Зууннайман ойл	272
12	2697807	Уужим-Од	806	32	5000505	Таван толгой транс	268
13	2808676	БУТИ	725	33	2580462	Касстаун	226
14	2057573	Макс Импэкс	712	34	2593009	Бридж Констракшн	226
15	5543495	Кэй Пи Эм Жи Монгол	604	35	2630478	Геомастер	169
16	5385075	Дарданговь	556	36	5961149	Церкон геологи	101
17	5850169	И Эс Эм Пи	487	37	2031256	Очир төв	82
18	2016192	Баян уул	456	38	2660954	Агайын	51
19	2070022	Нарантуул трейд	418	39	5	Дорноговь АЗЗА ТӨХК	3
20	2120879	ХЦ-ийн 0119-р анги	407	40	7	Хэнтий ус	2
Нийт дүн							89,389

Материаллаг байдлыг тооцохдоо ЗГ-ын тайланд тусгагдсан нийт төлбөр, орлогын дүнгийн 98%-иас дээш төлбөр, орлогыг заавал хамруулна гэсэн шалгуураар тооцох үндсэн зарчмыг баримталсан.

Үндсэн үйл ажиллагаа нь уул уурхайн бус компаниудын төлбөр, орлогын дүнг нийт Засгийн газрын тайлагнасан дүнгээс хасаж, дээр дурдсан аргачлалын дагуу букуу 300 сая төгрөгөөс дээш дүнтэй компаниудыг сонгоход нийт төлбөр, орлогын 98.4 хувийг хамрах дүр зураг харагдсан (Хүснэгт 3.4).

Хүснэгт 3.4 Материаллаг байдлын тооцоолол

Утга	Компанийн тоо	Засгийн газрын орлогын дүн (сая төгрөгөөр)
Цахим тайлангийн системд байгаа нийт Компанийн тоо	2,422	3,452,974
Уул уурхайн бус үйл ажиллагаа эрхэлдэг компани	40	89,389
Түүвэрлэх олонлог	2,382	3,363,584
300 сая төгрөгөөс дээш татвар, төлбөр, хураамж төлсөн компаниуд	163	3,310,330
Түүврийн хамралт	7.14%	98.4%

Эхлэлийн семинарын үеэр ОТАХ-ээс материаллаг байдлын босгыг 300.0 сая төгрөг байхаар зөвшөөрсөн.

3.2.5. Тайланд хамруулах санхүүгийн урсгалуудын сонголт

Нийт улсын төвшний 31 орлогын урсгалаас ямар нэгэн төлбөр, орлогын урсгал гараагүй 6 урсгалыг эс тооцвол улсын төвшний 25, орон нутгийн төвшний 14 төрлийн татвар, төлбөр, хураамжийг компаниуд төлж, ЗГ хүлээн авсан ба 2019 оны нэгтгэлийн тайланд бүх төрлийн төлбөр, орлогын урсгалыг хамруулан, зөрүүг тохируулахаар шийдвэрлэсэн.

3.2.6. Тайланд хамруулах төрийн байгууллагуудын сонголт

Орлогын төвлөрөлтэй холбоотой ОУИТБС-ын шаардлагын 4.1-д Татвар болон орлогыг цогцоор нь ил тод болгох; 4.5-д Төрийн өмчит аж ахуйн нэгжтэй холбоотой гүйлгээ, 4.6-д Орон нутгийн төлбөрийг ил тод болгохыг шаарддаг.

Төлбөр, орлогыг хүлээн авсан Засгийн газрын байгууллагуудыг ЗГ-ын тайлан дээр үндэслэн гаргавал дараах Хүснэгт 3.5-д харуулсан байдалтай байна.

ОТАХ-ээс дээр дурьдсан бүх ЗГ-ын байгууллагууд, мөн дараах орон нутгийн төрийн байгууллагуудыг нэгтгэлд хамруулахаар шийдвэрлэсэн. Үүнд:

- Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрууд
- Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрууд
- Орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд

Хүснэгт 3.5 Засгийн газрын байгууллагуудын хүлээн авсан төлбөр, орлого, сая төгрөгөөр

Улсын төвшний төрийн байгууллагууд	Дүн	Эзлэх хувь	Эзлэх хувь /өссөн дүнгээр/
Татварын ерөнхий газар	2,411,378	69.8	69.8
Ашигт малтмал, газрын тосны газар	314,311	9.1	78.9
Гаалийн ерөнхий газар	308,491	8.9	87.9
Нийгмийн даатгалын ерөнхий газар	294,956	8.5	96.4
Орон нутгийн засаг захиргаа	122,966	3.6	100.0
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	872	0.03	100.0
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	-		100.0
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	-		100.0
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	-		100.0
НИЙТ	3,452,974	100	

3.2.7. Тайланд хамруулах компаниудын сонголт

ОУИТБС-ын тайланд хамрагдах компаниудын төлсөн төлбөр, орлогын материаллаг байдлыг харгалзан нэгтгэлд хамруулахаар санал болгосон 163 компанийн жагсаалтыг Эхлэлийн семинар дээр хэлэлцэж, ОТАХ зөвшөөрсөн ба боловсруулах үйлдвэрлэл, цацраг идэвхт бодисын хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг томоохон төлбөр, орлого бүхий компаниудыг хамруулах саналыг ОТАХ-ийн гишүүдээс гаргаж, нэмж 8 компанийг хамруулснаар нийт 171 компанийг сонгосон.

Нэгтгэлд нийт 146 ашиглалтын болон хайгуулын ТЗЭ компани, газрын тосны чиглэлийн 6, ТӨААН 10, цацраг идэвхт ашигт малтмалын ТЗЭ 2, боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй 7 компани хамрагдсан байна. Тухайлбал:

Хүснэгт 3.6 Нэгтгэлд хамрагдсан компаниуд, төлбөр орлогын төвшнөөр, сая төгрөгөөр

Ангилал	Компанийн тоо	ЗГ-ын дүн	Үүнээс	
			Улсын төлбөр, орлого	Орон нутгийн төлбөр, орлого
Ашиглалтын болон хайгуулын ТЗЭ	146	1,216,200	1,152,747	63,453
Олборлох салбарын ТӨААН	10	1,685,895	1,637,985	47,910
Газрын тосны ТЗЭ	6	402,159	395,909	6,250
Цацраг идэвхт ашигт малтмалын ТЗЭ	2	3,261	3,145	116
Боловсруулах үйлдвэр	7	786	749	37
Нийт дүн	171	3,308,301	3,190,535	117,766

Компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

3.3 АРГАЧЛАЛ


3.3.1. Мэдээллийн цуглуулалт

Хараат бус хянагч-нэгтгэгч нь ОУИТБС-ын цахим тайлагналын системийг ашиглан төлбөр орлогын мэдээлэл болон орлогын бус мэдээллийг цуглуулсан ба анхны зөрүүг тодруулсан.

Сонгогдсон компаниудаас анхны зөрүүгийн шалтгааныг тодруулсан нэмэлт мэдээллийг цаасан баримтаар, эдгээр мэдээлэл нь үнэн зөв гэсэн баталгааг Удирдлагын хариуцлагын захидлаар гаргуулан авсан. Төрийн байгууллагуудаас тайланд орох олборлох салбарын талаарх үндсэн мэдээлэл, статистик тоон мэдээллүүд болон эдгээрийн үнэн зөвийг баталсан Удирдлагын хариуцлагын захидлыг цаасан баримтаар авсан.

Цахим тайлангийн систем дэх талуудын оролцооны байдлыг Хүснэгт 3.1-д харуулав.

Зураг 3.1 Цахим тайлангийн систем дэх талуудын оролцоо



3.3.2. Нэгтгэлд ашигласан маягтууд

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар сард хуралдсан 18 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу Ажлын албанаас ОУИТБС-ын компанийн тайлагналын маягтыг шинэчлэх ажлыг хэрэгжүүлсэн байна. Холбогдох техникийн ажлын хэсгийг ҮСХ, АТГ, АМГТГ, Эрдэнэт үйлдвэр, Нүүрс ассоциаци, Хил хязгааргүй алхам, Захиргааны шинэ санаачилга, Трансперенси Интернейшнл Монгол ТББ-ын төлөөллөөр байгуулж, ОУИТБС-ын шинэ стандарт болон Монгол улсын өөрийн онцлог шаардлагад үндэслэн шинэчилж, зарим маягтыг шинээр боловсруулсан байна.

Шинэ маягтыг ҮСХ-ны зөвшөөрснөөр УУХҮЯ-ны сайдын 2020 оны 3 дугаар сарын 5-ны А/37 тоот тушаалаар баталсан.

Шинэ маягтын агуулгад дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд тусгай зөвшөөрлийн өргөдлийн огноо, нөөцийн тухай мэдээлэл, төслийн төвшний тайлагнал, санхүүгийн тайлангийн чанар, ажиллагсдын дэлгэрэнгүй мэдээлэл, эрдсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын дэлгэрэнгүй мэдээлэл, эвдэрсэн газрын мэдээ, нөхөн сэргээлтийн мэдээлэл, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн тээвэрлэлтийн зардал, ус, цахилгаан, шатахуун, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүтээгдэхүүний ашиглалт, хог хаягдал, химийн бодисын хэрэглээ, баяжуулагч, оператор, туслан гүйцэтгэгч, нөлөөллийн бүс, эцсийн өмчлөгч, төрийн орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн ногдол ашиг, орон нутгийн удирдлагатай байгуулсан гэрээ, хэрэгжилтийн байдал, Төлөөлөн удирдах зөвлөл, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, бартер, зээл, зээлийн баталгаа, бүтээгдэхүүн хуваах гэрээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хамрагдаж байна.

3.3.3. Задаргааны түвшин

ОУИТБС-ын стандарт 4.7-д “Олон талт оролцогчдын бүлэг нь мэдээллийг олон нийтэд зориулан хэвлэн нийтлэхэд ямар түвшинд хүртэл задлах боломжтой байх асуудлыг зөвшилцөх шаардлагатай. ОУИТБС-ын тайлангийн мэдээлэл нь компаниуд, төрийн байгууллагууд болон орлогын урсгал нэг бүрээр нь дэлгэн харуулах боломжтой байх ёстой” гэж заасан байна.

Эхлэлийн семинар үеэр Монгол улсын 2019 оны тайлангийн хувьд нэгтгэлийн үр дүнг компаниуд, төрийн байгууллагууд болон орлогын урсгал нэг бүрээр нь тайлагнана гэж тохиролцсон. Түүнээс гадна төслөөр тайлагнах шаардлагын дагуу цахим тайлангийн системд шинэ маягтаар мэдээлэл цуглуулсан ба үр дүнг Бүлэг 6.10-аас харна уу.

3.4 БАТАЛГААЖУУЛАЛТ

3.4.1. Монгол улсын аудит, баталгаажуулалтын орчин нөхцөл

Монгол улсын төрийн аудитын ажиллагааг хэрэгжүүлэх дээд байгууллага нь Үндэсний Аудитын Газар (ҮАГ) юм. ҮАГ нь олон улсын аудитын ИНТОСАЙ байгууллагын гишүүн бөгөөд тус байгууллагын стандартын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

ҮАГ нь яамд, агентлагууд болон төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайлан болон ЗГ-ын нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж, УИХ-аар батлуулдаг. Орон нутгийн төрийн байгууллагууд (аймаг, сумд) санхүүгийн тайлангаа жил тутам гаргаж, ҮАГ-н харьяа орон нутгийн аудитын байгууллагаар хянуулж байх ёстой.

Мөн төрийн өмчит компаниудын жил тутмын санхүүгийн тайланд аудит хийх ажиллагааг ҮАГ хариуцдаг боловч тэдгээр аудитыг гүйцэтгүүлэхийн тулд зохих хэмжээний чадварлаг хувийн аудитын байгууллагуудыг сонгон шалгаруулах журмаар томилж ажиллуулахыг зөвшөөрдөг бөгөөд практикт голдуу ингэж ажиллаж байна. Тэдгээр аудитын байгууллагууд АОУС-ын дагуу аудитын ажлыг гүйцэтгэж байна.

Хөндлөнгийн аудит хийлгэж байх шаардлагатай компаниуд нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаа Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газарт жил тутам 6 дугаар сард багтаан хүргүүлэх үүргийг хүлээнэ. Гэхдээ Татварын ерөнхий хуульд заасан нууцлалтай холбоотой заалтаас хамаараад Сангийн яамны зүгээс тухайн компанийн зөвшөөрөлгүйгээр санхүүгийн тайланг шууд ил тод болгох боломжгүй юм.

Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газар нь уул уурхайн компаниудын зүгээс аудитын хамааралтай шаардлагуудыг даган мөрдүүлэх чиглэлд тодорхой үүрэг гүйцэтгэж болно.

Хувийн өмчит компаниуд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1-д заасны дагуу СТОУС-ын дагуу санхүүгийн тайлангаа гаргах ёстой бөгөөд нийт борлуулалтын орлогын хэмжээ, эсвэл цэвэр хөрөнгө нь тодорхой төвшнөөс давсан бол бүх компаниуд санхүүгийн тайландаа хөндлөнгийн аудит хийлгэхийг шаардсан байдаг.

3.4.2. ОУИТБС-ын тайлангийн баталгаажуулах явц

ЗГ-ын байгууллагууд, ТӨААН-үүд болон олборлох компаниуд өөрсдийн мэдээллийг Цахим тайлангийн системд оруулах шаардлагатай бөгөөд шаардлага гарах бүрт нэмэлт мэдээллийг Хараат бус хянагч-нэгтгэгчид өгч байх ёстой.

Тайлагнаж буй тоо мэдээний бүрэн гүйцэд, найдвартай байдлыг тайлагнагч байгууллага хариуцна.

Тайлан гаргаж байгаа байгууллагууд өөрсдийн өгсөн мэдээллийг найдвартай гэдгийг Хараат бус хянагч-нэгтгэгчид батлах үүрэгтэй.

2019 оны тайлангийн хамрах хүрээг хэлэлцэх хурлын үеэр “тайлан гаргаж байгаа төрийн байгууллага, агентлаг бүрийн удирдлагын төлөөлөл нь тухайн тайлан, мэдээлэлд бичгээр баталгаа гаргаж байх”-аар ОТАХ тохиролцсон юм.

ҮАГ-аас баталсан Санхүүгийн тайланд аудит хийх журамд “Олборлох үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн төсөвт төвлөрүүлсэн төлбөрийг ОУИТБС-ын Ажлын алба болон орлого хүлээн авсан Засгийн газрын байгууллагуудтай тулган баталгаажуулж, дүгнэлт гаргах” гэж орсон байдаг боловч 2019 онд ийм ажил хийгдээгүй, ҮАГ нь энэхүү баталгаажуулах ажлыг гүйцэтгэх боломжгүй байгаа нь харагдаж байна.

Тайлан гаргаж байгаа компаниудын Гүйцэтгэх удирдлага нь өөрсдийн тайлан, мэдээлэлд ТУЗ-ийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий баталгааг бичгээр гаргаж өгөхийг, мөн компани бүр аудит хийлгэсэн санхүүгийн тайлангийн мэдээллийг цахим тайлангийн системээр мэдээлж байхыг ОТАХ-тэй тохиролцсон юм.

Өмнөх жилүүдийн нэгтгэл тайланд хувийн болон ТӨААН-үүд нь *“ОУИТБС-ын тайланд өгсөн мэдээлэл нь АОУС-ын дагуу аудит хийлгэсэн санхүүгийн тайлангуудтай тохирч байгаа бөгөөд үнэн, зөв”* гэсэн баталгааг хөндлөнгийн аудитораасаа мэдэгдэл байдлаар гаргуулж ирүүлэхийг Хараат бус хянагч-нэгтгэгч шаардаж, үр дүнг тайлагнадаг байсан бол 2019 оны тайланд ийм баталгаажуулалтыг хийх цаг хугацааны боломж байсангүй.

4

ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН



4 ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

Төлбөр, орлогын анхны нэгтгэлээр нийт 41,762 сая төгрөгийн цэвэр зөрүү үүссэн ба Хараат бус хянагч-нэгтгэгч ЗГ-ын тайланд 371,051 сая төгрөгийн нэмэгдэх тохируулга, компанийн дүнд 293,050 сая төгрөгийн нэмэгдэх тохируулгыг цэвэр дүнгээр тус тус хийсэн.

Нэгтгэлийн явцад 2 компани мэдээллээ ирүүлээгүйгээс 36,263 сая төгрөгийн (дэлгэрэнгүйг Хүснэгт 2.4-өөс харна уу) зөрүүг шийдэж чадаагүй.

Энэ зөрүүг нэгтгэлээс хассанаар нийт 24 сая төгрөг буюу ЗГ-ын тайлагнасан нийт орлогын 0.001 хувьтай тэнцэх зөрүү тайлбарлагдаагүй үлдэж байна.

4.1 АНХЛАН ТАЙЛАГНАСАН УРСГАЛУУДЫН ХУРААНГУЙ

Анхлан тайлагнасан төлбөр, орлого болон нэгтгэлийн тохируулгыг нэгтгэн харуулбал дараах байдалтай байна (Хүснэгт 4.1). Үүнд:

Хүснэгт 4.1 Анхны тайлагнасан төлбөр, орлогын урсгал ба тохируулга, сая төгрөгөөр

Тайлан гаргагч	Компанийн тоо	Сонгогдсон гол орлогын урсгалууд (сая төгрөгөөр)		
		Улсын хэмжээнд	Орон нутгийн хэмжээнд	Нийт
Анхны тайлан				
ЗГ-ын байгууллага	171	3,190,535	92,189	3,282,724
Хувийн компаниуд	161	1,325,627	94,380	1,420,007
ТӨААН-үүд	10	1,810,908	93,571	1,904,479
Анхны нэгтгэлийн зөрүү	16	54,000	(95,762)	(41,762)
Нэгтгэл				
ЗГ-ын тохируулга		298,032	73,019	371,051
Компанийн тохируулга		310,336	(17,286)	293,050
ЗГ-ын дүн тохируулгын дараа		3,488,567	165,208	3,653,775
Компанийн дүн тохируулгын дараа		3,446,871	170,665	3,617,536
Тайлбарлагдаагүй зөрүү		41,696	(5,457)	36,239
Хасах нь: Хариу ирүүлээгүй байгаа компаниудын дүн		35,933	330	36,263
Эцсийн тайлбарлагдаагүй цэвэр зөрүү		5,763	(5,787)	(24)

Тохируулаагүй үлдсэн зөрүүг компани тус бүрээр Хавсралт 9-өөс харна уу.

4.2 АНХНЫ ТОХИРУУЛААГҮЙ ЗӨРҮҮ БОЛОН ТАЙЛАГНААГҮЙ КОМПАНИУД

Анхны нэгтгэлийн зөрүү нь Хүснэгт 4.2-т үзүүлсэн үндсэн шалтгаануудаас үүдэж байна.

Цахим тайлангийн системд тайланг оруулсан алдааг залруулах зорилгоор хийгдсэн тохируулгын байдлаас харахад

- мөнгөн дүнг мянгачилж тайлагнасан,
- анхны тайлангаа огт тайлагнаагүй, тайлагнасан боловч зарим орлогын урсгалыг тайлагнаагүй зөрчлөөс шалтгаалан анхны зөрүү үүссэн байна.

Нийт 664,101 сая төгрөгийн нэмсэн тохируулга хийсэн бөгөөд томоохон тохируулгуудыг тодруулбал дараах байдалтай байна.

Компанийн анхны тайланд хийгдсэн томоохон тохируулгуудаас танилцуулбал:

- “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь анхны тайлангаа мянгачилж тайлагнасан 282,702 сая

- төгрөг,
- “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ нь ГЕГ-т төлсөн НӨАТ-ыг давхардуулж тайлагнасан 21,237 сая төгрөг, сайн дурын мэдээлэл тайлагнасан 21,462 төгрөг
 - “Хишиг Арвин Индуриал” ХХК нь улсын төсөвт 16,598 сая төгрөгийн албан татвар, төлбөр, хураамж төлсөн боловч анхны тайлангаар 0.4 сая төгрөг тайлагнасан.

Хүснэгт 4.2 Тохируулаагүй зөрүү, сая төгрөгөөр

Орлогын урсгал (сая.төгрөг)	Компанийн анхны тайланд хийсэн тохируулга	Засгийн газрын анхны тайланд хийсэн тохируулга	Нийт тохируулсан дүн
Анхны тайлангаа бүхэлд нь болон зарим урсгалыг огт тайлагнаагүй	87,211	269,481	356,692
Мөнгөн дүнг мянгачилж тайлагнасан	282,703	5	282,708
Анхны тайланд дутуу тайлагнасан	27,755	97,824	125,579
Анхны тайланд илүү тайлагнасан	(41,737)	(12,123)	(53,860)
Сайн дурын мэдээллийг тайлагнасан	(27,318)	(457)	(27,775)
Давхардуулж тайлагнасан	(26,899)	(24)	(26,923)
Банк суутгасан АМНАТ-ыг дутуу тайлагнасан	-	16,845	16,845
Орлогын урсгалын ангилал андуурч тайлагнасан	(5,161)	(471)	(5,632)
Холбоотой талын хоорондын гүйлгээтэй холилдуулж тайлагнасан	(3,081)	(29)	(3,110)
Өссөн дүнгээр тайлагнасан	(423)	-	(423)
Нийт	293,050	371,051	664,101

Засгийн газрын хүлээн авсан орлогыг огт тайлагнаагүй төрийн байгууллагуудыг танилцуулбал:

- Өмнөговь аймагт төлсөн “Таван Толгой” ХК-ийн Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг 23,000 сая төгрөг,
- Төрийн санд төлсөн “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын Төрийн өмчийн ногдол ашиг 150,000 сая төгрөг,
- Төрийн санд төлсөн “Монголросцветмет” ТӨҮГ-ын Төрийн өмчийн ногдол ашиг 2,940 сая төгрөг,
- Татварын ерөнхий газарт төлсөн “Бороо Гоулд” ХХК-ийн Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт 3,527 сая төгрөг.

Анхны тайланд Засгийн газрын дутуу тайлагнасан орлогыг танилцуулбал:

- Гаалийн ерөнхий газар нь “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-иар дамжуулан төлсөн “Оюу Толгой” ХХК-ийн НӨАТ, гаалийн албан татвар 47,097 сая төгрөгийн орхигдуулсан,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь анхны тайлангаа тушаагаагүй шалтгаанаас 21,512 сая төгрөгийн гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийг орхигдуулсан,
- Өмнөговь аймгийн “Говийн оюу хөгжлийг дэмжих” санд өгсөн “Оюу Толгой” ХХК-ийн 13,163 сая төгрөгийн хандивыг орхигдуулсан,
- Гаалийн ерөнхий газарт төлсөн “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2,779 сая төгрөгийн гаалийн албан татвар, 5,812 сая төгрөгийн НӨАТ-ыг орхигдуулсан,
- Татварын ерөнхий газар нь алтны компаниудаас суутган авч, шилжүүлсэн Монголбанкны 16,845 сая төгрөгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тус тус орхигдуулсан.

Энэ нь Засгийн газрын зарим байгууллагууд болон компаниуд нь цахим тайлангийн системд анх тайлагнахдаа хайхрамжгүй хандаж байгааг илтгэж байна. Иймээс ЗГ нь хүлээн авсан орлогоо, уул уурхайн компаниуд нь төлсөн төлбөрийн мэдээгээ МОУИТБС-ын цахим тайлангийн системд

маш хариуцлагатай тайлагнаж байх шаардлагатай байна.

2019 оны ОУИТБС-ын Нэгтгэл тайланд хамрагдсан 171 компаниас зөвхөн “Онтрэ” ХХК нь анхны тайлангаа зөрүүгүй тайлагнасан байна (Хүснэгт 4.3). Тодруулбал:

Хүснэгт 4.3 Цахим тайлангийн системд зөрүүгүй тайлагнасан компани, сая төгрөгөөр

#	Компанийн регистр	Компанийн нэр	Засгийн газар тайлагнасан	Компани тайлагнасан	Анхны зөрүү
1	2705133	Онтрэ	2,536	2,536	-
Нийт			2,543	2,543	-

Цахим тайлагналын системд тайлагнаагүй 16 компани нь 20,877 сая төгрөгийн анхны зөрүү үүсгэж байна (Хүснэгт 4.4). Зөрүү үүсгэж байгаа компаниудыг харуулбал:

Хүснэгт 4.4 Цахим тайлангийн системд тайлан явуулаагүй компаниуд, сая төгрөгөөр

#	Компанийн нэр	Төлбөр
1	Улаанбаатар төмөр зам /Чулуун завод/ ХНН	11,164
2	Космо Коал ХХК	1,533
3	Орос Гэрэл ХХК	1,476
4	Адуунчулуун ХХК	1,042
5	Бадмаараг хаш ХХК	1,018
6	Монвольфрам ХХК	869
7	Фриендшип ресурсис ХХК	751
8	Мэжик бридж ХХК	715
9	Старто ХХК	550
10	Түвшин ХХК	466
11	Жинхуа орд ХХК	414
12	Аурум Ауруг ХХК	312
13	Коммонмакс ХХК	304
14	Эрдэнэс Тавантолгой майнинг ХХК	247
15	Хунбөө ХХК	13
16	Арева Монгол ХХК	3
Нийт		20,877

4.3 ТОХИРУУЛААГҮЙ ҮЛДСЭН ЗӨРҮҮ

Доорх Хүснэгт 4.5 нь тохируулгын дараах тайлбарлагдаагүй зөрүүгийн шинжилгээг харуулна.

Хүснэгт 4.5 Тайлбарлагдаагүй зөрүү, сая төгрөгөөр

Төлбөр, орлого (санхүүгийн урсгалаар)	Засгийн газар илүү тайлагнасан	Засгийн газар дутуу тайлагнасан
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	38,510	-
Гаалийн албан татвар	-	(922)
Нэмэгдсэн өртгийн албан татвар (ТЕГ-т төлсөн)	140	-
Нэмэгдсэн өртгийн албан татвар (Гааль)	1,305	-
Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	2	-
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	5,304	-
Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	-	(100)
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	-	(330)

Төлбөр, орлого (санхүүгийн урсгалаар)	Засгийн газар илүү тайлагнасан	Засгийн газар дутуу тайлагнасан
Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	-	(2)
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	133	-
Агаарын бохирдлын төлбөр	-	(15)
Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	-	(768)
Гаалийн үйлчилгээний хураамж	12	-
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал	-	(1)
Торгууль	-	(974)
Нөхөн төлбөр	-	(30)
БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ	-	(657)
Бусад	89	-
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	-	(222)
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	300	-
Газрын төлбөр	-	(630)
Ус ашигласны төлбөр	-	(943)
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	(1,356)
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	-	(68)
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	-	(20)
Торгууль	-	(1,498)
Нөхөн төлбөр	-	(6)
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	-	(40)
Бусад	1,152	-
Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	-	(2,126)
Цэвэр тохируулаагүй зөрүү	46,947	(10,708)

4.4 ТАЙЛАГНААГҮЙ КОМПАНИУД

Цахим тайлагналын системд тайлагнасан Засгийн газрын орлогын мэдээнээс нэгтгэлд хамрагдах 171 компанийг сонгосон бөгөөд үүнээс 2 компани нь тохируулгын явцад нэмэлт хүсэлтээр тайлангаа ирүүлээгүйгээс шалтгаалан үүсч буй цэвэр зөрүү 36,263 сая төгрөг юм. Дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 2.5.1-ээс үзнэ үү.

4.5 НЭГТГЭЛИЙН ҮР ДҮН

Улсын хэмжээний нэгтгэлийн үр дүнг харуулав.

Хүснэгт 4.6 Улсын хэмжээний нэгтгэл, орлогын үрсгалаар, сая төгрөгөөр Орлогын үрсгал

	Анхны тайлагнасан			Залруулга		Тохируулгын дараа		
	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	858,944	859,731	(787)	38,128	(1,169)	897,072	858,562	38,510
Гаалийн албан татвар	54,080	67,672	(13,592)	2,949	(9,721)	57,029	57,951	(922)
Нэмэгдсэн өртгийн албан татвар (ТЕГ-т төлсөн)	129,906	120,449	9,457	108	9,426	130,014	129,875	139
Нэмэгдсэн өртгийн албан татвар (Гааль)	116,828	91,762	25,066	5,724	29,485	122,552	121,247	1,305
Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	19	-	19	-	17	19	17	2
Автобензин, дизелийн түлшний албан татвар	230	-	230	-	230	230	230	-
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	1,350,361	1,380,503	(30,142)	28,705	(6,741)	1,379,066	1,373,762	5,304
Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	15,902	17,946	(2,044)	130	(1,814)	16,032	16,132	(100)
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	4,246	2,531	1,715	-	2,045	4,246	4,576	(330)
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт эхэлсний урамшуулал	-	430	(430)	-	(430)	-	-	-
Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	1,721	2,966	(1,245)	138	(1,105)	1,859	1,861	(2)
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	-	10,442	(10,442)	21,533	10,958	21,533	21,400	133
Агаарын бохирдлын төлбөр	47,332	47,290	42	-	57	47,332	47,347	(15)
Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	273,174	237,593	35,581	(4,012)	32,337	269,162	269,930	(768)
Гаалийн үйлчилгээний хураамж	65,328	54,225	11,103	356	11,447	65,684	65,672	12
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал	1,864	1,462	402	-	403	1,864	1,865	(1)
Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	728	393	335	-	335	728	728	-
Төрийн өмчийн ногдол ашиг	-	152,940	(152,940)	152,940	-	152,940	152,940	-
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого	232,267	21,868	210,399	-	210,399	232,267	232,267	-
Роялти	35,944	5,764	30,180	-	30,180	35,944	35,944	-

	Анхны тайлагнасан			Залруулга		Тохируулгын дараа		
	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
Торгууль	569	6,672	(6,103)	2,666	(2,463)	3,235	4,209	(974)
Нөхөн төлбөр	525	2,592	(2,067)	132	(1,905)	657	687	(30)
БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ	-	4,106	(4,106)	1,467	(1,982)	1,467	2,124	(657)
Бусад	567	47,198	(46,631)	47,068	347	47,635	47,545	90
Улсны хэмжээний нэгтгэлийн дүн	3,190,535	3,136,535	54,000	298,032	310,336	3,488,567	3,446,871	41,696

Орон нутгийн хэмжээний урсгалын нэгтгэлийн үр дүн (орлогын урсгалаар)

Хүснэгт 4.7 Орон нутгийн хэмжээний урсгалын нэгтгэл, орлогын урсгалаар, сая төгрөгөөр

Орлогын урсгал	Анхны тайлагнасан			Залруулга		Тохируулгын дараа		
	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	29,926	31,045	(1,119)	874	(23)	30,800	31,022	(222)
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,425	1,171	254	190	144	1,615	1,315	300
Газрын төлбөр	6,279	28,069	(21,790)	21,037	(124)	27,316	27,945	(629)
Ус ашигласны төлбөр	37,149	37,045	104	3,110	4,156	40,259	41,201	(942)
Ус бохирдуулсны төлбөр	493	103	390	(469)	(79)	24	24	-
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	1,424	7,307	(5,883)	(258)	(4,786)	1,166	2,521	(1,355)
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	-	2,829	(2,829)	336	(2,424)	336	405	(69)
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	431	582	(151)	-	(130)	431	452	(21)
Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	-	23,020	(23,020)	23,020	-	23,020	23,020	-
Торгууль	757	2,907	(2,150)	124	(528)	881	2,379	(1,498)
Нөхөн төлбөр	2	1,565	(1,563)	124	(1,432)	126	133	(7)
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	104	568	(464)	97	(327)	201	241	(40)
Бусад	7,364	23,755	(16,391)	(1,452)	(18,995)	5,912	4,760	1,152
Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	6,835	27,985	(21,150)	26,286	7,262	33,121	35,247	(2,126)
Орон нутгийн хэмжээний нэгтгэлийн дүн	92,189	187,951	(95,762)	73,019	(17,286)	165,208	170,665	(5,457)
Нийт дүн	3,282,724	3,324,486	(41,762)	371,051	293,050	3,653,775	3,617,536	36,239

5

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ
САЛБАР



5 МОНГОЛЫН ОЛБОРЛОХ САЛБАР

5.1 ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ БОЛОН ТӨСВИЙН БОДЛОГО (ШААРДЛАГА 2.1)

5.1.1. Олборлох салбарын эрх зүйн зохицуулалт

Энэхүү хэсэгт Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарыг зохицуулж буй хууль, тогтоомжийн талаарх мэдээллийг оруулсан.

5.1.1.1 Уул уурхай, газрын тос, цөмийн энергийн салбарын эрх зүйн тогтолцооны өнөөгийн байдал

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбар нь Ашигт малтмалын тухай, Газрын хэвлийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль зэрэг 30 гаруй хууль, 40 гаруй журмын хүрээнд зохицуулагдаж байна. Гэвч тэдгээрийн уялдаа, хэрэгжүүлэх механизм хангалттай бус гэж үзсээр байна.

Дэлхий нийтийн уул уурхайн чиг хандлага нь тогтвортой, харилцан ашигтай, ногоон хөгжлийн чиг хандлагад тулгуурлаж, тасралтгүй хөгжиж буй энэ цаг үед төрийн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын тогтвортой орчин, орон нутгийн иргэдтэй харилцах зэрэг асуудлуудыг илүү нарийвчилж зохицуулах шаардлагатай байна.

Уул уурхайн салбар дахь авилгын судалгаа (2016)-нд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос ашиглалт хүртэлх үе шатанд буй авилгын эрсдэлүүдийн үндсэн шалтгааныг уул уурхайн салбарын хууль, эрх зүйн баримт бичгүүд нь нэгд, хэт ерөнхий зохицуулалттай буюу тухайлсан зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй, хоёрт, аливаа зохицуулалтад тавигдах шаардлагууд тодорхойгүй, гуравт, дагалдах дүрэм, журмууд нь төдийлөн мэргэжлийн арга зүйд тулгуурлаагүй гэж тодорхойлсон байна.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгээс гаргадаг Баялгийн засаглалын индекс 2017 оны тайлангаас харахад Монгол Улс нь байгалийн баялгийн засаглалын индексээр “Засаглал хангалттай” гэсэн ангилалд багтаж байгаа боловч “Орлогын менежмент” үзүүлэлтээр Монгол Улс 100 оноо авахаас 54 оноо, “Төрийн өмчийн компанийн засаглал”-ын үзүүлэлтээр 40 оноо, “Монгол Улсын үндэсний баялгийн сан буюу Төсвийн тогтворжуулалтын сан”-гийн хувьд 42 оноог тус тус авсан байна. Өөрөөр хэлбэл, эдгээр гол үзүүлэлтүүдээр баялгийн засаглал султай, дундаас доогуур үнэлгээтэй байна.

Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль нь уурхайн амьдралын мөчлөгтэй холбоотой харилцааг иж бүрнээр нь зохицуулаагүй, эдгээрийн зарим зохицуулалт нь орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай төдийлөн уялдахгүй байна. Ашигт малтмалын тухай хууль нь “тусгай зөвшөөрөл”-тэй холбоотой харилцааг голчлон зохицуулж байгаа ба уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, олборлолт, баяжуулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нөхөн сэргээлт, хаалттай холбоотой харилцааг иж бүрнээр нь зохицуулахгүй байгаа тул холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, шинэтгэл хийх шаардлагатай байна.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль, түүний үзэл баримтлал

Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловруулж батлуулах” тухай тусгагдсан. Уг хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандалт судалгаа, үзэл баримтлал, хуулийн төслийг 2020 онд боловсруулж дуусгаад байна.

Эрдэс баялгийн салбар бол Монгол Улсын ДНБ-ний 20-30 орчим хувийг дангаараа хангаж, эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж болж ирсэн, эдийн засгийн бусад салбарт томоохон нөлөө үзүүлж байдаг. Энэхүү салбарын үйл ажиллагаанд түшиглэн, улсын эдийн засгийг бэхжүүлэх, нөгөө талаас уг салбарыг нээлттэй, ил тод, хариуцлагатай байлгаж, улсын төсөвт татварыг зохистой түвшинд төвлөрүүлэх, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор хяналт, дүн шинжилгээ болон хариуцлагатай тайлагнал зэргийг иж бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага тулгамдаад байна.

Олборлох салбар нь тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ОУВС, ЭЗХАХБ, Дэлхийн банк, Мөнгө угаах, санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага зэрэг олон улсын байгууллагууд ашигт малтмалын нөөц баялаг ихтэй улс орны уул уурхай, олборлох салбарыг эрсдэлтэйд тооцож, авилга, хээл хахууль, мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэргийн эрсдэлийг өндөр гэж үздэг. Уг салбар дахь шударга бус өрсөлдөөн, давамгайл байдлыг бууруулах нь нийгмийн давхаргын ялгааг арилгахад бодит хувь нэмэр болно гэж үздэг. Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын худалдан авалтаар дамжуулж авилга хээл хахуулийг бодит бус үнэ өртгөөр худалдан авалт хийж дамжуулах, улсад их хэмжээний хохирол учруулсан жишээ өнгөрсөн хугацаанд гарсанаар Монгол Улс олборлох салбарын цогц мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр дорвитой арга хэмжээ авах шаардлага бий болсныг харуулж байна.

Дэлхийн улс орнуудын эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангахад чиглэгдсэн зохицуулалт нь ихэвчлэн кодексыг буюу суурь хуулийн шинжтэй, үүнийгээ дагасан ашигт малтмал, гүн боловсруулалт, газрын тос, хий болон газар, ус зэрэг байгалийн баялгийн цогц мэдээллийг агуулдаг. Түүнчлэн энэ салбарт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн зөвшөөрөл, өмчлөгч, эцсийн эзэмшигч, гэрээ, орлого, татвар төлөлт, орон нутгийн харилцаа, нийгэм эдийн засагт үзүүлэх үр өгөөж, нөлөөллийн талаар маш нарийн чиг үүргийн зохицуулалттай, харилцан уялдааг хангасан, аливаа төлөвлөлтийн шийдвэрт сонирхол нь хөндөгдөж буй бүх талын оролцогчид чөлөөтэй оролцох нөхцөлийг бүрдүүлсэн байдаг.

Монгол Улс тус салбар дахь ил тод байдлыг нэмэгдүүлэх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлж ирсэн бөгөөд олборлох салбарын засаглалыг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төр болон хувийн хэвшлийг хариуцлагажуулах зорилго бүхий, дэлхийн 52 улс орон нэгдэн орсон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилга /ОУИТБС/-д 2007 онд, Нээлттэй засаглалын түншлэлд 2013 онд тус тус нэгдэж, олборлох салбарт гэрээ ба ашиг хүртэгч эцсийн өмчлөгчдийн мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлыг тусган хэрэгжүүлэхээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг амлалтыг авсан. Монгол Улсын Засгийн газраас 2006 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгыг дэмжих тухай 1 дүгээр тогтоолыг гаргаж, Санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг төрийн болон төрийн бус байгууллага, Компанийн төлөөлөлтэйгээр байгуулан ажиллах болсноор манай улс албан ёсоор “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай” олон улсын санаачилгыг хэрэгжүүлж эхэлсэн. ОУИТБС-д байнга шинэ дэвшилтэт өөрчлөлтүүд гарч байгаа боловч ОУИТБС-ын хүрээнд авсан үүрэг амлалтаа Монгол Улс бүрэн хэрэгжүүлэхэд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, журам, маягт батлах зэргээр хэрэгжилтэд баримталж ирсэн өнөөгийн эрх зүйн орчин хангалтгүй байна.

Тиймээс бие даасан хууль боловсруулан, салбарын цогц мэдээллийг бүрдүүлсэн мэдээллийн бааз суурь бий болгох, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна. Түүнчлэн тусгай зөвшөөрлийн тоо өсөн нэмэгдэж, олборлох үйлдвэрлэл өргөжин тэлэхийн хэрээр хариуцлагын асуудлыг иргэд, олон нийтийн зүгээс улам хурцаар тавьж байна. Төр, аж ахуйн нэгж болон орон нутгийн иргэд хоорондын харилцан ойлголцлыг бий болгосноор олборлох салбарт хөрөнгө оруулах эрсдэлийг бууруулж, эдийн засагт жинтэй хувь нэмэр оруулах тус салбарын хөгжил зогсонги байдалд хүрэхээс сэргийлэх боломж бүрдэхээр байна.

Мөн олборлох салбарын эдийн засгийн үр өгөөжийг иргэдэд хүртээхэд үүсдэг гол асуудлын нэг болох татвараар нэгэнт цуглуулсан орлогын хуваарилалтыг үндэсний баялгийн сангаар

дамжуулан зөв зохистой удирдах төрийн бодлогын гол түшээ, иргэдийн мэдлэгийг дэмжих, иргэдээс дэмжлэг авах улмаар олборлолтын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх шийдвэртэй гарц нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах явдал юм.

Түүнчлэн, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шууд бусаар шилжүүлэхэд татвар төлөхөөс зайлсхийх эрсдэлийг арилгах зорилгоор 2019 онд Татварын ерөнхий хуулийг шинэчлэн найруулж, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн “эцсийн эзэмшигч”-ийн мэдээллийг төрийн холбогдох байгууллагууд бүртгэх болсон.

2016 онд батлагдсан Захиргааны хуулийн 5 дугаар бүлгээр захиргааны гэрээ, түүнтэй холбоотой харилцааны эрх зүйн үндсийг тогтоосон. Иймд Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу байгуулагдах тодорхой төрлийн гэрээнүүдийг ил тод болгох үйл явцыг дээрх хуульд нийцүүлэх шаардлага үүсч байна.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2019 оны 3 сард Засгийн газраас УИХ-д өргөн барьсан. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2019 оны 21 дүгээр тогтоолоор хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг ажиллан, УИХ-аар 2020 онд хэлэлцүүлэх хууль тогтоомжийн жагсаалтад “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл” оруулсан байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл

УУХҮЯ-наас 2021 онд “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл” өргөн барихаар төлөвлөж байна.

Бичил уурхайн эрх зүйн орчин

Швейцарь улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Тогтвортой бичил уурхай төслийг 2005-2019 онд хэрэгжүүлсэн. Уг төсөл хэрэгжснээр бичил уурхайн эрх зүйн орчин бүрдэж хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг нөхөрлөл, хоршооны хэлбэрээр зохион байгуулалтад оруулж албажуулах, мөн Дархан-Уул, Баянхонгор аймагт алтны сорьц тогтоох нэгжийг байгуулсан байна. Швейцарь Хөгжлийн Агентлагтай хамтран “Хариуцлагатай бичил уурхай” форумыг уг төслийн хаалтын хүрээнд 2019 оны 11 сард зохион байгуулав. Форумын хүрээнд тус төслийн үр дүнг танилцуулан бичил уурхайн талаар баримталж буй бодлого, түүний үр нөлөөний талаар хэлэлцүүлэг өрнүүлэн шийлвэрлэж болох асуудлын талаар хэлэлцсэн байна.

Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн санаачилгаар УУХҮЯ-тай хамтран Монгол улсын олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийг “Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс”-т нэгтгэх “Хариуцлагаар нэгд” аяныг өрнүүллэн. Энэхүү аянд Аспайр Майнинг ХХК, Багануур ХК, Оюутолгой ХХК, Саусгоби Сэндс ХХК, Терра энерги ХХК, Энержи Ресурс ХХЗ болон Эрдэнэт үйлдвэр зэрэг компаниуд нэгдсэн байна. Санамж бичгийн хүрээнд талууд Монголын уул уурхайн салбарт хариуцлагатай уул уурхай, сайн жишгийг хөхиүлэн дэмжих, нэвтрүүлэх, дагаж мөрдөх замаар салбарын тогтвортой хөгжлийн төлөө хамтран ажиллах юм.

5.1.1.2 Салбарын гол хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт

Тус салбарын гол хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтүүдийг оноор харуулав. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль, 2006 (2017 онд 2 удаа, 2018, 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан)
 - **2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт:** тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй хоршоо, нөхөрлөл, тэдгээрээс ашигт малтмал худалдан авч экспортолсон, худалдсан этгээд болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, тайлагнах, бүртгэлжүүлэх боломжийг бүрдүүлснээрээ ач холбогдолтой юм. Түүнчлэн Монголбанкинд тушааж буй алтны хэмжээг

бууруулахгүй, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, улмаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэх, татварын суурийг өргөжүүлэх боломж бүрдэж байна.

- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2013, (2020 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Газрын хэвлийн тухай хууль, 1988
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014
- Цөмийн энергийн тухай хууль, 2009
- Газрын тосны тухай хууль, 2014 (2017 онд нэмэлт оруулсан)
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, 2005
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009
- Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009, 2015

5.1.1.3 Олборлох салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийсэн гол зохицуулалт (2019 ба 2020 оны эхний хагас жилээр)

Хүснэгт 5.1 Олборлох салбарын эрх зүйн зохицуулалт

Дугаар	Огноо	Гол агуулга, тайлбар
89	2019	Засгийн газрын тогтоол, 2014-2020 оны хооронд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын талбайг улсын нөөцөд авч гүйцэтгэж байна. Ийнхүү улс өөрөө төсвөөс хөрөнгө гарган геологийн суурь судалгаа хийх газрыг нөөцөд авч баталгаажуулсан байна.
176	2019	Засгийн газрын тогтоол, Газрын ховор элементийн судалгаа хийх төслийн нэгж байгуулж, Газрын ховор элементийн хайгуул, олборлолт, ашиглалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нөөц нь бүртгэгдсэн ордын эдийн засгийн үр ашгийн тооцоог гүйцэтгэх, тэдгээрийн өндөр хөгжилтний орнуудтай хамтран ашиглаж эдийн засгийн эргэлтэнд оруулахаар ажиллаж байна.
313	2019	Засгийн газрын тогтоол, “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”
355	2019	Засгийн газрын тогтоол, Бичил уурхайн үйл ажиллагааг цэгцлэх, хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны журам”.
178	2019	Засгийн газрын тогтоол, Газрын тосны бүртгэл, тооцооны журам
214	2019	Засгийн газрын тогтоол, “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр” (2019-2023) – Монгол улсын эдийн засгийн суурь бүтцийг бүрдүүлэх, хүнд үйлдвэрлэлийн салбарт тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, тус салбарт хөрөнгө оруулалт татах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилготой.
284	2019	Засгийн газрын тогтоол, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн байршлыг тодорхойлж, 466 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Үйлдвэрийн нийт хувьцааны 10-с доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших шийдвэрлэсэн.
A/193		УУХҮЯ-ны сайдын тушаал, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж /уран-тори, нүүрс, төмөр, алт, шороон орд, хайлуур жонш, зэс, газрын тос/

A/16	2019.01.21	УУХҮЯ-ны сайдын тушаал, “Журам батлах тухай”, Хавсралт 1 Уурхай, уулын болон баяжуулах, үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах, Хавсралт 2 Уурхай, уулын болон баяжуулах, үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардлагатай бичиг баримтын бүрдэл, Хавсралт 3 Баяжуулах, боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардлагатай бичиг баримтын бүрдэл
A/181, A/458	2019.08.28	УУХҮЯ, БОАЖЯ-ны сайдын хамтарсан тушаал, “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам” Хавсралт 1 Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам, Хавсралт 2 Хаалтын менежментийн төлөвлөгөөнд хавсаргах баримт бичиг
A/205	2019.10.17	УУХҮЯ-ны сайдын тушаал, “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”
A/231, A/368	2019.12.11	УУХҮЯ, ХНХЯ-ны сайдын хамтарсан тушаал, “Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийг шинэчлэн батлах тухай”
A/37	2020.03.5	УУХҮЯ-ны сайдын “Маягт, түүнийг нөхөх зааврыг батлах тухай” “Ашигт малтмалын хайгуул, олборлолт, үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны 20... оны тайлан (3-ОУИТБС-1)” маягтыг 1 дүгээр хавсралтаар, түүнийг нөхөх зааврыг 2 дугаар хавсралтаар, “Газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны 20.. оны тайлан (3-ОУИТБС-2)” маягтыг 3 дугаар хавсралтаар, түүнийг нөхөх зааврыг 4 дүгээр хавсралтаар
A/87	2020.04.27	УУХҮЯ-ны сайдын “Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам”
A/155, A/132	2020.05.29	УУХҮЯ, ХНХЯ-ны сайдын хамтарсан “Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”
A/180	2019	УУХҮЯ-ны сайдын тушаал, Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2019-2023)
C/02	2019	Стандарт хэмжил зүйн газрын даргын тушаал, “Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлын хэмжээг тооцох аргачлал MNS 6742:2019 стандарт

5.1.1.4 Салбарын харилцааг зохицуулж буй бусад хуулиуд (багцлан үзүүлэв)

Хүснэгт 5.2 Салбарын бусад хуулиуд

Байгаль орчны чиглэлийн	Төсөв, татварын чиглэлийн
Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, 2010	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006
Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 2008
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, 2017
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012	Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, 2012
Газрын тухай хууль, 2002	Ирээдүйн өв сангийн тухай хууль, 2016
Газрын төлбөрийн тухай хууль, 1997	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2006, 2015
Ойн тухай хууль, 2012	Татварын ерөнхий хууль, 2008
Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010
	Үл хөдлөх эд хөрөнгийн татварын тухай хууль, 2000
	Улсын тэмдэгийн хураамжийн тухай хууль, 2010

Хариуцлагын чиглэлийн	Бизнесийн харилцаа, орчны чиглэлийн
Аудитын тухай хууль, 1997, 2015	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001
Зөрчлийн тухай хууль, 2017	Захиргааны ерөнхий хууль, 2015
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017	Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2015	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, 2015
Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001

5.1.2. Эрдэс баялагийн салбарт Төрөөс баримтлах бодлогууд

5.1.2.1 Төрөөс эрдэс баялгийн салбарт 2025 он хүртэл баримтлах бодлого

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилго нь хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино.

Энэхүү бодлогын баримт бичиг нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим, хөгжлийн чиглэлийг тодорхойлж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэх бөгөөд тэдгээр нь эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дунд, урт хугацааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, төсөлд тусгагдан хэрэгжинэ.

5.1.2.2 Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018-2027)

Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүний нөөц, үндэсний ажиллах хүчийг чадавхжуулах, мэргэшүүлэх шаардлагын үүднээс Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2017 он хүртэл баримтлах бодлого”-ыг баталсан.

Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын зорилго нь Монгол Улсын газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангахад оршино.

Энэхүү бодлогын баримт бичигт тусгагдсан 6 үндсэн зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбогдуулан УУХҮ-ийн сайдын 2019 оны А/163 тоот тушаалаар “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2017 он хүртэл баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталж хэрэгжүүлж байна.

2018-2027 онд 2 үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд I үе шат: 2018-2021 онд газрын тосны салбарын бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож, дэд бүтцийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой газрын тосны компанийн байгуулах ажлыг эхлүүлснээр улсын нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадвар дээшилнэ, II үе шат: 2022-2027 онд стратегийн ач холбогдол бүхий газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажил эрчимжиж, газрын тосны нөөц, олборлолт нэмэгдэн боловсруулах үйлдвэр байгуулагдаж, хүний нөөцийн чадавх бэхжиж, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурь бий болно.

5.1.2.3 Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого

Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын зорилт нь цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч тэргүүлэгч орны нэг болох, улмаар цөмийн энергийг эдийн засаг, нийгмийн салбарт өргөн хүрээнд ашиглах, хүний эрүүл мэндэд аюулгүй, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй технологиор цөмийн эрчим хүч үйлдвэрлэхэд оршино.

5.1.3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд гарсан эрх зүйн баримт бичгүүд

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд Ашигт малтмалын тухай хууль (2006), Цөмийн энергийн тухай хууль (2009), Газрын тосны тухай хууль (2014), Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль (2014), Зөрчлийн тухай хууль (2017), Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017) зэрэг 6 хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна.

ОУИТБС-ыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор дараах төрийн бодлогын баримт бичгүүд батлагдсан байна, үүнд:

- УИХ-ын тогтоолоор баталсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014)-д ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг олон улсын санаачилгыг дэмжин хөгжүүлэх,
- Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2016)-т олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар тусган,
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2017)-нд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах 6 төрлийн арга хэмжээг 2017-2023 оны хугацаанд 2 үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 381 дүгээр тогтоолоор Нээлттэй засгийн түншлэлийн 2 дахь шатны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө (2016-2018)-г хэрэгжүүлж, байгалийн баялгийг ашиглах бенефициар өмчлөгчийн мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 1 дүгээр тогтоолоор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгыг дэмжин, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоол болон 2017 оны 263 дугаар тогтоолуудаар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах (зарим) арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгожээ. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 190 дүгээр тогтоолоор олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг жил бүр гаргаж, нийтэд мэдээлж, тайлагнаж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах хамтын ажиллагааны гэрээний загвар, мөн 2015 оны 104 дүгээр тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг баталсан байна.

Ерөнхий сайдын захирамж болон холбогдох яамдын сайдын тушаал, шийдвэрээр 15 гаруй дүрэм, журам, санамж бичиг, төлөвлөгөө батлагдан салбарын үйл ажиллагааг зохицуулж байна.

УУХҮЯ-ны сайдын “Маягт, түүнийг нөхөх зааврыг батлах тухай” 2020 оны А/37 дугаар тушаалаар “Ашигт малтмалын хайгуул, олборлолт, үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны 20... оны тайлан (3-ОУИТБС-1)” маягтыг 1 дүгээр хавсралтаар, түүнийг нөхөх зааврыг 2 дугаар хавсралтаар, “Газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгж,

байгууллагын үйл ажиллагааны 20.. оны тайлан (3-ОУИТБС-2)” маягыг 3 дугаар хавсралтаар, түүнийг нөхөх зааврыг 4 дүгээр хавсралтаар батласан.

Энэхүү зохицуулалтын хүрээнд ашигт малтмалын хайгуул, олборлолт, үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааныхаа тайланг маягтаар үнэн зөв гаргаж, дараа оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын алба (ОУИТБСАА)-ны цахим тайлагналын системд илгээнэ. ОУИТБСАА нь аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлангийн нэгтгэлийг 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний статистикийн хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Мөн газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааныхаа тайланг маягтаар үнэн зөв гаргаж, дараа оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын алба (ОУИТБСАА)-ны цахим тайлагналын системд илгээнэ. ОУИТБСАА нь аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлангийн нэгтгэлийг 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний статистикийн хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.1.4 Төсвийн бодлого, төсвийн хууль тогтоомж (шаардлага 2.1)

5.1.4.1 Төсвийн бүрдэлт, хуваарилалт

Төсөв нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх хэрэгсэл бөгөөд тухайн оны хугацаанд төрийн санд хуримтлагдах нийт орлого, түүнийг зарцуулах арга хэмжээг багтаасан орлого, зарлагын тэнцэл юм.

Төсвийн орлого нь татварын болон татварын бус орлого, тусламжаас бүрддэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлогоос Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санд ногдох хэсгийг хасаад үлдсэн орлогыг Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого гэнэ.

Татварын орлогод Татварын ерөнхий хуулийн дагуу тогтоосон татвар болон төлбөр орно. Татварын бус орлогод:

- (i) Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
- (ii) Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр;
- (iii) Төрийн болон орон нутгийн өмчийг хувьчилсан, худалдсан, түрээсэлсний орлого;
- (iv) Торгуулийн төлбөр;
- (v) Төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлого;
- (vi) ЗГ-т олгосон зээл, тусламж;
- (vii) Хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлсэн бусад орлого орно.

Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардлаас бүрдэнэ. Төсвийн зарлага нь төрөөс иргэдэд боловсрол олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх зэрэг төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулагддаг.

Монгол Улс **нэгдсэн төсөвтэй**. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Орон нутгийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрдэл болдог. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ. Улсын Их Хурал нь Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг баталдаг бол орон нутгийн төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталдаг.

Зураг 5.1 Төсвийн бүтэц



Эх үүсвэр: Иргэдийн төсөв-2018, СЯ

Улсын төсөв. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, ЗГ, яамд болон тэдгээрийн харьяа байгууллагуудын бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг улсын төсөв гэнэ. Улсын төсөв нь нэгдсэн төсвийн 80 хувь орчмыг эзэлдэг.

Орон нутгийн төсөв. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрдүүлэн зарцуулах төсвийг хэлнэ. Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг болон улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг Улсын Их Хурал баталдаг.

Нийгмийн даатгалын сангийн төсөв. Нийгмийн даатгалын хуулийн дагуу ажилтан болон ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, улсын төсвөөс олгосон санхүүжилтээр бүрдүүлсэн орлогоор Нийгмийн даатгалын хуулиудад заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу төр, иргэн, байгууллагаас төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

5.1.4.2 Төсвийн хууль тогтоомжууд

Улсын төсөвтэй холбоотой хууль тогтоомжид Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу гаргасан бусад хууль тогтоомжийн актууд орно.

Монгол Улсын төсвийн бодлого доор дурдсан хуулийн хүрээнд зохицуулагдана.

Төсвийн тухай хууль. Улсын нэгдсэн төсөв нь Төсвийн тухай хуулиар зохицуулагддаг. Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялагийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэ хууль нь зарчмын хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Энэхүү хуулиар ирээдүйн тэнцвэрт алдагдлын хувь, өрийн зөвшөөрөгдөх хэмжээ, зарлагын өсөлтийн хувь болон төсвийн орлогын тооцооллын процесс зэргийг тодруулж өгсөн. Үүнд:
 - нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх.
 - Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.
 - Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байна.

- ЗГ-ын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх (энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан).
- Төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлсон байх. Энэхүү хүрээ нь Засгийн газрын санхүүгийн зорилтуудыг, түүний хүлээгдэж буй төсвийн гүйцэтгэл, болон макро эдийн засгийн (ажил эрхлэлтийн түвшин, хэрэглээний үнийн индекс, гэх мэт) болон дараагийн гурван жилд баримтлах төсвийн төсөөлөл (төсвийн тэнцэл, төсвийн хөрөнгө оруулалт, гэх мэт) агуулсан байх ёстой.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль. Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Ирээдүйн өв сангийн тухай хууль. Ирээдүйн өв сангийн тухай хууль нь УИХ-аар 2016 онд батлагдаж, 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс бүх нийтээр дагаж мөрдөхөөр болсон. Энэ хуулийн зорилт нь

- нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг байгуулах,
- түүнд хөрөнгө төвлөрүүлэх, сангийн өгөөжийг хуваарилах, сангийн хөрөнгийг удирдах бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах,
- макро эдийн засгийн тогтвортой, үр ашигтай удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

5.1.4.3 Системтэйгээр ил тод болгосон байдал (Шаардлага 2.1.а)

Төсвийн бодлого, төсвийн хуваарилалтын түвшин, орон нутгийн шилжүүлэгтэй (орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаар дамжин эсвэл шууд аймгууд руу шилждэг) хамаарах мэдээлэл, орон нутагт заавал хийгдэж буй төлбөрийн эрх зүйн орчны талаар мэдээллийг Сангийн яамны www.mof.gov.mn, www.iltod.gov.mn хуудас, <https://shilendans.gov.mn> зэрэг вэбсайтад ил тод болгосон байна.

Иргэнд төсвийн талаар мэдлэг, мэдээллийг тогтмол өгч төсвийн үйл явцад иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдлыг сайжруулах зорилгоор Сангийн яамнаас “Иргэдийн төсөв” товхимлыг Монгол Улсын төсвийн төсөл болон төсвийн гүйцэтгэлийн мэдээллээр жишээ болгон “инфографик” буюу “зурган мэдээлэл” хэлбэрээр 2018 оноос эхлэн бэлтгэж хэвшсэн байна. Уг товхимлыг хэвлэмэл, цахим хэлбэрээр Сангийн яамны www.mof.gov.mn, www.iltod.gov.mn хуудас, олон нийтийн мэдээллийн сүлжээ, сангийн яамны фэйсбүк хуудаснаас үзэж болно.

5.2 УУЛ УУРХАЙ

5.2.1. Монголын ашигт малтмалын тухай тойм

Монгол улсад 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,772 аж ахуйн нэгжийн 2,796 тусгай зөвшөөрөлтэй талбай дээр ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна. Сүүлийн 3 жилийн дунджаар Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын эзлэх хувь 23.5 хувь байсан. Тус үзүүлэлт 2019 онд өмнөх оноос 1.2 хувиар өссөн байна.

Сүүлийн 3 жилийн дунджаар Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувь 72.1 хувь байсан. Тус үзүүлэлт нь 2019 онд өмнөх оноос 0.2 хувиар өссөн байна.

Дараах Хүснэгт 5.3-д уул уурхайн салбарын сүүлийн 3 жилийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг харуулав.


Хүснэгт 5.3 Уул уурхайн салбарын үндсэн үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	2017	2018	2019
1	Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо	3,369	3,078	2,796
	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	1,624	1,673	1,670
	Хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо	1,745	1,405	1,126
2	Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбай	10.7 сая га	8.7 сая га	7.3 сая га
	Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай	1.6 сая га	1.6 сая га	1.6 сая га
	Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай	9.1 сая га	7.1 сая га	5.7 сая га
3	Нийт нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь	6.80%	5.50%	4.80%
	Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь	1.00%	1.00%	1.00%
	Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь	5.80%	4.50%	3.80%
4	ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь	23.5%	23.8%	23.7%
5	АҮ-ийн нийт үйлдвэрлэлд УҮҮ-ийн эзлэх хувь	72.6%	71.9%	71.8%
6	Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл			
	Зэсийн баяжмал (метал агуулгаар)	1,317.1 мян.тн	1,310.8 мян.тн	1262.4 мян.тн
	Молибдений баяжмал (метал агуулгаар)	5,616.7 тн	5,486.1 тн	5302.8 тн
	Алт	19,846.0 кг	20,655.2 кг	16,251.3 кг
	Хайлуур жоншны баяжмал	55.2 мян.тн	80.7 мян.тн	47.5 мян.тн
	Төмрийн хүдэр, баяжмал	3,675.0 мян.тн	3,405.5 мян.тн	3,386.4 мян.тн
	Цайрын баяжмал	82.7 мян.тн	87.9 мян.тн	83.1 мян.тн
7	Экспортод гаргасан гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн			
	Төмрийн хүдэр, баяжмал	6,257.8 мян.тн	7449.1 мян.тн	8448.8 мян.тн
	Зэсийн баяжмал	1,472.2 мян.тн	1436.7 мян.тн	1403.6 мян.тн
	Цайрын хүдэр, баяжмал	118.2 мян.тн	123.9 мян.тн	134.8 мян.тн
	Боловсруулаагүй, хагас боловсруулсан алт	14,554.5 кг	3,431.9 кг	9,069.5 кг
	Нүүрс	33,400.1 мян.тн	36,671.4 мян.тн	36,809.10 мян.тн
8	Олборлосон нүүрс	49,480.3 мян.тн	54,572.3 мян.тн	57,128.80 мян.тн
9	Баяжуулсан нүүрс	41,904.6 мян.тн	45,741.9 мян.тн	47,047.80 мян.тн
10	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн ГСА	12.3 тэрбум төг	13.3 тэрбум төг	24.6 тэрбум төг

Эх сурвалж: 2017, 2018, 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, УУХҮЯ, Ашигт малтмал, газрын тосны газар, Гадаад худалдаа 2018, Гадаад худалдаа 2019, Монгол улсын үндэсний статистикийн хороо

Ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд 2019 онд хүлээлгэн өгсөн ордууд дараах байдалтай байсан (Зураг 5.2).

Зураг 5.2 Ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд хүлээлгэн өгсөн орд



Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ хуудас 15, 2019 он, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

5.2.2. Ураны тухай тойм мэдээлэл

Цөмийн энергийн тухай хууль 2009 онд батлагдаж, 27 аж ахуйн нэгжийн цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын 164 тусгай зөвшөөрөл байсан ба Монгол Улсын нутаг дэвсгэрийн 2.6 хувийг эзэлж байсан. 2019 оны байдлаар 6 байгууллагын 14 ураны тусгай зөвшөөрөл байсан.

Харин 2020 оны байдлаар АМГТГ-т 8 аж ахуйн нэгжийн цацраг идэвхт ашигт малтмалын 9, хайгуулын 7 тусгай зөвшөөрөл хүчинтэй байсан. Уран олборлолтын тусгай зөвшөөрөл ба 8 компанийн 14 ширхэг ураны хайгуулын тусгай зөвшөөрөл байсан. Энэ нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0.13 хувийг эзэлж байгаа ба 2009 онтой харьцуулахад 20 дахин багассан байна.

АМГТГ-аас 2020 оны 07 дугаар сарын байдлаар Монгол улсад ураны 13 орд (Дорнод, Гурванбулаг, Улаан, Нэмэр, Мардайн гол, Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийт, Дулаан-Уул, Зөөвч-Овоо, Энгэр ар, Далт)-ын хэмжээнд 192,241.02 тонн геологийн нөөц бүртгэж Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн бүртгэж авсан байна.

5.2.3. Стратегийн ач холбогдол бүхий ордууд

Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1.5-д “Засгийн газар нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох тухай саналыг Улсын их хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан байна.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд нь үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн түвшинд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд болзошгүй нөлөөтэй байж болох

эсхүл тухайн жилд нийт ДНБ-ний 5 хувиас илүү үйлдвэрлэх боломжтой эсвэл үйлдвэрлэж байгаа ордууд юм.

УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар болон 2015 оны 1 дүгээр сарын 23-ний өдрийн 11 тоот тогтоолоор батлагдсан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 16 ордуудын товч мэдээллийг дараах Хүснэгт 5.4-ээр харуулав. Үүнд:

Хүснэгт 5.4 Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд

№	Ордууд	Ашигт малтмалын төрөл	Байршил	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд	Эзэмшлийн хувь	
					ТӨР	ААН
1	Асгат	Мөнгө	Баян-Өлгий, Ногооннуур	Эрдэнэс Монгол ХХК	100	0
2	Багануур	Нүүрс	Улаанбаатар, Багануур	Багануур ХК	75	25
3	Бороо	Алт	Сэлэнгэ, Баянгол	Бороо гоулд	0	100
4	Бүрэнхаан	Фосфорит	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ	Сутайхэн цо ХХК	0	100
				Топруонхэнцо ХХК		
				Талст маргад ХХК		
5	Гацуурт	Алт	Сэлэнгэ, Мандал	Сентеррагоулд Монголия ХХК	Хэлэлцэж байна	
6	Гурванбулаг	Уран	Дорнод, Дашбалбар			
7	Дорнод	Уран	Дорнод, Дашбалбар			
8	Мардай	Уран	Дорнод, Дашбалбар	Адамасмайнинг ХХК		
9	Нарийн сухайт	Нүүрс	Өмнөговь, Гурвантэс	Монголын Алт МАК ХХК	0	100
				Чинхуа МАК НС ХХК		
				Саус гоби сэндс ХХК		
				Өсөх зоос ХХК		
10	Оюу толгой	Зэс, алт	Өмнөговь, Ханбогд	Оюу толгой ХХК	34	66
				Онтра ХХК		
11	Таван толгой	Нүүрс	Өмнөговь, Цогтцэций	Тавантолгой ХК	51	49
				Энержи Ресурс ХХК	0	100
				Эрдэнэс Таван Толгой ХХК	100	0
12	Төмөртэй	Төмөр	Сэлэнгэ, Хүдэр	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	100	0
13	Төмөртэйн овоо	Цайр	Сүхбаатар, Сүхбаатар	Цайрт Минералс ХХК	0	100
14	Шивээ овоо	Нүүрс	Говьсүмбэр, Сүмбэр	Шивээ-Овоо ХК	90	10
				Эрдэнэс монгол ХК		
				Эйкүсора ХХК		
15	Цагаан суварга	Зэс, молибден	Дорноговь, Мандах	Эрдэнэс Цагаан суварга ХХК	0	100
				Монголын Алт МАК ХХК		
16	Эрдэнэтийн овоо	Зэс, молибден	Орхон, Баян-Өндөр	Эрдэнэт үйлдвэр ХХК	51	49

Засгийн газрын 2018 оны “Стратерийн ач холбогдол бүхий ашигт малтмалын зарим ордын талбайд хил заагийг тогтоох тухай” 300 дугаар тогтоолоор Нарийн сухайт, Тавантолгой, Шивээ-Овоо, Багануур зэрэг нүүрсний орд, Цагаан суваргын зэс, молибден, Бүрэнхааны Фосфорит, Эрдэнэтийн зэс, молибдений орд зэрэг 7 ордын талбайн хил заагийг тодорхой болгосон байна.

5.2.4. Монголын ашигт малтмалын нөөц

Монгол Улсын нутаг дэвсгэрийн нэлээдгүй хэсэгт геологи хайгуулын ажил хийснээр ашигт малтмалын асар их нөөцийг олж илрүүлсээр байгаа бөгөөд Монголын Ашигт малтмалын нөөцийг

АМГТГ бүртгэж, тайлагнадаг. Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэгдсэн нөөцийн сүүлийн 2 жилийн мэдээллийг хураангуйлан харуулав. Үүнд:

Хүснэгт 5.5. Ашигт малтмалын нөөц, оноор

№	Ордын төрөл	Хэмжих нэгж	2018		2019	
			Хүдэр/шлих	Метал	Хүдэр/шлих	Метал
1	Алт (үндсэн)	мян.тн/кг	6,537.9	18,697.9	48,058.5	63,903.9
	Мөнгө	тн	-	-	-	265.3
	Хар тугалга	мян.тн	-	-	-	119.5
	Цайр	мян.тн	-	-	-	201.9
2	Алт (шороо)	кг	5,140.2	4,600.6	4,049.2	3,621.6
3	Төмөр	мян.тн	44,969.8	18,287.9	15,545.9	-
	Төмөр	мян.тн	-	-	-	4,992.3
	Цайр	мян.тн	-	-	-	70.3
4	Холимог метал	мян.тн	167,692.3	-	11,907.1	-
	Зэс	тн	-	51,909.0	-	1,284.8
	Цайр	тн	-	1,174,190.0	-	94,319.7
	Хар тугалга	тн	-	606,274.0	-	23,127.1
	Алт	кг	-	512,904.0	-	871.1
	Мөнгө	тн	-	132,224.9	-	91.3
5	Цагаан тугалга, гянтболдын шороон орд	тн	-	-	-	-
	Цагаан тугалга	тн	-	-	-	547.7
	Гянтболд	тн	-	-	-	75.4
6	Гянтболд (шороо)	тн	-	-	-	-
7	Гянтболд	мян.тн	36.6	1.4	74.9	965.3
8	Газрын ховор элемент	мян.тн	356.8	125.2	-	-
9	Зэс молибден холимог	мян.тн	55,871.2	-	-	-
	Зэс	тн	-	149.1	-	-
	Молибден	тн	-	2.2	-	-
10	Хайлуур жонш	мян.тн	6,932.0	1,239.1	3,538.3	1,572.3
11	Уран	мян.тн	51,583.2	15.5	-	-
12	Цайр холимог	мян.тн	-	-	3,273.9	-
	Цайр	мян.тн	-	-	-	308.6
	Хар тугалга	мян.тн	-	-	-	16.3
	Мөнгө	кг	-	-	-	87.8
	Төмөр	мян.тн	-	-	-	636.7
13	Никель	мян.тн	-	-	42,591.0	-
	Никель	мян.тн	-	-	-	78.8
	Кобальт	мян.тн	-	-	-	3.8
14	Нүүрс	сая.тн	9,662.7	-	5,151.2	-
15	Цахиур	мян.тн	-	-	182.1	-
16	Шохойн чулуу	сая.тн	52.7	-	130.9	-
17	Барилгын чулуу	мян.тн	-	-	336,337.7	-
18	Бал чулуу	мян.тн	-	-	347.4	-
19	Гөлтгөнө	мян.тн	-	-	683.3	-
20	Шавар	мян.м3	-	-	3,796.4	-
21	Элс хайрга	мян.м3	-	-	6,571.6	-
22	Элс	мян.м3	-	-	543.2	-
23	Гантиг	мян.м3	-	-	81,596.8	-

Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ хуудас 15, 2019 он, УУХҮЯ, Ашигт малтмал, газрын тосны газар

2019 оны ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэж батлуулсан ордын жагсаалт болон ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөний тайлан АМГТГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/72 дугаар тушаалаар нууцын зэрэглэлд хамаарч байгаа тул ил тод болгоогүй байна.

5.2.5. Бичил уурхай

Гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичил уул уурхай

Гар аргаар ашигт малтмал олборлох буюу Бичил уул уурхай (БУУ) гэдэг нь өргөн утгаараа Монгол Улсын нутаг дэвсгэрт нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн (ихэвчлэн хууль бус) эрхэлж буй ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хэлнэ. БУУ-н үйл ажиллагааны улирлын шинж чанар, тогтворгүй байдал болон албан ёсны статистик мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалан энэхүү тайланд бичил уул уурхайн салбарыг Монгол Улсын голлох олборлох салбарын тоймоос тусад нь авч үзсэн болно.

Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд 17 аймаг, 34 сум, Нийслэлийн 1 дүүргийн 178 нэгж талбайн 616.41 га талбайд олборлолт явуулж үүнээс эвдрэлд орсон талбайн хэмжээ 203.1 га, нөхөн сэргээсэн талбайн хэмжээ 62.7 га тус тус байна. БУУ эрхлэгчид нийт 178 талбай дээр бүртгэлтэй байгаа ба үүнээс Алтны 103 (6 нь үйл ажиллагаа явуулдаггүй), Жоншны 73, Вольфраммын 1, Дайрганы 1 (үйл ажиллагаа явуулдаггүй) бүртгэлтэй байна. Нийт 2,889 бичил уурхай эрхлэгчдээс 2,028 нь эрэгтэй, 861 нь эмэгтэй БУУ эрхлэгчид журмын дагуу ажиллаж байгаа талаар мэдээлэл ирүүлсэн байна².

5.2.5.1 Хууль, эрх зүйн орчин

УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолоор 2014-2025 он хүртэл Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг баталсан бөгөөд энэхүү бодлогын хүрээнд “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг төрөөс бодлогоор дэмжиж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” чиглэлийг баримталж байна.

Бичил уурхайн үйл ажиллагааг Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-аар зохицуулж байна. Шинэчлэн батлагдсан журам нь бичил уурхайн албажуулалтын хүрээг тэлэхэд эерэг үр нөлөө үзүүлээд зогсохгүй журмын дагуу бичил уурхайчид хуулийн этгээдийн нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйл ажиллагаа явуулж татварын холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар төлдөг болсноор бичил уурхайгаас улс орны эдийн засагт оруулж буй хувь нэмрийг бодитойгоор тооцох боломж бүрдүүлнэ.

Энэхүү тогтоолд аймгуудын засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхээр заасан. Аймгийн засаг захиргаа нь сумын БУУ-н үйл ажиллагааны тайланг нэгтгэн АМГТГ-т хүргэхээр үүрэг болгосон. Мөн тогтоолд бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм (АМГ-ын даргын 2011 оны 153-р тушаал, Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм)-ийг дагаж мөрдөх, бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг тусгасан байна.

Одоогийн байдлаар Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хоршооны тухай хууль, Нөхөрлөлийн тухай хуулиуд бичил уурхайн үйл ажиллагаанд мөрдөгдөж байна. Гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичил уурхайд дараах тогтоолууд мөрдөгдөж байна. Үүнд:

- "АЛТ-2" Үндсэний хөтөлбөр;
- Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмүүд – Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоол;
- "Бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм" - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Уул уурхай, үйлдвэрийн хүнд сайдын хамтарсан 2017 оны А/115, А/123 дугаар тушаал;
- “Бичил уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийх аргачлал” - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны А/226, А/182 дугаар тушаал;

² АМГТГ

- "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай" - Засгийн газрын 2019 оны 355 дугаар тогтоол.

Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчинтой болсноор бичил уурхайн эрхлэгчид төрийн үйлчилгээ авах боломжтой болж, нөхөн сэргээлт хийдэг болсон байна. Мөн хүдэр баяжуулах цехээр олборлосон алтаа ялгуулдаг болсноор мөнгөн усны хэрэглээ буурсан байна.

5.2.5.2 Бичил уул уурхайн эдийн засагт оруулж буй хувь нэмэр

Бичил уурхай нь олон хүний хувьд ядуурлаас гарах, амьжиргаагаа залгуулах чухал хэрэгсэл болж байгаа төдийгүй үндэсний болон орон нутгийн эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна. Бичил уурхайчид олборлосон алтаа албан ёсны сүлжээгээр дамжуулан борлуулснаар Монгол банкны гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаагаас гадна шууд болон шууд бусаар ажлын байрыг бий болгож, орон нутгаас төв рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг саармагжуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлж байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын алтны нийлүүлэлтийн сүлжээ бүрэн албажаагүй хэвээр байна. Монгол дахь алтны сүлжээний сүүлийн шат буюу Монгол банканд алтыг тушааснаар энэ сүлжээ нь албан ёсных болдог.

Монгол Банкнаас иргэдийн тушаасан алтны статистик мэдээллийг <https://www.mongolbank.mn/dblistgoldbom.aspx> - холбоосоор авах боломжтой бөгөөд сүүлийн 3 жилийн дундажаар Монгол Банкинд нийт тушаасан алтны 49.8 хувийг бичил уурхай эрхлэгчид эзэлж байгаа бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 5.6-д танилцуулж байна. Үүнд:

Хүснэгт 5.6 Монгол банкинд иргэдийн тушаасан алт

Он	Иргэдийн тоо (давхардсан тоогоор)	Иргэдийн тушаасан алт /кг/	Нийт тушаасан алт /кг/	Нийт тушаасан алт-д эзлэх хувь
2018	472	12,507.35	21,871.51	57.2%
2019	437	7,366.96	15,206.54	48.4%
2020 (I - XI сар)	446	9,152.11	20,963.84	43.7%

Эх сурвалж: Монгол банк

5.2.5.3 Бичил уурхайн талаарх мэдээллийн тархац, эх сурвалж

Орон нутгийн иргэдэд бичил уурхайн танилцуулга мэдээллийг олон нийтийг хамарсан сайн дурын ажил болон хандивын аянаар дамжуулан түгээдэг. Харин бичил уурхай эрхлэгчдийн болон олборлолтын талаарх статистик мэдээллийг Монголын бичил уурхайн нэгдсэн Дээвэр холбоо, Тогтвортой бичил уурхайн төсөл болон БОАЖЯ-аас авах боломжтой.

Бичил уурхайн нэгдсэн Дээвэр холбоонд 2019 оны байдлаар 14 аймагт байрлах 68 гишүүн байгууллагын 631 нөхөрлөлийн 7,917 гаруй бичил уурхай эрхлэгчид бүртгэлтэй байна. Нийт бичил уурхай эрхлэгчдийн 5,411 нь эрэгтэй, 2,505 нь эмэгтэй бичил уурхайчид эзэлж байна. Энэхүү холбооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг <http://bichiluurhai.mn/> сайтаас үзнэ үү.

Орон нутаг дахь гишүүн ТББ-уудын мэдээллийг Хавсралт 28 (а)-аас харна уу.

Үндэсний Статистикийн Хороо нь 5 жил тутам бичил уурхай эрхлэгчдийн судалгааг гаргадаг бөгөөд Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлагтай хамтран “Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны нэгдсэн тайлан 2016” буюу 2 дахь удаагийн судалгааг хийсэн. Монгол Улсын нутаг дэвсгэрт гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэд болон тэдгээртэй хамааралтай бүхий л үйл ажиллагааг газар зүйн байршлаар нь тогтоож, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд тэдний оруулж буй хувь нэмрийг тодорхойлоход энэхүү судалгааны үр дүн хувь нэмэр оруулж байна. ҮСХ-оос 2017 онд гаргасан “Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны нэгдсэн тайлан 2016”-г <http://sam.mn/бичил-уурхай-эрхлэгчдийн-судалгааны-нэгдсэн-тайлан-2016/> линк-ээр үзнэ үү.

2019 оны байдлаар АМГТГ-ын мэдээлснээр Бичил уурхайгаар олборлох дүгнэлт гарсан талбай нийтдээ 1,113.4 га байсан бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг аймагаар ангилан Хүснэгт 5.7-д харуулав.

Хүснэгт 5.7 Бичил уурхайгаар олборлох дүгнэлт гарсан талбай, га

№	Аймаг	Тоо	Дүгнэлт гарсан талбай (га)
1	Архангай	1	4.8
2	Баян-Өлгий	2	53.7
3	Баянхонгор	57	152.3
4	Булган	29	126.4
5	Говь-Алтай	1	5.7
6	Дархан-Уул	6	16.6
7	Дорноговь	12	59.6
8	Дорнод	2	26.2
9	Дундговь	13	104.4
10	Өвөрхангай	20	39.7
11	Өмнөговь	20	86.2
12	Сэлэнгэ	52	220.1
13	Төв	12	78.3
14	Улаанбаатар	5	19.0
15	Ховд	4	11.3
16	Хэнтий	36	109.4
	Дүн	272	1,113.4

Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 7, 2019 он, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

5.2.5.4 Монголд хэрэгжиж буй Тогтвортой Бичил Уурхайн Төсөл

Тогтвортой бичил уурхай (ТБУ) төсөл нь Швейцарийн хөгжлийн агентлагын буцалтгүй тусламжаар Монгол улсад 2005-2019 оны хооронд 4 үе шаттайгаар хэрэгжиж уул уурхайн салбарт бичил уурхайн эрх зүйн орчныг бий болгох, оролцогч талуудыг чадавхжуулах, бичил уурхайн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл, нийгмийн халамж, хамгааллыг сайжруулах, байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэх, борлуулалтын сүлжээг ил тод болгох, хариуцлагатай бичил уурхайн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн зорилгын хүрээнд төсөл амжилттай хэрэгжиж дууссан бөгөөд төсөл хэрэгжиж дууссаны дараа ч бичил уурхайн оролцогч талууд мэдлэг мэдээлэл авч, мэдээлээ хуваалцах мэдээллийн тогтолцоог бий болгосон байна. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://sam.mn/> - ээс авах боломжтой.

Европын Холбоо 2021 оноос гарал үүсэл нь тодорхой болсон алт болон бусад гурван төрлийн ашигт малтмалыг худалдан авах тухай мэдэгдсэн. Мөн Монголбанкнаас алтны дотоодын худалдан авалтыг хийхдээ Худалдан авалтын гэрээ байгуулахыг шаардах бодлого баримтлахаар төлөвлөж байна. Иймд БУУ-аар олборлосон ашигт малтмалыг гарал үүслийн бичигтэйгээр экспортлох шаардлагатай болж байгаа учир ТБУ төсөл нь бичил уурхайгаас бий болсон ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээ гарал үүслийг сайжруулах, түүнийг тодорхой болгох зорилготойгоор ажиллаж байна. Энэхүү зорилгын хүрээнд Дархан, Баянхонгор аймагт сорьцийн хяналтын лабораторийг 2018 онд нээсэн байна.


Монголд Даян дэлхийн байгаль хамгаалах (Global Environment Facility) сангаас Планет голд (planetGold) төслийг 5 жилийн хугацаанд Монгол Улсад хэрэгжүүлэхээр 2019 оны 4 сард эхэлсэн байна. Энэ төслийн хүрээнд бичил уурхайд шинэ, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хүдэр боловсруулах хүрээнд ашиглагдаж буй мөнгөн усны хэрэглээг бууруулах, бичил уурхай эрхлэгчдийг эдийн засгийн хувьд чадавхжуулснаар амьжиргааг дэмжих, орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх ажлууд хийгдэнэ. Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.planetgold.org/mn/mongolia> – ээс авах боломжтой.

5.2.5.5 Нөхөн сэргээлтийн байдал

Бичил уурхай эрхлэгч этгээд нь Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд заасны дагуу олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлт хийх ажлын төлөвлөгөө, төсөв, зардлын эх үүсвэрийн баталгааг гаргаж сум, дүүргийн Засаг даргатай байгуулах гэрээндээ тусган ажиллана. Бичил уурхай эрхлэгч нь олборлолтын талбайгаа тухайн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 2017 оны 8 дугаар сарын 17-ний өдрийн Байгал орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан А/226, А/182 дугаар тоот тушаалаар батлагдсан “Бичил уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийх аргачлал” – ын дагуу хийж байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан, сум, дүүргийн засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгнө.

Бичил уурхай эрхлэлтийн улмаас эвдэрсэн талбайн хэмжээг 2020 оны 11 сарын байдлаар Зураг 5.3-д танилцуулж байна.

Зураг 5.3 Эвдэрсэн талбай



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2000-2024 Нөхөн сэргээлтийн тайлан

Бичил уурхайн нэгдсэн Дээвэр холбооноос 2020 оны 12 сарын байдлаар нийт 494.9 га газарт, үүнээс хамгийн их нь Баянхонгор аймаг 99.3 га газарт, хамгийн бага нь Булган аймаг 5.9 га газарт тус тус бичил уурхайн нөхөн сэргээлт хийсэн бөгөөд Бичил уурхайн нөхөн сэргээлтийг хийсэн мэдээллийг аймгаар нь задалж дараах Хүснэгт 5.8-д танилцуулж байна.

Хүснэгт 5.8 Бичил уурхайн нөхөн сэргээлт, аймгаар, га

№	Аймаг	Өөрсдийн санхүүжилтээр нөхөн сэргээлт хийсэн талбай (га)	Гадны дэмжлэгтэйгээр болон хамтарч нөхөн сэргээлт хийсэн талбай (га)	Нийт нөхөн сэргээлт хийсэн талбай (га)
1	Баянхонгор	63.7	35.6	99.3
2	Булган	5.9	-	5.9
3	Говь-Алтай	32.8	38.2	71.0
4	Дархан-уул	19.0	-	19.0
5	Дорноговь	36.7	2.5	39.2
6	Дундговь	38.7	8.0	46.7
7	Өвөрхангай	-	47.5	47.5
8	Өмнөговь аймаг	26.0	2.2	28.2
9	Сэлэнгэ	1.0	28.1	29.1
10	Увс	-	10.0	10.0
11	Ховд	29.0	29.0	58.0
12	Хэнтий	30.9	10.0	40.9
	Нийт	283.7	211.1	494.9

Эх сурвалж: Дээвэр холбоо

Дээвэр Холбооны нөхөн сэргээлтийн дэлгэрэнгүй задаргааг Хавсралт 28 (б)-ээс харна уу.

5.2.6. Эрдэс баялагийн засаглал

Засаглал нь тухайн улсад эрх мэдлийг дамжуулан хэрэгжүүлдэг уламжлал, институцийн багц болох боломжтой гэдэг бөгөөд:

- Эрх мэдэлтнүүдийг сонгох, солих үйл явц
 - Дуу хоолой бөгөөд хариуцлага тооцолт
 - Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл, терроризмаас ангид байх
- Засгийн газрын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чадавх
 - Засгийн газрын үр дүнтэй ажиллагаа
 - Хяналтын чанар
- Хоорондын харилцааг нь зохицуулагч институцэд иргэд болон төрийн зүгээс хүндэтгэлтэй хандах байдал
 - Хуулийн засаглал
 - Авилгын хяналт

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс гаргасан судалгаагаар Монгол Улс хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг импортод зарцуулж буй бөгөөд үндсэндээ энэ хөрөнгө уул уурхай болон барилгын салбарт шингэж байна.

Манай улстай адил эрдэс баялагийн асар их нөөцтэй орнуудад дэлхийн зах зээл дээрх эрдсийн үнэ өсөхөд хөрөнгө оруулалтын урсгал нэмэгддэг ч, нүүрс, зэсийн үнэ буурахад хөрөнгө оруулалтын түвшин ч мөн адил буурдаг байна. Баялагийн нөөц ихтэй орнуудад хөрөнгө оруулалт татах, түүнийг зөв ашиглах боломж байгаа ч улс төрийн тогтвортой байдал хамгийн чухал гэдгийг судлаачид тодотгодог.

УУХҮЯ-аас геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлвэрийн салбарын хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд эрдэс баялагийн салбарийн хөгжлийн 2050 он хүртэлх зураглалыг тодорхойлсон. Энэхүү бодлогын матриц нь эрдэс баялагийн нөөц, макро болон микро түвшинд харгалзах стратеги, бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх замаар салбарын хэмжээнд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэх бөгөөд ингэхдээ эрдэс баялагийн нөөцийн бүтээмж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, баялагийн засаглал болон үндэсний хуримтлалын тогтолцооны үр ашигтай, оновчтой байдлыг хангана.

5.2.7. Ашигт малтмалын лиценз

Тайлант оны жилийн эцсийн байдлаарх ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ, аймаг, нийслэлээр ангилан дараах Хүснэгт 5.9-д харуулав.

Хүснэгт 5.9 Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ, аймаг, нийслэлээр


№	Аймаг, нийслэл	Бүгд			Үүнээс:					
					Ашиглалт			Хайгуул		
		Лиценз-ийн тоо	Талбай /мян.га/	Талбайн эзлэх хувь	Лиценз-ийн тоо	Талбай /мян.га/	Талбайн эзлэх хувь	Лиценз-ийн тоо	Талбай /мян.га/	Талбайн эзлэх хувь
1	Дорноговь	346	1,282.1	11.7%	187	232.6	2.1%	159	1,049.5	9.6%
2	Өмнөговь	178	1,113.8	6.7%	92	447.0	2.7%	86	666.7	4.0%
3	Говь-Алтай	145	706.6	5.0%	50	73.5	0.5%	95	633.2	4.5%
4	Дундговь	204	701.5	9.4%	106	182.6	2.4%	98	518.9	6.9%
5	Дорнод	153	512.4	4.1%	73	63.0	0.5%	80	449.4	3.6%
6	Увс	131	424.9	6.1%	49	21.4	0.3%	82	403.5	5.8%
7	Төв	393	377.1	5.1%	294	153.1	2.1%	99	224.0	3.0%
8	Баянхонгор	149	355.7	3.1%	94	124.5	1.1%	55	231.2	2.0%
9	Хэнтий	217	339.4	4.2%	120	52.0	0.6%	97	287.4	3.6%
10	Сүхбаатар	98	299.1	3.6%	66	58.9	0.7%	32	240.2	2.9%

№	Аймаг, нийслэл	Бүгд			Үүнээс:					
		Лиценз-ийн тоо	Талбай /мян.га/	Талбайн эзлэх хувь	Ашиглалт			Хайгуул		
					Лиценз-ийн тоо	Талбай /мян.га/	Талбайн эзлэх хувь	Лиценз-ийн тоо	Талбай /мян.га/	Талбайн эзлэх хувь
11	Завхан	56	271.9	3.3%	10	15.0	0.2%	46	256.9	3.1%
12	Ховд	103	266.9	3.5%	35	14.0	0.2%	68	252.9	3.3%
13	Баян-Өлгий	61	180.5	3.9%	28	15.4	0.3%	33	165.1	3.6%
14	Булган	110	136.4	2.8%	74	35.7	0.7%	36	100.7	2.1%
15	Өвөрхангай	48	136.0	2.2%	28	15.7	0.2%	20	120.4	1.9%
16	Сэлэнгэ	180	97.6	2.4%	141	42.9	1.0%	39	54.7	1.3%
17	Архангай	22	61.5	1.1%	15	6.2	0.1%	7	55.3	1.0%
18	Говьсүмбэр	18	45.6	8.2%	13	38.9	7.0%	5	6.7	1.2%
19	Хөвсгөл	26	17.0	0.2%	21	10.3	0.1%	5	6.7	0.1%
20	Улаанбаатар	172	14.7	3.1%	160	13.3	2.8%	12	1.4	0.3%
21	Дархан-Уул	69	12.7	3.9%	63	7.6	2.3%	6	5.1	1.6%
22	Орхон	9	11.1	13.2%	9	11.1	13.2%	-	-	0.0%
Улсын хэмжээнд		2,796	7,364.5	4.8%	1,670	1,634.6	1.0%	1,126	5,729.9	3.8%


Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 4, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

Жич: Зарим тусгай зөвшөөрлийн талбай нь нэгээс дээш аймгийн хилийг дамнасан байгаа тул аймаг тус бүрийн тоон дээр нэмэгдэж байгаа болно.

Зураг 5.4 Хайгуулын болон ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, жилээр



Зураг 5.5 Ашиглалтын тусгай зөвшөөрлийн ашигт малтмалын төрлөөрх бүтэц



Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 5, 26, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

5.2.7.1 Ашигт малтмалын тухай хуулинд тусгагдсан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эрх, үүргийн зохицуулалтууд

Ашигт малтмалын тухай хуулинд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой Хүснэгт 5.10-д үзүүлсэн онцлох зохицуулалтууд орсон байдаг. Үүнд:

Хүснэгт 5.10 Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд

Хуулийн заалтын дугаар	Эрх, үүрэг бүхий талууд	Ашигт малтмалын тухай хуулиар олгогдсон эрх, үүрэг
8.1.5.	УИХ	Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар тодорхой нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг, эсхүл хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хязгаарлах буюу хориглох
9.1.11.	Засгийн газар	Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын болон энэ хуулийн 24.1-т зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх

Хуулийн заалтын дугаар	Эрх, үүрэг бүхий талууд	Ашигт малтмалын тухай хуулиар олгогдсон эрх, үүрэг
11.1.13.	Төрийн захиргааны байгууллага, Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар томилогдсон Сонгон шалгаруулалтын комисс	Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох, дүгнэлт гаргах
11.1.16.	Төрийн захиргааны байгууллага	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг өргөдлийг хүлээн авч бүртгэх
11.1.19.	Төрийн захиргааны байгууллага	Түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох
11.1.25.	Төрийн захиргааны байгууллага	энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах
20.1.	Төрийн захиргааны байгууллага	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 10.1.2-д заасан журмын дагуу зохион байгуулах
26.1	Төрийн захиргааны байгууллага, АМГТГ	Энэ хуулийн 25.1-д заасан өргөдлийг хүлээн авч, хянан, шийдвэрлэх

Эх сурвалж: Ашигт малтмалын тухай хуулийн 2018.06.21-ний өдрийн шинэчилсэн найруулга

5.2.7.2 Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд орсон өөрчлөлт, 2018

Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг УУХҮЯ-ны сайдын 2018 оны А/28 дугаар тушаалаар өөрчлөн, баталсан. Шинэчилсэн найруулгад дараах онцлох өөрчлөлтүүд орсон (Хүснэгт 5.11).

Хүснэгт 5.11 Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам

Өмнөх заалт	Нэмэлт өөрчлөлт
Орон нутгийн тусгай хэрэгцээний газартай эхсүл хууль бус олборлолтод өртсөн талбайтай сонгон шалгаруулалтын талбай нь давхцаж байвал тухайн газарт тусгай зөвшөөрлийг олгох хязгаарлагдмал сонгон шалгаруулалтад оролцох эрхийг орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд олгоно (2017 оны шинэчлэн найруулсан журмын 1.6 дугаар заалт)	Заалтыг хүчингүй болгосон
Сонгон шалгаруулалтын комиссын саналын эрхтэй гишүүдийн 70 ба түүнээс дээш хувийн ирцтэйгээр сонгон шалгаруулалт хүчин төгөлдөр болно	80 хувь болгон өөрчилсөн.
Техникийн саналыг 10 (арав) өдөрт багтаан үнэлж, дүгнэлт гаргах	5 өдөр болгож өөрчилсөн.
Комиссын нэгдсэн дүгнэлтийг Төрийн захиргааны байгууллагын даргад ажлын 2 өдөрт багтаан хүргүүлэх	1 өдөр болгож өөрчилсөн.
Төрийн захиргааны байгууллагын дарга Комиссын нэгдсэн дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан холбогдох тушаал гаргах	2 өдөр болгож өөрчилсөн
Сонгон шалгаруулалтын журмаар олгогдсон тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг төрийн захиргааны байгууллагын цахим хуудас дээр нийтэд мэдээлнэ	Өдөр тутмын сонинд нийтэлнэ

- Сонгон шалгаруулалтыг тасралтгүй зохион явуулах, ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс 3 (гурав) хүртэл тооны сонгон шалгаруулалтын комиссыг томилж болох бөгөөд комиссын бүрэлдэхүүний 2/3-ийг хагас жил тутамд өөрчилж болно гэсэн заалтыг нэмж оруулсан.
- Техникийн саналд өгөх шалгуур үзүүлэлтүүдийг өмнөх журамд зааснаас илүү нарийвчлалтай, тодорхой зааж өгсөн.

- “Сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн техникийн болон үнийн саналууд, тэдгээрийг хэрхэн үнэлсэн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” “Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон талбайн солбицлыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтууд оруулснаар сонгон, шалгаруулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулсан байна.
- 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтын журмаар олгодог болсон. (Эх сурвалж: Монгол улсын Их хурлын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт буюу тус хуулийн 7.1 дүгээр заалт).

Мөн Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/16 дугаар тушаалаар дээрх журамд дахин нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд өөрчлөлтийг Хүснэгт 5.12-т харуулав.

Хүснэгт 5.12 Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд орсон өөрчлөлт

Заалт	Тайлбар
4.3.8. Сонгон шалгаруулалтын комисс нь сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн техникийн саналыг үнэлэх үед материал дутуу үнэлэх боломжгүй техникийн саналыг үнэлэхээс татгалзаж болно. Ийнхүү татгалзсан тохиолдолд журмын 4.2.5, 4.2.6-д заасны дагуу материалыг буцааж хүлээлгэн өгнө.	Энэ заалтыг УУХҮС-ын 2020 оны А/16 дугаар тушаалаар нэмсэн
5.1.6. Сонгон шалгаруулалтын журамд хугацаа заасан үйл ажиллагаануудыг тодорхой шалтгааны улмаас хугацаанд нь багтаан явуулах боломжгүй болсон тохиолдолд комиссын гишүүдийн хурлаар шийдвэрлэн оролцогч аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэн хугацааг өөрчилж болно	Энэ заалтыг УУХҮС-ын 2020 оны А/16 дугаар тушаалаар нэмсэн
Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамын 4.2.6, 4.6.5, 4.7.1, 4.7.3 заалтууд	Энэ заалтыг УУХҮС-ын 2020 оны А/16 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан

Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг УУХҮ сайдын 2018 оны А/80, 2019 оны А/38, 2019 оны А/62, 2020 оны А/204, 2020 оны А/215 дугаар тушаалуудаар тус тус баталсан байна.

5.2.7.3. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь 2019 онд өмнөх оныхтой ижил байсан (Хүснэгт 5.13).

Хүснэгт 5.13 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	АМГТГ	Өргөдөл гаргахаар бүртгүүлсэн этгээдэд дугаар олгож, өргөдөл хүлээн авна.
2	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, боломжтой эсэхийг тогтооно.
3	Орон нутгийн засаг захиргаа	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг аймгийн эсвэл хотын захиргаа руу 30 хоногийн дотор хариу авахаар хүргүүлэх бөгөөд хэрэв энэ хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд АМГ тухайн орон нутгийн засаг захиргааг уг саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.
4	АМГТГ	Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг зөвшөөрөл хүсэгч ажлын 10 өдөрт багтаан төлнө.
5	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	АМГ нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгох бөгөөд дараа нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 удаа тус бүр 3 жилийн хугацаатай сунгаж болно.

Эх сурвалж: АМГТГ

Өөрийн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг байрилд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргагч нь бусад өргөдөл гаргагч талуудаас давуу эрхтэй байдаг.

Хүснэгт 5.14 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөл болгож өөрчлөх үйл явц

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	АМГТГ	Хүсэлт хүлээн авна.
2	АМГТГ-ын Хуулийн хэлтэс	Хуулиар хориглосон зүйлс байгаа эсэх эсвэл барагдуулаагүй төлбөр байгаа эсэхийг тодорхойлно.
3	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Кадастрын системд хайгуулын тусгай зөвшөөрөл нь бүртгэгдсэн эсэхийг шалгана.
4	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Ашиглалтын талбай нь бусад тусгай зөвшөөрлийн газар, усны нөөц, улсын тусгай хэрэгцээний газар болон нөөцөд авсан талбай зэрэг газруудтай давхацсан эсэхийг шалгана.
5	АМГТГ-ын Уул Уурхайн болон Нүүрсний хэлтэс	Хүсэлт гаргагч нь олборлолтоос үүсч болох экологийн хохирлыг нөхөн сэргээх боломжтой эсэхийг шалгана.
6	АМГТГ-ын Хуулийн хэлтэс	Хүсэлт гаргагч нь Кадастрын хэлтсийн даргын гаргасан төлөвлөгөө болон бусад хууль дүрэм журмуудыг дагаж мөрдөж буй эсэхийг шалгана.
7	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Координатаар тогтоосон талбайн зургийг зөвшөөрөх: АМГ нь өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан зохих шийдвэр гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв зөвшөөрөл олгохоос татгалзсан бол шалтгаан, хуулийн үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.
8	АМГТГ	Мэдэгдэл авсан өдрөөс хойш 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлнө.
9	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Эхний жилийн төлбөрийг хуулийн дагуу хийснээс хойш ажлын 3 өдөрт багтаан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгох бөгөөд дараа нь ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2 удаа тус бүр 20 жилийн хугацаатай сунгаж болно.

Эх сурвалж: АМГТГ

Дараах шалгууруудын аль нэгийг хангасан тохиолдолд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг нийтэд нээлттэй болгож сонгон шалгаруулах замаар олгоно. Үүнд:

- Хайгуулын ажил хийсэн аж ахуйн нэгж нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаагүй;
- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн талбайд;
- Зохих хууль журмыг эсвэл шүүхийн шийдвэрийг зөрчсөнөөс үүдэн ашиглалтын тусгай зөвшөөрлийг буцаан авсан;
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан.

Хүснэгт 5.15 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулах замаар олгох үйл явц

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	АМГТГ	Сонгон шалгаруулах үйл явцыг эхлүүлж захирамж гаргана.
2	АМГТГ	Олон нийтэд сонгон шалгаруулалтыг зарлана.
3	АМГТГ	Сонгон шалгаруулалтын саналыг авна. Сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.
4	АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс	Сонгон шалгаруулалтын саналыг нээнэ.
5	АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс	Сонгон шалгаруулалтад оролцогчдыг ирүүлсэн баримтуудад үндэслэн үнэлнэ.
6	АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс	Сонгон шалгаруулалтад ирүүлсэн үнийн саналыг нээнэ.
7	АМГТГ	Сонгон шалгаруулалтын саналд үнэлээ хийж дууссанаас хойш 5 хоногийн дотор ялагчийг зарлана.

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
8	АМГТГ	Шалгарсан оролцогчид сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг 10 хоногт багтаан төлөх тухай мэдэгдэл өгнө. Бусад оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг өгнө.
9	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	АМГТГ-ын даргын болон сонгон шалгаруулах комиссын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийг олгоно.

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газрын сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох журам

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл явц

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг дараах нөхцөлд аж ахуйн нэгжийн хооронд бүрэн буюу хэсэгчлэн шилжүүлж болно. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.
- Хараат, охин компани нь толгой компанидаа тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.
- Аж ахуйн нэгж эрэл, хайгуулын талаарх анхдагч материал, тайлан зэрэг мэдээллийг худалдан авч, зохих албан татварыг төлсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.
- Аж ахуйн нэгж нь уурхайг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, баримт бичгийн хамт худалдан авч зохих татварыг төлсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.

Хүснэгт 5.16 Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл явц

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Холбогдох бичиг баримтуудыг хүлээн авна.
2	АМГТГ-ын Кадастрын болон Хуулийн хэлтэс	Бичиг баримтууд болон бусад мэдээллүүдэд шалгалт хийнэ.
3	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Шалгах ажиллагаа дууссаны дараа 5 хоногт багтаан шийдвэр гаргана.

Эх сурвалж: АМГТГ

Лиценз олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд (шаардлага 2.2.a.i)

2018 оны 02 дугаар сарын 13-нд өөрчлөн батласан лиценз олгоход ашигласан техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг доорх Хүснэгт 5.17-д харуулав. Үүнд:

Хүснэгт 5.17 Лиценз олгоход ашиглах техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд

№	Шалгуур үзүүлэлт	Жишиг	Онооны	Нийт
		оноо	хязгаар	онооны хязгаар
Төслийн баримт бичгийн үнэлгээ				25
1	Геологи хайгуулын ажлын талаар		0-15	
	Арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, дэвшилтэт аргачлал, техник технологийн шийдэл бүхий, өмнөх судалгааны материалыг бүрэн судалсан	13-15		
	Арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, дэвшилтэт аргачлал, техник технологийн шийдэл бүхий, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй	10-12		
	Арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, өмнөх судалгааны материалыг бүрэн судалсан	7-9		
	Арга, аргачлал, төлөвлөлт оновчгүй, дэвшилтэт аргачлал, техник технологийн шийдэл бүхий, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй	4-6		

№	Шалгуур үзүүлэлт	Жишиг	Онооны хязгаар	Нийт онооны хязгаар
		оноо		
	Арга, аргачлал, төлөвлөлтгүй, дэвшилтэт аргачлал, техник технологийн шийдлийг үйл ажиллагаандаа тусгаагүй, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй	1-3		
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөлт, ажлын нэр төрөл, түүнд зарцуулах зардлын хэмжээ, хэрэгжүүлэх хугацааг харгалзан		0-6	
	Бүрэн хангалттай	6		
	Хангалттай	3		
	Хангалтгүй	0		
	Орон нутгийг хөгжүүлэх, хамтран ажиллах төлөвлөгөө		0-4	
	Энэхүү журмын 3.3.2.8 дугаар заалтыг хангасан	4		
	Энэхүү журмын 3.3.2.8 дугаар заалтыг хангаагүй	0		
2	Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал болон тэдгээрийн туршлага чадвар			11
	Төсөлд ажиллах Монгол ажилтнуудын эзлэх хувь 100% бол	3	1-3	
	Төсөлд ажиллах Монгол ажилтнуудын эзлэх хувь 90%-аас дээш бол	2		
	Төсөлд ажиллах Монгол ажилтнуудын эзлэх хувь 90% буюу түүнээс доош бол	1		
	Төсөлд МУ-ын зөвлөх геологич ажиллах бол	3	0-3	
	Төсөлд МУ-ын мэргэшсэн геологич ажиллах бол	2		
	Төсөлд МУ-ын зөвлөх болон мэргэшсэн геологич аль аль нь байхгүй бол	1		
	Төсөлд оролцох ИТАжилтан болон Геологичид нь 100 хувь үндсэн ажилтантай бол	5	1-5	
	Төсөлд оролцох ИТАжилтан болон Геологичид нь үндсэн болон гэрээт ажилчдаас бүрдэх бол	3-4		
	Төсөлд оролцох ИТАжилтан болон Геологичид нь 100 хувь гэрээт ажилтантай бол	2		
	Төсөлд ямар нэг тодорхой ИТАжилтан болон геологич тусгагдаагүй бол	1		
3	Геологи, хайгуулын ажлын болон үйл ажиллагааны туршлага			10
	Геологи, хайгуулын салбарт 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан бол	4	1-4	
	Геологи, хайгуулын 5-10-н жил үйл ажиллагаа явуулсан бол	2-3		
	Геологи, хайгуулын салбарт 5 хүртэл жил үйл ажиллагаа явуулсан бол	1		
	Бусад салбарт 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан бол	2	1-2	
	Бусад салбарт 5 хүртэл жил үйл ажиллагаа явуулсан бол	1		
	Геологи хайгуулын төсөл, үйл ажиллагааг бие даан явуулсан, хангалттай баялаг туршлагатай	3-4	1-4	
	Геологи хайгуулын төсөл, үйл ажиллагаа явуулсан болон туслан гүйцэтгэгчээр оролцож байсан	1-2		
4	Төсөлд ажиллах техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал			9
	Төсөл хэрэгжүүлэгч ААН геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өөрийн эзэмшлийн өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан бол	7-9	1-9	
	Төсөл хэрэгжүүлэгч ААН геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжийн 50-аас дээшгүй хувийг түрээсэлдэг бол	4-6		
	Төсөл хэрэгжүүлэгч ААН геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжийг бүгдийг түрээсэлдэг бол	1-3		
НИЙТ ОНОО				55

Дээрх шалгуур үзүүлэлтүүдийг Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/16 дугаар тушаалаар сонгон шалгаруулалтын оноонд өөрчлөлт оруулсан бөгөөд өөрчлөлтийг дараах Хүснэгт 5.18 байдлаар харуулав.

Хүснэгт 5.18 Сонгон шалгаруулалтын үнэлгээ

№	Шалгуур үзүүлэлт	Жишиг	Онооны хязгаар	Нийт онооны хязгаар
3	Геологи, хайгуулын ажлын болон үйл ажиллагааны туршлага			10
3.1	Геологи, хайгуулын салбарт 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан бол	4	1-4	
	Геологи, хайгуулын 5-10-н жил үйл ажиллагаа явуулсан бол	2-3		
	Геологи, хайгуулын салбарт 5 хүртэл жил үйл ажиллагаа явуулсан бол	1		
3.2	Бусад салбарт 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан бол	3	1-3	
	Бусад салбарт 6-10 жил үйл ажиллагаа явуулсан бол	2		
	Бусад салбарт 5 хүртэл жил үйл ажиллагаа явуулсан бол	1		
3.3	Геологи хайгуулын төсөл, үйл ажиллагааг бие даан явуулсан, хангалттай баялаг туршлагатай	3	1-3	
	Геологи хайгуулын төсөл, үйл ажиллагаа явуулсан болон туслан гүйцэтгэгчээр оролцож байсан	1-2		

Тайлбар: 3 дугаар хэсэгт УУХҮС-ын 2020 оны А/16 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсныг тусгав.

5.2.7.4 Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Монгол улсын Цөмийн энергийн тухай хуулиар энэ үйл ажиллагаа нь зохицуулагддаг ба тус хуулийн 18 дугаар зүйл “Тусгай зөвшөөрөл олгох журам”-аар нарийвчлан зохицуулагддаг ба дараах үе шатаар явагддаг. (Хүснэгт 5.19)

Хүснэгт 5.19 Цацрагт идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	Цөмийн энергийн комисс	Санал гаргана
2	Тагнуулын төв байгууллага	Санал гаргана
3	Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Санал гаргана
4	АМГТГ	Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу өргөдөл гаргахад бүрдүүлэх баримт бичгүүдийг шалгаж, тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага хангасан эсэхийг тодорхойлно.
5	АМГТГ	Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хувьд 1-3 сарын дотор, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хувьд 6-12 сарын дотор тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг шийдвэрлэнэ.
6	АМГТГ	Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө.
7	АМГТГ	Шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгүүлнэ.

Эх сурвалж: Цөмийн энергийн тухай хууль

Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага

- Техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан байх;

- Бүс нутгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачилгатай оролцдог байх;
- Компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаархи дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн байх;
- Үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх;
- Ажиллагсдын сургалт, дадлагын асуудлыг шийдэж ирсэн туршлагатай байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх санхүүгийн чадавхитай байх;
- Байгаль орчны болон биологийн нөхөн сэргээлт хийх санхүүгийн чадавхитай байх;
- Хариуцлагатай уул уурхайг хөтлөн явуулдаг, энэ талаар зохих туршлага хуримтлуулсан байх;
- Уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, шаардлагыг хангаж ажилладаг байх.

Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага

- Дээр дурдсан хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах бүх шаардлагуулыг хангах;
- Цацраг идэвхт ашигт малтмалыг энхийн зорилгоор, дэлхийн зах зээлийн үнэд хүргэж борлуулах чадвартай, санхүүгийн хувьд бүрэн бие даасан байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалт, борлуулалтаар дэлхийн зах зээлд тогтвортой, тэргүүлэх байр суурь эзэлсэн байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт хийх санхүүгийн чадавхитай байх;
- Цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах олон жилийн туршлагатай байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн ашиглах тэргүүний технологитой байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах, ашиглахдаа эдийн засгийн илүү үр ашигтай, дэвшилтэт технологи ашигладаг байх;
- Цөмийн технологи нэвтрүүлэх чадвартай байх.

5.2.7.5 Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь Монгол улсын Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагддаг. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь дараах (Хүснэгт 5.20) үе шатаар явагддаг. Үүнд:

Хүснэгт 5.20 Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдлийг бүртгэж, хүлээн авна.
2	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуульд заасан зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага, өргөдлийн материалын иж бүрдлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд бүртгэсэн дарууд нь анхан шатны шүүлт хийж, шаардлагыг хангаагүй бол өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, татгалзсан шалтгаан, үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэнэ.
3	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөлд дурдсан талбай нь ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон, түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай давхцаж байгаа эсэхийг тогтоолгох өргөдлийг холбогдох материалын хамт төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
4	Төрийн захиргааны байгууллага	Өргөдөлд дурдсан талбай, холбогдох баримтуудыг шалган үзээд, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой, эсхүл боломжгүй талаар мэдэгдэнэ.
5	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хэрэв төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл олгох боломжгүй талаар хариу ирвэл өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэнэ.
6	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хэрэв төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл олгох боломжтой талаар хариу ирвэл тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч ажлын 10 өдрийн дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох, эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
7	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хэрэв тусгай зөвшөөрөл олгогдохоор шийдэгдвэл тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлөх тухай өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.
8	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хэрэв тусгай зөвшөөрөл олгогдохоор шийдвэр гарснаас хойш өргөдөл гаргасан этгээд нэг сарын дотор тусгай зөвшөөрлийг аваагүй, эсхүл эхний жилийн төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлөөгүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга өргөдлийг бүртгэлээс хасаж өргөдөл гаргасан этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэнэ.
9	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хэрэв өргөдөл гаргасан этгээд эхний жилийн төлбөрийг хуульд заасан хугацаанд төлсөн бол ажлын таван өдөрт багтаан түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно.
10	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, тухайн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай байрших аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагад түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон тухай мэдэгдэнэ.
11	Төрийн захиргааны байгууллага	Хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

Эх сурвалж: Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах эрхтэй байдаг. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь дараах (Хүснэгт 5.21) үе шатаар явагддаг. Үүнд:

Хүснэгт 5.21 Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдлийг бүртгэж, хүлээн авна.
2	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудас тус бүрд бүртгэлийн он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгнө.
3	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөл бүртгэсэн даруйд өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд анхан шатны шүүлт хийнэ.
4	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь хуульд заасан шаардлагыг хангаагүй бол өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, татгалзсан шалтгаан, үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэнэ.
5	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлөөр олгогдсон талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан бол өргөдөл гаргасан талбай нь хайгуулын талбайн хилийн дотор бүрэн багтаж байгаа эсэхийг тодруулна.

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
6	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөл гаргасан талбай нь тусгай хэрэгцээ болон нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай ямар нэгэн байдлаар давхцаж байгаа эсэхийг тодруулна.
7	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хайгуулаар тогтоогдсон ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсч болох байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлцэх эсэхийг тодруулна.
8	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 15 өдөрт багтаан доор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.
9	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлүүлнэ.
10	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Өргөдөлд дурдсан талбай нь ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайн аль нэг хэсэгтэй давхцсан бол ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, татгалзсан шалтгаан үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, энэ тухай өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэнэ.

Эх сурвалж: Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль

Тусгай зөвшөөрлийн өргөдлийн статистик мэдээлэл

Тусгай зөвшөөрөл авахаар гаргасан өргөдлийн статистик мэдээллийг сүүлийн 8 жилээр харьцуулан Хүснэгт 5.22-т харуулав.

Хүснэгт 5.22 Тусгай зөвшөөрөл авахаар гаргасан өргөдөл

Өргөдлийн төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
БҮГД	1,050	626	791	3,002	613	813	1,187	698
Шинээр авах	114	102	113	2,522	131	288	226	218
а. Ашиглалтын	114	102	98	87	103	65	78	73
б. Хайгуулын	-	-	-	2,335	-	-	-	-
в. Сонгон шалгаруулалтын	-	-	15	100	28	223	148	145
Сунгуулах	586	305	453	249	173	231	657	273
Шилжүүлэх	187	10	53	92	139	153	157	72
а. Ашиглалтын	43	10	36	52	49	78	25	24
б. Хайгуулын	144	-	17	40	90	75	132	48
Барьцаалах	50	67	44	22	33	37	61	25
а. Ашиглалтын	39	47	40	22	30	32	58	24
б. Хайгуулын	11	20	4	-	3	5	3	1
Талбай буцаах	113	142	128	117	137	104	86	110
а. Ашиглалтын	7	18	12	24	26	14	12	12
б. Хайгуулын	106	124	116	93	111	90	74	98

Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 12, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

Тайлант хугацаанд сонгон шалгаруулалтад оролцсон аж ахуй нэгжийн жагсаалтыг Хавсралт 16(м)-ээс харна уу.

5.2.7.6 2019 онд шинээр олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүд (шаардлага 2.2.a.iii)

Лиценз эзэмшигчдийн бүх өөрчлөлтийн дэлгэрэнгүйг ОУИТБС-ын тайланд тусгах нь Стандартын шаардлага юм. АМГТГ-ын олон нийтэд мэдээлсэн уул уурхай, геологийн статистик мэдээлэлд тусгай зөвшөөрлийн статистик мэдээлэл нь бидэнд гаргаж өгсөн мэдээллээс зөрүүтэй байсан. Энэ талаар 2015 оны нэгтгэлийн тайланд дэлгэрэнгүй тайлбарласан.

АМГТГ-аас бидэнд өгсөн мэдээллээр 2019 онд шинээр олгосон ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл 59, хайгуулын тусгай зөвшөөрөл олгоогүй байсан бөгөөд нийт шилжүүлсэн тусгай зөвшөөрөл 71, цуцалсан болон хүчингүй болсон тусгай зөвшөөрөл 189 байсан. АМГТГ-ын олон нийтэд мэдээлсэн уул уурхай, геологийн статистик мэдээлэлд дараах (Хүснэгт 23) байдлаар тусгагдан байна. Үүнд:

Хүснэгт 5.23 Шинээр олгосон, шилжүүлсэн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл

Бүртгэлийн төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Шинээр олгосон	95	72	113	827	750	151	85	130
а.Ашиглалт	95	72	97	91	93	77	61	59
б.Хайгуул	-	-	2	697	629	41	5	-
в.Сонгон шалгаруулалт	-	-	14	39	28	33	19	71
Талбай буцаасан	141	146	119	150	166	97	91	93
а.Ашиглалт	7	16	13	25	25	13	11	11
б.Хайгуул	134	130	106	125	141	84	80	82
Цуцалсан/Хүчингүй	270	347	123	173	241	237	181	189
а.Ашиглалт	139	43	14	10	37	35	33	70
б.Хайгуул	131	304	109	163	204	202	148	119
Дуусгавар болсон	175	253	289	179	124	176	209	199
Шилжүүлсэн	200	8	51	88	146	136	172	71
а.Ашиглалт	47	8	38	46	50	62	38	24
б.Хайгуул	153	-	13	42	96	74	134	47
Сунгуулсан	601	317	444	336	167	162	566	300
Барьцаалсан	38	61	40	22	29	39	56	24
а.Ашиглалт	22	42	34	22	27	34	53	23
б.Хайгуул	16	19	6	-	2	5	3	-
Барьцаа чөлөөлсөн	42	31	29	24	16	39	27	31
а.Ашиглалт	15	29	24	19	12	38	26	30
б.Хайгуул	27	2	5	5	4	1	1	1
Нөхөн олгосон	56	15	11	19	35	26	40	27
а.Ашиглалт	16	9	7	10	15	19	13	14
б.Хайгуул	40	6	4	9	20	7	27	13

Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 12, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

2019 оны жилийн эцсийн байдлаар ашигт малтмалын 10 ба түүнээс дээш тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалтыг дараах Хүснэгт 5.24-өөс харна уу.

Хүснэгт 5.24 Ашигт малтмалын 10 ба түүнээс дээш тусгай зөвшөөрөл эзэмшигчид

№	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ	Хуулийн этгээдийн ангилал	Хөрөнгө оруулагч улс
1	Монголросцветмет	26	15,086.00	Дотоодын А.А.Н	Монгол
2	Монголын алт МАК	22	60,037.60	Дотоодын А.А.Н	Монгол

№	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ	Хуулийн этгээдийн ангилал	Хөрөнгө оруулагч улс
3	Гацуурт	17	9,557.30	Дотоодын А.А.Н	Монгол
4	Цайна инвестмент монголиа	15	207,645.00	Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай	Сингапур
5	Олон-Овоот гоулд	14	90,111.60	Дотоодын А.А.Н	Монгол
6	Гобикоул энд энерги	12	7,139.80	Дотоодын А.А.Н	Монгол
7	Хүннү говь алтай	12	2,206.70	Дотоодын А.А.Н	Монгол
8	Платинумланд	11	3,621.30	Дотоодын А.А.Н	Монгол
9	МОЭНКО	10	12,807.40	Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай	Сингапур
10	Эрэл	10	10,960.90	Дотоодын А.А.Н	Монгол
11	МАК Цемент	10	3,745.90	Дотоодын А.А.Н	Монгол

Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 11, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

2019 оны жилийн эцсийн байдлаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий 100,000 ба түүнээс дээш гектар талбайг эзэмшигчдийн жагсаалтыг дараах Хүснэгт 5.25-аас харна уу.

Хүснэгт 5.25 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, гектар

№	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ	Хуулийн этгээдийн ангилал	Хөрөнгө оруулагч улс
1	Цайна инвестмент монголиа	15	207,645.00	Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай	Сингапур
2	Монгол ураниум ресурс	3	154,746.30	Дотоодын А.А.Н	Монгол
3	Монлаа	4	108,679.00	Дотоодын А.А.Н	Монгол

Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 11, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

АМГТГ-аас мэдээлснээр 2019 онд сонгон шалгаруулалтын бус замаар (шууд гэрээ, хэлэлцээр хийх замаар) олгосон тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 6-р дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 26-р тэмдэглэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 1/1929 тоот албан бичгийн дагуу Хайгуулын Салхит талбай дээр тусгай зөвшөөрлийг Эрдэнэс силвер ресурс ХХК-д олгов.
- Засгийн газрын 2019 оны 6-р сарын 12-ны өдрийн хуралдааны 26-р тэмдэглэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 1/1929 албан тоотыг үндэслэн Хайгуулын Баруун Хонгор талбай дээр тусгай зөвшөөрлийг Эрдэнэс Монгол ХХК-д тусгай зөвшөөрөл олгов. Дэлгэрэнгүй мэлээллийг Хавсралт 16(ө) – ээс харна уу.

5.2.7.7 Тусгай зөвшөөрлийн ил тод байдал (шаардлага 2.3)

АМГТГ-ын кадастрын цахим хуудсанд (<http://cmcs.mram.gov.mn/cmcs#c=License>) одоогийн хүчин төгөлдөр байгаа 2,652 тусгай зөвшөөрлийн мэдээллийг нийтэд ил болгосон байна. Харин ураны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээллүүдийг оруулаагүй байна.

МОУИТБС-ын Ажлын алба цахим хуудсанд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг нийтэд ил болгодог. 2020 оны 03 дугаар сарын байдлаар нийт 3,266 тусгай зөвшөөрлийн мэдээллүүдийг оруулсан байгаа бөгөөд тооны зөрүүтэй байгаа нь өнөөдрийн байдлаар шинэчлэлт хийгдээгүй байна.

Мөн цахим хуудасны “Ил тодын шигтгээ” цэсний хэсэгт 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх тусгай зөвшөөрлүүдийн статистик тойм мэдээллүүдийг харуулсан ба мэдээллээ шинэчлээгүй байна. Мөн тус цэсний бүтээгдэхүүн борлуулалт, татвар төлөлт гэх мэт мэдээллийн хэсгүүд нь 2012 оноос шинэчлэгдээгүй, мөн тус цахим хуудасны зарим хэсэг нь ажиллагаагүй байна.

5.3 АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТ (ШААРДЛАГА 3.1)

5.3.1. Ашигт малтмалын хайгуул

Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд гүйцэтгэсэн геологи хайгуулын ажил

Төрөө эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого болон Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан геологийн суурь судалгааны ажлуудыг 2016 онд 9.3, 2017 онд 13.1, 2019 онд 23.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2019 оны байдлаар хийсэн хайгуулын ажлын төслийг дараах байдлаар харуулав³.

- Монгол улсын нутаг дэвсгэрийн 40.5 хувийг 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар бүрхэж тухайн газрын геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг тодорхойлж, хэтийн төлөвийн үнэлгээг өгсөн бөгөөд 5 хувьд энэ төрлийн судалгааны ажлыг гүйцэтгэж байна.
- Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлыг нутаг дэвсгэрийн 94 хувьд гүйцэтгэн үр дүнгийн тайланг хүлээн авч нэгдсэн мэдээллийн санг үүсгээд байна. Үлдсэн 6 хувьд судалгааны ажлыг гүйцэтгэн үр дүнгийн тайланг хүлээн авахаар ажиллаж байна. Мөн 2016 оноос дээрх судалгааны ажлуудыг К, L, M хавтгай хэмжээнд нэгтгэх ажлыг хэрэгжүүлж байна.
- Сэдэвчилсэн судалгааны ажлын хүрээнд “Голлох ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа”-г улсын хэмжээнд хэрэгжүүлснээр олон тооны орд, илрэл, эрдэсжсэн цэгүүдийг шалган үнэлгээг хийсэн.
- Алт-2 үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол орны төв, зүүн бүс болон баруун, баруун өмнө, хангайн бүсийн алтны хүдэржилт, хэтийн төлөвийн судалгааг хэрэгжүүлснээр олон тооны алтны үндсэн болон шороон орд, илрэл, эрдэсжсэн цэгийг шалган үнэлгээ хийсэн. Энэхүү судалгааны ажлын үр дүнгийн тайланг хүлээн авснаар дээрх 2 бүсийн хэмжээнд алтны хэтийн төлөвийн үнэлгээ тодорхой болно.
- Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын 5 сувгын судалгааны ажлыг улсын баруун өмнөд хэсэгт Алтай-1, Алтай-2 нэртэйгээр хэрэгжүүлэн үр дүнгийн тайланг хүлээн авсан. Судалгааны ажлын үр дүнд тухайн бүс нутгаар хар болон өнгөт, үнэт металлын хэтийн төлөвтэй орд илрүүлэх шалгуур үзүүлэлтийг тогтоож, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл тодорхой болсон.
- Геохимийн 1:1000000-ын масштабын зураглалын ажлыг Монгол орны нутаг дэвсгэрийн 1,148,729 км² талбайд гүйцэтгэхээр судалгааны ажлыг эхлүүлсэн.
- Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтоогдсон ашигт малтмалын төрлүүдийг тектоник, металлогени болон бусад геологийн хүчин зүйлс, дэд бүтэц зэрэг нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүдтэй хамтатган судалж, өнөөдрийн нөхцөлд стратегийн ашигт малтмал гэж авч үзэх төрлүүдийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн тодорхойлох, үнэлэлт, дүгнэлт өгөх, энэхүү судалгааны үр дүнд дэлхийн түүхий эдийн зах зээл дээр эрэлт ихтэй өндөр технологийн болон энергийн түүхий эдийг нарийвчлан судалж, экспортын чиг хандлагыг тодорхойлох суурь судалгааны ГАСАМ төслийг хэрэгжүүлж эхэлсэн.
- Улаанбаатар, Эрдэнэт хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд эвдэрсэн газар, агаар, хөрс, усны бохирдлын хэмжээ, бохирдуулагч элементийн тархалтыг тодорхойлох судалгааг хэрэгжүүлж шинжлэх ухааны дүгнэлт, зөвлөмж өгөхөөр ажиллаж байна.

³ УУХҮЯ

Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн геологи, судалгааны ажлын сүүлийн 5 жилийн тойм статистик мэдээллийг харуулбал дараах байдалтай байна (Хүснэгт 5.26). Үүнд:

Хүснэгт 5.26 Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн геологи, судалгааны ажил

Ажлын төрөл	2015		2016		2017	
	Сая.төг	Гүйцэтгэл	Сая.төг	Гүйцэтгэл	Сая.төг	Гүйцэтгэл
БҮГД	9,280.60	82%	9,341.10	100%	12,255.10	91.80%
УГЗ 1:200000	330.5	63%	642.7	100%	482.3	100%
1:50000 ГЗЕЭА	5,556.70	78%	4,975.80	100%	5,355.87	100%
Сэдэвчилсэн ажил	3,167.70	92%	3,476.10	100%	6,274.57	80.80%
Хамтын ажиллагааны төсөл	225.6	79%	246.6	100%	142.4	100%

Ажлын төрөл	2018		2019	
	Сая.төг	Гүйцэтгэл	Сая.төг	Гүйцэтгэл
БҮГД	13,335.00	100%	24,621.00	100%
УГЗ 1:200000	408.5	100%	753	100%
1:50000 ГЗЕЭА	4,692.70	100%	8,115.10	100%
Сэдэвчилсэн ажил	8,144.10	100%	15,471.60	100%
Хамтын ажиллагааны төсөл	90	100%	281.3	100%

Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 13, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

Хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хайгуулын үйл ажиллагаа

Тусгай зөвшөөрлийн талбайд хувийн хөрөнгөөр гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэсэн тайлан, зардал хянуулсан, баталгаажуулсан байдлын хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс жил бүрийн хайгуулын ажлын төлөвлөгөө, 48.1.2-д заасны дагуу хайгуулын ажлын жил тайланг хүлээн авч хянах бөгөөд 33.1, 33.2-т заасны дагуу хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянаж, санхүүгийн жилийн тайлан тэнцэлд тулгуурлан баталгаажуулдаг.

2019 оны хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, тайлан ирүүлсэн болон хайгуулын зардал баталгаажсан тусгай зөвшөөрлийн тоо ил тод болоогүй тул 2018 оноор авч дараах Хүснэгт 5.27-д харуулж байна.

Хүснэгт 5.27 Хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан, зардал баталгаажсан тусгай зөвшөөрөл

	2015	2016	2017	2018
Төлөвлөгөө				
Ирүүлэх ёстой	1,345	2,051	1,748	1,695
Ирүүлсэн	1,307	1,750	1,724	1,674
Ирц %	97.20%	85.30%	98.60%	98.80%
Тайлан				
Ирүүлэх ёстой	1,802	1,974	1,745	1,408
Ирүүлсэн	1,260	1,666	1,546	1,300
Ирц %	69.90%	83.00%	88.50%	92.30%
Хайгуулын ажлын тайлангийн зардлын доод хэмжээг хянасан хувь	97.00%	99.70%	98.00%	10.00%
Зардал санхүүгийн тайлангаар баталгаажсан хувь	91.70%	94.90%	90.80%	8.00%

Эх сурвалж: 2018 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 15, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

Тайлант 2019 онд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид геологи, хайгуулын ажилд урьдчилсан тооцоогоор 87.2 сая төгрөг зарцуулсан ба гүйцэтгэсэн ажлын төрлөөр нь сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг харьцуулбал дараах байдалтай байна (Хүснэгт 5.28). Үүнд:

Хүснэгт 5.28 Геологи, хайгуулын ажилд зарцуулсан, гүйцэтгэсэн ажлын төрлөөр

Ажлын төрөл	2015 (Сая ₮)	2016 (Сая ₮)	2017 (Сая ₮)	2018 (Сая ₮)	2019 (Сая ₮)
Бэлтгэл ажил	2,998.70	8,924.20	3,615.20	3,447.80	2.60
Зураглалын ажил	2,314.20	5,815.30	1,886.10	3,444.10	1.00
Эрлийн маршрут	2,789.20	6,383.50	2,334.60	2,746.30	1.30
Сорьцлолт	2,047.10	32,645.90	80,896.60	11,786.90	1.50
Геофизикийн ажил	10,716.50	9,826.50	15,008.90	10,461.70	4.10
Уулын ажил	2,784.20	1,697.10	-	15,257.00	4.70
Өрөмдлөг	49,794.50	68,917.00	5,825.90	75,064.20	49.40
Геохимийн ажил	779.10	-	-	-	-
Лаборатори	6,710.60	8,833.10	11,413.40	12,601.00	9.10
Топогеодезийн ажил	1,638.30	2,248.60	5,518.10	1,621.30	2.80
Гидрогеологийн ажил	2,549.90	1,174.10	943.70	1,442.80	0.80
Геоэкологийн судалгаа	-	-	-	823.20	2.80
Тээвэр	3,112.80	17,331.00	341.40	3,761.30	-
Суурин боловсруулалт	11,055.00	11,685.70	1,120.40	1,118.20	0.30
Байгаль орчны нөхөн сэргээлт	1,749.60	1,346.90	348.30	378.40	0.30
Талбайн сорьцлолт	1,246.90	2,101.30	929.40	1,674.90	0.80
Геоморфологи	20.60	-	-	-	-
Археологи, палентологийн судалгаа	140.10	231.20	162.20	6,638.40	0.50
Магадлашгүй зардал	-	-	-	173.20	5.00
Бусад	4,791.00	11,098.50	242.40	852.30	0.20
БҮГД	107,238.30	190,259.90	130,586.60	153,292.90	87.20

Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 14, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

*Жич: 2019 оны зардлын мэдээлэл үргэлжлэн хянагдаж байгаа тул урьдчилсан тооцоогоор тусгав. Эх сурвалж: АМГТГ

5.3.2 Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Монгол улсын уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2019 онд ерөнхийдөө өсөлттэй байж, тус салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь 23.7 хувь, Аж үйлдвэрийн салбарт эзлэх хувь 71.8 хувь байсан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах Хүснэгт 5.29-ээр харуулж байна.

Хүснэгт 5.29 Уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ДНБ, хувиар

	2016	2017	2018	2019
ДНБ	23,942.90	27,876.30	32,411.20	36,897.60
Уул уурхай, олборлох (үнээр)	4,817.30	6,543.40	7,721.00	8,779.20
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл	9,927.20	12,938.60	15,619.90	17,371.40
Уул уурхай, олборлох үйлдвэрлэл	7,067.40	9,388.80	11,223.90	12,467.10
АҮ-ийн нийт үйлдвэрлэлд УУҮ-ийн эзлэх хувь	71.2%	72.6%	71.9%	71.8%
ДНБ-д УУҮ-ийн эзлэх хувь	20.1%	23.5%	23.8%	23.8%

Эх сурвалж: ДНБ, Аж үйлдвэрийн салбар, 2019 он, Монголын Үндэсний Статистикийн Хороо

АМГТГ-ын 2019 оны статистик мэдээлэлд үндэслэн хүснэгтээр сүүлийн 6 жилийн Нүүрсний олборлолт, борлуулалт болон экспортын мэдээг харуулж байна.

Хүснэгт 5.30 Нүүрсний олборлолт, борлуулалт болон экспорт, нэгжээр

Он	Хөрс хуулалт (мян.м.куб)	Олборлолт (мян.тн)	Борлуулалт (мян.тн)	Экспорт (мян.тн)
2014	95,600.0	24,449.0	27,305.0	19,513.0
2015	92,975.0	23,979.0	22,125.0	14,468.0
2016	102,374.3	35,096.5	33,831.7	25,809.3
2017	197,240.8	49,480.3	41,904.6	33,400.1
2018	244,861.2	54,572.3	45,741.9	36,671.4
2019	292,181.7	57,128.8	47,047.8	36,809.1

Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 21, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

Хүснэгт 5.31-ээр 2019 оны Нүүрсний нийт борлуулалтын мэдээг нүүрсний төрлөөр нь харуулж байна.

Хүснэгт 5.31 Нүүрсний нийт борлуулалт, нүүрсний төрлөөр

Нүүрсний төрөл	Экспорт (мян.тн)	Дотоодын борлуулалт (мян.тн)	Бүгд (мян.тн)
Чулуун баяжуулсан коксжих	6,846.0	-	6,846.0
Чулуун түүхий коксжих	16,797.1	-	16,797.1
Чулуун сул коксжих	8,699.3	-	8,699.3
Чулуун эрчим хүчний	4,466.7	-	4,466.7
Чулуун болон хүрэн	-	10,238.7	10,238.7
Бүгд	36,809.1	10,238.7	47,047.8

Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 21, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр Хүснэгт 5.32-д харуулж байна. Үүнд:

Хүснэгт 5.32 Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, нэгжээр

№	Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2019	% өөрчлөлт
1	Чулуун нүүрс	мян.тн	18,471.7	29,339.6	40,707.4	43,353.9	48,448.5	12%
2	Хүрэн нүүрс	мян.тн	5,677.2	6,149.3	6,394.0	6,655.4	7,350.9	10%
3	Зэсийн баяжмал (метал агуулгаараа)	мян.тн	1,334.7	1,445.1	1,317.1	1,310.8	1,262.4	-4%
4	Төмрийн хүдэр	мян.тн	4,273.6	4,936.2	7,694.7	6,225.4	8,572.2	38%
5	Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	6,899.8	2,209.9	3,675.0	3,405.5	3,386.4	-1%
6	Алт	кг	14,532.8	18,435.7	19,849.0	20,655.2	16,251.3	-21%
7	Хайлуур жонш	мян.тн	183.5	167.7	108.9	101.2	156.1	54%
8	Хайлуур, жоншны баяжмал	мян.тн	47.3	34.1	55.2	80.7	47.5	-41%
9	Цайрын баяжмал	мян.тн	89.6	100.2	82.7	87.9	83.1	-5%
10	Молибдений баяжмал (метал агуулгаараа)	тн	5,207.0	5,174.4	5,759.6	5,486.1	5,302.8	-3%
11	Гянтболдын баяжмал	тн	1,024.0	710.2	623.1	434.9	441.3	1%

Эх сурвалж: Аж үйлдвэрийн салбар, хуудас 25, 2019 он, Үндэсний статистикийн хороо

Сүүлийн 5 жилийн уул уурхай олборлолтын мөнгөн дүнг Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр Хүснэгт 5.33-д харуулав.

Хүснэгт 5.33 Уул уурхай олборлолт, сая төгрөгөөр

№	Ашигт малтмалын төрөл	2015	2016	2017	2018	2019	% өөрчлөлт
1	Металлын хүдэр олборлолт	5,863,579.5	5,891,282.7	6,685,608.2	7,914,168.9	8,189,457.6	3%
2	Нүүрс олборлолт	952,491.7	1,612,627.3	3,880,567.2	5,312,415.8	6,832,966.9	29%
3	Газрын тос олборлолт	834,989.5	722,820.5	897,804.3	953,258.3	980,487.8	3%
4	Уул уурхай, олборлолтын туслах бусад үйл ажиллагаа	361,648.0	347,637.2	402,940.9	704,260.6	782,774.0	11%
5	Бусад ашигт малтмал олборлолт	141,855.0	137,046.8	231,878.8	464,514.8	516,300.5	11%
Нийт уул уурхайн олборлолт		8,154,563.6	8,711,414.4	12,098,799.3	15,348,618.5	17,301,986.9	

Эх сурвалж: 2019 оны статистикийн эмхэтгэл, хуудас 738, Үндэсний статистикийн хороо

АМГТГ нь уул уурхайн байгууллагуудаас ирсэн тайланд үндэслэн бүтээгдэхүүний олборлолтын хэмжээг тооцдог бөгөөд энэ нь бусад эх үүсвэрээс гарсан мэдээлэлтэй зөрөх магадлалтай юм. 2019 онд Ашигт малтмалын тухай хуулийн дагуу тухайн оны Ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа (АМАҮА)-ны 227 тайлан ирүүлсэн бөгөөд 187 тайлан баталгаажсан. Уг АМАҮА тайланд үндэсдэл 2019 оны эцсийн байдлаар баяжуулах болон боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалтын мэдээг Хүснэгт 5.34-т харуулж байна.

Хүснэгт 5.34 Баяжуулах болон боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалт, нэгжээр

№	Ашигт малтмалын төрөл	Боловсруулсан хүдэр, элсний хэмжээ		Бүтээгдэхүүн гаргалт	
		Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга
1	АЛТ (Нийт)	-	-	кг	14,550.5
	АЛТ (Баяжмалд дагалдан гарч байгаа алтны хэмжээ)	-	-	кг	7,615.5
	АЛТ (Үндсэн болон шороон ордоос олборлох нийт алтны хэмжээ)	-	-	-	6,935.0
	АЛТ (Үндсэн ордоос олборлох алтны хэмжээ)	мян.тн	4,998.7	-	2,045.0
	АЛТ (Шороон ордоос олборлох алтны хэмжээ)	мян.м ³	7,517.9	кг	4,890.1
2	БАРИЛГЫН МАТЕРИАЛ	-	-	-	-
	Цемент	мян.тн	2,311.3	мян.тн	1,706.7
	Шохой	-	-	мян.тн	55.6
	Шохойн чулуу	-	-	мян.тн	412.4
3	ГӨЛТГӨНӨ	мян.тн	189.4	тн	107.1
4	ГЯНТБОЛД	-	291.2	-	165.5
5	ЗЭС	мян.тн	73,033.9	мян.тн	1,259.5
6	ЗЭС (КАТОД)	мян.тн	9,549.1	мян.тн	9.7
7	МОЛИБДЕНИ	мян.тн	32,200.0	мян.тн	5.3
8	МӨНГӨ	-	-	кг	2,972.6
9	МӨНГӨ (Баяжмалд дагалдан гарч байгаа мөнгөний хэмжээ)	-	-	кг	76,891.6
10	ӨНГӨЛГӨӨНИЙ ЧУЛУУ	мян.тн	5,579.8	тн	369.9
11	ТӨМӨР	мян.тн	15,305.8	мян.тн	9,623.7
	Төмрийн бүхэллэг баяжмал	-	-	мян.тн	1,372.8
	Төмрийн нунтаг баяжмал	-	-	мян.тн	2,549.7
	Төмрийн бүхэллэг хүдэр	-	-	мян.тн	2,226.9
	Төмрийн нунтаг хүдэр	-	-	мян.тн	3,474.3
12	ХАЙЛУУР ЖОНШ	мян.тн	717.4	мян.тн	344.5
	Хайлуур жоншны баяжмал ФФ-97	-	-	мян.тн	58.3
	Хайлуур жоншны баяжмал ФФ-95	-	-	мян.тн	26.7
	Бүхэллэг жонш ФК-92	-	-	мян.тн	2.8
	Бүхэллэг жонш ФК-85	-	-	мян.тн	3.5

№	Ашигт малтмалын төрөл	Боловсруулсан хүдэр, элсний хэмжээ		Бүтээгдэхүүн гаргалт	
		Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга
	Бүхэллэг жонш ФК-80	-	-	мян.тн	1.1
	Бүхэллэг жонш ФК-75	-	-	мян.тн	32.7
	Бүхэллэг жонш ФК-65	-	-	мян.тн	15.1
	Хайлуур жоншны хүдэр ФР	-	-	мян.тн	204.3
13	ХАР ТУГАЛГА	мян.тн	839.3	мян.тн	29.6
14	ЦАГААН ТУГАЛГА	мян.м³	57.4	тн	26.4
15	ЦАЙР	мян.тн	1,511.9	мян.тн	123.7

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар, УУХҮЯ

5.3.3 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт (Шаардлага 6.3.с)

Тайлант оны нийт экспортын хэмжээ өмнөх оныхоос 8.7 хувиар өсч сүүлийн 10 жилд хамгийн өндөр дүнд буюу 7.6 тэрбум ам. долларт хүрсэн. Энэ өсөлт нь уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспортын өсөлтөөс шууд хамааралтай байсан.

Уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний сүүлийн 5 жилийн экспортын хэмжээ болон дүнг Хүснэгт 5.35-д харуулав.

Хүснэгт 5.35 Уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний экспорт, нэгжээр, сая ам.доллараар


Ашигт малтмалын бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2019
Чулуун нүүрс	мян.тн	14,426.3	25,713.9	32,990.9	35,758.2	36,466.8
	сая ам.доллар	555.0	971.8	2,256.7	2,786.2	3,074.4
Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн	1,477.8	1,562.0	1,447.2	1,436.7	1,403.6
	сая ам.доллар	2,280.1	1,607.8	1,613.1	2,012.2	1,795.9
Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн	5,065.1	6,084.8	6,258.0	7,449.1	8,448.8
	сая ам.доллар	227.2	249.9	313.4	342.2	576.4
Боловсруулаагүй, хагас боловсруулсан алт	кг	11,343.2	19,168.5	14,554.5	3,431.9	9,069.5
	сая ам.доллар	420.6	758.4	595.4	144.5	418.4
Жонш	мян.тн	280.1	248.8	319.3	555.2	700.1
	сая ам.доллар	65.5	59.0	84.2	189.9	205.5
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	84.1	126.0	118.2	123.9	134.8
	сая ам.доллар	101.7	145.4	180.8	197.8	189.0
Молибдены хүдэр, баяжмал	мян.тн	5.0	5.8	6.5	6.0	5.7
	сая ам.доллар	29.5	26.4	37.4	49.9	49.0
Гянт болдын хүдэр, баяжмал	мян.тн	1.7	1.5	1.0	0.8	0.7
	сая ам.доллар	13.5	10.5	8.1	8.8	6.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

<https://www.customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info&pid=0&id=131>

Эрдэс бүтээгдэхүүний экспортын борлуултын дүнгээр (сая ам.доллараар) сүүлийн 5 жилээр харьцуулан дараах Зураг 5.6-д харууллаа.

Зураг 5.6 Эрдэс бүтээгдэхүүний экспортын борлуулт, төрлөөр, сая ам.доллараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Дээрх уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний экспортын борлуулалтыг улсаар нь харьцуулахад 2019 оны экспортын дийлэнх хэсэг буюу 91.3 хувийг БНХАУ-руу, үүний дараа 4.1 хувийг Их Британи Улсруу экспортлосон байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 5.36-аас харах боломжтой.


Хүснэгт 5.36 Уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний экспорт, улсаар

№	Улс	Гол нэр төрлийн ашиг малтмал	Хэмжих нэгж	2017		2018		2019	
				Тоо хэмжээ	Үнэ (сая ам.доллар)	Тоо хэмжээ	Үнэ (сая ам.доллар)	Тоо хэмжээ	Үнэ (сая ам.доллар)
1	БНХАУ	Чулуун нүүрс	мян.тн	32,292	2,187,781	35,361	2,754,550	35,798	3,014,307
		Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн	1,447	1,613,117	1,429	2,000,538	1,404	1,795,868
		Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн	6,258	313,363	7,449	342,186	8,449	576,412
		Бусад ашигт малтмал	мян.тн	259	256,752	494	370,087	672	381,024
		Дүн			4,371,014		5,467,361		5,767,611
		Нийт экспортонд эзлэх %		85.9%		95.4%		91.3%	
2	Их Британи	Чулуун нүүрс	мян.тн	490	55,391	98	12,076	333	35,838
		Боловсруулаагүй, хагас боловсруулсан алт	кг	14,551	595,216	3,432	144,499	4,976	225,728
		Дүн			650,607		156,575		261,566
		Нийт экспортонд эзлэх %			12.8%		2.7%		4.1%

Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Эрдэс бүтээгдэхүүний экспортын хэмжээгээр (сая тонноор) сүүлийн 3 жилээр харьцуулан дараах Зураг 5.7-д харууллаа.

Зураг 5.7 Эрдэс бүтээгдэхүүний экспорт, сая тонноор



Эх сурвалж: ДНБ 2019 он, Монголын Үндэсний Статистикийн Хороо

5.4 ГАЗРЫН ТОС БОЛОН БАЙГАЛИЙН ХИЙ

5.4.1. Газрын тосны тухай тойм

Монгол Улсын Дорноговь аймгийн Сайншанд хотоос зүүн хойш 18 км-т Алтанширээ сумын нутаг дэвсгэрт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн гаднах дэд бүтцийг 2019 оны 10 дугаар сарын 8-ны өдөр ашиглалтад хүлээн авч, барилга угсралт, хөрөнгө оруулалтыг албан ёсоор эхэлээд байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд 27км төмөр зам, 17,2 км хүнд даацын авто зам барьж, улсын чанартай төв автозам болон төмөр замтай холбожээ. Мөн 110 кВт-ын эрчим хүчний агаарын дамжуулах шугам барьж, үйлдвэрийн талбайг бэлтгэх, тэгшлэх ажлыг гүйцэтгэсэн байна. Монгол Улсад одоогийн байдлаар нийт 32 тусгай зөвшөөрөлтэй газрын тосны талбай байдгаас өнөөдрийн байдлаар 25 талбайд 21 гэрээлэгч БХГ байгуулан, Засгийн газраар батлуулан ажиллаж байна. Үүнээс олборлолтын үйл ажиллагаа явуулж буй 3 талбай, хайгуулын үйл ажиллагаа явуулж буй 22 талбай, үлдсэн талбайд эрлийн үйл ажиллагаа явуулж байна. Газрын тос олборлож буй 3 талбайд 2 компани үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Пэтрочайнагийн охин компани болох “Пэтрочайна Дачин Тамсаг” ХХК нь газрын тосны дийлэнх хувийг олборлож экспортод гаргадаг.

Одоогийн байдлаар Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр, тоног төхөөрөмж байхгүйн улмаас олборлосон газрын тосыг түүхий газрын тос хэлбэрээр экспортолж байна. Монгол Улс дотоодын хэрэгцээний газрын тосны бүтээгдэхүүнээ ихэвчлэн ОХУ-аас импортолдог.

2019 оны байдлаар манай улс цахилгаан эрчим хүчний 80.0 хувийг дотооддоо үйлдвэрлэж, 20.0 хувийг БНХАУ болон ОХУ-аас импортоор авч, нийт олборлосон газрын тосны 95.2 хувийг түүхийгээр экспортолж байна. *Эх сурвалж: Монгол Улсын Үндсэний Статистикийн хороо*

Хүснэгт 5.37 Газрын тосны олборлолт явуулж байгаа компанийн талбайн мэдээлэл

Д/д	Ашиглалтын талбайн нэр	Гэрээлэгч компани	Гэрээ байгуулсан огноо
1	Тосон-Уул XIX	Петросайна Дачин Тамсаг ХХК	1993/04/26
2	Тамсаг-XXI		1995/12/11
3	БХГ-97	Доншен газрын тос Монгол ХХК	1997/01/24

Тосон-Уул-ХIХ, Тамсаг-ХХI талбайд “Петрочайна дачин тамсаг” ХХК, БХГ-97 талбайд “Доншен газрын тос Монгол” ХХК тус тус газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж байна (Хүснэгт 5.37).

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК: Хятадын Үндэсний газрын тосны корпорацийн харьяа төрийн өмчит “Дачин Ойл Фийлд Лимитед” компани нь 2005 оны 8 дугаар сард Тамсагийн сав газрын ХIХ, ХХI, ХХII гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах БХГ-ний эрх үүргийг АНУ-ын “СОКО Интернейшнл” ХХК-иас шилжүүлэн авч, БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийг Монгол Улсад байгуулан Дорнод аймгийн Халх гол, Матад сумдын нутагт орших Тосон-Уул ХIХ, Тамсаг ХХI талбайнуудад газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

“Доншен газрын тос Монгол” ХХК: БНХАУ-ын “Доншен Жингүн Петролеум Девелопмент Групп Сток” компани нь Монгол Улсын Засгийн газрын 1997.02.19-ний өдрийн 47 тоот тогтоолоор 2003 оны 2 дугаар сарын 15-нд батлагдсан БХГ-ний эрх, үүргийг Австралийн “Рок Ойл (Говь)” компаниас шилжүүлэн авч, БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Доншен газрын тос Монгол” ХХК-ийг Монгол Улсад байгуулан, Дорноговь аймгийн нутагт орших 1997 оны БХГ-т талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Газрын тосны үйл ажиллагаанд газрын тостой холбоотой хайгуул болон олборлолт багтана. Харин уламжлалт бус газрын тосны үйл ажиллагаа нь байгалийн битум, шатдаг занар, тослог элс, хийн элс, хийн занар болон нүүрсний метантай холбоотой.

5.4.2. Байгалийн хийн тухай тойм

Газрын тосны тухай хуулийн дагуух нэр томъёогоор “Газрын тос” гэдэгт түүхий тос, байгалийн хий орно. Мөн АМГТГ нь байгалийн хийн талаар ямар нэгэн гэрээ хэрэгжүүлээгүй ба байгалийн хийн эрэл, хайгуулын ажил явагдаагүй байна.

Эрдэнэс Метан ХХК нь 2016 оны 02 дугаар сард уламжлалт болон уламжлалт бус байгалийн хий, газрын тос хайх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийг зохицуулах болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-ийн 100 хувийн өмчлөлтэй охин компани болон байгуулагдсан.

Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын «Газпром» нээлттэй хувьцаат нийгэмлэг хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт 2019 оны 12 сард гарын үсэг зурсан байна. Уг санамж бичгийн дагуу Монголоор дамжуулах хоолойн асуудлыг хариуцах ажлын хэсгийг байгуулсан тухай 2020 оны 2-р сарын 18-нд мэдэгдсэн.

5.4.3. Газрын тосны нөөц

Манай улсын нутаг дэвсгэрт газрын тосны тав, нүүрсний давхаргын метан хийн долоо, шатдаг занарын эрэл хайгуулын дөрвөн гэрээ хэрэгжүүлж байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 22 талбайд газрын тосны хайгуул хийж, гурван талбайг олборлон ашиглаж байна. Нийт нутаг дэвсгэрийн 25 хувьд хүндийн хүч болон гурван хэмжээст чичирхийллийг судалж 1534 цооногийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгөөр өрөмдөж байна. Ийнхүү газрын тосны эрэл, хайгуулын дүнд манай улс газрын тос олборлогч улс болж, олборлож буй гурван талбайд 332.64 сая тонн газрын тосны нөөц, 43.258 сая тонн ашиглах баталгаат нөөцийг тогтоож Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн санд бүртгээд байна. *Эх сурвалж: 192@montsame.mn*

“Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос Монгол” ХХК нь хайгуул, үнэлгээ, туршилтын олборлолт, ашиглалтын нийт 1702465 цооног (Тосон-Уул XIX талбайд 982 цооног, Тамсаг XXI талбайд 589 цооног, БХГ-97 талбайд 131) өрөмдөн, 12.78 мянган тууш км хоёр хэмжээст (Тосон-Уул XIX талбайд 4.37 мянган тууш км, Тамсаг XXI талбайд 3.27 мянган тууш км, БХГ-97 талбайд 5.14 мянган тууш км), 5.33 мянган км² гурван хэмжээст (Тосон-Уул XIX талбайд 2.32 мянган км², Тамсаг XXI талбайд 2.67 мянган км², БХГ-97 талбайд 339.6 км²) чичирхийллийн судалгаа хийсэн.

ЭБМЗ-өөр 2011 онд Тосон-Уул XIX талбайн газрын тосны нөөцийн тооцооны нэмэлт тайланг дахин хэлэлцүүлж, тус зөвлөлийн 2011 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 06 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын 2011 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 148 дугаар тушаалаар газрын тосны “баталгаат” нөөцийг 60.06 сая тн, үүнээс газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 6.50 сая тонноор нэмж, Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэснээр дээрх талбайн нийт газрын тосны “баталгаат” нөөц 179.08 сая тн, үүнээс газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөц 20.17 сая тонн гэж бүртгэгджээ.

Тамсаг XXI талбайн газрын тосны нөөцийн тооцооны тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж, тус зөвлөлийн 2012 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 01/12 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын 2012 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 41 дүгээр тушаалаар газрын тосны “баталгаат” нөөцийг 127.509 сая тн, үүнээс байгалийн горимоор ашиглах газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 14.01 сая тонн, ус шахалтын горимоор ашиглах газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 21.018 сая тонноор Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн.

БНХАУ-ын Шандун мужийн Шенлигийн газрын тосны удирдах товчооны Геологийн эрдэм шинжилгээний хүрээлэн 1997 оны БХГ-т талбайн ТЕ-14 (Цагаанцав), ТЕ-1 (Шинэхудаг), ТЕ-27 (Шинэхудаг), ZB (Цагаанцав), SWZB (Цагаанцав), EZB-1 (Цагаанцав), EZB-4 (Цагаанцав) ба WTE-1 (Цагаанцав) блокуудын нөөцийн тооцооны тайланг боловсруулсан

БХГ-97 талбайн газрын тосны нөөцийг 26.05 сая тонн буюу 186.3 сая баррель; үүнээс “ашиглалтын баталгаат” нөөцийг 2.07 сая тонн буюу 14.86 сая баррелиар тус тус тогтоосон ба уг нөөцийн тооцооны тайланг хуучин нэрээр ЭБЭХЯ-ны дэргэдэх ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, тус зөвлөлийн 2010.04.18-ны өдрийн 03 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын “Нөөц бүртгэх тухай” 2011.06.08-ны өдрийн 137 дугаар тушаалаар газрын тосны “баталгаат” нөөцийг 26,05 сая тонн буюу 186,3 сая баррель; үүнээс “ашиглалтын баталгаат” нөөцийг 2,07 сая тонн буюу 14,86 сая баррелиар тус тус Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн байна.

2019 оны байдлаар газрын тосны нөөцийг БХГ-т талбай тус бүрээр Хүснэгт 5.38-д харуулав.

Хүснэгт 5.38 Газрын тосны нөөц, талбайгаар

Хайгуулын талбай	Газрын тосны орд	Газрын тосны нөөцийн зэрэглэл /сая тонн/					
		Баталгаат нөөц	Ашиглалтын баталгаат нөөц	Магадтай	Ашиглалтын магадтай	Боломжит	Ашиглалтын боломжит
Тосон-Уул XIX	Тосон-Уул	179,08	20,17	16,81	-	-	-
Тамсаг-XXI	Тамсаг	127,509	21,018	10,261	3,145	7,844	1,62
БХГ-97	Зүүнбаян Цагаан-Элс	26,056	2,079	-	-	25,58	-
Нийт		332,645	43,267	27,071	3,145	33,424	1,62

Газрын тосны тухай хууль болон нөөц бүртгэх тухай тушаалын дагуу АМГТГ нь жил бүр газрын тосны нөөцийн хөдөлгөөний тайланг хянаж, бүртгэл хөтлөж байгаа болно. Жил бүр олборлосон газрын тосны хэмжээг хасч тооцож байгаа ба дээрх “нөөц бүртгэх тухай” тушаалуудаас гадна нөөцийн зэрэглэлийг ахиулах, орд ашиглалтын аргыг өөрчилснөөр ашиглалтын нөөц нэмэгдэх зэрэг бусад төрлийн өөрчлөлт ороогүй болно.

5.4.4. Газрын тосны хайгуул

Дараах хүснэгтэд 2019 онд хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн газрын тосны хайгуулын төслүүдийн үйл ажиллагааг Хүснэгт 5.39-д харуулбал:

Хүснэгт 5.39 Хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн газрын тосны хайгуулын төслүүд

Д/д	Талбайн нэр	Байршил	Техник эдийн засгийн үнэлгээ хийгдсэн эсэх	Баталгаат нөөц	Нөөцийн хэмжээ	Хайгуул хийгдэх хугацаа /эхлэх, дуусах огноо одоогийн байдлаар/
1	Матад XX	Дорнод, Сүхбаатар	Үгүй	Байхгүй	0	2009.07.29 - 2020.07.04
2	Галба XI	Дорноговь, Өмнөговь	Үгүй	Байхгүй	0	2009.05.20– 2019.05.20
3	Богд IV	Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай	Үгүй	Байхгүй	0	2009.07.29 - 2019.07.28
4	Онги V	Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь	Үгүй	Байхгүй	0	2009.07.29 - 2019.07.28
5	Төхөм X (хойд)	Дундговь, Дорноговь	Үгүй	Байхгүй	0	2012.07.29 – 2020.07.28

6	Баянтүмэн XVII	Дорнод	Үгүй	Байхгүй	0	2010.12.08 – 2021.12.07
7	Дарьганга XXIV	Сүхбаатар	Үгүй	Байхгүй	0	2011.02.09 – 2021.02.08
8	Төхөм X (урд)	Дундговь, Дорноговь, Өмнөговь	Үгүй	Байхгүй	0	2012.07.29 – 2020.07.28
9	Сүхбаатар XXVII	Дорнод, Сүхбаатар, Хэнтий	Үгүй	Байхгүй	0	2013.01.05 – 2021.01.04
10	Хэрлэнтохой XXVIII	Дорнод, Сүхбаатар	Үгүй	Байхгүй	0	2015.11.19 - 2023.11.18
11	Ар булаг XXIX	Дорнод, Сүхбаатар	Үгүй	Байхгүй	0	2017.08.29 - 2025.08.28
12	Эргэл XII	Дорноговь	Үгүй	Байхгүй	0	2017.06.12 – 2025.06.11

Хувийн хөрөнгөөр санхүүжсан газрын тосны хайгуулын талбайд ТЭЗҮ, нөөц, нөөцийн хэмжээг Хүснэгт 5.40-д харуулав:

Хүснэгт 5.40 Хувийн хөрөнгөөр санхүүжсан газрын тосны хайгуулын талбайнөөц

Компанийн нэр	Талбайн нэр	Байршил	Санхүүжилт /сая ам.доллар/		Техник эдийн засгийн	Баталгаат нөөц	Ашиглалтын баталгаат нөөц	Нөөцийн хэмжээ
			2018	2019	үнэлгээ хийгдсэн эсэх	/байгаа, байхгүй/	/сая тонн/	
			Хувийн	Хувийн				
Петрочайна Дачин Тамсаг	Тосон-Уул XIX	Дорнод, Матад сум	117.72	116.93	ТЭЗҮ хийгдсэн	Байгаа	Байгаа	15.23
Петрочайна Дачин Тамсаг	Тамсаг XXI	Дорнод, Халхгол сум	117.27	98.75	ТЭЗҮ хийгдсэн	Байгаа	Байгаа	18.17
Доншен Газрын тос (Монгол)	1997 оны БХГ	Дорноговь, Сайншанд	10.66	16.6	ТЭЗҮ хийгдсэн	Байгаа	Байгаа	0.70

Эх сурвалж: Ашигт малтмал газрын тосны газар

5.4.5. Газрын тосны лиценз

Газрын тосны эрэл, хайгуул болон олборлолт, үйлдвэрлэлтийн үйл явцтай холбоотой харилцааг Газрын тосны тухай хууль (<http://www.legalinfo.mn/law/details/10484>)-аар зохицуулдаг.

Газрын тосны эрлийн үйл ажиллагаа нь тодорхой нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хэтийн төлөвийг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизикийн тойм судалгааны ажлыг хэлнэ.

Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа нь газрын тосны орд нээж, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизик, өрөмдлөг, олборлолтын туршилтын ажлыг багтаадаг.

Газрын тосны ашиглалт гэдэгт газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглалтын бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагааг оруулна.

2015 оны 11 дүгээр сард орон нутгийн засаг захиргаа болон газрын тосны лиценз эзэмшигчдийн хооронд байгуулах "Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх тухай" гэсэн хамтын ажиллагааны гэрээний загварыг Засгийн Газрын 430 тоот тогтоолоор баталсан.

2016 оны 3 сард орон нутгийн засаг захиргаа болон ашигт малтмалын хайгуул, олборлолтын лиценз эзэмшигчдийн хооронд байгуулах "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай" гэсэн хамтын ажиллагааны гэрээний загварыг Засгийн Газрын 179 тоот тогтоолоор баталсан.

Тусгай зөвшөөрөл олгох болон олгосон тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын Тосны Газар байсан бол 2016 оноос энэ газар нь АМГ-тай нийлж, АМГТГ болсон⁴.

5.4.6. Газрын тосны тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэх үйл явц (шаардлага 2.2.a.i)

Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Хүснэгт 5.41 Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл

Үе шат	Байгууллага	Үйл явц
I.	УУХҮЯ	УУХҮЯ-нд хүсэлт гаргана: - Бүтээгдэхүүн хуваах гэрээний хуулбар (БХГ); - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ; - Тухай жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө; - Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баримт;
II.		Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох - Газрын тосны хайгуулын хугацаа найм хүртэл жил байх бөгөөд уг хугацааг хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. - Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа арав хүртэл жил байх бөгөөд уг хугацааг тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно. - БХГ-г байгуулсан өдрөөс хайгуулын хугацааг тооцно. - Газрын тосны газар (ГТГ) нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ

Эх сурвалж: Газрын тосны тухай хуулиас

Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Газрын тосны тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргахад бусад хүсэлт гаргагчдаас давуу эрх эдэлнэ.

Хүснэгт 5.42 Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл

Үе шат	Төрийн захиргааны төв байгууллага	Үйл явц
I.	УУХҮЯ	УУХҮЯ газрын тосны нөөцийг хүлээн авах тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гэрээлэгч ашиглалтын үйл ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргана.
II.		Ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад дараах бичиг баримтыг бүрдүүлж УУХҮЯ-нд ирүүлнэ: - Газрын тосны нөөц бүртгэсэн тухай УУХҮЯ-ны шийдвэр; - Тухай жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл; - Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө;

⁴ (<http://www.pam.gov.mn/>)

Үе шат	Төрийн захиргааны төв байгууллага	Үйл явц
		<ul style="list-style-type: none"> - Ашиглалтын үеийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ; - Байр зүйн зураг ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбилцлыг тэмдэглэсэн зураг; - Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баримт;
III.	УУХҮЯ	УУХҮЯ нь ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ

Эх сурвалж: Газрын тосны тухай хуулиас

2016 онд Дарьганга ХХIV БХГ-г 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Засгийн Газрын 41 тоот тогтоолоор “Апедскро Инвэстмэнт” ХХК-аас “Монгол Шин Лью” ХХК руу шилжүүлсэнээс хойш өөнөөдрийг хүртэл хугацаанд газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн компани хараахан байхгүй байна.

Түүнчлэн энэхүү БХГ-үүд нь сонгон шалгаруулалтаар олгогдсон.

“Түвшин Интернэшнл” ХХК болон “Си Си Эф Петролиум” ХХК нь Арбулаг ХХIX талбайн сонгон шалгаруулалтад оролцож шалгараагүй бол “Күнанан Юаншинг Индистри, Трейд” ХХК нь Эргэл XII талбайн сонгон шалгаруулалтад оролцсон боловч шалгараагүй байна.

Лиценз олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг Хүснэгт 5.43-д харуулав.

Хүснэгт 5.43 Лиценз олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд

Д/д	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1.	АМГТГ	ГТГ нь нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгаа талаарх мэдээллийг өөрийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гурваас доошгүй удаа зарлана.
2.		<p>ГТГ сонгон шалгаруулалтын материалыг 60 хүртэл хоног байх бөгөөд сонгон шалгаруулалтын эхний захиалга хүлээн авсан өдрөөс хойш тав хоногийн дотор захиалга хүлээн авах эцсийн хугацааг зарлана. Оролцогч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Эрх зүйн байдлыг нотлох баримт бичиг; (<i>Улсын бүртгэлийн гэрчилгээ</i>) - Хөрөнгө оруулагчийн танилцуулга; - Төлөөлөх хүний овог, нэр, албан тушаал, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг, түүнд эрх олгосныг нотлох баримт; - Техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварыг нотлох баримт бичиг; - Ажилд зарцуулах хөрөнгийн баталгаа; - Гүйцэтгэх ажлын төлөвлөгөө төсөв; - Хуулиндд заасан хайгуулын талбайн захиалгын үйлчилгээний хөлс 20,000 ам доллар төлсөн баримт; - Оролцогч нь бизнесийн түншлэлтэй бол түүний хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, оролцох хувь, хэмжээ;
3.		ГТГ нь өргөдлийг хүлээн авсан эсэх талаар ажлын таван өдрийн дотор оролцогчид бичгээр мэдэгдэнэ

Д/д	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
4.	УУХУЯ ба АМГТГ	Оролцогчийн талаарх мэдээллийг гэрээ байгуулах хүртэл гуравдагч этгээдэд задруулахгүй.
5.	АМГТГ	ГТГ нь дараах шалгуурыг үндэслэн ЗГ хамгийн ашигтай санал ирүүлсэн орлоцогчийг ялагчаар тодруулан энэ тухай сонгоно: - ЗГ-т ноогдох ашиг газрын тосны ноогдох хувь; - Нөөц ашигласны төлбөрийн хувь; - Өртөгт газрын тосны хязгаарын хувь; - Хайгуулын хөрөнгө оруулалтын хэмжээ; - Байгаль орчны нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн хэмжээ; - Сургалтын урамшууллын хэмжээ; - Гэрээнд гарын үсэг зурсны урамшууллын хэмжээ; - Олборлолт эхэлсний урамшууллын хэмжээ; - Олборлолт нэмэгдүүлсний урамшууллын хэмжээ; - Орон нутгийг хөгжүүлэх урамшууллын хэмжээ; - Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг - ЗГ-т санал болгох сусад ашигтай нөхцөл;

5.4.7. Бүтээгдэхүүн хуваах гэрээ

2019 оны байдлаар БХГ байгуулсан компаниудыг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5.44 Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан компаниуд

Д/д	БХГ-т талбай	БХГ батлагдсан огноо, Засгийн газрын тогтоолын дугаар	Гэрээлэгч компани	Оператор компани	Гэрээлэгчийн харьяалал	Талбайн хэмжээ, км.кв
1	Тосон-Уул XIX	1993.04.26	Daqing Oil Field Ltd	Петрочайна Дачин Тамсаг ХХК	БНХАУ	650
2	Тамсаг XXI	1996.08.07- ЗГ-ын тогтоол №183				209,2
3	1997БХГ	1997.02.19- ЗГ-ын тогтоол №47	Доншен Жингүн Девелопмент Групп	Доншен газрын тос (Монгол) ХХК	БНХАУ	239,5
4	Матад ХХ	2006.07.19- ЗГ-ын тогтоол №170	Petromatad Invest Limited	ПетроМатад ХХК	Их Британий Мэний арал	10343,2
5	Нялга XVI	2007.06.20- ЗГ-ын тогтоол №148	Panasian Energy Ltd	Шэйман ХХК	Канадын Невисийн арал	9239,4
6	Цагаан-элс XIII	2009.05.20- ЗГ-ын тогтоол №148	DWM Petroleum AG	Гоби энержи партнерс Гмбх ХХК	Швейцарь	1980
7	Зүүнбаян XIV					1030,7
8	Галба XI	2009.05.20- ЗГ-ын тогтоол №147	Zong Heng You Tian Ltd	Зон Хэн Юу Тиан ХХК	БНХАУ	9769,2
9	Сулинхээр XXIII	2009.07.22- ЗГ-ын тогтоол №224	Шунхлай Энержи ХХК	Шунхлай Энержи ХХК	Монгол улс	13576
10	Борзон VII	2009.07.29- ЗГ-ын тогтоол №236	Импайр Газ Монголиа ХХК	Импайр Газ Монголиа ХХК	Мэний арал	31432
11	Хөхнуур XVIII	2009.07.29- ЗГ-ын тогтоол №238	Эн Пи Ай ХХК	Эн Пи Ай ХХК	БНХАУ	5276
12	Төхөм X _(хойд)	2009.07.29- ЗГ-ын тогтоол №237	Сансарын геологи хайгуул ХХК	Сансарын геологи хайгуул ХХК	Монгол улс	9813
13	Цайдам XXVI					11175,2
14	Богд IV	2009.07.29- ЗГ-ын тогтоол №235	Сентрал азиан петролеум корпорэйшн лимитед	Капкорп монголиа ХХК	Их Британий Кэйманий арал	28998,6
15	Онги V					21148,7
16	Баянтүмэн XVII	2010.12.08- ЗГ-ын тогтоол №316	Магнай трейд ХХК	Магнай трейд ХХК	Монгол улс	7832
17	Дарьганга XXIV	2011.02.09- ЗГ-ын тогтоол №39	Апекспро инвестмент лимитед	Эй Пи Экс Пи Эр Өү ХХК	Британий Виржини арал	17178

д/д	БХГ-т талбай	БХГ батлагдсан огноо, Засгийн газрын тогтоолын дугаар	Гэрээлэгч компани	Оператор компани	Гэрээлэгчийн харьяалал	Талбайн хэмжээ, км.кв
18	Төхөм Х (урд)	2012.07.25- ЗГ-ын тогтоол №253	Монголын алт (МАК) ХХК	Монголын алт (МАК) ХХК	Монгол улс	24706,2
19	Сүхбаатар ХХVII	2013.01.05- ЗГ-ын тогтоол №39	Вульф петролеум ХХК	Вульф петролеум ХХК	Австрали	23047,5
20	Номгон IX	2014.02.09- ЗГ-ын тогтоол №39	Өмнөд монголын газар нутгийн тос ХХК			29866,8
21	Увс I	2015.04.20, ЗГ-ын тогтоол №162	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Хонгконг	19720
22	Хэрлэнтохой ХХVIII	2015.04.20- ЗГ-ын тогтоол №162	Хонгконг Вэлпэк Индастриал ХХК	Хонгконг Вэлпэк Индастриал ХХК	Хонгконг	14280
23	Хар-ус II	2015.06.15- ЗГ-ын тогтоол №246	Ренова илч ХХК	Ренова илч ХХК	БНХАУ	27409,3
24	Эргэл-ХII	2016.06.20- ЗГ-ын тогтоол №337,	Макс ойл ХХК	Макс ойл ХХК	Монгол улс	/875+894.41 6/ 1769.416
25	Ар булаг-ХХIX	2016.08.24- ЗГ-ын тогтоол №53	Смарт ойл инвестмент лимитед	Смарт ойл инвестмент ХХК	БНХАУ	11035

Эх сурвалж: АМГТГ-ын Газрын тосны ашиглалтын хэлтэс, Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс

5.4.8. БХГ-ний талаарх ил тод байдал (Шаардлага 2.4)

Засгийн газар нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний мэдээллийг ил тод болгоход татгалзах зүйлгүй байгаа бөгөөд Бүтээгдэхүүн хуваах гэрээг олон нийтэд мэдээлэхийг үүрэг болгосон Засгийн газрын 222 тоот тогтоолыг 2012 оны 7 дугаар сарын 4-нд баталсан.

Монгол Улсын эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор Нээлттэй нийгэм Форум (ННФ), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОУИТБС) Ажлын алба хамтран iltodgereee.mn мэдээллийн сайтыг байгуулж, энэхүү мэдээллийн сайт дээр 31 Бүтээгдэхүүн хуваах гэрээ, 4 эрлийн ажил гүйцэтгэх гэрээг ил тод болгосон нь олон жил хаалттай явж ирсэн мэдээллийг ил тод болгосон нь үнэхээр сайшаалтай сайн жишиг болсон байна.

Уг сайт дээр ил болгосон БХГ-ний жагсаалт дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5.45 Ил болгосон Бүтээгдэхүүн хуваах гэрээ)

№	Гэрээний нэр	Үзэглэсэн огноо	Гэрээлэгч талууд	
1	Төхөм Х урд талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Ашигт малтмал, газрын тосны газар болон Монголын алт ХХК хооронд шинэчлэн байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)	2017-06-16	АМГТГ	Монголын алт ХХК
2	Газрын тосны хайгуулын Богд-IV талбайн талаар Газрын тосны газар болон "Сентрал Азиан Петролеум корпорэйшн лимитэд" Компанийн хооронд байгуулах БХГ	2009-07-08	Газрын тосны газар	Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд
3	Монгол газрын тосны товчоо болон Команд петролиум лимитед, Цагаан шонхор ойл корпораци, Соко Тамсаг Монголиа Инк. нарын (гэрээлэгч) хооронд байгуулсан БХГ	1995-12-11	Монгол газрын тос товчоо	Цагаан шонхор ойл корпорац; Команд Петролеум Лимитед (Австрали); Соко Тамсаг Монголиа Инк

№	Гэрээний нэр	Үзэглэсэн огноо	Гэрээлэгч талууд	
4	Газрын тосны хайгуулын Дарьганга-XXIV талбайн талаар Газрын тосны газар, "Апекспро Инвестмент Лимитэд"-ийн хооронд байгуулсан БХГ	2010-12-17	Газрын тосны газар	Апекспро инвестмент лимитэд
5	Газрын тосны Онги-V талбайн талаар Газрын тосны газар болон Сентрал Азиан Петролеум корпорэйшн лимитэд Компанийн хооронд байгуулах БХГ	2009-07-08	Газрын тосны газар	Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд
8	Хөх нуур XVIII талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Ашигт малтмал, газрын тосны газар болон Эн Пи Ай ХХК хооронд шинэчлэн байгуулсан БХГ		АМГТГ	Эн Пи Ай
9	Газрын тосны хайгуулын Галба-XI талбайн талаар Газрын тосны газар, "Зон хэн юу тиан" ХХК-ийн хооронд байгуулсан БХГ	2009-04-27	Газрын тосны газар	Зон хэн юу тиан ХХК
10	Газрын тосны хайгуулын Сулинхээр XXIII талбайн талаар Газрын тосны газар, "Шунхлай энержи" ХХК-ийн хооронд БХГ	2009-07-22	Газрын тосны газар	Шунхлай Энержи ХХК
11	Матад-XX талбайд Петро матад ХХК болон Газрын тосны газар хооронд байгуулсан БХГ	2006-05-16	АМГТГ	Петро Матад ХХК
12	Газрын тосны хайгуулын Цайдам - XXVI талбайн талаар Газрын тосны газар, "Сансарын геологи хайгуул" ХХК-ийн хооронд байгуулсан БХГ	2009-07-10	Газрын тосны газар	Сансарын геологи хайгуул ХХК
15	Дорнод аймгийн Матад сум, Петрочайна Дачин Тамсаг компанийн хооронд байгуулсан Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээ	2016-08-18	Дорнод аймгийн Матад сумын Засаг даргын тамгын газар	Петрочайна Дачин Тамсаг
16	Газрын тосны хайгуулын Сулинхээр XXIII талбайн талаар Газрын тосны газар, "Шунхлай энержи" ХХК-ийн хооронд байгуулсан БХГ	2009-07-22	Газрын тосны газар	Шунхлай Энержи ХХК
17	Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Газрын тосны хэрэг эрхлэх газар болон Нескор энержи Компанийн хооронд байгуулсан БХГ	1997-01-24	Газрын тосны хэрэг эрхлэх газар	Нескор Энержи ХХК
18	Тосон уул XIX гэрээт талбайн талаар Монгол газрын тос (МГТ) компани болон Медаллион Монгол Ойл Компанийн (ММО) хооронд байгуулсан БХГ	1993-04-26	Монгол газрын тос компани	Медаллион Монгол Ойл
19	"Эргэл XII" талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Ашигт малтмал, газрын тосны газар "Смарт ойл инвестмент лтд" Компанийн хооронд байгуулсан БХГ	2016-09-09	АМГТГ	Смарт ойл инвестмент лтд
20	"Ар булаг-XXIX" талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Газрын тосны газар, "Макс ойл" ХХК-ийн хооронд байгуулсан БХГ	2017-07-06	Газрын тосны газар	"Макс ойл" ХХК
21	Газрын тосны хайгуулын Номгон - IX талбайн талаар Газрын тосны газар, "Сансарын геологи хайгуул" ХХК-ийн хооронд байгуулсан БХГ	2014-01-26	Газрын тосны газар	Сансарын геологи хайгуул ХХК
22	Газрын тосны хайгуулын Төхөм хойд - X талбайн талаар Газрын тосны газар, "Сансарын геологи хайгуул" ХХК-ийн хооронд байгуулсан БХГ	2009-07-10	Газрын тосны газар	Сансарын геологи хайгуул ХХК
23	Газрын тосны хайгуулын Хөх нуур - XVIII талбайн талаар Газрын тосны газар болон БНХАУ-ын "Эн Пи Ай" ХХК-ийн хооронд байгуулсан БХГ	2009-07-06	Газрын тосны газар	Эн Пи Ай ХХК
24	DWM Petroleum AG, Tsagaan Els XIII Area, PSA, 2009	2009-05-20	Газрын тосны газар	DWM Petroleum AG

№	Гэрээний нэр	Үзэглэсэн огноо	Гэрээлэгч талууд	
25	Ашигт малтмал газрын тосны газар, Дорнод аймгийн Засаг дарга, Петрожайна Дачин Тамсаг ХХК хоорондын гурван талт хэлцэл	2018-10-29	Газрын тосны газар, Дорнод аймгийн ЗД	Петрожайна Дачин Тамсаг
26	Сүхбаатар-XXVII талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар "Ашигт малтмал, газрын тосны газар" болон "Вульф петролеум" ХХК-ийн хооронд шинэчлэн байгуулсан БХГ		АМГТГ	Вульф Петролеум
27	Борзон VII талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Ашигт малтмал, газрын тосны газар болон Импейр Газ Монголиа ХХК-ийн шинэчлэн байгуулсан БХГ	2017-06-16	АМГТГ	Импейр Газ Монголиа
28	Газрын тосны хайгуулын Баянтүмэн-ХVII талбайн талаар Газрын тосны газар болон "Магнай трейд" ХХК-ийн хооронд байгуулсан БХГ	2009-12-23	Газрын тосны газар	"Магнай трейд" ХХК
29	Нялга-ХVI гэрээт талбайн талаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Канад улсын "Шаман ресурсэс ЛТД" Компанийн хооронд байгуулсан БХГ	2007-04-18	АМГТГ	Шаман ресурсэс ЛТД
30	"Хар ус - II" талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Газрын тосны газар, "Ренова-Илч" ХХК-ийн хооронд байгуулсан БХГ	2015-04-17	Газрын тосны газар	Ренова Илч ХХК
31	"Хэрлэн тохой ХХVIII" талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Газрын тосны газар, "Хонконг Вэлпэк Индастриал" Компанийн хооронд байгуулсан БХГ	2015-04-16		Хонконг вэлпэк индастриал

Уг сайт дээр ил болгосон Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний жагсаалт даарх байдалтай байна.

Хүснэгт 5.46 Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ

№	Гэрээний нэр	Гарын үсэг зурсан огноо	Гэрээлэгч талууд	
1	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Софтрок ХХК	2018-09-17	Ашигт малтмал, газрын тосны газар	Софтрок ХХК
2	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Фронтинер Петролеум ХХК	2018-06-07	Ашигт малтмал, газрын тосны газар	Фронтинер Петролеум ХХК
3	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Бигстоне	2019-01-25	Ашигт малтмал, газрын тосны газар	Бигстоне ХХК
4	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ, Сарны сувдан чулуу ХХК	2018-09-13	Ашигт малтмал, газрын тосны газар	Сарны сувдан чулуу ХХК

5.4.9. Газрын тосны бүтээгдэхүүний орлого

Газрын тосны тухай хуульд зааснаар газрын тос олборлогч аж ахуй нэгжүүд нь газрын тосны орлогоо ЗГ-тай хийсэн БХГ-нд заасан хувь хэмжээний дагуу хуваадаг. АМГТГ-ын мэдэгдсэнээр компаниуд нь одоогийн дагаж байгаа тохиролцооны дагуу ЗГ-т борлуулалтын ашгийг мөнгөөр буюу ам.доллараар төлдөг.

БХГ-ний загварт ЗГ ашигт газрын тосноос өөрт ногдох хувийг мөнгөн бус (газрын тосоор) хэлбэрээр авах эрх үүсдэг, эсвэл ЗГ-т ногдох газрын тосыг гэрээлэгч компани арилжаалаад орлогыг ЗГ руу шилжүүлэх хүсэлт тавьж болно. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ЗГ-т ГТНАТ төлөх ёстой. Одоогоор ЗГ өөрт ногдох ашигт газрын тосоо мөнгөн бус хэлбэрээр авахгүй байна.

ОУИТБС-ын Шаардлага 2.4-д зааснаар ЗГ, ТӨААН-үүдийн борлуулсан газрын тосны биет хэмжээ ба борлуулалтын орлогыг ил тод тайлагнах ёстой. Үүний дагуу, бид БХГ-нд зааснаар газрын тосны нийт үйлдвэрлэлээс ЗГ-т ногдох биет хэмжээгээр, болон мөнгөн дүнгээр тайлагнах хүсэлтийг тавьсан боловч, борлуулалтаас ЗГ-ын хүлээн авсан хувь хэмжээг мөнгөн дүнгээр АМГТГ гаргаж өгөөгүй. АМГТГ-аас тайлагнасан мэдээллийг Хүснэгт 5.47-д харуулав.

Хүснэгт 5.47 Ашигт малтмалын үйлдвэрлэсэн нөөц, мян.баррель

№	Компанийн нэр	Ашигт малтмалын үйлдвэрлэсэн/олборлосон нөөц	Төрд хамаарах хэсэг		Борлуулалт /сая төгрөг/
			Хувь хэмжээ	Дүн (сая төгрөг)	
1	Петрочайна Дачин Тамсаг	3172.44	24%	95,799.41	95,799.41
2	Петрочайна Дачин Тамсаг	3323.39	27.80%	114,780.06	114,780.06
3	Доншен Газрын тос	376.07	28.30%	21,687.65	21,687.65

5.4.10. Газрын тосны үйлдвэрлэл, экспорт

2019 онд олборлолтын гурван бүсэд 6,876,055 баррель газрын тос олборлож, 6,546,397 баррель газрын тос экспортод гаргасан байна (Хүснэгт 5.48).

Хүснэгт 5.48 Газрын тосны олборлолт, экспортыг БХГ байгуулсан, компани түс бүрээр

Компанийн нэр	2019 он			
	Олборлолт		Экспорт	
	баррель	Гүйцэтгэл, %	баррель	Гүйцэтгэл, %
Петрочайна Дачин Тамсаг	6,495,834.32	541.20	6,174,583.24	512.92
Доншен Газрын тос (Монгол)	380,220.68	591.92	371,813.76	548.48
	6,876,055.00		6,546,397.00	

Монгол улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2019 онд 2,108,444 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолж дотоодын хэрэгцээг хангасан.

Хүснэгт 5.49 Газрын тосны бүтээгдэхүүний импорт, бүтээгдэхүүний төрөл, сараар, тонн

2019 он									
сар	Автобензин А-80	Автобензин АИ-92	Автобензин АИ-95	Автобензин АИ-98	Дизелийн түлш	Онгоцны түлш ТС-1	Шингэрүүлсэн шатдаг хий	Бусад	Нийт
Нийт	70,554	509,424	25,845	1,139	1,169,265	51,849	44,757	235,611	2,108,444

Газрын тосны бүтээгдэхүүний импортыг бүтцээр нь авч үзвэл 90-ээс дээш октантай автобензин 25.44%, 90-ээс доош октантай автобензин 3.35%, дизель түлш 55.46%, онгоцны түлш 2.46%, бусад /тос тосолгооны материал, мазут, хий / 13.30%-ийг эзэлж байна. Нийт импортын 91.55 хувийг ОХУ, 0.34 хувийг БНСУ, 7.72 хувийг БНХАУ, үлдсэн 0.38 хувийг бусад улсаас импортолсон.

Хүснэгт 5.50 Газрын тосны бүтээгдэхүүний импорт, төрөл, улсаар, тонн

Улсын нэр	Орос	БНХАУ	БНСУ	Бусад	Нийт
Бүтээгдэхүүний төрөл					
Автобензин А-80	7,309	-	-	-	7,309
Автобензин АИ-92	51,880	9,933	-	-	61,813
Автобензин АИ-95	2,424	-	-	-	2,424
Автобензин АИ-98	63	-	-	-	63
Дизелийн түлш	92,468	1,256	-	-	93,724
Онгоцны түлш ТС-1	3,285	-	-	-	3,285
Шингэрүүлсэн шатдаг хий	3,406	-	64	-	3,470
Бусад	17,166	3,820	604	743	22,333
Нийт	178,001	15,009	668	743	194,421

Эх сурвалж: АМГТГ-ын Газрын тосны ашиглалтын хэлтэс, Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс.

5.4.11. Газрын тосны бүтээгдэхүүний үнэ

Дэлхийн томоохон биржид борлогдож буй газрын тосны дундаж үнэ (ам.доллар, тонноор) ийн-мэдээллийг дараах эх сурвалжийг харна уу

Эх сурвалж: www.wtrg.com, www.bloomberg.com, www.reuters.com, www.topoilnews.com, www.oil.in-en.com, www.nymex.com, www.finmarket.ru, www.ineng.org, www.quandl.com.

5.4.12. Газрын тосны салбар дахь төрийн оролцоо

Монгол Улсын нутаг дэвсгэрт 2019 оны байдлаар 18 талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээ (газрын тосны 10, нүүрсний давхаргын метан хийн 5, шатдаг занарын 3), 25 талбай (*газрын тосны хайгуулын 22, ашиглалтын 3*)-д бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна.

Манай Улсад газрын тосны эрэл, хайгуул, олборлолт, ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах үндэсний компани байхгүй, мэргэшсэн боловсон хүчин дутмаг, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл байхгүй, боловсруулах үйлдвэр баригдаагүй, дотоодод боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүний хангамж, чанарын хяналт, хадгалалтын тогтолцоо хангалттай сайн бүрдээгүй зэрэг шалтгаанаар тус салбарт хийгдэж байгаа ихээхэн хэмжээний гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын дийлэнх хувь (*90 орчим*) нь гадаадаас авсан ажил, үйлчилгээ, зөвлөхийн төлбөр, ажиллах хүчний ажлын хөлс, зэрэгт зарцуулагдаж байгаа нь гадагшлах мөнгөн урсгалыг нэмэгдүүлж байна.

Иймд Төрөөс газрын тосны салбарт 2027 он хүртэл Монгол Улсын үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдол бүхий газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, бүс нутгийн хөгжлийг дэмжих, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх замаар газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурийг бий болгоход зорьж байна.

Мөн түүнчлэн Монгол улсын засгийн газрын 2016-2020 оныг хүртэлх хөтөлбөртөө газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах зорилт дэвшүүлсэн байна. Энэхүү зорилтын хүрээнд Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн өмчит компани байгуулах шийдвэр гарч, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит ХХК-ийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 108-р тогтоолоор байгуулж, улмаар жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барих нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байна.


Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний дотоодын хэрэглээгээ хангах боловсруулах үйлдвэр байхгүйн улмаас ОХУ, БНХАУ, БНСУ зэрэг орнуудаас 100 хувь импортоор шатахууны хэрэгцээгээ хангаж байгаа бөгөөд жилд ойролцоогоор 1.3 сая тонн шатахуун импортолж байна.

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 169 тогтоолоор төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 хүртэл баримтлах бодлого баталсан байна.

Монгол Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын нийт 97 агуулах, 1252 шатахуун түгээх станц, шингэрүүлсэн шатдаг хий цэнэглэх 10 станц (агуулах), автомашин хийгээр цэнэглэх 78 станцаар дамжуулан бөөний болон жижиглэнгийн худалдаа үйлчилгээ үзүүлж байна

Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 2022 он гэхэд шинээр 3 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ, 2027 он гэхэд шинээр 2 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах зорилт тавьсан байна.

5.5 ОЛБОРЛОХ САЛБАРЫН ЗҮГЭЭС ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР




5.5.1. Эдийн засгийн өсөлт (шаардлага 6.3а)

Сүүлийн жилүүдэд уул уурхай, эрдэс баялгийн салбар хурдацтайгаар хөгжиж, Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болж байна. Стратегийн ач холбогдол бүхий томоохон ашигт малтмалын орд, газрууд эдийн засгийн эргэлтэд орсон нь уул уурхайн салбарын үйлдвэрлэл цаашид өсөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Эдийн засгийн бодит өсөлт 2019 онд 5.1 хувьтай байна. Уул уурхайн салбар 2018 оны эдийн засгийн өсөлтийн 1.35 нэгж хувийг бүрдүүлж байсан бол 2019 онд (-0.12) нэгж хувь болж буурсан байна. Нүүрсний үйлдвэрлэл бараг өсөөгүй, Оюутолгой төслийн олборлож байгаа баяжмал дахь металлын агууламж буурсан нь уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл буурахад голлон нөлөөлжээ⁵.

Уул уурхайн салбар 2019 оны жилийн эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 23.7 хувийг бүрдүүлж байна.

Зураг 5.8 ДНБ-ий өсөлт дэх голлох салбаруудын хувь нэмэр



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

⁵ 2019 онд Оюутолгойн баяжмал дахь алтны хэмжээ 15 хувиар буурсан, зэсийн агууламж 20.1 хувь болж багассан байна.

5.5.2. Үйлдвэрлэл (шаардлага 6.3а)

Уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар нь аж үйлдвэрийн салбарт томоохон хувийн жин эзэлдэг. Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 12,467.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар өссөн байна.

Уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэр төрлөөр буюу олон улсын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар дараах 4 дэд салбарт ангилан авч үзлээ.

- Металлын хүдэр олборлолт
- Нүүрс олборлолт
- Газрын тос олборлолт
- Бусад ашигт малтмал олборлолт

Алт олборлолт

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль 2009 онд батлагдан, хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор алтны үйлдвэрлэлийн хэмжээ харьцангуй буурч байсан. Засгийн газраас алтны олборлолтыг дэмжиж хууль эрхзүй, татварын таатай нөхцөл бүрдүүлснээр 2013 оноос үйлдвэрлэл өссөн. Цаашид ч алт олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай хэмээн үзэж, 2016 онд Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монгол Банкны хамтарсан ажлын хэсэг байгуулагдан, “Алт 2” хөтөлбөрийг боловсруулж, 2017 оноос хэрэгжүүлж эхлэсэн байна (Эх үүсвэр: Ашигт малтмал, газрын тосны газар).

2019 онд 16.3 тонн алт олборлосон нь өмнөх оноос 4.4 тонн буюу 21.1 хувиар буурсан байна. Нийт олборлосон алтны 9.1 тонн буюу 55.8 хувийг экспортолсон бөгөөд өмнөх оноос 5.7 тонн буюу 2.6 дахин буурсан байна. Нэг хүнд ногдох алт олборлолтын хэмжээ 2019 онд 5.1 грамм болж, өмнөх оноос 1.4 грамм буюу 22.1 хувиар буурсан байна.

Мөн “Алт 2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хээрийн судалгааны ажлыг 521200 км² талбай буюу 33.3 хувьд гүйцэтгэж, алтны хүдэржилт бүхий талбай, дүүрэг, зангилаа, түүнд тогтоогдсон орд, илрэл, эрдэсэжсэн цэг, сарнилын хүрээ бүхий хэсгүүдийг нарийвчлан тодорхойлоод байна.

Нүүрс олборлолт

Монгол Улс нүүрсний нөөцөөр дэлхийд эхний 10 орны тоонд багтдаг. Одоогийн байдлаар 15 сав газрын 300 гаруй орд, илрэл байгаа бөгөөд Монгол орны нүүрсний геологийн таамаг нөөц 173.3 тэрбум тонн бөгөөд цаашдаа өсөх боломжтой. Уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт төрийн болон орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгж, байгууллага 8 уурхайд, дотоодын болон хамтарсан 28 аж ахуйн нэгж, байгууллага 33 уурхайд, гадаадын хөрөнгө оруулалттай 7 аж ахуйн нэгж 8 уурхайд тус тус нүүрс олборлож байна (Эх үүсвэр: Ашигт малтмал, газрын тосны газар).

2019 онд 55.8 сая тонн нүүрс олборлосон нь өмнөх оноос 4.4 сая тонн буюу 8.5 хувиар өссөн байна. Нийт олборлосон нүүрсний 36.6 сая тонн буюу 65.6 хувийг экспортолсон бөгөөд өмнөх оноос 0.3 сая тонн буюу 0.9 хувиар өсөж, нүүрс нь экспортын тэргүүлэгч бүтээгдэхүүн болоод байна. 2019 онд олборлосон нийт нүүрсний 48.8 сая тонн буюу 87.5 хувь нь чулуун нүүрс, 7.0 сая тонн буюу 12.5 хувь нь хүрэн нүүрс байна. Чулуун нүүрс өмнөх оноос 4.4 сая тонн буюу 10.0 хувиар, өссөн байна.

Нэг хүнд ногдох нийт нүүрс олборлолтын хэмжээ 2019 онд 17.5 тонн болж, өмнөх оноос 1.2 тонн буюу 7.3 хувиар өссөн байна. Нэг хүнд ногдох чулуун нүүрс олборлолтын хэмжээ 2019 онд 15.3 тонн болж, өмнөх оноос 1.2 тонн буюу 8.9 хувиар өссөн бол нэг хүнд ногдох хүрэн нүүрс 2019 онд 2.2 тонн болж өсжээ. Харин нэг хүнд ногдох нүүрсний экспортын хэмжээ 2019 онд 11.5 тонн болж, өмнөх оноос 1.3 тонн буюу 13.1 хувиар өссөн байна.

Нүүрс олборлолтын салбарт 2019 онд 6.8 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 1.5 их наяд төгрөг буюу 28.6 хувиар өсжээ.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд нүүрс олборлолтын эзлэх хувь 2019 онд 22.7 хувь болж, өмнөх оноос 2.7 пунктээр нэмэгдсэн байна. Харин уул уурхай, олборлох үйлдвэрт нүүрс олборлолтын эзлэх хувь 2019 онд 39.5 хувь болж, өмнөх оноос 4.9 пунктээр өссөн байна.

Хүснэгт 5.51 Нүүрс олборлолтын салбарын үйлдвэрлэл, их наяд төгрөгөөр

Салбар	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019*
Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл	6.5	8.8	9.8	10.4	14.4	14.8	15.7	21.0	26.5	30.1
Уул уурхай, олборлох үйлдвэр	4.1	5.7	5.8	6.1	9.3	8.2	8.7	12.1	15.3	17.3
Нүүрс олборлолт	0.9	2.1	1.7	1.5	1.1	1.0	1.6	3.9	5.3	6.8
Олборлосон 1 тн нүүрсний өртөг, мян.төг	33.9	40.3	44.5	36.4	34.5	32.1	38.6	52.0	80.3	101.6
Нүүрс олборлолтын эзлэх хувь: АҮ-ийн нийт үйлдвэрлэлд	14.4	24.4	17.5	14.0	7.5	6.4	10.3	18.5	20.0	22.7
Уул уурхай, олборлох үйлдвэрт	22.6	37.7	29.8	24.0	11.7	11.7	18.5	32.1	34.6	39.5

2019 онд нийт хэрэглэсэн нүүрсний 7.7 сая тонн буюу 78.9 хувийг дулааны цахилгаан станцуудад, 541.0 мянган тонн буюу 5.5 хувийг орон сууц, нийтийн аж ахуйд, 176.0 мянган тонн буюу 1.8 хувийг үйлдвэр, барилгын салбарт, 56.0 мянган тонн буюу 0.6 хувийг тээвэр, холбооны салбарт, үлдсэн 1.3 сая тонн буюу 13.2 хувийг бусад салбарт хэрэглэжээ.

Газрын тос олборлолт

Манай улс 1996 оноос газрын тос олборлож, газрын тосны олборлох салбар шинээр хөгжиж ирсэн. Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 32 талбай ялгаснаас одоогоор 25 талбайд 21 гэрээлэгч ажиллаж байна. Одоогоор олборлолтын үйл ажиллагааг “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос Монгол” ХХК-ууд эрхэлж байна.

2019 онд 6.9 сая баррель газрын тос олборлосон нь өмнөх оноос 0.5 сая баррель буюу 7.6 хувиар өсөж, нийт олборлосон газрын тосны 6.5 сая баррель буюу 95.2 хувийг экспортолсон бөгөөд экспортлогдсон газрын тос өмнөх оноос 0.4 сая баррель буюу 5.7 хувиар өссөн байна (Хүснэгт 5.52).

Хүснэгт 5.52 Газрын тос олборлолтын салбарын үйлдвэрлэл, их наяд төгрөгөөр

Салбар	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019*
Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл	6.5	8.8	9.8	10.4	14.4	14.8	15.7	21.0	26.5	30.1
Уул уурхай, олборлох үйлдвэр	4.1	5.7	5.8	6.1	9.3	8.2	8.7	12.1	15.3	17.3
Газрын тос олборлолт	0.2	0.3	0.4	0.8	1.1	0.8	0.7	0.9	1.0	1.0
Газрын тос олборлолтын эзлэх хувь: АҮ-ийн нийт үйлдвэрлэлд	2.5	3.1	4.4	7.4	7.8	5.6	4.6	4.3	3.8	3.3
Уул уурхай, олборлох үйлдвэрт	4.0	4.8	7.4	12.6	12.1	10.2	8.3	7.4	6.7	5.7

Нэг хүнд ногдох газрын тос олборлолтын хэмжээ 2019 онд 2.2 баррель байгаа нь өмнөх оноос 0.2 баррель буюу 7.8 хувиар буурсан байна. Харин нэг хүнд ногдох газрын тосны экспортын хэмжээ 2019 онд 2.1 баррель болж өмнөх оноос 0.1 баррель буюу 4.7 хувиар буурчээ.

Газрын тос олборлолтын дэд салбарт 2019 онд 980.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 27.2 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар буурчээ. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд газрын тос олборлолтын эзлэх хувь 2019 онд 3.3 хувь болж, өмнөх оноос 0.5 пунктээр, 2014 оноос 4.5 пунктээр буурч, 2010 оноос 0.8 пунктээр өссөн байна. Харин уул уурхай, олборлох үйлдвэрт газрын тос олборлолтын эзлэх хувь 2019 онд 5.7 хувь болж, өмнөх оноос 1.0 пунктээр, 2014 оноос 6.4 пунктээр буурч, 2010 оноос 1.7 пунктээр нэмэгджээ.

Бусад ашигт малтмалын олборлолт

Уул уурхай, олборлох үйлдвэрийн бусад нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзвэл, 2019 онд хайлуур жонш 54.9 мянган тонн буюу 54.3 хувиар, төмрийн хүдэр 2.4 сая тонн буюу 37.7 хувиар өсөж, харин молибдений баяжмал 0.2 мянган тонн буюу 3.3 хувиар, хайлуур жоншны баяжмал 33.2 мянган тонн буюу 41.2 хувиар, төмрийн хүдрийн баяжмал 19.1 мянган тонн буюу 0.6 хувиар буурсан байна. Зэсийн баяжмал металл агуулгаараа 2019 онд 1262.4 мянган тонн болж, өмнөх онтой харьцуулахад 48.4 мянган тонн буюу 3.7 хувиар буурч, 2014 оноос 182.0 мянган тонн буюу 16.8 хувиар, 2010 оноос 740.4 мянган тонн буюу 2.4 дахин өссөн байна.

Хүснэгт 5.53 Бусад ашигт малтмалын олборлолт, үйлдвэрлэл, биет хэмжээгээр

Ашигт малтмалын төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019*
Зэсийн баяжмал, металл агуулгаар	522.0	513.7	517.9	803.0	1080.4	1334.7	1445.1	1317.6	1310.8	1262.4
Молибдений баяжмал, металл агуулгаар	4.4	4.0	3.9	3.7	4.1	5.2	5.2	5.8	5.5	5.3
Хайлуур жонш	727.0	658.7	484.0	161.7	303.0	183.5	167.7	108.9	101.2	156.1
Хайлуур жоншны баяжмал	140.7	116.4	157.2	76.4	71.9	47.3	34.1	55.2	80.7	47.5
Төмрийн хүдэр	3076.6	5139.9	6898.0	5011.9	6293.1	4273.6	4936.2	7694.7	6225.4	8572.2
Төмрийн хүдрийн баяжмал	126.6	484.4	5214.1	6124.0	3967.4	1899.8	2209.9	3675.0	3405.5	3386.4
Цайрын баяжмал	112.6	104.7	119.1	104.1	93.2	89.6	100.2	82.7	87.9	83.1
Гянтболдын баяжмал	-	-	0.1	-	1.0	1.0	0.7	0.6	0.4	0.4

Зэсийн хүдэр, баяжмалын экспорт 2019 онд 1403.6 мянган тонн болж өмнөх оноос 33.1 мянган тонн буюу 0.3 хувиар, гянтболдын баяжмалын экспорт 0.7 мянган тонн болж 0.1 мянган тонн буюу 14.7 хувиар, молибдений баяжмалын экспорт 5.7 мянган тонн болж, өмнөх оноос 0.3 мянган тонн буюу 5.1 хувиар тус тус буурчээ. Харин төмрийн хүдэр, баяжмалын экспорт 2019 онд 8448.8 мянган тонн болж, өмнөх оноос 1.0 сая тонн буюу 13.4 хувиар, цайрын хүдэр, баяжмалын экспорт 134.8 мянган тонн болж, өмнөх оноос 10.9 мянган тонн буюу 8.8 хувиар нэмэгдсэн байна.

Нэг хүнд ногдох зэсийн баяжмал 2019 онд 395.7 кг болж, өмнөх оноос 19.2 кг буюу 4.6 хувиар, молибдений баяжмал 1.8 кг болж, өмнөх оноос өөрчлөлтгүй, хайлуур жоншны баяжмал 14.9 кг болж, 10.6 кг буюу 41.7 хувиар, төмрийн хүдрийн баяжмал 1061.5 кг болж, 16.5 кг буюу 1.5 хувиар, цайрын баяжмал 26.0 кг болж, 1.8 кг буюу 6.4 хувиар тус тус буурчээ. Харин нэг хүнд ногдох хайлуур жонш баяжмал 2019 онд 48.9 кг болж өмнөх оноос 16.9 кг буюу 52.7 хувиар, төмрийн хүдэр 2687.2 кг болж, 716.5 кг буюу 36.6 хувиар нэмэгдсэн байна.

5.5.3. Олборлох салбараас орсон Засгийн газрын нийт орлого (Шаард 6.3.б)

Уул уурхайн салбарын орлого 3,138.5 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 138.4 (4.6 хувь) тэрбум, өмнөх оноос 744.9 (31.1 хувь) тэрбум төгрөгөөр давж биелсэн нь алт, төмрийн хүдрийн зах зээлийн үнэ өссөн, жоншны биет хэмжээ 2 дахин, бусад орлого 96.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн зэргээс голлон шалтгаалсан байна (Эх сурвалж: СЯ).

Хүснэгт 5.54 Уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ, тэнцвэржүүлсэн үнэ, нийт орлого

Бүтээгдэхүүний нэр төрөл	Биет хэмжээ			Үнэ, ам.доллар/нэгж			Нийт орлого /тэрбум төгрөг/		
	2018	2019		2018	2019		2018	2019	
	Гүйц	Төлөв	Гүйц	Гүйц	Төлөв	Гүйц	Гүйц	Төлөв	Гүйц
Зэсийн баяжмал /мян.тн/	1436.7	1400.0	1403.6	6524.8	6272.2	6004.6	999.0	1304.4	1333.3
Нүүрс /мян.тн/	36265.1	42000.0	36748.8	77.3	75-100	84.5	998.0	1310.8	1282.2
Алт /тн/	18.1	21.0	13.2	1266.5	1262.1	1389.6	80.0	82.5	116.8
Цайр /мян.тн/	123.9	78.2	134.8	1596.3	2899.2	2548.6	78.0	56.2	76.6
Төмрийн хүдэр /мян.тн/	7449.0	7550.0	8448.8	45.9	40.0	68.3	31.5	67.2	47.5
Жонш /мян.тн/	555.2	360.0	699.4	341.9	355.0	293.5	18.2	23.1	39.3
Бусад	-	-	-	-	-	-	188.9	155.9	251.8
Нийт дүн							2393.6	3000.1	3138.5

Эх үүсвэр: Сангийн яам

Уул уурхайн гол нэрийн зарим эрдэс бүтээгдэхүүний биет хэмжээг өөдрөг төлөвлөснөөс үүссэн орлогын зөрүүг үнийн өсөлттэй бүтээгдэхүүний орлогоор нөхсөн байна. Газрын тосны орлого 231.7 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 103.9 (30.9 хувь) тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь экспортын хэмжээ төлөвлөснөөс 1.6 сая баррелиар бага байгаагаас шалтгаалжээ.

Нэгдсэн төсвийн нийт орлогын 26.1 хувийг уул уурхайн салбарын орлого эзэлж байгаа нь өмнөх оноос 2.6 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 5.55 Уул уурхайн салбарын татварын орлогын гүйцэтгэл, сүүлийн 4 жилийн байдлаар, тэрбум төгрөг

Орлогын албан татвар	Он				
	2016	2017	2018	2019	2019/2018
АМНАТ	288.7	847.8	1047.0	1425.7	136.2
ААНОАТ	225.8	443.7	653.1	869.2	133.1
НӨАТ	22.1	30.8	31.3	43.1	137.7
Бусад	231.0	300.8	662.2	800.5	120.9
Дүн	767.6	1623.1	2393.6	3138.5	131.1

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

Уул уурхайн салбарын 2019 оны нийт орлогын 45.4 хувийг АМНАТ, 27.7 хувийг ААНОАТ, 1.4 хувийг НӨАТ, 25.5 хувийг бусад татварын болон татварын бус орлого тус тус бүрдүүлсэн байна.

5.5.4. Олборлох үйлдвэрлэлийн экспорт орлого (Шаардлага 6.3.с)

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 онд 13.7 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 6.7 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оноос 31.3 хувиар өссөн байна.

2019 онд экспортоор 7.6 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өмнөх оноос 8.7 хувиар өссөн байна. Уг өсөлтөд нүүрс, зэсийн баяжмал, жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Уул уурхайн салбар 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт экспортын 88.6 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Дэлхийн эдийн засгийн удаашралт нь үйлдвэрлэлийн үндсэн орц болох газрын тос, зэс зэрэг бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дэх үнийг бууруулж байгаа нь экспортын хэмжээ 2019 онд буурахад хүргэсэн байна. Харин дэлхийн зах зээл дэх зарим түүхий эдийн үнэ 2019 онд өндөр байсантай холбоотойгоор манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүд болох чулуун нүүрс, боловсруулаагүй алт, төмрийн хүдрийн экспорт өссөн нь барааны тэнцэл 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарахад голлон нөлөөлсөн байна.

Байгалийн нөөцөөр баялаг, хөгжиж буй бусад улс орнуудын адил Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын экспорт нь нь цөөн тооны, нэмүү өртөг багатай уул уурхайн түүхий эдэд суурилж байна. Аж үйлдвэрийн салбарын 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэмэгдэл өртгийн 67.0 хувийг уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар, 27.3 хувийг боловсруулах үйлдвэрийн салбар бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд, аж үйлдвэрийн салбарт уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын эзлэх хувь өндөр байна.

5.6 ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУД

Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хамгийн их оролцоотой Засгийн газрын байгууллагуудын нэрсийг, ажил үүргийн ерөнхий чиглэлийн хамт Хүснэгт 5.56-д харуулав.

Хүснэгт 5.56 Засгийн газрын байгууллагууд

Засгийн газрын байгууллагууд	Вебсайтууд
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	www.mmhi.gov.mn
Ашигт малтмал, газрын тосны газар	www.mrpam.gov.mn
Байгаль орчин, аялал жуучлалын яам	www.mne.mn
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	www.mlsp.gov.mn
Татварын Ерөнхий Газар	www.mta.mn
Гаалийн ерөнхий газар	www.customs.gov.mn
Үндэсний аудитын газар	www.audit.mn
Цөмийн энергийн комисс	www.nea.gov.mn
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	www.pcsp.gov.mn

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхэм зорилго нь ил тод, хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулж, эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгоход оршино.

Уул уурхай, түлш, газрын тос, хүнд үйлдвэр, геологийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлого, дунд, урт хугацааны стратеги, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, хэрэгжилтэд дотоодын хяналт-шинжилгээ хийх, төсвийн санхүүжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах нь тус яамны зорилго юм.

Ашигт малтмал, газрын тосны газар

Ашигт малтмал, газрын тосны газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид,

хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд зорилт тавьж ажилладаг.

Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалт болон Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсүүд нь Газрын тосны тухай хууль болон холбогдох дүрэм, журмуудын дагуу Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

БОАЖЯ-ны үндсэн үйл ажиллагаа нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой үндэсний бодлого, хууль журмын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалахад оршино. Түүнчлэн, БОАЖЯ нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой тусгай асуудлуудын хүрээнд нийслэлийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын дагаж мөрдвөл зохих дүрэм журам, бодлогыг боловсруулж батлах, түүнтэй холбогдох шийдвэрийг гаргадаг.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тусгай зөвшөөрөлдөө хүлээж аваад 30 хоногийн дотор байгаль хамгаалах төлөвлөгөө БОАЖЯ-нд ирүүлэх ёстой байдаг ба яам уг тайланг хүлээн авч, хянах үүрэгтэй. Яам нь компаниудын байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд төсөвлөсөн зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлдэг. Тухайн компани байгаль хамгаалах төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлээгүй нөхцөлд уг 50 хувийг төлөвлөсөн зориулалтаар нь БОАЖЯ зарцуулах эрхтэй.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ХНХЯ-ны үндсэн үүрэг нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах явдал бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бодлогыг хэрэгжүүлэх, хөдөлмөрлөх таатай орчин бүрдүүлэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах замаар хүний нөөцийг хөгжүүлэх явдал юм.

ХНХЯ нь хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах, ажиллах нөхцөл ба амьжиргааны өртгийн асуудлыг сайжруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэдийн ажил эрхлэлтийн асуудал болон гадаад улсад хөдөлмөр эрхлэгчдийн асуудлыг зохицуулах үүрэгтэй. ХНХЯ-ны эрхэм зорилго нь хөдөлмөрлөх таатай орчин болон хөдөлмөрийн зах зээл дэх тэгш боломжийг бүрдүүлэх явдал юм.

Татварын Ерөнхий Газар

Татварын ерөнхий хуульд зааснаар Үндэсний татварын алба нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ТЕГ), аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагчаас бүрдэнэ. ТЕГ нь ЗГ-ын санхүүгийн асуудал хариуцсан байгууллага болох Сангийн Яамны харъяа байгууллага бөгөөд түүний удирдлагад ажилладаг.

ТЕГ-ын үндсэн чиг үүрэг нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх явдал юм.

Гаалийн ерөнхий газар

Монгол Улсын Гаалийн үйл ажиллагааг гаалийн төв байгууллага болох ГЕГ удирдан чиглүүлдэг бөгөөд түүний харьяанд аймаг, нийслэлийн гаалийн албадууд хамаарна. ГЕГ нь гаалийн хууль тогтоомжийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага бөгөөд Сангийн Яамны хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг.

ГЕГ-ын үндсэн чиг үүрэг нь гаалийн хуулийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх, түүний нийцлийг хянах, гаалийн хяналтын стратегийг тодорхойлох, гаалийн алба хэлтсийн үйл ажиллагааг зохицуулах, Гаалийн Хөгжлийн Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх юм.

Үндэсний аудитын газар

Үндэсний аудитын газар нь Монгол Улсын аудитын дээд байгууллага бөгөөд Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт захирагдана.

Үндэсний аудитын газар болон Монгол Улсын Ерөнхий аудиторын үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Улсын Их Хурлаас бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавих, үүрэг даалгавар өгөхийг хориглоно.

Улсын Их Хурлаас бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрээс нь үл хамааран аудит хийх бүрэн эрхтэй байдаг.

ҮАГ нь Гүйцэтгэлийн аудитын газар, Санхүүгийн аудитын газар, Нийцлийн аудитын газар, Бодлого, төлөвлөлтийн газар, Хуулийн хэлтэс гэсэн таван газар, хэлтсээс бүрддэг.

Цөмийн Энергийн Комисс

Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийг бэлтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилт тавьж ажилладаг.

Цөмийн Энергийн Комиссын үндсэн үйл ажиллагаанууд нь цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн ашиглалтыг зохицуулах Засгийн Газрын бодлогыг хэрэгжүүлэх; цөмийн байгууламж, материал, цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой тусгай зөвшөөрлийг олгох эсвэл цуцлах; Монгол Улсын цөмийн энергийн салбарын шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагааг зохицуулах, хянах; цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

Цөмийн Энергийн Комисс нь Тамгын газар, Цөмийн технологийн бодлогын газар, Цөмийн аюулгүй байдлын бодлогын газар, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс гэсэн дөрвөн газар, хэлтсээс бүрддэг.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн өмчийн талаарх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, менежментийг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэж, ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангах чиглэлээр ажиллаж байна.

Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”, 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 438 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн худалдан авах ажиллагааны газрыг байгуулсан.

5.7 ОЛБОРЛОХ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО

5.7.1 Төрийн өмчит аж ахуйн нэгжийн тодорхойлолт

ОУИТБС-ын Стандарт (2.6.a.i)-д ОУИТБС-ын тайлагналын зорилгоор төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨААН)-үүдийг “Засгийн газрыг төлөөлөн олборлох үйл ажиллагаа эрхэлдэг бүхэлдээ эсхүл ихэнх нь төрийн эзэмшлийн компани” хэмээн тодорхойлсон. ОУИТБС-ын Стандартаар ОТОБ нь үндэсний хууль эрх зүй, ЗГ-ын бүтэц, зохион байгуулалтын онцлогт нийцүүлэн ТӨААН-ийн

тодорхойлолтыг баримтжуулахыг хөхүүлэн дэмждэг бөгөөд ОТОБ-с уг тодорхойлолтыг тусгайлан хэлэлцэж, батлаагүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд төрийн өмчит аж ахуйн нэгжийг дараах байдлаар ангилж, тодорхойлсон. Үүнд:

- төрийн өмчит,
- төрийн өмчийн оролцоотой,
- төрийн өмчит үйлдвэрийн газар,
- төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар,
- орон нутгийн өмчит үйлдвэрийн газар,
- орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар зэргээр ангилна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн⁶ 13 дугаар зүйлд “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг **төрийн өмчит хуулийн этгээд** гэнэ” болон 21.1 дугаар зүйлд “Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг **төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ**” гэж заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу, **төрийн өмчит үйлдвэрийн газар** гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь **аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар** гэж ангилна. Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг **аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар** гэнэ. Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар** гэнэ.

Компанийн тухай хуулийн⁷ 12.5 дугаар зүйлд **төр, түүний байгууллага** нь дараах тохиолдолд Компанийн үүсгэн байгуулагч болон түүний хувьцаа эзэмшигч байж болно гэж заасан. Үүнд:

- төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар шинээр бий болсон Компанийн;
- төрийн өмчит үйлдвэрийн газрыг Компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулах замаар үүссэн төрийн өмчит Компанийн;
- хууль тогтоомжид заасан журмын дагуу дампуурч байгаа Компанийн төрд төлөх өрийг хувьцаагаар нь сольж авсан Компанийн (Энэ тохиолдолд төр тухайн хувьцааг гурван жилийн дотор бусад этгээдэд худалдах үүрэгтэй);
- гадаад улсын хуулийн этгээдтэй хамтран байгуулсан Компанийн;
- хуульд заасан бусад

5.7.2 Олборлох салбар дахь төрийн оролцоог зохицуулах хууль эрх зүй

Одоогийн хууль эрх зүйн орчинд Монгол улс нь Эрдэнэс Монгол ХХК болон тэдгээрийн охин компаниудаар дамжуулан стратегийн ордууд дээр хувь эзэмшиж, оролцож байна.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого⁸ (2014-2025 он)-д төрийн зохицуулалтыг ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд оролцох оролцоог зохистой түвшинд байлгахыг тусгасан.

ТӨААН-ийн Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмаар⁹ зохицуулан томилдог. Энэхүү журмын 2.3-т олборлох салбарын төрийн

⁶ <https://www.legalinfo.mn/law/details/492>

⁷ <https://www.legalinfo.mn/law/details/310>

⁸ <https://www.legalinfo.mn/law/details/9756>

⁹ <https://www.legalinfo.mn/law/details/12142>

өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд төрийн өмчийн төлөөлөгчийг дараах байдлаар томилно гэж заажээ:

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэм”-ийн 7.1, 8.2-т заасны дагуу Засгийн газар томилж, чөлөөлнө.
- “Оюу толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын чиглэл болгосны дагуу “Эрдэнэс Оюу толгой” ХХК нэр дэвшүүлж, “Оюу толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал томилж, чөлөөлнө.
- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяа төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэс Оюу толгой” ХХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Мон-Атом” ХХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол хязгаарлагдмал хариуцлагатай Компанийн дүрэм”-ийн 11.8-д заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл болгосны дагуу төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилж, чөлөөлнө.
- Энэ журмын 2.4-2.91-т зааснаас бусад тохиолдолд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилж, чөлөөлнө.

5.7.3. ЗГ болон ТӨААН-ийн олборлох салбарын компаниуд дахь эзэмшил, эзэмшилд гарсан өөрчлөлтийн шилжүүлгийн нөхцөл

ОУИТБС-ын Стандартын 2.6.а.ii-д ЗГ болон ТӨААН нь тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад эзэмших өөрсдийн хувь эзэмшлийн түвшинг ил тод болгоно. Энэ нь ТӨААН-үүдийн салбар болон хамтарсан аж ахуйн нэгжид бас хамааралтай бөгөөд тайлангийн хугацаанд эзэмшилд гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийг ил тод болгох ёстой.

Компанийн тухай хуулийн 2.6-ын дагуу төрийн өмчит Компанийн хувьд өмчлөгч нь төрийг төлөөлж Улсын Их Хурал, орон нутгийн өмчит Компанийн хувьд тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд тэдгээрийг төлөөлж хувьцаа эзэмшигч нь ЗГ болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас эрх олгосон этгээд байж болно.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит 20 Компанийн эзэмшил нь үндсэндээ төрийн мэдлийн хоёр холдинг группт хамаардаг. Эрдэнэс Монгол нь стратегийн ач холбогдолтой 6 ордод хамаарах төрийн өмчийг хянадаг бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь бусад 14 аж ахуйн нэгж дэх төрийн өмчийг эзэмшиж байна (барилгын материал үйлдвэрлэгч компаниуд, Эрдэнэт болон Монголросцветмет гэх мэт).

Хүснэгт 5.57 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий ТӨААН

№	Регистрийн дугаар	Төрийн өмчит аж ахуйн нэгж	ОУИТБС-ын нэгтгэлд хамрагдсан эсэх	Тусгай зөвшөөрлийн тоо	Ашигт малтмал	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшлийн хувь
Орон нутгийн өмчийн оролцоотой							
1	2014491	Баянтээг ХК	Тийм	1	Нүүрс	Шунхлай групп ХХК Орон нутгийн өмч Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	23.54% 70% 6.46%
2	3753298	Баян Хишиг Хараа ХХК	Үгүй	1	тодорхойгүй	Орон нутгийн өмч Кристал Топ Майн Групп	мэдээлэл олдоогүй

№	Регистрийн дугаар	Төрийн өмчит аж ахуйн нэгж	ОУИТБС-ын нэгтгэлд хамрагдсан эсэх	Тусгай зөвшөөрлийн тоо	Ашигт малтмал	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшлийн хувь
3	2034859	Могойн гол ХК	Тийм	2	Нүүрс	ЖИГЖИДСҮРЭН БАТБОЛД Транс нефт ХХК Орон нутгийн өмч Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	16.33% 15% 51% 17.67%
4	3753603	Сэлэнгэ байгалийн нөөц ХХК	Үгүй	2	Алт	Баянгол Хөгжлийн Гүүр Сэлэнгэ Баялаг Ирээдүй Сэргээгдэх Байгалийн Нөөц	мэдээлэл олдоогүй
5	2016656	Тавантолгой ХК	Тийм	1	Нүүрс	Шандас импекс ХХК Ажнай Корпораци ХХК Орон нутгийн өмч Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	16.97% 19.73% 51% 12.3%
Төрийн өмчийн							
6	9011706	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 439 дүгээр хаалттай хорих анги ТБАГУТҮГ	Үгүй	1	Шохойн чулуу	МУЗГ	100%
7	2550466	Монголросцвет мет ТӨХХК	Тийм	26	нүүрс, зэс, алт, жонш, гянтболд, төмөр, шохойн чулуу	МУЗГ	100%
8	9073523	Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих анги	Үгүй	2	шавар, түгээмэл тархацтай ашигт малтмал	МУЗГ	100%
9	2053152	ШТН ТӨААТҮГ	Үгүй	1	Шохойн чулуу	МУЗГ	100%
10	5124913	Эрдэнэс Монгол ХХК	Тийм	9	Нүүрс, мөнгө	МУЗГ	100%
11	6436226	Эрдэнэс силвер ресурс ХХК	Үгүй	1	Мөнгө, Алт /Шороо/	Эрдэнэс Монгол ХХК	100%
12	5435528	Эрдэнэс Тавантолгой ХК	Тийм	7	Нүүрс	Иргэн ААН Эрдэнэс Монгол ХХК	18.44% 0.06% 81.5%
13	2074192	Эрдэнэт ТӨХХК	Тийм	7	Зэс, молибден и, дайрга, түгээмэл тархацтай ашигт малтмал	МУЗГ	100%
Төрийн өмчийн оролцоотой							
14	2008572	Багануур ХК	Тийм	3	Нүүрс, хайрга, элс	Эрдэнэс МГЛ ХХК Монголиан коал корпорашн Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	75% 21.06% 3.94%
15	2074737	Гурвансайхан ХХК	Үгүй	4	Уран	Эрдэнэс Монгол ХХК Интернэшнл Ураниум ХХК	15% 85%
16	2051303	Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХК	Тийм	3	Төмөр	МУЗГ	100%

№	Регистрийн дугаар	Төрийн өмчит аж ахуйн нэгж	ОУИТБС-ын нэгтгэлд хамрагдсан эсэх	Тусгай зөвшөөрлийн тоо	Ашигт малтмал	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшлийн хувь
17	5976723	Мончех ураниум ХХК	Үгүй	1	тодорхой гүй	Эрдэнэс Монгол ХХК Ураниум Индастри ХХК	51% 49%
18	2004879	Шивээ-Овоо ХК	Тийм	1	Нүүрс	Эрдэнэс МГЛ ХХК Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	90% 10%
Төрийн хамтарсан							
19	2657457	Оюу Толгой ХХК	Тийм	3	Дайрга, Алт, Зэс, Холимог металл, Шавар, Элс	МУЗГ Туркойз Хилл Ресурс Рио Тинто	34% 66%
20	2076675	Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам (Улаанбаатар төмөр зам /Чулуун завод/ ХНН)	Тийм	1	Дайрга, Түгээмэл тархацтай ашигт малтмал	Зөвлөлтийн Зам Харилцааны Яам МУЗГ	49% 51%

Эх сурвалж: ОУИТБС-ын цахим тайлагнал болон Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны 10 дугаар сарын 29-ний байдлаарх лицензийн мэдээлэл, Компаниудаас ирүүлсэн мэдээлэл, УБЕГ-ын нээлттэй цахим мэдээлэл

5.7.4. Төрийн эзэмшилд гарсан өөрчлөлт

Компанийн нэр	Өөрчлөгдөхөөс өмнөх төрийн эзэмшлийн хувь	Өөрчлөлтийн дараах төрийн эзэмшлийн хувь
Эрдэнэт үйлдвэр ХХК ¹⁰	51%	100%

“Эрдэнэт” үйлдвэр нь хоёр улсын ЗГ хоорондын 1991 оны хэлэлцээрийн дагуу 51:49 хувийн эзэмшилтэй хамтарсан үйлдвэр, 2003 оны хэлэлцээрийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/-ийн хэлбэрээр ажиллаж байгаад 2016 оны 6 дугаар сард ОХУ-ын “Ростех” корпораци өөрийн эзэмшлийн 49 хувийг худалдсанаар Монгол Улсын Засгийн газар 51 хувийг, “Монголиан коппер корпорейшн” ХХК 49 хувийг эзэмшиж байв.

Монгол Улсын Засгийн газар 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр тогтоол гаргаж, “Эрдэнэт үйлдвэр”-ийг Төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг баталсан.¹¹

Хувьцааг төрийн өмчид бүртгэх, холбогдох төлбөрийг суутган тооцох тухай Монгол улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 7 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг Хөгжлийн банк болон Монголбанкнаас Худалдаа хөгжлийн банканд байршуулсан мөнгөн хөрөнгө, ногдол ашиг, вексель зэрэг эх үүсвэрээс суутган тооцохоор болж, суутган тооцох үйл ажиллагаа хийгдэж дуусаагүй.

5.7.5. Олборлох салбар дахь ТӨААН-үүдийн гүйцэтгэх үүрэг роль

Эрдэнэс Монгол ХХК

“Эрдэнэс Монгол” ХХК нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийн ордыг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан компани юм.

¹⁰ <http://www.pcsp.gov.mn/togtool/7.pdf>


¹¹ https://www.erdenetmc.mn/about_us/

Тус компани нь дараах охин компаниудаараа уул уурхайн ба бусад чиглэлийн үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

Хүснэгт 5.58 Эрдэнэс Монгол ХХК-ийн бүтэц

Компанийн нэр	Гүйцэтгэх үүрэг роль
1. Эрдэнэс Оюутолгой ХХК	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын Оюу толгой ордод үйл ажиллагаа явуулж буй “Оюу Толгой” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх
2. Эрдэнэс Тавантолгой ХК	Стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн коксжих нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах
3. Багануур ХК	Төвийн эрчим хүчний системийн харьяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах
4. Шивээ Овоо ХК	Дотоодын нүүрсний хэрэгцээ, Дулааны цахилгаан станц-4-ыг нүүрсээр хангах
5. Мон Атом ХХК	Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх
6. Гашуун сухайт авто зам ХХК	Өмнөговь аймгийн Цогтцэций суманд орших Таван толгойн уурхайгаас Гашуун Сухайтын хилийн боомт хүртэлх 239 км уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалт бүхий хүнд даацын хатуу хучилттай авто замын ашиглалт, үйлчилгээ, засвар арчилгааг хариуцан ажиллах
7. Эрдэнэс Метан ХХК	Монгол улсын нутаг дэвгэрт нүүрсний сав газрууд дахь нүүрсний давхаргын метан хийн /НДМ/ эрэл судалгааны ажлыг гүйцэтгэх, судалгааны ажлын үр дүнд үндэслэн метан хийн нөөцийг тогтоох, хөрөнгө санхүүжилт босгох, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, НДМ хийг олборлох, ашиглах чиглэлээр тодорхой төлөвлөгөө боловсруулах
8. Эрдэнэс шивээ энерги ХХК	Стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн байгуулах “Эрчим хүчний экспортын Шивээ Энержи цогцолбор төсөл”-ийг нүүрсээр хангах
9. Эрдэнэс силвер ресурс ХХК	Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, Ашигт малтмал эрэх, хайх, Ашигт малтмал олборлох, ашиглах, гэрээгээр өрөмдлөг хийх
10. Эрдэнэс алт ресурс ХХК	Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй “Алт 2” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт үнэт металл эрэх, хайх, олборлох, цэвэршүүлэх, борлуулах
11. Эрдэнэс ашид ХХК	Хайгуул, судалгааны ажил хийгдсэн болон хийгдээгүй эрдсийн хуримтлал бүхий талбайд геологийн эрэл-үнэлгээ, нарийвчилсан хайгуулын ажил эрхлэх, орд газрыг түшиглэн ашигт малтмалыг баяжуулах болон олборлолт, үйлдвэрлэх
12. Эрдэнэс стийл ХХК	Кокс, ган төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийн төслийг гүйцэтгэх
13. Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК	Стратегийн ач холбогдол бүхий том төслүүдэд мэргэжлийн хөрөнгө оруулагч нараас хөрөнгө оруулалт татах
14. Газрын ховор элементийн төслийн нэгж	Монгол Улсын газрын ховрын элементийн судалгаа хийх, орд газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах
15. Монголын эрдэс баялийн бирж ХХК	Экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах зорилгоор эрдэс баялгийн бирж байгуулах

Зураг 5.9 “Эрдэнэс Монгол” ХХК-ийн уул уурхайн салбан компаниудын бүтцийн зураглал




Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК <http://www.erdnesmongol.mn>

Эх сурвалж: ОУ-ын Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн

<https://resourcegovernance.org/sites/default/files/documents/erdnes-mongol-mongolian.pdf>

Зураг 5.10 Эрдэнэс Монгол” ХХК-ийн хувь эзэмшлийн зураглал



Эх сурвалж: ОУ-ын Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн

<https://resourcegovernance.org/sites/default/files/documents/erdenes-mongol-mongolian.pdf>

Эрдэнэс Монгол ХХК-ийн үүсгэн байгуулалт

“Эрдэнэс Монгол” ХХК өөрийн охин компаниудаараа дамжуулан зэс, алт, молибден, мөнгө, коксжуулсан хүдэр, цайрын баяжмал, төмрийн хүдэр, холимог металл болон фосфорит үйлдвэрлэх зэргээр уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг. Компани нь 2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Засгийн Газрын 266 дугаар тогтоол болон 2007 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Төрийн Өмчийн Хорооны 52 дугаар тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан ба Улаанбаатар хотод байрладаг.

МУ-ын ЗГ-ын 2016 оны 80 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан.

Энэхүү журмын 2.6-д “Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяа төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэс Оюу толгой” ХХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Мон-Атом” ХХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн¹² 11.8-д заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.

Эрдэнэс оюу толгой ХХК

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Оюу толгойн зэс-алтны ордыг ашиглах “Хөрөнгө оруулалтын гэрээ”-г Монгол Улсын Засгийн Газар, “Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед” ХХК, “Айвенхоу Майнз” ХХК-ууд 2009 онд байгуулсан. Түүнчлэн “Оюу Толгой” ХХК-ийн хувь нийлүүлэгч талуудын хооронд “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”-г 2010 онд байгуулан ажиллаж байна.

Эдгээр гэрээнүүдийн дагуу “Оюу Толгой” ХХК-ийн хувьцааны 34 хувийг Монгол Улсын Засгийн Газар эзэмшиж байгаа бөгөөд “Эрдэнэс Монгол” ХХК-нд энэхүү 34 хувийг эзэмшүүлсэн.

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 348 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолуудаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани болох “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийг шинээр үүсгэн байгуулж, “Оюу Толгой” ХХК-ийн хувьцааны 34 хувийг “Эрдэнэс Монгол” ХХК-иас “Эрдэнэс Оюу Толгой”¹³ ХХК-нд албан ёсоор шилжүүлэв.

“Эрдэнэс Оюу Толгой” ХХК нь Монголын талын 34 хувийн хувьцааг эзэмшин, “Оюу Толгой” ХХК-ийн үйл ажиллагаанд оролцож, ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх явдал юм.

Оюу толгойн ил болон гүний уурхай бүрэн ашиглалтад орсноор ирээдүйд дэлхийн хэмжээний 5 том зэсийн уурхайн нэг болж Ази тивд олборлох нийт зэсийн 24 хувийг олборлоно.

Эрдэнэс Тавантолгой ХК

МУ-ын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн коксжих нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор 2010 онд “Эрдэнэс Таван толгой” ХК¹⁴-ийг байгуулсан.

“Эрдэнэс Таван толгой” ХК нь “Ашигт малтмалын тухай” хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлээр ажилладаг.

“Эрдэнэс Таван толгой” төсөл нь нүүрс олборлолт, бүтээгдэхүүн боловсруулах, дэд бүтэц, үйлдвэрүүдийг барьж байгуулах, ус хангамжийн системийг байгуулах, ордод нэмэлт хайгуул, судалгаа хийх, бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд хүргэх, дотоодын болон олон улсын

¹² <https://www.legalinfo.mn/annex/details/7188?lawid=11796>

¹³ <http://eot.mn/>

¹⁴ <https://ett.mn/mon/>

хөрөнгийн зах зээлд хувьцаа арилжаалах гэсэн үндсэн чиглэлээр хэрэгжих юм.

Цанхийн Зүүн уурхайн ТЭЗҮ-ийг 2011 онд батлуулан, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд Цанхийн Баруун ТЭЗҮ-ийг 2012 онд батлуулан, олборлолтын үйл ажиллагааг 2013 оны 2 дугаар сараас тус тус эхлүүлсэн.

Ордын нийт нөөц: 6.008 тэрбум.тн

- Коксжих – 2.050 тэрбум.тн
- Эрчим хүчний – 3.757 тэрбум.тн
- Исэлдсэн – 0.201 тэрбум.тн

Багануур ХК

Багануур ХК анх 1978 онд Төвийн эрчим хүчний системийн харьяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зориулалтаар байгуулагдсанаас хойш 39 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. 2015 оны 2-р сарын 9-нд 100.0 сая дахь тонн нүүрсээ олборлосон.

1995 онд хувьчлагдан төрийн өмч давамгайлсан “Багануур” хувьцаат компани болон өөрчлөгдсөн. Нийт хувьцааны 75 хувийг төр буюу “Эрдэнэс Монгол” ХХК, 25 хувийг иргэд эзэмшдэг.

Үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал 4.0 сая.тн бөгөөд дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч 3.6-3.8 сая.тн нүүрсийг олборлож 16.0-18.0 сая шоо метр хөрс хуулж, авто тээвэртэй болон тээвэргүй хосолсон ашиглалтын системээр олборлолт явуулдаг. Монгол Улсын нүүрсний хэрэгцээний 60%, төвийн бүсийн нүүрсний хэрэгцээний 70 гаруй хувийг дангаараа хангаж ирсэн.

Багануурын нүүрс нь өөрийн физик, хими шинж чанараараа зөвхөн эрчим хүчний зориулалтаар ашиглагдах төдийгүй дахин боловсруулалт хийгдэн шатдаг хий, түлш, шингэн ба шахмал түлш, бусад химийн үйлдвэрлэлийн түүхий эд болох бүрэн боломжтой нь судалгаагаар батлагдсан.

Ордын нийт нөөц: 812 060.6 мян.тн

- Балансын – 584 458.4 мян.тн
- Балансын бус – 227 602.2 мян.тн

Өмнөх хайгуулаар ордын нийт нөөц 599.7 сая.тн байсан ба нэмэлт хайгуулаар нөөц 812.1 сая.тн болж 212.4 сая.тн-оор нэмэгдсэн.

Шивээ овоо ХК

1995 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус уурхайг Төрийн өмч давамгайлсан “Шивээ-Овоо” ХК болгон зохион байгуулав. Нийт хувьцааны 90 хувийг төр буюу “Эрдэнэс Монгол” ХХК, 10 хувийг иргэд эзэмшдэг.

Сүүлийн жилүүдэд уурхайн уулын ажлын/нүүрс олборлолт, борлуулалт, хөрс хуулалт/ хэмжээ тогтвортой нэмэгдэж нүүрсний дотоодын зах зээл дээр эзлэх байр суурь улам бүр бэхжиж байна. Тус компани нь Монгол Улсын дотоодын нүүрсний хэрэгцээний 30%, “ДЦС-4” ТӨХК-ийн хэрэгцээний 50%-ийг хангаж байна.

Шивээ-Овоогийн нүүрсний уурхай нь Улаанбаатар хотоос зүүн урагшаа 265 километр, Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт, далайн төвшнөөс дээш 1,200 метрт оршдог.

Шивээ-Овоогийн нүүрсний орд нь нийт 29,500.0 га талбайг хамардаг бөгөөд нийт 2,708.7 сая тн нүүрсний нөөцтэй, 3 үндсэн хэсгээс бүрдэж байна. Үүнд:

Ордын нийт нөөц: 2,708.7 сая. тн

- Шинэ усны хэсэг - 564.1 сая.тн
- Өөхийн цагааны хэсэг – 1,147.9 сая.тн
- Ногоон тойрмын хэсэг - 996.7 сая.тн

Мон атом ХХК

Цөмийн энергийн тухай хуульд цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хэмжээнээс нь үл хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулж, ордыг ашиглах тохиолдолд төрийн төлөөллийг заавал хангасан байхыг шаарддаг. Энэ чиг үүргийг хариуцуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 45 дугаар тогтоолоор уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх үүднээс “Мон атом” ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Тус компани нь Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд бодлого, зохицуулалтын хувьд Цөмийн энергийн газарт, санхүүгийн хувьд Төрийн өмчийн хорооны мэдэлд анх үйл ажиллагаа явуулж байсан.

Гашуун сухайт авто зам ХХК

2011 онд Монголын хувийн хэвшлийн “Энержи Ресурс” ХХК 239 км замыг ашиглалтад оруулсныг Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Нүүрсний экспортыг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” 299 дүгээр тогтоолоор авто замын өмчлөлийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлсэн.

2014 онд нүүрсний голлох экспортлогч “Энержи Ресурс” ХХК, “Эрдэнэс Таван толгой” ХК¹⁵ болон “Таван толгой” ХК зэрэг компаниудын оролцоотойгоор “Гашуун Сухайт авто зам” ХХК-ийг компанийн байгуулж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн замын хариуцагчаар ажиллаж байна.

Эрдэнэс Метан ХХК

2016 оны 2 дугаар сард “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани “Эрдэнэс Метан” ХХК нь байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлэв. “Эрдэнэс Метан” ХХК нь тэргүүн ээлжид гадаадын хөрөнгө оруулалт татах замаар Таван Толгой болон бусад ордын нүүрсний давхаргын метаны нөөцийг тогтоох, дараагийн ээлжид метаны олборлолтыг эхлүүлж Улаанбаатар зэрэг хот суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, цаашид Монгол Улсыг хий экспортлогч орон болгох зорилготой ажиллаж байна.

Эрдэнэс шивээ энержи ХХК

Төр, хувийн хэвшлийн хамтарсан “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК нь 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдөр “Эрдэнэс Монгол” ХХК болон “Эйкүсора” ХХК-ийн хоорондын гэрээгээр байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 64-р хуралдааны тэмдэглэлийг үндэслэн байгуулагдсан 1.2 тэрбум тонн нүүрсний нөөцтэй “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК нь стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн байгуулах Эрчим хүчний экспортын Шивээ Энержи цогцолбор төслийг нүүрсээр хангах юм.

Тус Компанийн 50 хувийг Төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК, үлдсэн 50 хувийг хувийн хэвшлийн “Шинэ Шивээ” ХХК-ийн хувьцааг эзэмшдэг “Эйкүсора” ХХК тус тус эзэмшдэг.

Эрдэнэс силвер ресурс ХХК

Монгол улсын Засгийн газрын 2014 оны 133 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор “Эрдэнэс силвер ресурс”¹⁶ ХХК-ийг 2019 оны 05 дугаар сард үүсгэн байгуулсан.

“Эрдэнэс силвер ресурс” ХХК нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

¹⁵ <http://page.gsr.mn/>

¹⁶ <http://erdenessilver.mn/6/single>

- Уул уурхайн чиглэлээр зөвөлгөө өгөх
- Ашигт малтмал эрэх, хайх
- Ашигт малтмал олборлох, ашиглах
- Гэрээгээр өрөмдлөг хийх

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хүрээнд Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэл, Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр шийдвэрээр Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхит нэртэй 2887.85 га талбай бүхий ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл /XV-2021416/-ийг олгосон.

Эрдэнэс алт ресурс ХХК

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Алт-2” үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор үнэт металл эрэх, хайх, олборлох, цэвэршүүлэх, борлуулах чиг үүрэг бүхий “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-г 2018 онд байгуулсан. “Эрдэнэс Алт Ресурс” ХХК нь “Эрдэнэс Монгол” ХХК-н 100%-н эзэмшлийн компани юм

Эрдэнэс ашид ХХК

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт байрлах гурван талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулах зорилгоор “Эрдэнэс Ашид” ХХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК “Монголын Алт” ХХК-тай хамтран байгуулсан.

Эрдэнэс стийл ХХК

Монгол Улс дахь ган төмөрлөгийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор “Бэрэн групп” ХХК-тай хамтран кокс, ган төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийн төслийг санаачлан эхлүүлж, 2017 оны 04 дүгээр сард төсөл хэрэгжүүлэгч төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэс Стийл” 17 ХХК-ийг байгуулан ажиллаж байна. Эрдэнэс Монгол ХХК 100% эзэмшдэг.

Эрдэнэс ассет менежмент ХХК

Хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө босгох, бонд шаргах, хувьцаа эзэмших, худалдаалах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Тус компани нь СЗХ-ны даргын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны №296 тогтоолоор хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан байна. Эрдэнэс Монгол ХХК 100% эзэмшдэг.

Газрын ховор элементийн нэгжийн төсөл

2019 онд Засгийн газраас газрын ховор элементийн хайгуул, олборлолт, ашиглалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эдийн засгийн үр ашгийг тооцох судалгаа хийх үүрэгтэй төслийн нэгж байгуулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу “Газрын ховор элементийн судалгааны төслийн нэгж” нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны тавдугаар сарын 1-ний өдрийн 176 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны тавдугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар тогтоолоор байгуулагдсан.

Монголын эрдэс баялгийн бирж ХХК

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор Эрдэс баялгийн биржийг 100 хувь хувийн хэвшлийн хөрөнгөөр дотоод, гадаадын аж ахуйн нэгжүүдийн түншлэлд тулгуурлан байгуулахаар шийдвэрлэсэн.

¹⁷ <https://erdenessteel.mn/about-us-2/>

5.7.6. Олборлох салбарын нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүд

“Эрдэнэт Үйлдвэр ХХК

“Эрдэнэт Үйлдвэр ХХК нь дэлхийд томоохонд тооцогддог зэсийн уурхай, баяжуулах үйлдвэр юм. Анх 1978 онд Монгол – Орос хоёр орны ЗГ хоорондын гэрээний дагуу үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн.

2016 онд Оросын ЗГ-ын эзэмшиж байсан 49 хувь Монгол улс дахь хувийн эзэмшилд шилжсэн ба энэхүү хэлэлцээр нь хууль шүүхийн байгууллага дээр маргаантай байна. 2017 оны байдлаар тус үйлдвэр нь 657.3 сая тонн хүдэр зэсийн баяжмал үйлдвэрлэн боловсруулсан байна. Монгол Улсын Засгийн газар 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр тогтоол гаргаж, “Эрдэнэт үйлдвэр”-ийг Төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг баталсан.¹⁸

Монголросцветмет ХХК

Монголросцветмет нь хайлуур жоншны уул уурхайн үйлдвэрлэл явуулдаг бөгөөд одоогийн байдлаар гурван далд уурхайн орд, хоёр ил уурхайн орд болон боловсруулах үйлдвэрийн хүчин чадалтай компани юм. Компани нь хүчил болон төмөрлөгийн хайлуур жоншны, мөн алтыг баяжуулан боловсруулах үйл ажиллагаа явуулдаг.

Өнөөдрийн байдлаар үйлдвэрийн газар нь Улаанбаатар хотод Захиргаа, Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд орших “Бор-Өндөр”уулын баяжуулах үйлдвэр, Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Шижир алт” ХХК, “Зэрэгцээ” алтны үйлдвэрүүдийг багтаан үйл ажиллагаа явуулж байна. Оросын Засгийн Газрын эзэмшиж байсан 49 хувь Монгол улс дахь хувийн эзэмшилд 2016 онд шилжсэн ба Монгол улсын Засгийн газар 100 хувь эзэмшиж байна.

Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр

Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр нь 1990 онд Дархан-Сэлэнгийн төмрийн хүдрийн уурхайн үйлдвэрт суурилан үүсгэн байгуулагдсан. Төмөрлөгийн хүдрийн стратегийн ач холбогдол бүхий орд газрын нөөц нь ойролцоогоор 230 сая тонн байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд төмрийн хүдрийн нойтон соронзон боловсруулах цогц үйлдвэрийг 2014 онд байгуулсан. 2015 онд Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр менежментийн хувьчлалд орсон.

Улаанбаатар Төмөр Зам чулуун завод

Улаанбаатар Төмөр Замыг МУ-ын ЗГ 50 хувийг, үлдсэн 50 хувийг ОХУ-ын ЗГ эзэмшдэг. Түүний нэг салбар нэгж болох чулуун завод нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг бөгөөд 1956 оноос хойш Дорноговь аймгийн Даланжаргалан суманд хайрга олборлолтын үйл ажиллагааг явуулж байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд

Тавантолгой ХК

Тус уурхай нь зах зээлийн нөхцөлд зохицон 1994 оны 12 дугаар сарын 05-ны Засгийн газрын өмч хувьчлалын комиссын хурлын 42 тоот тогтоолоор төрийн өмч давамгайлсан Тавантолгой ХК болсон байна. 1995 оноос эхлэн Тавантолгой ХК нь орон нутгийн өмчит компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тавантолгойн нүүрсний орд нь Өмнөговь аймагт, Хятад – Монголын хилээс ойролцоогоор 270 км-ийн зайтай байрладаг.

Могойн Гол ХК

Могойн Гол ХК нь 1970 онд үүсгэн байгуулагдсан нүүрс олборлодог компани юм. Уурхай нь Хөвсгөл аймагт байрладаг бөгөөд 1994 оноос хойш Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй байна.

¹⁸ https://www.erdenetmc.mn/about_us/

Баянтээг ХК

Баянтээг ХК нь 1961 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд нүүрсний уурхайн орд газар нь Өвөрхангай аймагт буюу Улаанбаатар хотоос 560 км зайтай байрладаг. 1995 онд хувьцаат компани болж дахин зохион байгуулагдсан ба хувьцааны 70 хувь нь төрийн эзэмшилд байдаг. 1994 оноос хойш Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй байна.

Бусад ТӨААН-үүд

АМГТГ-аас ирүүлсэн тусгай зөвшөөрлийн мэдээлэлд үндэслэн бид ТӨААН-үүдээр дамжуулан ОУ-ийн салбар дахь бусад ТӨААН-үүдийн талаар олж мэдсэн. Гэвч эдгээр аж ахуй нэгжүүд нь 2019 онд материаллаг төлбөр хийгээгүй учраас нэгтгэлийн хүрээнд хамрагдаагүй. Үүнд:

- ШТН ТӨААТҮГ,
- Баян Хишиг Хараа ХХК,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 439 дүгээр хаалттай хорих анги ТБАГУТҮГ ,
- Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих анги , болон
- Сэлэнгэ байгалийн нөөц ХХК зэрэг багтаж байна.

Газрын тосны салбар дахь төрийн оролцоог энэхүү тайлангийн 5.4.12-с харна уу.

5.7.7. Засгийн газар болон ТӨААН-үүдийн санхүүгийн харилцаа**5.7.7.1. ЗГ болон ТӨААН-үүдийн санхүүгийн харилцааг зохицуулсан үндсэн дүрэм журам**

ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль болон хуулийн дагалдах Төрийн өмчийг хэрэгжүүлэх журмуудаар зохицуулдаг. Энэхүү хуульд тусгайлан заагаагүй бол ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Компанийн тухай хууль болон тухайн төрийн өмчит аж ахуйн нэгжийн Компанийн дүрмээр зохицуулдаг.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.15-т Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдал, ажлын үр дүнд хяналт тавина гэж заасан.

Хуулийн 21.16-д Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана. /Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/ Гэхдээ тухайн санхүүгийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр богино хугацаанд авах зээл, үнэт цаасанд хамаарахгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 13 дугаар заалтад Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигч нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс олгох ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр гаргана. Харин Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ (эсвэл Хувьцаа эзэмшигчдийн хурал ТУЗ-ийг орлож) ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг хуваарилах өдөр зэргийг тогтооно гэж заасан байна.

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргах зорилт дэвшүүлсэн.

ОУИТБС-ын стандартын ТӨААН-үүдтэй холбоотой шаардлагуудыг багтаасан тусгай маягтыг

Засгийн Газарт материаллаг төлбөр хийсэн 10 ТӨААН-үүд рүү явуулсан. Энэ маягтад ТӨААН болон Засгийн Газрын хоорондын санхүүгийн харилцаа, зээл болон зээлийн баталгаа, шилжүүлэг болон төсвийн шинжтэй зарцуулалт гэх мэт стандарт шаардлагуудыг багтаасан.

5.7.7.2. Хуримтлагдсан ашиг, ногдол ашиг

ТӨААН-ийн ногдол ашгийн бодлого нь холбогдох статусаасаа хамааран ялгаатай хууль эрх зүйгээр зохицуулагдана.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.3-т заасны дагуу ТӨБЗГ нь төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоодог. Компанийн тухай хуулийн 46.1-д Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

Компанийн тухай хуулийн дагуу ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх, өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх, эргүүлэн худалдаж авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх зэрэг нөхцөл бүрдсэн үед энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна.

Эрдэнэс тавантолгой ХК цахим хуудсаараа ТУЗ-ийн 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан ногдол ашгийн журмаа ил болгосон (Хүснэгт 5.59).¹⁹

Хүснэгт 5.59 Санхүүгийн харилцааг зохицуулах дүрэм журам

	ТӨААН нь өөрийн ногдол ашгийн бодлогыг баталж, мөрдөх эрхтэй юу?	ТӨААН нь ашиг хуримтлуулах эрхтэй юу?	ТӨААН нь үйл ажиллагаандаа дахин хөрөнгө оруулалт хийх эрхтэй юу?	ТӨААН нь гуравдагч талаас санхүүжилт /зээл авах эсвэл хувьцаа гаргах замаар/ татах эрхтэй юу?
Хууль, дүрэм журам	Тийм. ТӨХК-иудын хувьд Компанийн тухай хуулийн 46, 47-р зүйлийн дагуу ТУЗ ногдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргадаг.	Тийм. ТӨХК-иудын Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ хэдий хэмжээний ашгийг хуваарилах, хэдий хэмжээг хуримтлуулах шийдвэрийг Компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвар зэргээс хамааран гаргана.	Тийм. Тусгайлсан хуулийн зохицуулалт байхгүй ч ТУЗ эрх мэдлийн хүрээнд дахин хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрхтэй.	Тийм. ТӨХК-иудын хуулийн 41.1.Компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгөөр өөрийн бичиг гаргаж болно. 42.1 зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, Компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өөрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргана. Шилэн дансны тухай хуулийн 6.4.8, 6.8.1 Бонд, зээл, өөрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгслийг ил болгохыг шаарддаг.

¹⁹ <https://ett.mn/mon/143/single1>

Хүснэгт 5.60 Практик хэрэгжилт, сая төгрөгөөр

ТӨААН-ийн нэр	2019 оны үр дүнгээр зарласан ногдол ашиг	2019.12.31 хуримтлагдсан ашиг (алдагдал)	2019 онд хийсэн дахин хөрөнгө оруулалт	Гуравдагч талаас татсан санхүүжилт (зээл, өрийн болон өмч)
Багануур ХК	0	10,168	0	12,708
Баянтээг ХК	500	5,764	0	0
Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХК	0	(33,450)	0	0
Могойн гол ХК	0	2,029	0	0
Монголросцветмет ХХК	1,568	25,832	0	0
Тавантолгой ХК	44,923	88,923	0	0
Шивээ-Овоо ХК	0	(3,917)	0	0
Эрдэнэс Монгол ХХК	0	6,557	0	0
Эрдэнэс-Тавантолгой ХК	199,811	1,833,919	0	0
Эрдэнэт үйлдвэр ХХК	182,087	1,695,298	0	0
Эрдэнэс Оюу толгой ХХК	-	(9,512)	0	0
Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ	-	2,450	0	0
Эрдэнэт алт ресурс ХХК	-	(722)	0	0

Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан, компаниудаас ирүүлсэн мэдээлэл

5.7.7.3. Олгосон зээл, зээл эргэн төлөх хуваарь, хүү

ОУИТБС-ын стандарт 2019-н шаардлага 2.6.a.ii-д ЗГ болон ТӨААН нь тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй газрын тос болон байгалийн хийн компаниудад зээл олгосон, баталгаа гаргасан бол үүний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ОУИТБС-ын тайланд тусгасан байх ёстой. Үүнд эргэн төлөх хуваарь, хүү гэх мэт.

Стандартын шаардлагыг хангах үүднээс СЯ, МУХБ, ТӨААН-үүдээс зээл, зээлийн баталгааны талаар мэдээлэл ирүүлэхийг хүссэн. МУХБ-наас олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨААН-үүдэд олгосон зээлийн мэдээллийг ирүүлэхийг хүссэн боловч Банкны тухай хуулийн 7.2 дахь заалт, харилцагчтай байгуулсан гэрээнд заасны дагуу зээлдэгч нарын мэдээллийг гаргаж өгөх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн. ТӨААН-үүдээс Багануур ХК, Эрдэнэс тавантолгой ХК мэдээлэл ирүүлсэн.

Засгийн газраас “Эрдэнэс Монгол” ХХК-д гаргасан зээлийн баталгаа

“Эрдэнэс Монгол” ХХК болон Азийн хөгжлийн банкны хоорондын 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 35 сая ам.долларын, 12 жилд багтаан төлөх, LIBOR+0.60% хувьсах хүүгийн нөхцөлтэй зээлийн гэрээ (3385-МОН)-ний дагуу Эрдэнэс Монгол компанийн институцийн тогтолцоо, удирдлагын чадавхийг бэхжүүлэх зорилготой төсөлд МУЗГ батлан даагч болсон. Батлан даалтын гэрээ 20-г МУЗГ болон АХБ хооронд 2016 оны 6 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан. Төсөл нь 2019 оны 4 сарын 30-нд дуусах нөхцөлтэй. Зээлийн гэрээний нөхцөлүүд, эргэн төлөлтийн хуваарийг АХБ-ны цахим хуудаснаас харна уу. 21

Зээл

ТӨААН-үүдийн 2019 оны эцсээрх төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийн мэдээллийг аудитлагдсан санхүүгийн тайлангаас хураангуйлбал:

²⁰ <https://www.adb.org/sites/default/files/project-document/185252/49409-001-ga1.pdf>

²¹ <https://www.adb.org/sites/default/files/project-document/185253/49409-001-lbj.pdf>

Хүснэгт 5.61 ТӨААН-үүдийн төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл, 2019

Компанийн нэр	Зээлийн үлдэгдэл 2019.12.31	Үүнээс:				
		МУХБ	СЯ /АХБ/	Эрдэнэс Монгол	Арилжааны банк	Бусад
Эрдэнэс Монгол ХХК	184,949	160,492.90	24,455.75	-	-	0
Эрдэнэс-Тавантолгой ХК	0	0	0	-	-	0
Багануур ХК	81,040	0	31,905	34,005	12,708	2,422
Шивээ овоо ХК	4,897	Мэдээлэл ил тод биш				
Баянтээг ХК	771	Мэдээлэл ил тод биш				
Могойн гол ХК	0					0
Тавантолгой ХК	0					0
Монголросцветмет ТӨХХК	20,652	Мэдээлэл ил тод биш				
Эрдэнэт үйлдвэр ТӨХХК	0					0
Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХК	196,325	Мэдээлэл ил тод биш				

Эх сурвалж: Компаниудын аудитлагдсан санхүүгийн тайлан

Багануур ХК-ийн хувьд дараах зээлийг ЗГ болон ТӨААН-с авч, 2019 оны байдлаар үлдэгдэлтэй байна. Үүнд:

Хүснэгт 5.62 Багануур ХК-ийн зээл

Зээлдүүлэгч байгууллага	Олгосон огноо	Төлөгдөж дуусах огноо	Валют	Хүүний түвшин	Олгосон дүн /сая төгрөг өөр/	Төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл 2019-12-31 байдлаар сая төгрөг	Зээлийн зориулалт
Сангийн яам MON 2854	3/13/1997	6/1/2031	Төгрөг	1.8%	25,062	20,587	Багануурын хүрэн нүүрсний уурхайн техник, технологийн шинэчлэл хийх, тус уурхайн зохион байгуулалтыг бэхжүүлэх, нүүрсний салбарын стратеги төлөвлөгөө боловсруулах
Сангийн яам MON-P4	2/6/1998	2/22/2022	Төгрөг	1.8%	19,580	11,318	
Эрдэнэс Монгол ХХК	12/30/2014		Төгрөг		10,205	10,105	
Эрдэнэс Тавантолгой ХХК	6/7/2018	6/7/2019	Төгрөг	2.0%	13,900	13,900	Мөнгөн хөрөнгийн дутагдлыг багасгах, богино хугацаат зээл, өр төлбөрийг барагдуулах
Эрдэнэс Монгол ХХК	9/3/2018	2/28/2019	Төгрөг	8.4%	6,000	6,000	2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл, үйлдвэрлэлийн найдварт ажиллагааг хангахад хүрэлцэхүйц хэмжээний түлш, шатахуун худалдан авах, бэлэн нүүрсний нөөц бүрдүүлэх, их засварын ажлуудыг гүйцэтгэх
Эрдэнэс Монгол ХХК	9/2/2019	12/20/2019	Төгрөг	11.0%	4,000	4,000	Үүссэн мөнгөн хөрөнгийн дутагдлыг түр арилгах

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

5.7.8. ТӨААН-үүдийн хоорондын гүйлгээ (шаардлага 4.5)

ОУИТБС стандартын шаардлага 4.5-н дагуу Олборлох компаниудын зүгээс ТӨААН-дэд хийсэн төлбөр, ТӨААН-ээс төрийн байгууллагууд, төрийн байгууллагаас ТӨААН хооронд хийгдсэн материаллаг төлбөрийг ил тод болгоно.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-р заалтын хүрээнд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг ил тод болгох ёстой.

Нэгтгэл тайланд хамрагдсан нийт 11 ТӨААН-ээс 4 ТӨААН шилэн дансанд мэдээллээ ил тод болгосон. Тэдгээрийн мөнгөн орлого, зарлагын мэдээллээс ТӨААН-үүд хооронд хийгдсэн материаллаг төлбөрийг хураангуйлбал:

Хүснэгт 5.63 Эрдэнэс Монгол ХХК-ийн ТӨААН-үүдтэй хийсэн материаллаг гүйлгээ, сая төгрөгөөр Харилцагч ТӨААН-үүдийн нэр

ТӨААН-үүдийн нэр	Орлого	Зарлага	Гүйлгээний утга
Багануур ХК	533	4,000	Зээл, зээлийн хүү
Гашуун сухайт авто зам ХХК		13,454	Санхүүжилт, хоорондын тооцоо
Мон-Атом ХХК		1,147	Санхүүжилт, хоорондын тооцоо
Монгол улсын хөгжлийн банк		19,167	Зээл, зээлийн хүү
Шивээ Овоо ХК		1,500	Гэрээний дагуу зам засвар, барилга
ЭНЕРЖИ РЕСУРС	16,405	-	Замын хураамжийн орлого
Эрдэнэс Алт Ресурс ХХК		2,334	Санхүүжилт, хоорондын тооцоо
Эрдэнэс Ассет Менежмент ХХК		308	Санхүүжилт, хоорондын тооцоо
Эрдэнэс Метан ХХК		297	Санхүүжилт, хоорондын тооцоо
Эрдэнэс Оюу Толгой ХХК		755	Санхүүжилт, хоорондын тооцоо
Эрдэнэс силвер ресурс ХХК		468	Санхүүжилт, хоорондын тооцоо
Эрдэнэс Таван Толгой ХК		309	Гэрээний дагуу зээлийн төлбөр
Эрдэнэс-Оюу Толгой ХХК		70	Санхүүжилт, хоорондын тооцоо
Эрчим хүчний Экспортын Шивээ-Энержи цогцолбор төсөл		212	Төслийн санхүүжилт, хоорондын тооцоо

Хүснэгт 5.64 Шивээ овоо ХК-ийн ТӨААН-үүдтэй хийсэн материаллаг гүйлгээ, сая төгрөгөөр

Харилцагч ТӨААН-үүдийн нэр	Орлого	Зарлага	Гүйлгээний утга
Амгалан ДСтанц ХХК	3,121	-	Нүүрсний орлого
Бор Өндөрийн үйлдвэр	1,393	-	Нүүрсний орлого
ГС.ШШГГАЗАР 425-Р ХОРИХ АНГИ	-	100	Универсалжойнт ХХК, Ти Өү Би ХХК-н төлбөрт /тендер/
ДЦС-2 ТӨХК	615	-	Нүүрсний орлого
Зэвсэгт хүчний 281-р анги	20	-	Нүүрсний орлого
Илчлэг Шивээ ОНӨҮГ	10	-	Нүүрсний орлого
МЗХНН УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ /Замын 3-р анги/	-	47	Зам арчилгаа, засвар үйлчилгээний хөлс
Налайх дулааны станц ТӨХК	781	-	Нүүрсний орлого
Сэлэнгэ Энерго ОНӨҮГазар	205	-	Нүүрсний орлого
-Зүүнхараа ОНӨҮГ	206	-	Нүүрсний орлого
Туулын хишиг ОНӨААТҮГ	10	-	Нүүрсний орлого
УБТЗ ХНН	-	792	Тээврийн хөлс
УБТЗ-ын Аж ахуйн хэлтэс	-	11	АТҮЦС программын ашиглалтын багцын төлбөр
Улаанбаатар ТЭЦ-4	47,160	-	Нүүрсний орлого
Ус-Ду ОНӨААТҮГ	269	-	Нүүрсний орлого

ХИЛИЙН 0129-Р АНГИ /Улаан-Уул /	50	-	Нүүрсний орлого
Хорих анги Чойр	21	-	Нүүрсний орлого
Чандмань илч ХХК Дорноговь	1,515	15	Нүүрсний орлого, Тосны үнэ /тендер/
Шивээ сервис ХХК	-	978	Шивээ сервис ххк охин компанид ажилчидын хоол, хувцас угаалгын төлбөр
Эрдэнэс Монгол ХХК	1,500	-	Зээл

Хүснэгт 5.65 Монросцветмет ТӨХХК-ийн ТӨААН-үүдтэй хийсэн материаллаг гүйлгээ (2019 оны 1-р улирлын мэдээлэл ороогүй), сая төгрөгөөр

Харилцагч ТӨААН-үүдийн нэр	Орлого	Зарлага	Гүйлгээний утга
БНЗӨБЦТС ТӨХК	-	7,261	цахилгааны төлбөр
Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ ХК	-	761	цахилгааны төлбөр
ДСЦТС ХК	-	302	цахилгааны төлбөр
МЗХНН УБ Төмөр зам	-	3,700	тээврийн хөлс
Монголын далд уурхайн музей,сургалт судалгаа,аялал жуулчлалын төв	-	737	санхүүжилт
Шивээ овоо ХХК	-	893	нүүрсний үнэ
Шижир-алт АУ	521	-	Алтны борлуулалт
ШШГЕГ газар	165	-	барьцаа төлбөрийг буцаав
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	-	6	сэлбэг
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН ТӨААТҮГ	-	82	гэрээний төлбөр МР-2018-02-06 эрчим хүчний хэрэглээний аудит

Хүснэгт 5.66 Эрдэнэт үйлдвэр ТӨХХК-ийн ТӨААН-үүдтэй хийсэн материаллаг гүйлгээ (2019 оны 1, 2-р сарын мэдээлэл ороогүй), сая төгрөгөөр

Харилцагч ТӨААН-үүдийн нэр	Орлого	Зарлага	Гүйлгээний утга
Ачит Их ХХК /Эрдэнэт үйлдвэр 34% эзэмшдэг/	2,084	-	Ус, ашиглалтын төлбөр
Диспетчерийн үндэсний төв ТӨХХК	32,271	-	ДҮТ орлого
Дулааны цахилгаан станц	1,108	-	Усны төлбөр
МОНГОЛ УС ТӨААТҮГ	-	158	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулсны төлбөр /УХЦ/
Монгол Шуудан ХК Орхон	-	42	Шуудангийн төлбөр
Мон-Илч ХХК	-	2,223	Дулааны цахилгаан станцын БКЗ 75-39 ФБ маркийн зуух №3-ын их засварын ажил, өр
Нуурсний уурхай-Шарын гол	-	17,429	Эрчим хүчний нүүрс
УБТЗ-н хувь нийлуулсэн нийгэмлэг	2,300	24,000	РД:2074192 тээврийн хөлс, 2019 оны 03 дугаар сарын 01-ний байдлаар
Хаан Хунс ЭрдэнэтХХК	-	5,990	Халуун хоол, 2019/04
Хөтөл Цемент шохойн комбинат	54	2,500	Технологийн шохой, Цемент шохой ХК-ийн өмнөөс
Шуудан йлчилгээний газар Орхон	-	484	Гадаад дотоод хэвлэл захиалга, 2017 оны гадаад дотоод хэвлэл захиалга
ЭБЦТС ТӨХК	16,995	156,820	Цахилгаан эрчим хүчээр хангах, 2019/02
Эрдмин ХХК	3,631	-	Эрдмин ХХК-с ногдол ашгийн орлого
Эрдэнэт-Ус УҮГ	1,215	-	Усны үнэ / Эрдэнэт ус ДТС ОНӨХК
Эрчим хүчний зохицуулах хороо	-	172	2019 оны зохицуулах үйлчилгээний хөлс

Эх сурвалж: Шилэн дансанд ил тод болсон 5 сая төгрөгөөс дээших гүйлгээний мэдээлэл

5.7.9. ТӨААН-д санхүүгийн тайлангаа олон нийтэд ил тод болгосон байдал (шаардлага 2.6.б)

Хүснэгт 5.67 Санхүүгийн тайлан ил тод болгосон ТӨААН

ОУИБТС-ын стандартын зааварт тусгагдсан асуулт	ТӨААН нь санхүүгийн тайлан бэлтгэдэг үү?	Санхүүгийн тайлан нь аудитлагдсан уу?	НББ-ийн Олон улсын стандартын (НББОУС/СТОУС)-ын дагуу тайлангуудыг бэлтгэсэн үү?	Олон улсын стандартын дагуу аудитласан уу?	ТӨААН-ийн тайланг олон нийтэд ил тод болгосон уу? Хэрэв үгүй бол шалтгаан нь юу вэ?	Хэрэв иж бүрэн санхүүгийн тайланг ил болгоогүй бол Санхүүгийн хураангуй үзүүлэлтийг ил тод болгох боломжтой юу?	Санхүүгийн болон аудитын тайланг ил болгоход ямар нэмэлт арга хэмжээ авч болох вэ?
Зохицуулах хууль, дүрэм, журам	Тийм. НББ-ийн 8-р зүйлийн дагуу СТ заавал бэлтгэнэ.	Тийм. Аудитын тухай хуулийн дагуу 10-р зүйлийн дагуу заавал аудит хийлгэнэ.	Тийм. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4-р зүйлийн дагуу олон улсын стандартыг мөрдөнө.	Тийм. Төрийн аудитын тухай хуулийн 14.1 болон Аудитын тухай хуулийн 5.1	Тийм.	НББ-ийн тухай хуулийн 9.7.ААНБ нь зөвхөн аудит хийлгэсэн жилийн СТ болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт өөрийн цахим хуудсанд байршуулж ил тод болгож болно. МХБ-д бүртгэлтэй ХК-иуд санхүүгийн гол үзүүлэлтийг МХБ-ны цахим хуудсанд тавьдаг.	Ямар нэгэн нэмэлт арга хэмжээ авах шаардлагагүй .
ТӨААН-н нэр							
Эрдэнэс Монгол ХХК	тийм	тийм	тийм	тийм	Үгүй*		
Эрдэнэс-Тавантолгой ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм		
Багануур ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм		
Шивээ овоо ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм		
Баянтээг ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм		
Могойн гол ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм		
Тавантолгой ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм		
Монголросцветмет ТӨХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм	Үгүй*	
Эрдэнэт үйлдвэр ТӨХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм		
Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХК	тийм	Үгүй. Аудит хийгдэж байгаа.	Тийм	тодорхойгүй	Үгүй		

*Аудитлагдсан санхүүгийн тайланг ил тод болгосон тул аудитлаагүй тайланг ил болгох шаардлагагүй гэж үзсэн.

5.7.10. ТӨААН-үүдийн санхүүгийн тайлан

ОУИТБС-ын Стандарт 2019-р шинээр нэмэгдсэн шаардлагаар Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь өөрийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан боломжгүй бол өөрийн санхүүгийн гол үзүүлэлтүүдийг (баланс, ашиг/алдагдлын тайлан, мөнгөн урсгал гэх мэт) олон нийтэд ил тод болгох арга хэмжээ авна.

Хөрөнгийн биржид нээлттэй хувьцаат уул уурхайн компаниудын хувьд Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар²² дамжуулан аудитлаагүй санхүүгийн гол үзүүлэлт болон Сангийн яаманд тушаадаг иж бүрэн санхүүгийн тайланг олон нийтэд ил тод болгодог.

Нэгтгэлд хамрагдсан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 11 компаниас 6 компани нь нээлттэй хувьцаат компани, 1 компани нь хаалттай хувьцаат компани, үлдсэн 4 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу төрийн өмчит аж ахуйн нэгжүүд санхүүгийн болон аудитын тайлангаа ил тод болгох ёстой.

Хүснэгт 5.68 Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн ил тод байдал

Регистрийн дугаар	Компанийн нэр	МХБ дэх код	Шилэн дансанд санхүүгийн тайланг ил болгосон эсэх	МХБ-ийн цахим хуудсанд ил болгосон эсэх	Компанийн цахим хуудсанд ил болсон эсэх	Санхүүгийн тайланг ил тод болгосон линк
5124913	Эрдэнэс Монгол ХХК	-	үгүй	хамааралгүй	үгүй	
5435528	Эрдэнэс-Тавантолгой ХК	-	үгүй	хамааралгүй	тийм	https://ett.mn/mon/upload/news_files/d30062849c32a052e1d53a8b6f951d97.pdf
2008572	Багануур ХК	BAN	тийм	тийм	тийм	https://shilendans.gov.mn/org/5244?form=4418385&year=2019&month=12&group=0&task=725 http://www.baganuurmine.mn/?cat=38
2004879	Шивээ овоо ХК	SHV	үгүй	тийм	Цахим хуудас ажиллагаагүй	http://mse.mn/mn/company/460
2014491	Баянтээг ХК	BTG	үгүй	тийм	Цахим хуудасгүй	http://mse.mn/mn/company/445
2034859	Могойн гол ХК	BDL	үгүй	тийм	Цахим хуудасгүй	http://mse.mn/mn/company/444
2016656	Тавантолгой ХК	TTL	үгүй	тийм	үгүй	http://mse.mn/mn/company/458
2550466	Монголросцветмет ТӨХХК	-	тийм	хамааралгүй	үгүй	https://shilendans.gov.mn/org/5240?form=3857436&year=2019&month=12&group=0&task=728
2074192	Эрдэнэт үйлдвэр ТӨХХК	-	тийм	хамааралгүй	Тийм**	https://shilendans.gov.mn/pdfview?file=adfabf890a0265a7771b6cc5741918e5.pdf
2051303	Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХК	DTU	байхгүй	тийм	үгүй	http://mse.mn/mn/company/526

²² www.mse.mn

*Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хуулийн үйлчлэх хүрээнд багтаагүй тул шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ ил тод болгодоггүй.

**Эрдэнэт үйлдвэр нь цахим хуудсандаа шилэн дансны цэс оруулснаар ЗГ-ын шилэн дансны цахим хуудсанд шууд холбогдож байна.

5.7.11. ТӨААН-үүдийн аудитын тайлан

5.7.11.1. ТӨААН-үүдийн аудитын тайланг ил тод болгох хууль дүрэм, журам

Төрийн аудитын тухай хуулийн дагуу Төрийн аудитын байгууллага аудитын тайланг цахим хуудсаараа ил тод болгодог.

Төрийн аудитын тухай 2003.01.03-ны хуучин хууль нь 2019 онд үйлчилж байсан бөгөөд хуулийн 23.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн аудитын байгууллага гүйцэтгэлийн аудитын болон бусад тайланг хэвлэн нийтлэх буюу бусад арга замаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээж болно” гэж заасан.

Төрийн аудитын тухай хуулийн 2020.05.01-ний шинэчилсэн найруулгын 37.2-д Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

5.7.11.2. ТӨААН-үүдийн аудитын тайланг ил тод болгох хууль дүрэм, журмын практик хэрэгжилт

ОУИТБС-ын 2019 оны ЗГ-ын ирүүлсэн тайлангаар нийт хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй 20 ТӨААН байгаа бөгөөд эдгээрээс 8 байгууллагын аудитын тайланг www.audit.mn цахим хуудсанд ил тод болгосон. Нэгтгэлд хамрагдсан 10 ТӨААН-с 5 байгууллагын аудитын тайлан ТАБ-ын цахим хуудсанд, 1 байгууллагын аудитлагдсан тайлан шилэн дансны цахим хуудсанд ил тод болсон.

ТАБ-аас ирүүлсэн тайлбараар ил тод болгоогүй ТӨААН-ийн тайлан нь нууцын зэрэгтэй байж болно.

Хүснэгт 5.69 Тайлан ил тод болгоогүй ТӨААН

Регистрийн дугаар	Компанийн нэр	ТАБ-ын цахим хуудсанд ил тод болгосон эсэх	Ил тод болгосон линк
5124913	Эрдэнэс Монгол ХХК	Тийм	https://tailan.audit.mn/api/pages/116166e5e709c8efff03da104c27c0d6/watermarked.pdf
5435528	Эрдэнэс-Тавантолгой ХК	тийм	http://tailan.audit.mn/detail/5eba37ccd2ddc
2008572	Багануур ХК	тийм	http://tailan.audit.mn/detail/5eba33d017718
2004879	Шивээ овоо ХК	тийм	http://tailan.audit.mn/detail/5eba35f2df96f
2014491	Баянтээг ХК	Үгүй	
2034859	Могойн гол ХК	Үгүй	
2016656	Тавантолгой ХК	үгүй	
2550466	Монголпросцветмет ТӨХХК	тийм	http://tailan.audit.mn/detail/5eba34a1625c2
2074192	Эрдэнэт үйлдвэр ТӨХХК	Үгүй	https://shilendans.gov.mn/pdfview?file=7e6f510f0a0265a75c12f6cd2df7d622.pdf
2051303	Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХК	Үгүй	

5.7.12. ТӨААН-үүдийн үйл ажиллагаа, хөрөнгийн зардал, худалдан авалт, туслах гүйцэтгэгч, Компанийн засаглалтай холбоотой дүрэм журам, практик үйл ажиллагаа (шаардлага 2.6.с)

5.7.12.1. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа,

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулах суурь бичиг баримт нь Компанийн дүрэм байна.

Доорх хүснэгтээр ТӨААН-ийн дүрэм нийтэд ил тод болгосон холбоос харуулав.

Хүснэгт 5.70 ТӨААН-ийн дүрэм

Регистрийн дугаар	Компанийн нэр	Дүрэм баталсан огноо, дугаар	Ил тод болгосон линк
5124913	Эрдэнэс Монгол ХХК	Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоол	https://www.legalinfo.mn/annex/details/7188?lawid=11796
5435528	Эрдэнэс-Тавантолгой ХК	Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 01 тоот шийдвэр	https://ett.mn/mon/101/single1
2008572	Багануур ХК	Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016 оны шийдвэр	http://www.baganuurmine.mn/?p=3708
2004879	Шивээ овоо ХК	Ил тод болоогүй	
2014491	Баянтээг ХК	Ил тод болоогүй	
2034859	Могойн гол ХК	Хувь нийлүүлэгчдийн хурлын 2015 оны 02 дугаар тогтоол	http://governance.mn/upload/company/files/2015/12/18/b5c87eaa6f8f06f5a488687c8808ea88.pdf
2016656	Тавантолгой ХК	Ил тод болоогүй	
2550466	Монголросцветмет ТӨХХК	ТӨБЗГ-ын даргын 2018 оны 06 дугаар тогтоол	http://www.pcsp.gov.mn/togtool/6.pdf
2074192	Эрдэнэт үйлдвэр ТӨХХК	ТӨБЗГ-ын даргын 2018 оны 07 дугаар тогтоол	http://www.pcsp.gov.mn/togtool/7.pdf
2051303	Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХХК	Ил тод болоогүй	

5.7.12.2. ТӨААН-ийн зарцуулалтын удирдлагад (үйл ажиллагааны /урсгал/ болон хөрөнгө оруулалтын) хамаарах дүрэм журам, практик үйл ажиллагаа

ТӨААН-ийн зарцуулалтын удирдлагад хамаарах дүрэм журам

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхтэй: төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасан.

ТӨБЗГ нь ТӨААН-ийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, эдгээрт үндэслэн бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТӨААН-ийн саналыг үндэслэн баталж, хэрэгжилтэд ТУЗ-д төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдээр дамжуулан хяналт тавьж ажилладаг.

Түүнчлэн Шилэн дансны тухай хуулийн дагуу:

1. Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт сар бүр (Хуулийн 6.1.1, 6.1.6, 6.2.1, 6.2.2, 6.2.3, 6.2.6, 6.3.1, 6.3.3 заалтын хүрээнд).

- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (Хуулийн 6.2.4, 6.3.7 заалтын хүрээнд) зэргийг шилэн дансны цахим сайтад сар бүр мэдээллэх үүрэгтэй.

Дээрх 2 мэдээллийг ТӨААН шилэн дансанд хэрхэн ил тод болгосныг доорх хүснэгтээс харна уу.

5.7.12.3. ТӨААН-ийн зарцуулалтын удирдлагын практик үйл ажиллагаа

Хүснэгт 5.71 Шилэн дансны ил тод байдал

Регистрийн дугаар	Компанийн нэр	Шилэн дансад ил болгосон эсэх	
		1-р мэдээлэл	2-р мэдээлэл
5124913	Эрдэнэс Монгол ХХК	үгүй	үгүй
5435528	Эрдэнэс-Тавантолгой ХК*	тийм	тийм
2008572	Багануур ХК	үгүй	үгүй
2004879	Шивээ овоо ХК	Шилэн дансанд бүртгэлгүй	
2014491	Баянтээг ХК	үгүй	үгүй
2034859	Могойн гол ХК	үгүй	үгүй
2016656	Тавантолгой ХК	үгүй	үгүй
2550466	Монголросцветмет ТӨХХК	тийм	тийм
2074192	Эрдэнэт үйлдвэр ТӨХХК	тийм	тийм
2051303	Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХХК	Шилэн дансанд бүртгэлгүй	

*Өөрийн цахим хуудсанд байршуулсан.

5.7.12.4. ТӨААН-ийн худалдан авалтад хамаарах дүрэм журам, практик үйл ажиллагаа

ТӨААН-д Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу худалдан авалтыг явуулна.

ТӨААН-үүд уг хуульд нийцүүлэн дотооддоо худалдан авалтын дүрэм журам батлан мөрддөг. Тухайлбал, Эрдэнэс тавантолгой ХК өөрийн цахим хуудсанд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмыг байршуулсан байна.²³

Шилэн дансны тухай хуулиар:

- худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Хуулийн 6.1.1 заалтын хүрээнд),
- худалдан авах ажиллагааны тайлан (Хуулийн 6.1.1, 6.1.2 заалтын хүрээнд)
- худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг тухай бүр /хэрэв байгаа бол/
- хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг (Хуулийн 6.3.6, 6.4.3, 6.8.2 заалтын хүрээнд) тухай бүр ил болгох шаардлагатай.

Доорх хүснэгтээр дээрх 1-4 мэдээллийг хэрхэн ил тод болгосныг хураангуйлж харуулав (1-4 код):

²³ <https://ett.mn/mon/112/item1/1341>

Хүснэгт 5.72 Худалдан авалтын ил тод байдал

Регистрийн дугаар	Компанийн нэр	Шилэн дансад ил болгосон эсэх				Ил тод болгосон линк
		1	2	3	4	
5124913	Эрдэнэс Монгол ХХК	тийм	үгүй	хамаар алгүй	тийм	https://shilendans.gov.mn/org/5231?group=0&year=2019
5435528	Эрдэнэс-Тавантолгой ХК	тийм	тийм	хамаар алгүй	тийм	https://shilendans.gov.mn/org/5232?group=1&year=2019
2008572	Багануур ХК	тийм	тийм	хамаар алгүй	тийм	https://shilendans.gov.mn/org/5244?group=1&year=2019
2004879	Шивээ овоо ХК					Шилэн дансанд бүртгэлгүй
2014491	Баянтээг ХК	үгүй	тийм	хамаар алгүй	тийм	https://shilendans.gov.mn/org/5681?group=2&year=2019
2034859	Могойн гол ХК	тийм	тийм	хамаар алгүй	тийм	https://shilendans.gov.mn/org/5356?group=2&year=2019
2016656	Тавантолгой ХК	үгүй	тийм	хамаар алгүй	тийм	https://shilendans.gov.mn/org/7174?group=1&year=2019
2550466	Монголросцветмет ТӨХХК	тийм	тийм	хамаар алгүй	тийм	https://shilendans.gov.mn/org/5240?group=2&year=2019
2074192	Эрдэнэт үйлдвэр ТӨХХК	тийм	тийм	хамаар алгүй	тийм	

5.7.12.5. ТӨААН-ийн туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулахтай холбоотой дүрэм журам, практик үйл ажиллагаа

ТӨААН-ийн туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулахтай холбоотой хуулийн тусгайлсан зохицуулалт байхгүй. ТӨААН-үүдээс туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний мэдээллийг ирүүлээгүй.

5.7.13. Компанийн засаглалтай холбоотой дүрэм журам болон практик үйл ажиллагаа

ТУЗ-ийн бүрэлдэхүүн томилох дүрэм журам, практик үйл ажиллагаа

Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулдаг.

МУЗГ-ын 2016 оны 80 дугаар тогтоолоор Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдэд тавих шаардлага, түүний эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байдаг. Нийт гаргасан энгийн хувьцааны 100 хувь болон тодорхой хувийг эзэмшдэг бол Төрийн өмчийн оролцоотой этгээд гэж үзнэ. Төр тухайн хуулийн этгээдийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх гишүүнээр томилсон этгээдээр дамжуулан эрх, үүргээ хэрэгжүүлдэг. Компанийн тухай хуулийн 77.1 болон Компанийн дүрмээр тогтоосон журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгож, чөлөөлнө. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.6 төрийн

өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавина.

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлд ТУЗ-ийн гишүүдийн тоог Компанийн дүрмээр тодорхойлох бөгөөд хувьцаат компани болон төрийн өмчийн Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна гэж заасан.

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлд ТУЗ-ийг сонгох, эрхийг хугацаанаас нь дуусвар болгохтой холбоотой асуудлыг тусгасан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгоно. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхийн саналаар сонгоно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно.

ХХК-иудын хувьд Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно. Хувьцаат Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг ТӨААН хуульд нийцүүлэн баталж, мөрддөг. ТӨААН-үүдийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг энэхүү тайлангийн Хавсралт 21-д харуулав.

Хүснэгт 5.73 ТУЗ-ийн цалин урамшууллын мэдээлэл, сая төгрөгөөр

Компанийн нэр	ТУЗ-ийн урамшууллын дүн	Хөнгөлөлт, урамшуулал	Томилолтын зардал
Багануур ХК	78.1	5.3	13.1

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

5.7.14 Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрүүд

ОУИТБС-ын стандартын шаардлагын дагуу төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрт төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хүлээн зөвшөөрсөн нийтийн нийгмийн хөрөнгө оруулалт, тухайлбал нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтэц, түлшний татаас, засгийн газрын өрийн төлбөр гэх мэт улсын төсвөөс гадуурх зардлууд ордог.

Нэгтгэлд хамрагдсан 10 ТӨААН-үүдээс төсвийн шинжтэй зарцуулалтын мэдээг хүссэн. Үүнээс Багануур ХК зарцуулалтаа тайлагнаж, Эрдэнэс монгол ХХК, Таван Толгой ХК-иуд 2019 онд ямар нэг төсвийн шинжтэй зарцуулалт байхгүй гэж мэдээлсэн. Бусад 7 ТӨААН-үүдээс хариу ирүүлээгүй болно. Тодруулбал:

Хүснэгт 5.74 Төсвийн шинжтэй зарцуулалт, сая.төгрөгөөр

ТӨААН	Төсвийн шинжтэй зарцуулалт	Төлбөрийн хэлбэр	Дүн
Багануур ХК	Түлшний татаас /хөнгөлөлттэй үнээр нүүрс борлуулсан/		
	"ДЦС-4" ТӨХК	Мөнгөн	1,300
	"ДЦС-2" ТӨХК		351
	"ДДЦС" ТӨХК		235
	"ЭДЦС" ТӨХК		4
	"Амгалан ДС" ТӨХК		80
"Багануур Дулааны станц" ТӨХК	1,434		
Дэд дүн			3,404

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

Багануур ХК-ийн түлшний татаасыг дэлгэрүүлбэл дулааны цахилгаан станцуудад дэлхийн зах зээлийн үнээс 3-4 дахин бага үнээр нүүрс нийлүүлдэг гэдэг нь харагдаж байна.

Хүснэгт 5.75 Нүүрс нийлүүлэлт

№	ААНБ	Нийт татан авалтад эзлэх %	Нийлүүл элт нүүрс тн	Нийлүүл лэлт сая.төг	1тн нүүрсний дундаж үнэ /төг/	1тн нүүрсний дундаж өртөг /төг/	1 тн нүүрсний дундаж үнэ ам.доллар	1 тн дулааны нүүрсний дундаж дэлхийн зах зээлийн үнэ ам.доллар
Багануур ХК								
1	"ДЦС-4" ТӨХК	100%	1,853,452	62,526	33,735	34,436	12.25	29.81
2	"ДЦС-2" ТӨХК	100%	239,780	7,906	32,970			
3	"ДДЦС" ТӨХК	100%	129,817	4,236	32,627			
4	"ЭДЦС" ТӨХК	100%	2,935	97	33,026			
5	"Амгалан ДС" ТӨХК	100%	102,611	3,454	33,657			
6	"Багануур Дулааны станц" ТӨХК	100%	61,196	673	11,000			

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл, ОУ-ын 33-ийн үнийг АМГТГ-ын статистик мэдээлэл

Төгрөгөөрх нүүрсний борлуулалтын үнийг ам.долларт хөрвүүлэхдээ Монголбанкны 2019 оны дундаж албан ханшийг ашигласан.

5.8 ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ БОЛОН ОРЛОГЫН ХУВААРИЛАЛТ

5.8.1. Олборлох салбарын орлогын хуваарилалт

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулинд улсын төсвийн орлогын хуваарилалтад орж буй өөрчлөлтүүдийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг 2019 оноос эхлэн орон нутагт шилжүүлнэ.
- Уул уурхайн салбар хөгжихийн хэрээр тус салбарын нийгмийн хариуцлага нэмэгдэж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх шаардлага бий болохын зэрэгцээ уул уурхайн салбараас бий болсон орлогоос тухайн орон нутагт нь ахиу хөрөнгө хуваарилах шаардлага бий болж байна.
- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.7 дах заалтад “ашигт малтмалын хайгуулын болон тусгай зөвшөөрлийн төлбөр”-ийн орлогыг Улсын төсвийн татварын орлогын бүрэлдэхүүнд тусгасан. Энэхүү эх үүсвэрийн 50 хувийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7-д заасны дагуу аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилах хуулийн зохицуулалттай бөгөөд энэ нь 2020 оноос эхлэн мөрдөгдөнө.
- Хуулийн хэрэгжилтийг нэг жилээр наашлуулж ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувийг 2019 онд, үлдэх 50 хувийг 2020 онд буюу нийтдээ 100 хувь тухайн хайгуулын талбай оршиж байгаа орон нутгийн төсөвт шилжүүлэх зохицуулалтыг хийнэ. Харин ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувийг тухайн олборлолт явагдаж байгаа орон нутгийн төсөвт 2020 оноос эхлэн шилжүүлнэ. Энэхүү зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7-д өөрчлөлт оруулах байдлаар хийх ба үүнтэй уялдуулан мөн хуулийн 71 дүгээр зүйлийн 71.6 дахь хэсгийг хүчингүй болгохоор тооцсон байна.

5.8.2. Олборлох салбараас орж ирсэн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж бүртгээгүй тохиолдол (Шаардлага 5)

Улсын төсөвт бүртгээгүй байж болох орлогын мэдээлэл, ирээдүйд авах татварыг урьдчилан авчихсан боловч “өр” гэж бүртгэсэн байж болох тухай мэдээлэл байхгүй гэж Сангийн яам мэдээлсэн.

5.8.2.1. Орон нутгийн шилжүүлэг

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (шаардлага 5.2)

Орон нутгийн хөгжлийн сан бол иргэдийн саналаар шийдэж зарцуулах төсөв юм. Тус сан нь засаг захиргааны нэгжүүд өөрсдийн хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд болон бие даан хэрэгжүүлэх ёстой чиг үүргүүдээ санхүүжүүлэх боломж бүрдүүлдгээрээ давуу талтай юм.

2019 оны хувьд дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын 5 хувь, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 5 хувь, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30 хувь, олон улсын байгууллагаас олгох урамшуулал, дэмжлэгийг нийлүүлээд нийт 53.0 тэрбум төгрөгийг санд хуваарилсан байна.

Сангаас хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн хөгжлийн индекс зэргийг харгалзсан томъёогоор аймаг, нийслэл бүрт ногдох шилжүүлгийг хуваарилна. Аймаг, нийслэл өөрт ногдох хэсгээ үлдээж, 30 хувиас доошгүйг сум, дүүрэгтээ мөн ижил үзүүлэлт бүхий томъёо ашиглан шилжүүлэх ёстой.

Тухайн орон нутгийн иргэд олон нийтийн бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн, мөн тэдний санал санаачилгаар дэмжигдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах бөгөөд тухайн орон нутгийн иргэдийн нийтийн хурал, ИТХ-ын шийдвэрээр баталгаажих төсөвт тусгагдах ёстой.

Зураг 5.11 Орон нутгийн хөгжлийн сан дахь иргэдийн оролцоо



Эх үүсвэр: Иргэдийн төсөв-2018, СЯ

2013 онд Сангийн яамнаас орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн системийг нэвтрүүлсэн. Уг системээс 2013 оноос хойших хугацааны орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хуваарилалтыг аймаг, нийслэл, сум, дүүргээр харах боломжтой. www.tusuv-oronnutag.mof.gov.mn харна уу.

5.8.3. Орлогын менежмент ба зарцуулалт (шаардлага 5.3)

5.8.3.1. Төсвийн орлого бүрдүүлэлтэд олборлох салбарын оролцоо

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль, “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” хуульд дараах байдлаар заасан. Үүнд:

- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувийг 2019 оноос эхлэн тухайн хайгуулын талбай байршиж байгаа аймгийн орон нутгийн хөгжлийн санд улсын төсвөөс шилжүүлж байгаатай холбогдуулан шинэ хөрөнгө оруулалтын төслүүдийг эрэмблэх замаар хөрөнгийг оновчтой үр дүнтэй төлөвлөж зарцуулах, гүйцэтгэлийн хяналтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

- Түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50 хувь, газрын тосны тусгай зөвшөөрлийн орлогын 30 хувийг нүүрс болон газрын тос олборлож байгаа тухайн аймагт улсын төсвөөс шилжүүлж байгаа тул хуваарилсан хөрөнгийг агаарын бохирдолыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах үйл ажиллагаанд үр дүнтэй зарцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

5.8.3.2. Орлогын тогтвортой байдал, байгалийн баялагаас хамааралтай байдал (Шаардлага 5.3.b)

Хараат бус хянагч–нэгтгэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Сангийн яамнаас ирээдүйд төсвийн мөчлөгт гарах өөрчлөлтүүдийн талаарх таамаглал, олборлох салбарын үйлдвэрлэлийн хэмжээний талаарх төсөөлөл, ашигт малтмалын зах зээлийн үнийн төлөв байдал, олборлох салбараас орох орлогын хэмжээний тухай урьдчилсан тооцоо, олборлох салбарын орлогын улсын төсөвт эзлэх урьдчилан таамаглаж буй хувь хэмжээ зэрэг мэдээлэл ирүүлэхийг хүссэн. Яамдаас дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлээгүй байна.


5.8.3.3. Уул уурхайн салбарын хөгжлийн хандлага

Дэлхийн эдийн засгийн төлөв. Дэлхийн эдийн засаг 2020 онд 3.0 хувиар агшиж, 2021 онд 5.8 хувиар өсөхөөр таамаглагдаж байна. ОУВС-гийн зүгээс дэлхий дахиныг өргөн цар хүрээнд хамарч буй COVID-19 халдварын тархалт 2020 оны хоёрдугаар хагаст намжиж, хязгаарлалтын хориг арга хэмжээнүүд аажмаар цуцлагдсан тохиолдолд дэлхийн эдийн засаг 2021 онд эргэн сэргэнэ гэж таамаглаж байна. Гэсэн хэдий ч энэхүү цар тахлын цаашдын тархалтын төлөв, вакцин хөгжүүлэлт, тархалтыг хязгаарлахаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр дүн, дэлхийн санхүү болон таваарын зах зээлийн савлагаа зэрэг дэлхийн эдийн засгийн төлөвт нөлөөлөх олон хүчин зүйлс тодорхой бус хэвээр байгаа нь дэлхийн эдийн засгийн цаашдын хандлагыг оновчтой таамаглах боломжийг хязгаарлаж байна. Хэрвээ цар тахлын үргэлжлэх хугацаа уртсаж, 2021 онд дахин тархах тохиолдолд 2020 оны дэлхийн эдийн засгийн өсөлт төсөөлсөн түвшинд хүрэхгүй байх эрсдэлтэйг ОУВС анхааруулж байна.

5.8.3.4. Голлох ашигт малтмалын бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

Зэс. Зэсийн үнэ 2019 онд дунджаар 6,020.3 ам.доллар байж, өмнөх оны дунджаас 8.7 хувиар буурсан байна. Олон улсын шинжээчдийн дийлэнх нь зэсийн үнийг 2020 онд буурахаар төсөөлж байгаа бол харин 2021 онд өсөхөөр төсөөлсөн байна. Блүүмбергийн судалгаагаар сүүлийн гурван сарын хугацаанд шинжээчид 2020 оны зэсийн үнийн төсөөллийг бууруулаад байна. Энэ нь COVID-19 вирусийн тархалттай холбоотойгоор эдийн засгийн нийт эрэлт саарч байгаатай холбоотой юм. Харин судлаачид 2021 оны зэсийн үнийн талаар эерэг хүлээлттэй байна.

График 5.12. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/тонн/




Эх үүсвэр: Блүүмберг терминал

Алт. Алтны үнэ 2019 онд дунджаар 1,393.4 ам.доллар байж, өмнөх оны дунджаас 9.8 хувиар өсжээ. Алтны бодит хэрэглээ 2019 онд өсөөгүй хэдий ч, зах зээл дээрх тодорхой бус байдалтай холбоотойгоор алтанд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна. Мөн төв банкуудын алтны

цэвэр худалдан авалт өндөр байсан болон АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ гурван удаа буруулсан нь алтны үнэ нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Олон улсын шинжээчид алтны ханшийг 2020 онд үргэлжлэн өснө гэж таамаглаж байна. Дэлхийн зах зээл дээрх алтны үнэ 2020 онд дунджаар 1,640.0 ам.доллар, 2021 онд дунджаар 1660.0 ам.доллар байх төлөвтэй байна.

График 5.13. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/трой унц/




Эх үүсвэр: Блүүмберг терминал

Дунд хугацаанд алтны үнэ өсөхөөр байгаа нь дэлхийн зах зээл дээрх санхүүгийн болон улс төрийн тогтворгүй байдал, мөн дэлхийн улсуудын бодлогын хүү доогуур байгаатай холбоотой байна. Зах зээл дээрх тодорхой бус байдалтай холбоотойгоор төв банкуудын алтны худалдан авалт өндөр байгаа нь алтны эрэлтийг дэмжиж байна. Олон улсын мэргэжлийн шинжээчид 2020 болон 2021 оны алтны үнийн төсөөллөө өмнө таамаглаж байснаас нэмэгдүүлсэн байна.

Төмрийн хүдэр. Төмрийн хүдрийн үнэ 2019 онд дунджаар 93.1 ам.доллар байж, өмнөх оноос 35 орчим хувиар өссөн байна. Шинжээчид 2020 оны гангийн хэрэглээний өсөлт буурахаар төсөөлж байна. Иймд олон улсын байгууллагууд төмрийн хүдрийн үнийг 2020-2023 онд буурахаар төсөөлж байна.


График 5.14. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/тонн/



Эх үүсвэр: Блүүмберг терминал

Нүүрс. Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнэ 2019 онд 15 хувиар буурч, 177 ам.долларт хүрсэн байна. Судалгааны байгууллагууд дунд хугацаанд Австрали нүүрсний үнийг буурахаар төсөөлж байна.

График 5.15 Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/тонн/.




Эх үүсвэр: Блүүмберг терминал

Газрын тос. Газрын тосны үнэ 2019 онд дунджаар 57.0 ам.доллар байж, өмнөх оны дунджаас 12 хувиар буурсан байна. Судлаачдын таамгаар газрын тосны үнэ 2020 онд буурах бол 2021 онд эргээд өсөхөөр байна.

Сүүлийн саруудад ихэнх судалгааны байгууллагууд 2020 оны газрын тосны үнийн төсөөллөө бууруулж байна.

График 5.16 Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/баррель/.



Эх үүсвэр: Блүүмберг терминал

5.8.3.5. Системтэйгээр ил тод болгосон байдал

Олборлох салбараас олсон орлогыг төвлөрүүлж буй сангуудын орлого, зардал, үйл ажиллагааны тухай мэдээллийг ил тод болгох (Шаардлага 5.3.а).

Улсын төсөв, аудитын үйл ажиллагааны тухай тайлбар болон төсөв боловсруулах, зарцуулах, төслийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн тухай олон нийт дараах сувгуудаас нээлттэй мэдээлэл авч болно (Шаардлага 5.3.а).

Хүснэгт 5.76 Улсын төсөв, аудитын үйл ажиллагааны нээлттэй мэдээлэл

Цахим хуудас	Тайлбар
www.mof.gov.mn	Сангийн яамны үндсэн цахим хуудас бөгөөд яамны бүтэц, бодлого, чиглэл, төсвийн талаарх мэдээ, мэдээлэл
www.iltod.gov.mn	Төсвийн тухай цаг үеийн мэдээ, мэдээлэл, жил бүрийн төсвийн мэдээлэл, төсвийн холбогдолтой хууль, тогтоол, заавар журам
www.shilendans.gov.mn	Бүх төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газруудын төсөв, түүний зарцуулалтын талаарх мэдээ мэдээлэл
www.tusuv-oronnutag.mof.gov.mn	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл
https://publicinvestment.gov.mn “Төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшн	Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагааны онлайн веб хуудас болон гар утасны “Төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшн
www.e-balance.mof.gov.mn	Аж ахуйн тайлангийн нэгдсэн систем бөгөөд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой заавар, тушаал зөвлөгөө
www.audit.mn	Аудитын төлөвлөгөө, тайлан, зөвлөмж
www.tender.gov.mn	Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем
www.1212.mn	Үндэсний статистикийн хорооны мэдээллийн нэгдсэн сан
www.worldbank.org/mn/country/mongolia	Дэлхийн банкны Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас
www.imf.org/en/Countries/ResRep/MNG	Олон улсын валютын сангийн Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас
www.adb.org/countries/mongolia/main	Азийн хөгжлийн банкны Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас
www.internationalbudget.org	Интернэйшнэл Баджет Партнершип ТББ-ын цахим хуудас

6

БУСАД АСУУДЛУУД



6 БУСАД АСУУДЛУУД

6.1 БЕНЕФИЦИАР ЭЗЭД (ШААРДЛАГА 2.5)

Бенефициар эзэд гэдэг нь аливаа компанийн гинжхэнэ эзэмшдэг, удирддаг, эсвэл түүнээс ашиг хүртдэг хүмүүсийг хэлэх ба хууль ёсны хувьцаа эзэмшигчид болон компанийн төлөөлж ажиллаж байгаа албан тушаалтнуудаас өөр хүмүүсийг хэлдэг. Бенефициар эзэн нь тухайн компанид заавал хувь эзэмшсэн байх шаардлагагүй бөгөөд Компанийн шийдвэр гаргалтад оролцож, нөлөөлж, нарийн төвөгтэй өмчлөлийн бүтцийн ард нуугдаж, шууд болон шууд бусаар ашиг хүртэж байдаг.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон улсын стандартаар 2020 оны 1 дүгээр сарын 1 гэхэд эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, тендерт оролцогч компаниудын ашиг хүртэгч эцсийн эзэнг олон нийтэд нээлттэй болгох, холбогдох бүртгэлийн сантай байхыг хэрэгжүүлэгч улс орнууддаа шаардлага болгосон билээ.

Бенефициар эздийн талаар ОУИТБС-ын Олон улсын хорооноос дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Хүснэгт 6.1 Бенефициар эзэд

Он, сар	Арга хэмжээ
2013 оны 5 сар	БӨ-ийн бүртгэлийг тайлагнахыг шаардах болсон.
2013 оны 10 сар	ОУИТБС-ын 11 орон БӨ-ийн туршилтын төслийг хэрэгжүүлсэн
2016 оны 1 сар	ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч 29 орон тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байна. 9 орон тайландаа энэ мэдээллийг оруулж байна.
2016 оны 2 сар	ОУИТБС-ын шинэ стандартаар 2020 оны 1-р сарын 1 гэхэд БӨ-ийг ил тод болгохыг шаардсан.

6.1.1. Монгол улсын хандлага, ЗГ-ын бодлого

2016 онд ОТАХ-ээс ашиг хүртэгч эзэд буюу бенефициар гэдэг ойлголт, түүний эрх зүйн орчин, боломж, сорилт, асуудал, ашиглаж болох тогтолцоо зэргийг судлах ажлын дэд хэсэг томилсон ба тус дэд ажлын хэсгээс бенефициар эздийн мэдээллийг ил тод болгох Замын зургийн төслийг боловсруулж, 2016 оны 12-р сарын 20-ны өдрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, 2017 оны 12-р сарын 21-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

Замын зурагт 2020 он хүртэл хэрэгжүүлэх 32 үйл ажиллагааг 7 зорилтын хүрээнд төлөвлөсөн. Замын зургийн дэлгэрэнгүйг дараах линкээр үзнэ үү. <http://www.eitimongolia.mn/mn/beneficial-ownership-disclosure>.

ОУИТБС-ын Ажлын хэсгийн 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар ашиг хүртэгч эцсийн эзэнг ил тод болгохтой холбоотойгоор нэр томъёо, тодорхойлолт, хамрах хүрээ, материаллаг босго, цуглуулах мэдээлэл зэргийг хэлэлцэж, эцэслэн баталсан. Энэхүү хуралдаанаар батлахаас өмнө төр, компани, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн 9 цуврал хэлэлцүүлгээр нийт 260 гаруй оролцогчид хэлэлцэж, саналыг тусган, эцсийн хувилбарыг боловсруулсан байна. Мөн дараах тодорхойлолтуудыг тохирсон:

“Ашиг хүртэгч эцсийн эзэн” гэдэгт эрдэс баялгийн салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигч, хөрөнгө оруулагч, тендерт оролцогч, гэрээлэгч хуулийн этгээдийн 5 хувь буюу түүнээс дээш хувьцаа эсхүл түүнтэй адилтгах үнэт цаасыг, 20 хувь буюу түүнээс дээш саналын эрхийг, хувь буюу түүнээс ногдол ашгийг шууд болон шууд бусаар эзэмшдэг, өмчилдэг, хүртдэг, удирдлага, хяналтыг шууд болон шууд бусаар хэрэгжүүлдэг, эсхүл бусад хэлбэрээр эрхээ хэрэгжүүлдэг хувь хүнийг ойлгоно.

“Эзэмшил, өмчлөлийн эрхийг шууд бус хэлбэрээр хэрэгжүүлэх” гэдэгт өөрийн эзэмшлийн хувьцаа, түүнтэй адилтгах үнэт цаас, саналын бусад эрхийг гэрээ, итгэмжлэл, төлөөллийн бусад хэлбэрээр өөрийн хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой, холбогдох этгээдээр дамжуулан

хэрэгжүүлэх эсхүл 1 буюу түүнээс дээш үргэлжлэх гинжин холбоо бүхий хуулийн этгээдийн үүсгэн байгуулахыг ойлгоно.

“**Шууд удирдлага, хяналтын эрх**” гэдэгт Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл болон Компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтныг томилох, их хэмжээний хэлцлийг байгуулах шийдвэрийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран гаргах эрхийг ойлгоно.

“**Шууд бус удирдлага, хяналт**” гэдэгт Компанийн удирдлага, хяналтын эрхийг гэрээ, итгэмжлэл, төлөөллийн бусад хэлбэрээр эсхүл өөрийн хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээдээр дамжуулан хэрэгжүүлэх нөхцөл байдлыг ойлгоно

Хэрэв ашиг хүртэгч эцсийн эзэн нь **улс төрд нөлөө бүхий этгээд** бол түүнд болон түүний хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээдийн хувь эзэмшилд босго тогтоох шаардлагагүй (0 хувь) бөгөөд нийтэд заавал ил тод мэдээлнэ.

Улс төрд нөлөө бүхий этгээд гэдэгт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20,2-т заасан албан тушаалтнуудыг ойлгоно.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 4-р сарын 12-ны 114 тоот тогтоолоор Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан. Энэхүү тогтоолын хавсралт төлөвлөгөөний 4.1.6.5-д Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох ба 2020-2022 онд хэрэгжүүлж, ОУИТБС-ын Ажлын алба хариуцахаар тусгасан байна.

Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлөөс “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө (ҮАҮТ)”-г Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаар ҮАҮТ-ний төслийг дэмжиж, Засгийн газрын гишүүдийн саналыг тусгасан ба нийт 13 зорилтот үйл ажиллагаа бүхий ҮАҮТ-ний төслийг Үндэсний зөвлөл 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдөр хуралдан хэлэлцэж, батласан.

Энэхүү төлөвлөгөөний 12 дахь зорилтот үйл ажиллагаа нь Байгалийн баялгийг ашиглагч этгээдийн эздийг буюу бенефициар өмчлөгчдийг ил болгох тухай бөгөөд Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллахаар даалгажээ.

6.1.2. Бенефициар эздийн ил тод байдал

2019 оны ОУИТБС-ын тайланд зориулан нэг үе шат бүхий асуулгаар шууд бенефициар өмчлөгчийг тодорхойлох маягыг боловсруулж, цахим тайлангийн системд оруулсан.

Маягтаар ОУИТБС-ын шаардлагын дагуу дараах мэдээллийг цуглуулах боловч нийтэд хэсэгчилэн ил тод болгосон. Үүнд:

- Овог нэр,
- Үндэс угсаа,
- Регистрийн дугаар,
- Төрсөн огноо,
- Иргэний харьяалал, давхар иргэншил
- Оршин суугаа улсын нэр
- Улс төрд нөлөө бүхий этгээд эсэх,
- Компанидаа удирдах албан тушаал хашдаг эсэх
- Одоо хашиж буй ажлын газрын хаяг,
- Өмчлөлийн хувь хэмжээ,
- Бусдын өмнөөс эрх хэрэгжүүлдэг эсэх,

Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч 2,093 компаниас 291 компани бенефициар өмчлөгчийн мэдээллээ ирүүлсэнээс нэгтгэлд хамрагдсан 45 компани байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч 291 Компанийн бенефициар өмчлөгчийн талаар ирүүлсэн мэдээллийг хураангуйлбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн бенефициар өмчлөгч

Улс, орон	Үүнээс удирдах албан тушаалтан	Хувь хүмүүс		Олон нийтэд нээлттэй компани	Нийт
		Бусад			
Монгол	3	200	120	2	325
БНХАУ	-	32	-	-	32
Канад	-	-	20	8	28
Япон	-	-	2	-	2
ОХУ	-	4	7	-	11
Тайланд	-	5	1	-	6
Авсрали	-	-	-	1	1
Хонг Конг	-	2	-	1	3
Испани	-	1	2	-	3
АНУ	-	2	2	-	4
Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	-	-	-	2	2
Күүкийн Арлууд	-	-	-	2	2
Швейцарь	-	-	-	-	-
Бермуд	-	-	2	1	3
Герман	-	-	-	1	1
Люксэмбург	-	-	-	1	1
Мэн Арал	-	-	-	1	1
Сингапур	-	1	-	-	1
Нийт	3	200	120	2	325

Монгол Улсын хувьд 2013 оноос эхлэн Ашиг хүртэгч жинхэнэ эздийн зарим мэдээллийг тайлагнаж буй байдлыг дараах линкээр үзнэ үү: www.eitimongolia.mn/mn/beneficial-ownership-disclosure

Компаниудаас ирүүлсэн мэдээллийн дэлгэрэнгүйг Хавсралт 21(б,в)-д харуулсан.

6.2 ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ

6.2.1. Гэрээний ил тод байдлыг сайжруулах санаачилга

Засгийн газрын зүгээс олборлох компаниудтай байгуулсан гэрээний ил тод байлыг сайжруулах зорилгоор хэд хэдэн арга хэмжээ авсан. Үүнд:

- УИХ-аас Газрын тосны тухай хуульд 2014 онд нэмэлт, өөрчлөлт оруулснаар уламжлалт бус газрын тостой холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн боломжтой болсон. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах загвар гэрээнээс гэрээний нууцлалтай холбоотой заалтыг хүчингүй болгосон.
- 2015 онд батлагдсан Захиргааны ерөнхий хуульд Засгийн газрын байгууллагуудын байгуулсан гэрээнүүд нь бүгд ил тод байх ёстой гэсэн заалт орсон.

Сүүлийн жилүүдэд олборлох үйлдвэрлэлд зориулсан авто зам, төмөр зам, цахилгаан, дулаан, ус хангамж бусад ложистикийн бүтцийг дэмжих зорилгоор концессын гэрээг Засгийн газраас байгуулж байна. 2014 онд батлагдсан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 болон 6.5.9-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Концессын гэрээ, түншлэлийн Концессын гэрээ, түншлэлийн гэрээний талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлнэ” гэж заасан

ба энэ нь гэрээг бүхэлд нь биш, зөвхөн мэдээлэл бэлтгэж олон нийтэд мэдээлэх тухай заалт байсан.

Нээлттэй нийгэм форумаас (ННФ) “Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдал” олон талт оролцогчдын хэлэлцүүлгийг ОУИТБС-ын Ажлын алба, Төлсөн Авсанаа Нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвсэл, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУА)-тай хамтран УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Уул уурхайн яамны дэмжлэгтэйгээр 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан.

Хүснэгт 6.3 Гэрээний ил тод байдал

№	Хууль тогтоомжийн нэр	Гэрээ, түүний ил тод байдалд холбогдох зүйл заалт
Хууль		
1	Монгол Улсын Үндсэн хууль	6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.17 дахь хэсэг
2	Ашигт малтмалын тухай хууль	5 дугаар зүйлийн 5.3-5.5 дахь хэсэг, 42 дугаар зүйл
3	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	40 дүгээр зүйл
4	Газрын тосны тухай хууль	12,13,14, 17 дугаар зүйл
5	Цөмийн энергийн тухай хууль	4 дүгээр бүлэг 29-31 дүгээр зүйл
6	Хөрөнгө оруулалтын тухай хууль	20 дугаар зүйл
7	Концессын тухай хууль	
8	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын, хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, 3 ба 4 дүгээр зүйл.
9	Захиргааны ерөнхий хууль	11, 26-28 дугаар зүйл
10	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль	Уг хууль бүхэлдээ хамаарна
11	Байгууллагын нууцын тухай хууль	4 ба 6 дугаар зүйл
Төрийн бодлого		
12	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого	3.1.7 ба 3.5.2 дахь заалт
13	Шилэн дансны тухай хууль	6 дугаар зүйлийн 6.4.8, 6.5.9-6.5.10, 7.1.1 дэх заалт
Дүрэм журам		
14	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам	Уг журам бүхэлдээ хамаарна
УИХ-ын тогтоол		
15	Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна
16	Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна
17	“Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна
18	Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээ тогтоох тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна
Засгийн газрын тогтоол		
19	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай	7 ба 8 дахь заалт
20	Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна

Эх сурвалж: Эрдэс баялагийн гэрээний мэдээллийн сан, Нээлттэй нийгэм форум, <http://www.iltodgeree.mn/>

Хэлэлцүүлгээр эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдалтай холбоотой өнөөгийн хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт, олон улсын туршлага сургамж, гэрээг ил тод болгохтой холбоотойгоор талуудад тулгарч буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, олон талын хамтын ажиллагааны талаар хэлэлцэн дараах асуудлуудаар нэгдсэн ойлголт, байр сууринд хүрсэн. Үүнд:

- Эрдэс баялгийн салбарын гэрээний ил тод байдал, мэдээллийн хүртээмж, зохион байгуулалтыг хангах үүднээс ЗГ, түүний холбогдох байгууллагаас ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан Тогтвортой байдлын гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Геологийн ажлын гэрээ болон Ашиглалтын өмнөх гэрээ зэрэг гэрээнүүдийн эх бичвэрүүдийг мэдээллийн нэгдсэн сан үүсгэж системтэйгээр байршуулахын сацуу холбогдох төрийн байгууллагын цахим хуудаст байршуулан бүхэлд нь олон нийтэд ил тод болгох;
- Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах гэрээний ил тод байдлыг нэмэгдүүлж, орон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах болон орон нутгийн иргэдийн онцлог хэрэгцээ шаардлагад тохирсон хэлбэрээр мэдээлэл түгээхэд нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар санаачилга гарган хамтран ажиллах; Гэрээ байгуулах, батлах, гэрээний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх бүх шатанд мэдээллийг ил тод байлгах, нийтийн сонсгол, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх замаар олон тал, ялангуяа иргэний нийгмийн оролцоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Энэхүү олон талт хэлэлцүүлэг нь эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хангах, эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлаар оролцогч талууд, түүний дотор төр, олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниуд, иргэний нийгмийн ойлголт, байр суурийг нэгтгэн хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан юм.

Ийнхүү Нээлттэй нийгэм Форум (ННФ), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОУИТБС) Ажлын алба хамтран iltodgeree.mn сайтыг байгуулсан. Уг санд ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмал гэх мэт байгалийн баялгийг ашиглахтай холбоотой Хөрөнгө оруулалтын болон Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Концессын гэрээ, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн захиргаатай байгуулдаг Орон нутгийн гэрээ зэрэг Монгол улсын эрдэс баялгийн салбарт байгуулагддаг гэрээнүүдийн эх бичвэрийг байршуулж байна.

Дараах хүснэгтээр гэрээний ил тод байдалд хамаарах, тэр дундаа олборлох салбарт хамаарах хууль эрх зүйн үндсэн заалтуудын жагсаалтыг хүснэгт 6.3-аар харуулав²⁴.

6.2.2. Гэрээний ил тод байдал

2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Нээлттэй нийгэм форум, ОУИТБС болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамтран ОУИТБС-ын стандарт 2.4 дэх шаардлагыг биелүүлэх, гэрээний ил тод байдлыг сайжруулах зорилгоор Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн цахим санг байгуулсан. Энэхүү мэдээллийн цахим сан нь олон нийт, сэтгүүлчид, эрдэмтдэд эрдэс баялагийн гэрээнүүд болон бусад холбогдох баримт бичгүүдийг бүрэн эхээр нь нээлттэй болгож өгсөн.

2020 оны 12-р сарын 14-ний байдлаар энэхүү мэдээллийн санд 796 гэрээг байршуулсан байна:

Хүснэгт 6.4 Мэдээллийн санд байршуулсан гэрээ

№	Гэрээний төрлүүд	Тоо
1	Газар ашиглах гэрээ	124
2	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ	180
3	Концессийн гэрээ	4
4	Ус ашиглах гэрээ	53
5	Гол мөрний урсац бүрэлдэх эх, Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, Ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, Ашиглахыг хориглох тухай хуулийн дагуу хийгдэх гэрээ	23
6	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	26

²⁴ <http://www.iltodgeree.mn/legal/3/detail>

№	Гэрээний төрлүүд	Тоо
7	Хөрөнгө оруулалтын гэрээ	4
8	Тогтвортой байдлын гэрээ	11
9	Ашиглалтын өмнөх гэрээ	45
10	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээ	67
11	Үйлчилгээний гэрээ	1
12	Газрын тосны эрлийн гэрээ	16
13	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ	238
14	Төлөвлөгөө	1
15	Гэрээний хавсралт	1
16	Бусад гэрээнүүд	2
Нийт гэрээ		796

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор орж харна уу: <http://www.iltodgerree.mn/>

6.3. БЭЛЭН БУС ОРЛОГО (ШААРДЛАГА 4.2)

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2019 оны стандартын шаардлага 4.2.а-н дагуу АМГТГ-с “Үйлдвэрлэлээс төрд ноогдох хувь хэмжээг зарж борлуулсан борлуулалт”-ын талаар дараах мэдээллийг гаргасан. Үүнд:

Хүснэгт 6.5 Үйлдвэрлэлээс төрд ноогдох хувь хэмжээг зарж борлуулсан борлуулалт

№	Компанийн нэр	Ашигт малтмалын төрөл	Ашигт малтмалын үйлдвэрлэсэн (олборлосон) нөөц	Төрд хамаарах хэсэг		2019 оны Борлуулалт /сая төгрөг/
				Хувь хэмжээ	Дүн (сая төгрөг)	
1	Петрочайна Дачин Тамсаг ххк	Газрын тос	3172.44 мян.баррель	24%	95,799.41	95,799.41
2	Петрочайна Дачин Тамсаг ххк	Газрын тос	3323.39 мян.баррель	27.80%	114,780.06	114,780.06
3	Доншен Газрын тос (Монгол)	Газрын тос	376.07 мян.баррель	28.30%	21,687.65	21,687.65

Эх үүсвэр: АМГТГ

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2019 оны стандартын шаардлага 4.2.б.с-н дагуу ТӨААН-үүдэд Засгийн газраас, тэр дундаа төрийн өмчит компаниуд нь өөрийн бүтээгдэхүүнээ хэрхэн (бэлэн,бэлэн бус) борлуулсан талаар мэдээлэл болон холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгөхийг хүсэж албан бичиг явуулсан боловч хариу ирүүлээгүй байна. Мөн тус мэдээллүүд нь Эрдэнэс Монголын цахим хуудсан (ett.mn)-д ил тод болоогүй байна.

Шилэн дансанд мэдээллээ оруулсан 3 ТӨААН-ийн борлуулалтын мэдээллийг харуулбал дараах байдалтай байна. Бусад ТӨААН-үүд шилэн дансанд мэдээллээ оруулаагүй байна.

Хүснэгт 6.6 ТӨААН-ийн борлуулалт

ТӨААН	Худалдсан бүтээгдэхүүн		Худалдан авагч Компанийн нэр
	Нэр төрөл	Дүн (сая төгрөг)	
Шивээ овоо ХК	Нүүрс	3,120.8	Амгалан ДСтанц ХХК
	Нүүрс	1,392.6	Бор Өндөрийн үйлдвэр
	Нүүрс	615.1	ДЦС-2 ТӨХК
	Нүүрс	781.0	Налайх дулааны станц ТӨХК
	Нүүрс	204.5	Сэлэнгэ Энержо ОНӨҮГазар
	Нүүрс	206.1	Сэлэнгэ-Зүүнхараа ОНӨҮГ
	Нүүрс	47,160.0	Улаанбаатар ТЭЦ-4

ТӨААН	Худалдсан бүтээгдэхүүн		Худалдан авагч Компанийн нэр
	Нэр төрөл	Дүн (сая төгрөг)	
	Нүүрс	269.0	Ус-Ду ОНӨААТҮГ
	Нүүрс	1,514.9	Чандмань илч ХХК Дорноговь
	Нүүрс	139.00	Хөтөл энержи дулаан ХХК
	Нүүрс	821.50	Чандмань бадрал ХХК
	Нүүрс	1,500.00	Чандмань илч ХХК Дорноговь
	Нүүрс	181.00	ЭНЕРЖИ ПЛАС ХХК
	Нүүрс	217.5	Бусад
Эрдэнэт үйлдвэр ТӨХХК	Зэсийн баяжмал	6,634.60	TFMetall Limited ltd
	Зэсийн баяжмал	58,941.0	Гоулд Майлас Лимитед ХХК
	Зэсийн баяжмал	20,816.0	Жералд Металлз Ins
	Зэсийн баяжмал	11,226.0	Жин Сун Интернэшнл PTE.LTD
	Зэсийн баяжмал	213,194.0	Кинг Файн ХХК
	Зэсийн баяжмал	17,437.0	Кливеден Трэйдинг АГ
	Зэсийн баяжмал	1,239.0	Клиэриж Трэйдинг ХХК
	Зэсийн баяжмал	240,685.0	Миллифорд Глобал Корпорэйшн ХХК
	Зэсийн баяжмал	283,428.0	Океан Партнерс
	Зэсийн баяжмал	165,575.0	Ред Металл inc
	Зэсийн баяжмал	256,470.0	Самсунг фирма ХХК
	Зэсийн баяжмал	240,852.0	Таурус Металл
	Зэсийн баяжмал	23,893.0	Трафигура
Монголросцветмет ТӨҮГ	Алтны борлуулалт	521.5	Шижир-алт АҮ
	Жонш үнэ	4,694.0	Ган эрдэнэс хүдэр ХХК
	Жонш үнэ	5,740.0	Жинтайхэ ХХК
	Жонш үнэ	3,968.0	Интерстиль ХХК
	Жонш үнэ	1,111.0	Марияа трейд ХХК
	Жонш үнэ	2,763.0	Рейт инвест ХХК
	Жонш үнэ	3,716.0	Рич хилл майнинг ХХК
	Жонш үнэ	20,026.0	Сэнтурия монгу ХХК
	Жонш үнэ	3,160.00	Сентору Монгу ХХК
	Жонш үнэ	100.00	ЦЕРКОН ГЕОЛОГИ ХХК
	Жонш үнэ	1,674.00	Эко хэлхээ ХХК
	Жонш үнэ	118.50	Эм кэй метал ХХК
	Жонш үнэ	6,007.00	Bozhong trade Co LTD

Эх үүсвэр: Шилэн данс

6.4. ДЭД БҮТЦЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БА БАРТЕРЫН СОЛИЛЦОО (ШААРДЛАГА 4.3)

Зарим тохиолдолд улс орны байгалийн нөөц баялгийг ашиглах эрх олох зорилгоор олборлох үйлдвэрлэлийн компаниуд мөнгөн бус хэлбэрээр бараа болон үйлчилгээ үзүүлэх (дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх) гэрээг төрийн байгууллагуудтай хийдэг. Эдгээр дэд бүтцийн хөрөнгө оруулалтын жишээнд зам, төмөр зам, цахилгаан станц, сургууль болон эмнэлгүүд багтана.

Тухайн компаниудад ирэх өгөөж нь газрын тос, байгалийн хий эсвэл ашигт малтмалын нөөц бөгөөд газар, эрчим хүч болон усны нөөц ашиглах эрх гэх мэт бусад элементээс бүрддэг. Ийм гэрээг бартерын солилцооны гэрээ эсвэл “дэд бүтцийг ашигт малтмалаар солилцох гэрээ” гэж нэрлэдэг.

Бид нэгтгэлд хамрагдсан компаниуд руу 2019 онд дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт ба бартерын солилцооны талаар МОУИТБС-ын 2019 оны шинэ маягтаар мэдээлэл ирүүлэхийг хүссэн ба нэгтгэлд хамрагдсан компаниудаас ийм ажил гүйлгээ гараагүй гэсэн хариу ирсэн байна.

6.5. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ОРЛОГО (ШААРДЛАГА 4.4)

Газрын тос, байгалийн хий, байгалийн баялгийн тээвэрлэлтээс олсон орлого нь материаллаг байгаа үед ЗГ болон Төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨААН)-үүд хүлээн авсан орлогоо толилуулах шаардлагатай байдаг.

ААН-үүдийн тээвэрлэлтийн орлогын мэдээлэл болох тээвэрлэсэн бүтээгдэхүүний төрөл, тээвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэмжих нэгж болон тээвэрлэлтийн орлогыг хүлээн авсан төрийн байгууллагуудын нэрийг дараах хүснэгтэд тайлагнасан байна.

Хүснэгт 6.7 ААН-үүдийн тээвэрлэлтийн орлого

№	Компанийн нэр	Тээвэрлэсэн эрдэс баялгийн төрөл	Тээврийн орлогыг хүлээн авсан байгууллагын нэр	Нийт дүн /сая төгрөг/
1	2018 онд тээвэрлэлт хийлгэсэн ХХК-ууд	Нүүрс	МТЗ ТӨХК	2,534.50
2	2019 онд тээвэрлэлт хийлгэсэн ХХК-ууд	Нүүрс	МТЗ ТӨХК	3,802.60

Эх сурвалж: МТЗ ТӨХК-ийн ирүүлсэн мэдээлэл

Хэвлэн нийтэлсэн мэдээлэл нь өөр бусад орлогын урсгал, төлбөрийн урсгалын нэгэн адил хэмжээнд задаргаатай байх шаардлагатай (4.7). Олон талт оролцогчдын бүлэг нь тээвэрлэлтийн орлогын тухай мэдээллийн чанар, дээр заасан мэдээллийн баталгаажуулалттай холбоотой журмыг Шаардлага 4.9 дээр заасны дагуу гарган, хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ. Санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд нь дараах мэдээллийг ил болгоно. Үүнд:

- Тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаарх мэдээлэл, үүнд тээвэрлэж буй бүтээгдэхүүн, тээвэрлэлтийн маршрут, тээвэрлэлтэд оролцож буй компани болон төрийн байгууллага (төрийн өмчит аж ахуйн нэгж мөн хамаарна);
- Тээвэрлэлтийн татвар, тариф, бусад төлбөр, болон тэдгээрийг тооцох аргачлалын тухай тайлбар;
- Тарифын хувь хэмжээ болон тээвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг ил тод болгон тайлагнах;
- Газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын тээвэрлэлтээс төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн хүлээн авсан орлогыг ил тод болгон тайлагнах

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газраас, Төмөр замаар эрдэс баялгийн 2019 оны тээвэрлэлтийн мэдээллийн дэлгэрэнгүйг дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 6.8 Төмөр замаар тээвэрлэсэн эрдэс баялгийн мэдээлэл

№	Ачааны нэр / эрдэс баялаг /	Вагон /ширхэг/		Ачаа /мянган тонн/	
		2018	2019	2018	2019
1	Нүүрс	133882	129462	8821.5	8550.3
2	Нефть, нефтийн бүтээгдэхүүн	10547	9362	641	564.7
3	Жонш, жоншны баяжмал	8215	10178	543.7	679.7
4	Зэс болон молибдений баяжмал	9893	9779	657.9	651.8
5	Төмрийн хүдэр	82301	101450	5780.1	7111.6
6	Цайрын баяжмал	389	484	24.1	30.1
7	Барилгын материал. Үүнээс:	25067	32659	1621.8	2115
8	Цемент	11143	13568	757.7	931.7
9	Балласт	6074	8839	368.1	543
10	Бетон	889	1060	51.8	61.4

Эх үүсвэр: Зам тээврийн яам


Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газраас Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын эрдэс баялгийн 2019 оны авто замын тээвэрлэлтийн мэдээллийн дэлгэрэнгүйг дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 6.9 Авто замын тээвэрлэлт

№	Компанийн нэр	Ачааны нэр /эрдэс баялаг /	Маршрут	Тээвэрлэсэн ачааны хэмжээ /мянган тонн/	Ачааны эргэлт /мянган тн.км/	Орлого / сая төгрөг/
1	Петро чайна дачин тамсаг ХХК	Газрын тос, нефть	Бичигт боомт	283.4	232.3	22,469.0
2	Андын илч ХХК	Хүрэн нүүрс, төмрийн хүдэр		76.4	6.1	1.0
3	Петро чайна дачин тамсаг ХХК	Газрын тос	Баянхошуу -Өвдөг боомт	527.4	337.5	50.9
4	"Алтайн хүдэр" ХХК	Төмрийн хүдрийн баяжмал	Бургастай боомт	1,006.5	80.5	27.5
5	Оюу толгой ХХК	Зэсийн баяжмал	Гашуун сухайт боомт	739.3	170.0	20.4
6	Аж ахуйн нэгж, байгууллага	Нүүрс		18,766.5	4.5	202.0
7	Аж ахуйн нэгж байгууллага /Иргэн/	Нүүрс	Замын-Үүд	118.9	0.8	3.0
8	Иргэн	Жонш	Хавирга-Ар хашаат	7.4	-	-
9	Аж ахуйн нэгж, байгууллага	Нүүрс	Ханги	777.8	150.5	8.4
10	Аж ахуйн нэгж, байгууллага	Цайр		2.3	0.4	-
11	Мон Лаа ХХК	Хүдэр		81.3	1.6	-
12	Аж ахуйн нэгж, байгууллага	Нүүрс	Шивээ хүрэн	10,865.1	706.2	117.3
13	Аж ахуйн нэгж, байгууллага	Нүүрс	Ярант	1,221.5	427.5	33.4
14		Хүдэр		3.2	1.1	-

Эх үүсвэр:Зам тээврийн яам

Зураг 6.1 Нүүрсний экспортын хэмжээ, боомт тус бүрээр



6.6. НИЙГМИЙН ЗАРЦУУЛАЛТ (ШААРДЛАГА 6.1)

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын нэгтгэлд хамрагдсан 171 компанийн 2019 онд мөнгөн ба мөнгөн бус хэлбэрийн хандив дэмжлэгийг төрийн болон орон нутгийн байгууллагуудад үзүүлсэн. Төрийн байгууллагууд хүлээн авсан хандив дэмжлэгийн дүнгээ маш дутуу дүнгээр тайлагнадаг тул тохируулга хийж зөрүүг тохируулсан. Дээр дурдсанчлан заавал тайлагнах хандив дэмжлэгүүдийг нэгтгэлд оруулж тохируулга хийсэн бол сайн дурын хандив дэмжлэгүүд тохируулга хийгдээгүй болно.

Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг зориулалтаар нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6.10 Нийт хандив, дэмжлэг, зориулалтаар

Зориулалт	Хандивын Дүн /сая.төг/	Эзлэх хувь
Боловсрол	14,603	43.2%
Эрүүл мэнд	1,162	3.4%
Соёл, спорт	5,353	15.9%
Бусад	12,656	37.5%
Нийт	33,774	100%

2019 онд нэгтгэлд хамрагдсан компаниудаас 72 компани нийт 33,774 сая төгрөгийн мөнгөн ба мөнгөн бус хандивыг олгосон байна. Нийт хандив, дэмжлэгийн 87.1 хувийг Оюу Толгой ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Энержи ресурс ХХК, МоЭнКо ХХК, Саусгоби Сэндс ХХК, Тод ундарга ХХК, Платинумланд ХХК, Бадрах энержи ХХК, Хангад Эксплорейшн ХХК, Цайрминерал ХХК гэсэн 10 компани үзүүлжээ.

Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг авсан төрийн байгууллагуудын төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна

Хүснэгт 6.11 Нийт хандив, дэмжлэг, төрийн байгууллагуудаар

Хандив хүлээн авагч	Мөнгөн хандив /сая төгрөгөөр/	Мөнгөн бус хандив /сая төгрөгөөр/	Дүн /сая төгрөгөөр/	Эзлэх хувь
Яам, агентлагт	298.5	13.2	311.7	1%
Аймаг, нийслэлд	17,712.8	354.3	18,067.1	53.5%
Сум, дүүрэгт	4,099.1	6,289.5	10,388.6	30.5%
Бусад байгууллагад	4,832.7	233.9	5,066.6	15%
Хандивын тохируулсан дүн	26,883.1	6,890.9	33,774	100%

Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг авсан аймгуудаар нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6.12 Нийт хандив, дэмжлэг, аймгуудаар

Хандив хүлээн авагч	Мөнгөн хандив /сая.төгрөгөөр/	Мөнгөн бус хандив /сая.төгрөгөөр/	Дүн /сая төгрөгөөр/	Эзлэх хувь
Баянхонгор	479.8	104.7	584.5	1.73%
Булган	1,646.70	8.1	1,654.80	4.90%
Говь- алтай	77.5	3.5	81	0.24%
Дархан	3.5	90	93.5	0.28%
Дорноговь	571.8	639.4	1,211.2	3.59%
Дорнод	113.5	60	173.5	0.51%

Хандив хүлээн авагч	Мөнгөн хандив /сая.төгрөгөөр/	Мөнгөн бус хандив /сая.төгрөгөөр/	Дүн /сая төгрөгөөр/	Эзлэх хувь
Дундговь	425	107.8	532.8	1.58%
Орхон	4,696.90	9.1	4,706	13.93%
Өвөрхангай	11.5	60	71.5	0.21%
Өмнөговь	13,487.7	4,328.2	17,815.9	52.75%
Сүхбаатар	1,946	10.9	1,956.9	5.79%
Сэлэнгэ	445.1	704.7	1,149.8	3.40%
Төв	239.9	252.8	492.7	1.46%
Улаанбаатар	904.1	55.7	959.8	2.84%
Увс	44.3	13.8	58.1	0.17%
Ховд	1,860.40	342.2	2,202.60	6.52%
Хөвсгөл	9.8	-	9.8	0.03%
Хэнтий	19.6	-	19.6	0.06%
Нийт	26,901.2	6,872.8	33,774	100%

6.7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн асуудлын зохицуулалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) болон тус яамны харьяа Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) зэрэг үндсэн 3 байгууллага хариуцдаг.

Уул уурхайн салбар байгаль орчинд хамгийн их доройтол учруулдаг, байгалийн нөхөн сэргээгдэхгүй баялгийг ашигладаг, Монголын ард түмний уламжлалт нүүдлийн мал аж ахуйд сөрөг нөлөөлдөг.

Ийм ч учраас уул уурхайн байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн ажилд дагаж мөрдөх хууль, журам, стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх, баталгаажуулах, хэрэгжилтийг хангах ажилд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байнга анхаарал хандуулж ажиллаж ирсэн.

6.7.1. Төрөөс байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээнд баримтлах бодлого

Байгаль орчны хамгаалах уул уурхайн нөхөн сэргээлтийн ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин 1988 оноос эхлэн бүрэлдэж, холбогдох хуулиуд батлагдаж, шинэчлэгдсээр байна.

Уул уурхайн ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр дараах эрх зүйн актууд мөрдөгдөж байна. Үүнд:

- Газрын хэвлийн тухай хууль (1988),
- Ашигт малтмалын тухай хууль (1997, 2006),
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009),
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2001, 2006, 2012),
- Байгаль орчны бусад хуулиуд, эрх зүйн актууд мөрдөгдөж байна.

Ашигт малмалын тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтыг өөрчлөн найруулж “тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан

үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан” гэж тусгасан .

Түүнчлэн эдгээр хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 30 гаруй журам, аргачлал батлан мөрдүүлж байна. Тухайлбал:

- "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам" (2014),
- "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" (2014)
- "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал" (2015),
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын хамтарсан 2018 оны А/50, А/31 дугаар хамтарсан тушаалаар “Газрын тос, уламжлалт бус газрын тос эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүн авах” журам,
- “Уурхайн, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам” – Уул уулхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/181, А/458 дугаар тоот тушаал,
- “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” - Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал

Байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн чиглэлээр хийгдэхээр төлөвлөж байгаа хөтөлбөрүүдийн хүрээнд хувьд БОАЖЯ-аас мэдээлснээр дараах хөтөлбөр багтаж байна²⁵. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5.1.10.Туул голын сав газраас түгээмэл тархацтай ашигт малтмал олборлохыг таслан зогсоож, нөхөн сэргээлт хийж, усны түвшинг нэмэгдүүлнэ.
- 2020 онд улсын хэмжээнд "Нөхөн сэргээлт-2020" арга хэмжээг зохион байгуулж, эвдэрсэн газрын хэмжээг шинэчлэн гаргаж, нөхөн сэргээсэн талбайн хэмжээг нэмэгдүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.8-д “Уул уурхайн улмаас эвдэрч, олон орхигдсон 8 мянган га газрыг нөхөн сэргээнэ” гэж тусгагдсаны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачлан "Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээг УУХҮЯ, ЦЕГ, МХЕГ-тай хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр “Байгаль орчны засаглал” төслийн хүрээнд Хамтын Оролцоот Байгаль Орчны Мониторинг (ХОБОМ)-ийн загварыг Уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны зөрчлийг шийдэх болон шийдвэр гаргах үйл явцад төр, бизнес, иргэний нийгэм, нутгийн иргэдийн идэвхитэй оролцоо, хамтын ажиллагаа туйлын чухал байдаг. 2020 оны 5 дугаар сард Хэнтий, Сүхбаатар аймагт анх удаа Хамтын Оролцоот Байгаль Орчны Мониторингийг БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, АМГТГ, Хүний эрхийн үндэсний комисс, Экологийн цагдаагийн албаны төлөөлөл, аймгийн БОАЖГ, сумын Засаг дарга нарын төлөөл уул уурхайн аж ахуйн нэгж дээр туршиж, зөвлөгөө өгч ажилласан байна. Мөн энэ төслийн хүрээнд Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд Хүний Эрхэд Нөлөөлөх Байдлын Үнэлгээг анх удаа хийж гүйцэтгэсэн бөгөөд уурхайн бүс нутгийн байгаль орчин, хүний эрхэд тулгамдаж буй байгаль экологийн доройтол, агаар орчны бохирдол, тоосжилт, нүүрс тээврийн аюулгүй байдал, жолооч нарын хөдөлмөрлөх нөхцөл, иргэдийн эрүүл ахуй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж зэрэг асуудлыг хөндөж зөвлөмж гаргасан. Цаашид ХОБОМ-ыг нэвтрүүлэхэд зориулсан гарын авлага, аргачлал гаргахаар зорьж байна²⁶.

Байгаль орчны нөхөн сэргээлтийн хүрээнд БОАЖЯ-аас дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна²⁷. Үүнд:

²⁵ БОАЖЯ

²⁶ БОАЖЯ

²⁷ БОАЖЯ

- 2019 оны байдлаар нийт 21 аймгийн 72 сумд 152 аж ахуйн нэгжийн БОХ 1.3 маягыг бөглүүлж хугацаанд нь ирүүлсэн. Мөн 152 аж ахуйн нэгж 632.89 га-д нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн ба 843.95 га-д нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://eic.mn/box/box13.php> - ээс харах боломжтой.
- Улсын хэмжээнд эвдэрсэн газрын тооллого зохион байгуулсан бөгөөд Байгаль орчны мэдээллийн сан болох www.eic.mn цахим хуудаснаас үзэх боломжтой.

6.7.2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон менежментийн төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь хүний эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах эрхийг хангах зорилгоор байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүйгээр байгалийн нөөцийг ашиглах, үйлдвэр, үйлчилгээ эрхлэх, салбарын хүрээнд баримтлах бодлого болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг урьдчилан тогтоох зорилготой юм.

Уг зорилгын хүрээнд Уул уурхайн салбарын хувьд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)-иас ихээхэн хамааралтай. Энэ хуулийн дагуу аливаа уул уурхайн төслийг хэрэгжүүлж эхлэхийн өмнө байгаль орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБҮ) хийлгэхийг шаарддаг бөгөөд энэ үйл явцыг дараах байдлаар харуулж байна. Үүнд:

1. Төсөл хэрэгжүүлэгч нь төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө БОТБҮ-г эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
2. БОТБҮ-г үндэслэн БОАЯЖ болон аймаг, нийслэлийн Байгаль орчны алба ажлын 14 хоногт багтаан БОНЕҮ-ний дүгнэлт гаргана.
3. БОННҮ хийлгэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гэрээ байгуулан ажиллах бөгөөд мэргэжлийн байгууллага нь БОННҮ болон 5 жилийн Багаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г боловсруулж хамт БОАЖЯ-д хүргүүлнэ.
4. БОННҮ-ний тайланг хүлээн авсан шинжээч ажлын 18 өдөрт багтаан үнэлгээний шинжилгээ хийж дүгнэлт гаргана.
5. БОАЖЯ-ны БОНҮ-ний мэргэжлийн зөвлөл нь БОННҮ-ний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх талаар эцсийн шийдвэр гаргана.

Дээрх дурьдсан БОННҮ-ээс БОМТ болон мониторингийн хөтөлбөр боловсруулдаг бөгөөд эдгээр нь БОНБҮ-д багтсан зөвлөмж, дүгнэлтүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдаг. Уул уурхайн үйл ажиллагаа эхэлсэн тохиолдолд Байгаль орчны менежментийн төлөвлөгөө дараах үе шаттайгаар боловсруулах шаардлагатай байдаг. Үүнд:


1. Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн БОМТ-г Байгаль хамгаалах хууль тогтоомж, БОННҮ-ний үр дүн, батлагдсан БОМТ-д үндэслэн ашиглалтын жил бүр шинэчлэн боловсруулна.
2. БОМТ-ний гүйцэтгэл, биелэлтийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор төсөл хэрэгжиж буй аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгуулж ажлын хэсгийн дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ны дотор гаргуулна.
3. Ашигт малтмалын орд ашиглаж буй төсөл хэрэгжүүлэгч уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн тухайн оны жилийн мэдээ маягт БОХ-3-ын дагуу холбогдох мэдээллийг гаргаж, тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор хүргүүлэх ба уг маягыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заавал хавсаргана.
4. Төсөл хэрэгжүүлэгч нь БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг хавсарган дараа жилийн БОМТ-г боловсруулан БОАЖЯ-нд 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.

5. Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр заалтын дагуу БОННУ-ний тайлан, БОМТ-ний хэрэгжилтэд 2 жил тутамд хийлгэсэн байгаль орчны аудитын тайланг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт БОАЖЯ-нд ирүүлнэ.
6. БОАЖЯ тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан, батална.

БОАЖЯ-аас мэдээлнээр Уул уурхайн олборлолтын төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар бүлэгт зааснаар байгаль орчны мэдээллийн сангийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн мэдээллийн хэсэгт хуримтлагддаг болно. Уг мэдээллийн санд уул уурхайн чиглэлээр байгаль орчны үнэлгээ хийх 86 байгууллага байгаа бөгөөд олборлолтын төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний 1,286 үндсэн, 211 нэмэлт тодотгол тайлан батлагдсан тухай мэдээлэлтэй байна. Мөн уул уурхайн салбарын байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний 1,860 тайлан байна.

Сүүлийн 3 жилд гарсан үнэлгээний тайлангийн тоо хэмжээ, БО-ны ерөнхий нөлөөллийн үнэлгээний тайланг төслийн төрлөөр нь тус тус харуулж байна.

Зураг 6.2 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ тайлан



Үнэлгээний тайлангийн дэлгэрэнгүйг <https://eic.mn/eia/generalreport.php> холбоосоор харах боломжтой юм.

6.7.3. Байгаль орчныг хамгаалах тусгай данс

Нөхөн сэргээлтийн хувьд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид Байгаль орчны тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн 38, 39 дүгээр заалтуудыг дагаж мөрдөх ёстой. Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар заалт нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах үүргийг тодорхойлсон бол 39 дүгээр заалт нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг тодорхойлсон байдаг.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчныг хамгаалах шаардлага хангуулах зорилготойгоор хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид аль аль нь холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд өөрсдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд шаардагдсан тухайн жилийн төсвийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнг шилжүүлэх үүрэгтэй.

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд /БОХТ/ тусгагдсан үүргээ биелүүлсэн тохиолдолд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцааж олгоно. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид БОНБУ болон БОХТ-д тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол байршуулсан мөнгөн хөрөнгийг уурхайн хаалтын үе

шатанд буцааж олгоно. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОХТ-д тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглан шаардлагатай арга хэмжээг нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Ийм тохиолдолд нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд нэмж шаардагдах мөнгөн дүнг тусгай зөвшөөрөл эзэмшигч маргаангүй олгох ёстой.

БОАЖЯ-ны мэдээлснээр 2019 онд Байгаль хамгаалалтын тусгай дансанд 2,317 сая төгрөг төвлөрсөн ба буцаан олголт байхгүй гэж мэдэгдсэн байна. 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдэл нь 16,354 сая.төгрөг байна. Тухайлбал:

Хүснэгт 6.13 Байгаль хамгаалалтын тусгай данс, сая.төгрөгөөр


Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Орлого	22	612	566	385	942	1,216	2,014
Зарлага	-	-	21	126	1	5	16
Эцсийн үлдэгдэл	22	634	1,179	1,438	2,379	3,590	5,588

Он	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Орлого	1,545	2,273	1,027	1,317	1,102	1,411	2,317
Зарлага	225	1	-	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	6,908	9,180	10,207	11,524	12,626	14,037	16,354

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

БОАЖЯ-аас мэдээлснээр нэг байгууллага нь хэд хэдэн тусгай зөвшөөрөлтэй байдаг бөгөөд тусгай зөвшөөрөл бүрт байгууллага нь барьцаа байршуулдаг. Нөхөн сэргээлтийн Байгаль хамгаалалтын тусгай дансанд барьцаа төлбөрөөр тэргүүлсэн 10 байгууллагыг сонгосон бөгөөд сонгохдоо зөвхөн байгууллагаар нь нэгтгэн төлсөн дүнгээр нь авсан. Эдгээр байгууллагын дотроос хамгийн өндөр барьцаатай байгууллага нь Петрочайна Дачин Тамсаг Монгол ХХК 1,369.60 сая.төгрөг байгаа нь 2019 онд тус компани 760.0 сая.төгрөг нэмж байршуулсантай холбоотой. Дэлгэрэнгүйг дараах графикаар харуулж байна.

Зураг 6.3 Байгаль хамгаалалтын тусгай дансанд барьцаа, төлбөрөөр



Эх сурвалж: БОАЖЯ

2019 оны Нөхөн сэргээлтийн барьцаа дансанд төвлөрүүлсэн аж ахуйн нэгжүүд, барьцаанд төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн задаргааг Хавсралт 23-аас харна уу.

6.7.4. 2019 оны уулын ажлын болон нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн мэдээлэл

2019 он болон өмнөх онуудын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын уулын ажлын болон нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 6.14 Уулын ажлын болон нөхөн сэргээлт

Онууд	Уулын ажилд хамрагдсан талбай (га)	Нөхөн сэргээлт хийгдсэн талбай (га)	Нөхөн сэргээлтийн харьцаа (%)	Нөхөн сэргээлтийн зардал (сая.төгрөг)
Өмнөх жилүүд	24,636.0	18,355.0	75%	79,648.0
2014	1,560.7	959.6	61%	9,211.6
2015	871.0	750.0	86%	4,019.0
2016	703.5	876.4	125%	2,167.2
2017	1,002.3	677.2	68%	2,966.4
2018	1,059.3	924.2	87%	3,891.2
2019	467.3	2,470.2	529%	11,241.0
Нийт	30,300.1	25,012.6	83%	113,144.4

Эх сурвалж: 2019 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 20, болон 2020 оны 04 сарын Эрдэс баялгийн мэдээ, хуудас 20, УУХУЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

БОАЖЯ-ны тайлагнаснаар Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын эрээл хайгуул, болон олборлолтын үйл ажиллагаанаас үүдэн эдвдэрсэн тайлбай 2016 онд 4.3 мянган га, 2017 онд 3.3 мянган га, 2018 онд 21.7 мянган га, 2019 онд 27.3 мянган га талбай тус тус байсан байна.

БОАЖЯ-аас ирүүлсэн мэдээгээр 2017-2019 оны хооронд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, нутгийн иргэдийн оролцоотойгоор нөхөн сэргээлт хийсэн судалгааны үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

- 2017 онд 20 аймгийн 55 сум, нийслэлийн 2 дүүргийн нутагт 120 тусгай зөвшөөрөлтэй ААН, 17 нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, 3 ТББ, 6 нөхөрлөл, 1 холбоод нийт 734 га-д техникийн, 325 га-д биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийн ажилд ААН-үүд нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгаас нийт 403 хүн гэрээгээр авч ажиллуулсан байна.
- 2018 онд 19 аймгийн 50 сум, нийслэлийн 4 дүүргийн нутагт 108 тусгай зөвшөөрөлтэй ААН, 14 нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, 1 ТББ, 8 нөхөрлөл, 1 холбоод нийт 912 га-д техникийн, 335 га-д биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийн ажилд ААН-үүд нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгаас нийт 328 хүн гэрээгээр авч ажиллуулсан байна.
- 2019 онд Нийслэлийн 7 дүүрэг, 16 аймгийн нутагт 97 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд 810 га талбайд техникийн, 254 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийж, орон нутагт актаар хүлээлгэж өгсөн байна.

Сүүлийн 4 жилийн Техникийн болон Биологийн нөхөн сэргээлтийн талбайн (га) мэдээллийн дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 6.15 Техникийн болон Биологийн нөхөн сэргээлтийн талбай (га)

Он	Техникийн нөхөн сэргээлт	Биологийн нөхөн сэргээлт	Нийт нөхөн сэргээлт хийсэн талбай (га)
2017 он	734 га	325 га	1,059 га
2018 он	912 га	335 га	1,247 га
2019 он	810 га	254 га	1,064 га
2020 он	1,973 га	634 га	2,607 га

Эх сурвалж: Байгаль, орчин аялал жуучлалын яам

6.7.5. Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл (нүүрс олборлогчдоос бусад)

АМГТГ-ын мэдээлснээр 2019 онд нийт 183 компани уулын ажил болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хэрэгжилтээ тайлагнасан байна. Компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 20(а)-с харна уу. Уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн хураангуйг Хүснэгт 6.16-д харуулав.

Хүснэгт 6.16 Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл											
№	Ашигт малтмалын төрөл	Нийт ААН-ын тоо	Уулын ажил				Нөхөн сэргээлт				
			Талбай (га)		Эзэлхүүн (м3)		Талбай (га)		Эзэлхүүн (м3)		Нийт зардал (сая төгрөгөөр)
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө
1	Алт (Үндсэн)	7	7	10	3,929,322	3,853,251	11,226	12,497	30,419	79,931	181
2	Алт (Үүсмэл)	4	3	5	208,146	340,350	19	38	96,850	643,300	47
3	Алт (Шороон)	82	337	502	46,602,167	53,553,685	673	1,343	2,180,653	2,332,881	6,681
4	Бар/м (Цемент)	3	49	59	451,800	739,960	14	5	26,881	6,096	35
5	Гөлтгөнө	5	1	4	-	264,080	18	4	9,302	840	89
6	Гянтболд (Үндсэн)	3	2	1	18,075	13,088	2	19	26,470	33,500	82
7	Зэс	3	16	13	9,600	24,369	6	174	9,520	0	34
8	Төмөр	19	40	123	16,100,142	27,547,976	1,447	60	232,597	178,130	295
9	Хайлуур жонш	38	48	59	1,027,126	1,348,901	43	64	135,918	80,023	847
10	Хас	1	2	0	102,900	54	-	-	-	-	-
11	Холимог металл	5	51	56	530,660	588,400	8	14	63,800	74,600	149
12	Цагаан гантиг	2	15	13	-	-	3	60	-	-	10
13	Цагаантугалга (Шороон)	1	-	3	-	57,899	20	7	40,000	5,250	6
14	Цайр	1	1	1	850,649	1,086,946	1	2	-	1,250	38
15	Шохойн чулуу	9	113	115	561,996	325,742	13	36	35,474	30,970	141
Нийт		183	683	964	70,392,583	89,744,700	13,493	14,323	2,887,883	3,466,771	8,634

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар, УУХҮЯ

6.7.6. Нүүрс олборлогчдын уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Нүүрсний асуудлыг АМГТГ-т тусдаа хэлтэс зохицуулдаг тул төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан нь бусад ашигт малтмалын тайлангаас ялгаатай гардаг. Нийт 60 нүүрс олборлогч компаниуд уулын ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээгээ тайлагнасан байна. Нүүрс олборлогч 60 компанийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө гүйцэтгэлийн дэлгэрэнгүйг Хавсралт 20(б)-с харна уу.

6.7.7. Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөхөн сэргээлтийн 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 6.17 Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөхөн сэргээлтийн 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Ажил	Нэгж үнэ (доллар)	Төлөвлөгдсөн хэмжээ	Гүйцэтгэл	Тайлбар
Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон-Уул XIX талбай					
1	Өрмийн хаягдал шингэний саармагжуулалт, нөхөн сэргээлт	3,500	20	20	2019 онд өрмийн шингэн хаягдлын 20 ширхэг өрмийн шаврын хаягдлын санд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг "Зорголын гүнж" ХХК хийж гүйцэтгэсэн байна.
2	Газрын хөрсний дээж авах, авсан дээжинд лабораторын шинжилгээ хийх	600	30	30	2019 оны 6 дугаар сарын 26-27-ны MNS 3298-90 стандартын дагуу "Байгаль тандалт" ХХК-р хийж гүйцэтгүүлсэн байна. Нийт 30 ширхэг нөхөн сэргээлт хийгдсэн өрөмдлөгийн шингэн хаягдлын сангаас дээж авч шинжлүүлсэн.
3	Байгаль орчны үнэлгээний ажил	20,000	4	4	Химийн бодисын агуулах, импортлох, хадгалах, ашиглах төсөлд. Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламжийн өргөтгөл мөн ТА 1 байгууламжийн гүний болоод тостой ус цэвэршүүлэх байгууламжийн өргөтгөл, тос усны 53 цооног, хээрийн түр сууринд усан халаалт суурилуулах төсөлд "Экологий бүтээмж" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
4	Биологийн нөхөн сэргээлт ба ургамалжуулалт	1	50000 м.кв		Биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжийн орчимд 600 ширхэг хайлаас модыг тариалсан байна.
5	Гүний усны мониторинг хийх зориулалт бүхий усны цооногийн өрөмдлөг	12,500	2	0	Хийгдээгүй
Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийг Тамсаг XXI талбай					
6	Өрмийн хаягдал шингэний саармагжуулалт, нөхөн сэргээлт	3,500	35	35	2019 онд өрмийн шингэн хаягдлын 35 ширхэг өрмийн шингэн сангийн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг "Зорголын гүнж" ХХК хийж гүйцэтгэсэн байна.
7	Газрын хөрсний дээж авах, авсан дээжинд лабораторын шинжилгээ хийх	600	30	30	30 цооногийн өрөмдлөгийн шаврын хаягдлын сангаас хөрсний дээж авах ажлыг MNS 3298:90 стандартын дагуу итгэмжлэгдсэн лаборатори болох Геологийн төв лаборатори болон Цаг уур орчны шинжилгээний газар байгаль орчин хэмжилзүйн төв лабораторид тус тус хөрсний бохирдол байгаа эсэх шинжилгээ хийлгүүлэхээр 2019 оны 7 дугаар сарын 3-4-ний хоорнод хөрсний дээж авч шинжилгээг хийлгэсэн. Шинжилгээний үр дүнд бохирдуулагч элементийн хэмжээ хортой болон аюултай хэмжээнээс давсан тохиолдол гараагүй байна.

№	Ажил	Нэгж үнэ (доллар)	Төлөвлөгдсөн хэмжээ	Гүйцэтгэл	Тайлбар
8	Байгаль орчны үнэлгээний ажил	20,000	4	4	2019 онд -Мэнд шүтээн ХХК: Ажилчдын нэгдсэн кемпийн өргөтгөл, зөөврийн сууцны угсралтын ажил - Экологийн бүтээмж ХХК: ТА-2 нэгдсэн байгууламжийн химийн бодисын агуулах шинээр барих - Цавчирийн хөндий ХХК: ТА-21 Үйлдвэрлэлийн баазын гал унтраах болон хамгаалалтын бүтээн байгуулалтын ажил, 21 дүгээр талбайн олборлотыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтын ажил зэрэгт байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил хийгдсэн.
9	Биологийн нөхөн сэргээлт ба ургамалжуулалт	1	24000 м.кв	24000 м.кв	2019 оны 9 дүгээр сарын 5-22-ны "Халодевилоп" ХХК нийт 2.4 га талбайд биологий нөхөн сэргээлтийн ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн байна. Тус ажлын хүрээнд 160 кг үр тарьсан бөгөөд үүнээс 50 кг нь эмзэг түрүүт өлөнгө, 110кг нь соргүй согооворын үр байсан.
10	Гүний усны мониторинг хийх зориулалт бүхий усны цооногийн ерөмдлөг	15,000	4	0	Тус ажил хийгдээгүй

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар, УУХҮЯ

Хүснэгт 6.18 Сентрал азиан петролеум корпорэйшн лимитед ХХК

№	Ажил	Нэгж үнэ (доллар)	Төлөвлөгдсөн хэмжээ	Гүйцэтгэл (доллар)	Тайлбар
Сентрал азиан петролеум корпорэйшн лимитед ХХК-ийн Богд IV, Онги V талбай					
1	Техникийн нөхөн сэргээлт	-	-	-	Өрмийн ажлын зардалд орсон
Петроматад ХХК-ийг Матад ХХ талбай					
2	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр			48,000	
3	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан /БОННУ/			12,000	
4	Байгаль орчны зөвлөх үйлчилгээ			8,000	

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар, УУХҮЯ

6.7.8. Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд, тэдгээрийн байршил

Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд нь уул уурхайн компаниуд эсвэл уурхай байрлах холбогдох дүүрэг, аймгийн Засаг дарга нартай гэрээ хийж шаардагдах ажлыг гүйцэтгэдэг.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгжид байгаль орчны чиглэлээр мэргэжлийн байгууллагын эрх олгох журам"-ын дагуу эрх олгож, сунгадаг. 2018 оны 08 сараас эрх шинээр олгохыг, 2019 оны 04 сараас эрх сунгахыг хориглосон бөгөөд энэ хугацаанаас хойш шинээр олгохгүй, сунгахгүй байна.

Нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын мэдээллийг Байгаль орчны мэдээллийн сан буюу <https://eic.mn/dlid/orgname.php> холбоосоор харах боломжтой юм.

Эдгээр байгууллагуудыг байршлаар нь авч үзвэл 45 компани Улаанбаатар хотод, үлдсэн 16 компаниуд Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймагуудад байна. Ихэнх нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд нь уул уурхайн компаниудтай гэрээ хийж ажилладаг болохыг БОАЖЯ мэдээлсэн ба нөхөн сэргээлтийн компаниудын байршил нь тэдгээрийн үйл ажиллагаа явуулж буй байршлыг тодорхойлохгүй болно.

2019 оны нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөлтэй компаниудын байршлаар нь ангилж доорх хүснэгтэд харуулав. Үүнд:

Хүснэгт 6.19 Нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөлтэй компаниуд, байршлаар

Хот/ Аймаг	Дүүрэг/ Сум	Компаниудын тоо	Хот/ Аймаг	Дүүрэг/ Сум	Компаниудын тоо
Баян-Өлгий	Өлгий сум	1	Сэлэнгэ аймаг	Сүхбаатар сум	1
Баянхонгор	Баянхонгор сум	1	Төв аймаг	Баянчандмань сум	1
Говь-Алтай	Жаргалант сум	1	Төв аймаг	Заамар сум	1
Дархан-Уул	Дархан сум	1	Улаанбаатар	Баянгол дүүрэг	10
Дорнод	Хэрлэн сум	4	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг	13
Орхон аймаг	Баян-Өндөр сум	1	Улаанбаатар	Сонгинохайрхан дүүрэг	2
Өвөрхангай	Арвайхээр сум	1	Улаанбаатар	Сүхбаатар дүүрэг	9
Өвөрхангай	Уянга сум	2	Улаанбаатар	Хан-Уул дүүрэг	4
Өмнөговь	Даланзадгад сум	1	Улаанбаатар	Чингэлтэй дүүрэг	7
Дүн					61

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

2019 оны зөвшөөрөлтэй 61 компанийн дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 26 (а)-с харна уу.

2018-2019 онд эрх нь цуцлагдсан газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагын тоо 64 байсан бөгөөд А-153 тушаалаар нийт 62 компани байсан ба үүнийг тоот тушаалаар, аймаг, нийслэл, сум, дүргээр ангилан мэдээллийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 6.20 Эрх нь цуцлагдсан газрын хэвлийн нөхөн сэргээлт

Тушаалын дугаар, огноо	Аймаг /нийслэл/	Сум /дүүрэг/-ийн нэр	Цуцалсан компанийн тоо
Хүчингүй болсон /2018.02.09-ний А-23 тушаалаар/	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүрэг	1
Хүчингүй болсон /2018.05.22-ны А-147 тушаалаар/	Улаанбаатар хот	Хан-Уул дүүрэг	1
Хүчингүй болсон /2019.05.01-ний А-153 тушаалаар/	Баянхонгор аймаг	Баян-Овоо сум	1
	Баянхонгор аймаг	Баянхонгор сум	17
	Баянхонгор аймаг	Бөмбөгөр сум	1
	Дархан-Уул аймаг	Дархан сум	1
	Орхон аймаг	Баян-Өндөр сум	1
	Өвөрхангай аймаг	Арвайхээр сум	1
	Өвөрхангай аймаг	Тарагт сум	1
	Сэлэнгэ аймаг	Ерөө сум	1
	Сэлэнгэ аймаг	Мандал сум	1
	Төв аймаг	Зуунмод сум	1
	Улаанбаатар хот	Багахангай дүүрэг	1
	Увс аймаг	Тариалан сум	1
	Улаанбаатар хот	Баянгол дүүрэг	7
	Улаанбаатар хот	Баянзүрх дүүрэг	11
	Улаанбаатар хот	Сонгинохайрхан дүүрэг	4
	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүрэг	3
	Улаанбаатар хот	Хан-Уул дүүрэг	4
Улаанбаатар хот	Чингэлтэй дүүрэг	3	
Ховд аймаг	Жаргалант сум	2	
Дүн			64

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам


2019 оны байдлаар нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан 64 компанийн дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 26(б)-с харна уу.

6.8. ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМ

6.8.1 Цахим тайлагналын системийн танилцуулга

Цахим тайлагналын системийн зориулалт нь газрын тос, байгалийн хий, ашигт малтмал зэрэг байгалийн баялгийг хэрхэн удирдаж буй талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэх, энэ талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байдаг. Үүний үр дүнд төр болон компани, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, итгэлцлийг нэмэгдүүлэх юм. Тиймээс энэхүү цахим тайлагналын систем нь улс орны хэмжээнд өндөр ач холбогдолтой.

Зураг 6.4 Цахим тайлагналын систем




(<https://www.interactive.mn/projects/e-reporting-system-of-mining-and-oil-sector/>, 2020)

Уул уурхайн салбарт өрнөж буй үйл ажиллагааны талаарх гол мэдээллүүдийг интернетээр олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй болгох боломж ийнхүү бүрдсэн юм. Мөн тус цахим тайлагналын системийг боловсруулахдаа баримталсан зарчмуудыг тодорхойлбол:

- Нээлттэй ба үнэ төлбөргүй мэдээлэл: Мэдээллийг интернетээр нийтлэх, ингэснээр олон нийтэд үнэ төлбөргүй мэдээллийг хүртээх боломжтой
- Олон нийт хандах боломжтой байх: Компьютер ба цахимд суурилсан хэрэгслүүдийг ашиглан мэдээлэлд хандах боломжтой байх буюу оролцогч талууд өөрсдийн хэрэгцээний дагуу мэдээллийг бүх төрлөөр харж болдог байх,
- Өөртөө үйлчлэх: хэрэглэгч өөрийн хүссэнээр дагуу мэдээллийг МОУИТБС-ын өгөгдлийн сангаас шууд татан авч, төрөл бүрийн байдлаар задлан шинжлэх хэрэглэх боломжтой байх


Зураг 6.5 Зарчим



(Эх сурвалж: “ОУИТБС-ын онлайн тайлагналын системийн хөгжүүлэлт, хэрэжүүлэлт” кейс судалгаа, Хуудас 11, 2016 он)


Одоогоор тус цахим хуудсаар олон нийт, иргэдэд Монгол улсын ОУИТБС-ын нэгтгэлийн тайлангуудыг хавсралтуудын хамт үнэ төлбөргүйгээр хүргэхээс гадна уул уурхайн салбарт өрнөж буй үйл ажиллагааны талаар дараах гол статистик тойм мэдээллүүдийг цахим хуудсаар (<http://eitimongolia.mn/>) толилуулдаг байна. Үүнд:

Зураг 6.6 Цахим хуудас дахь мэдээлэл



(www.eitimongolia.mn, 2020)

Зураг 6.7 Системийн бүрэлдэхүүн хэсэг



(ОУИТБС-ын Цахим тайлангийн системийн гарын авлага, хууд. 3)

6.8.2 Цахим тайлагналын системийн байдал

Төрийн байгууллагууд болон компаниудаас тайлагнасан төлбөр, орлогын тоо мэдээллийг тулган баталгаажуулж, нэгтгэх ажлын эхний явцад МОУИТБС-ийн цахим тайлагналын системд хэд хэдэн төрлийн доголдлууд гарсан ч Ажлын албаны мэдээллийн технологийн менежер цаг алдалгүй арга хэмжээ авч хэвийн ажиллагаанд оруулсан.

Олон нийт, хэрэглэгчид цахим тайлагналын системээс компаниудын тайлагнасан дүнг орж үзэх боломжтой боловч компаниудын ил тодын тайлангийн тушаасан байдал маш хангалгүй байна.

Харин статистик тойм мэдээллүүдийг ОУИТБС-ийн цахим тайлагналын системд ил болгосон хэдий ч мэдээллийн хувьд байнга шинэчлэлт хийгдээгүй байна. Энэ талаарх дүгнэлт тайлбарыг дараах хүснэгтээр харууллаа. Үүнд:

Хүснэгт 6.21 Цахим тайлагналын систем

Тойм статистик мэдээллийн төрөл	Мэдээлэл боловсруулалтын талаарх дүгнэлт
Олгогдсон тусгай зөвшөөрлийн статистик мэдээлэл	2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй
Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний статистик мэдээлэл	Линкээр дэлгэрэнгүй жагсаалтыг харуулах товч байгаа боловч ажиллагаагүй. Ашигт малтмал, газрын тосны газрын цахим хуудсын мэдээлэл шинэчлэгдсэн холбоотойгоор ажиллахгүй болсон.
Хайгуулын ажлын статистик мэдээлэл	2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй
Бүтээгдэхүүн борлуулалтын статистик мэдээлэл	2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй
Татвар төлбөрийн статистик мэдээлэл	2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй
Хандив дэмжлэгийн статистик мэдээлэл	2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй
Байгаль орчны нөхөн сэргээлтийн статистик мэдээлэл	2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй
Эдийн засагт оруулсан хувь нэмэрийн талаарх статистик мэдээлэл	2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй
Бенефициар эзэд	2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй
Ил тод, нээлттэй компаниуд	2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй
Ашиг хүртэгч эздийн ил тод байдал	2017 оны байдлаар 190 Компанийн мэдээллийг ил тод болгосон
Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ	2016 оны байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй
Байгаль орчин	2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан.

2019 оны ил тод байдлын тайланг компаниудаас цахим тайлангийн системээр шинэ, хуучин 2 маягтаар авсан байна. Хуучин маягтаар 2020 оны 4 дүгээр сарын 30-ныг хүртэл, шинэ маягтаар 10 дугаар сарын 30-ныг хүртэл тайлан авсан гэж Ажлын албанаас мэдэгдсэн.

Хуучин маягтаар нийт 1472 компани тайлан илгээсэн бол, 881 компани тайлангаа илгээгээгүй, харин 633 компани шинэ маягтаар тайлангаа гаргажээ. Төрийн 2 яам, 4 агентлаг болон орон нутгийн 19 аймаг, 8 дүүргийн засаг захиргаа хүлээн авсан төлбөр, орлогоо цахимаар тайлагнасан байна.

Шинэ маягтуудыг гараар байршуулж байгаа бөгөөд програм хоорондын нийлэмжийг шинэчлэх ажил хийгдэж дуусаагүйн улмаас шинэчилсэн маягтаар ирүүлсэн мэдээллүүдэд доорх алдаанууд илэрч байна. Үүнд:

- Мэдээллүүд давхардсан,
- Олон сонголтод мэдээллүүдийг тодорхойлох боломжгүй,
- Компаниудын ирүүлсэн мэдээлэл хоосон

гэх мэт дутуу боловсруулагдсан мэдээллийг олон нийтэд ил тод болгох, цаашлаад тайлан хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах эрсдэлтэй байна.

6.9. АШИГЛАСАН УСНЫ МЭДЭЭЛЭЛ

Монголын ОУИТБС-ын ОТАХ-ийн гишүүдийн саналаар 2019 оны ОУИТБС-ын нэгтгэл тайланд сонгогдсон уул уурхайн компаниудын ашигласан усны хэмжээг ил тод болгохыг хүссэн. Иймд

ашигласан усны мэдээллийг компаниудаас авах зорилгоор цахим тайлагналын системд шинэ маягтаар 10 дугаар сарын 30-ныг хүртэл тайлан авсан гэж Ажлын албанаас мэдэгдсэн.

Гэвч энэ хугацаанд компаниуд шинэ маягтаар ашигласан усны мэдээллээ огт илгээгээгүй тул хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс 2020 оны 12 дугаар сарын 7-ноос 12 дугаар сарын 17 хүртэл цахим тайлангийн маягтаар ашигласан усны мэдээллийг ирүүлэхийг хүсэхэд нийт нэгтгэлд сонгогдсон 171 компаниас 19 компани хариу ирүүлсэн. Эдгээр 19 компани нь 2019 онд ус ашигласны төлбөрт ЗГ-т 1,576.2 сая.төгрөг төлсөн.

Маягтыг бөглөсөн компанийн мэдээллийг нэгтгэж үзэхэд нийт 8,136,195.79 метр.куб ус ашиглахаар гэрээ хийсэн боловч 8,010,623.29 метр.куб буюу гэрээлсэн усны 98.4 хувийг ашигласан байна.

Хүснэгт 6.22 Ус ашиглах гэрээ

Үзүүлэлт	Гэрээнд заасан ашиглах усны хэмжээ (метр.куб)	Ашигласан гадаргын усны хэмжээ (метр.куб)	Ашигласан газрын доорх усны хэмжээ (метр.куб)	Ашигласан нийт усны хэмжээ (метр.куб)	Саарал ус буюу ахуйн хэрэглээнээс үүссэн бохир усыг дахин ашигласан бол хэмжээ (метр.куб)
Тоо хэмжээ	8,136,195.79	1,868,142.09	6,142,481.20	8,010,623.29	116,320.00

2019 онд хамгийн их усны төлбөр төлсөн топ 10 компанийг Хүснэгт 6.23-д харуулав.

Хүснэгт 6.23 Усны төлбөр төлсөн топ 10 компани

Компанийн нэр	Ус ашигласны төлбөр (сая.төг)	Ашигласан усны хэмжээ метр.куб			Саарал ус буюу ахуйн хэрэглээнээс үүссэн бохир усыг дахин ашигласан бол хэмжээ (метр.куб)
		Гадаргын	Газрын доорх	Нийт	
Оюу Толгой	14,825	Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй			
Эрдэнэт	12,701.7	Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй			
Петрочайна Дачин Тамсаг	2,873.4	Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй			
Энержи Ресурс Багануур	1,590.8	Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй			
Монголросцветмет	893.8	-	5,930,179.6	5,930,179.6	-
Бүрдэл майнинг ХХК	675.2	Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй			
Монголын Алт МАК	510.6	Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй			
Цагаан Өвөлжөө	488.7	Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй			
Цайртминерал	440.9	Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй			
	414.9	Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй			

2019 онд ЗГ нийт нэгтгэлд сонгогдсон 171 компаниас ус ашигласны төлбөр гэж 40,258.5 сая.төгрөг хүлээн авсан ба дээрх 10 компаниуд 35,414.9 сая.төгрөг буюу 87.97 хувийг бүрдүүлж байна.

6.10. ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголын ОУИТБС-ын ОТАХ-ийн гишүүдийн саналаар 2019 оны ОУИТБС-ын нэгтгэл тайланд сонгогдсон уул уурхайн компаниудын ашигласан хог, хаягдлын мэдээллийг ил тод болгохыг хүссэн. Иймд хог, хаягдлын мэдээллийг компаниудаас авах зорилгоор цахим тайлагналын системд шинэ маягтаар 2020 оны 10 дугаар сарын 30-ныг хүртэл тайлан авсан гэж Ажлын албанаас мэдэгдсэн.

Гэвч энэ хугацаанд компаниуд шинэ маягтаар хог, хаягдлын мэдээллээ огт илгээгүй тул хараат бус хянагч 2020 оны 12 дугаар сарын 7-оос 12 дугаар сарын 17 хүртэл цахим тайлагналын системээр уг мэдээллийг авахад 16 компани хариу ирүүлсэн.

Маягтыг бөглөсөн компанийн мэдээллийг нэгтгэж үзэхэд 95.6 хувь буюу 20,213.18 метр.куб-г энгийн хог хаягдал, 4.4 хувь буюу 890.29 метр.куб нь аюултай хог хаягдал байна. Мөн 6646.2 метр.куб хог хаягдлыг устгасан ба үүний 93.4 хувийг буюу 6209 метр.куб хог хаягдлыг ландфилл булшилах, 6.6 хувийг буюу 437.2 метр.куб хог хаягдлыг хими физикийн арга, шатаах, бусад зэрэг аргуудаар устгасан байна.

Бидэнд ирүүлсэн 16 компанийн хог хаягдлын мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6.24 Хог хаягдлын мэдээлэл

Компанийн нэр	Аймаг/ Нийслэл	Аюултай хог хаягдлын хэмжээ (метр.куб)	Энгийн хог хаягдлын хэмжээ (метр.куб)	Нийт хог хаягдлын хэмжээ (метр.куб)	Төлсөн төлбөр (мян.төг)	Устгасан хог хаягдлын хэмжээ	Устгасан хог хаягдлын хэмжээ (Ландфилл булшилсан)
Хос-Хас	Булган	21.39	11.19	32.58	390	11	6
ГОК Булган-Уул	Хэнтий	-	-	-	1,784	-	-
Сауд гоби коэл транс	Өмнөговь	25	6	31	250	-	-
Хөх Бүрдний Эх	Хэнтий	-	-	-	904	-	-
Эм Ди Эф И	Дундговь	1.5	-	1.5	200	1.5	-
Их ундарга майнинг	Төв	0	-	0	360	4	-
Эм Жи Жи И Си	Төв	5	-	5	361	-	-
Хөх шугам	Төв	2	-	2	360	-	-
Сонор трейд	Сэлэнгэ	6,233	439	6,672	-	6,173	6,173
Улз гол	Төв	-	-	-	36	-	-
ХАНШАШИР	Хэнтий	-	-	-	3,600	-	-
Багануур	Улаанбаатар	48	9	57	1,115	-	-
Эй Эл Жи Ти	Увс	4.5	0.5	5	0.6	-	-
Гоби коул энд энержи ХҮРЭН ТОЛГОЙ КОАЛ МАЙНИНГ	Баянхонгор	2.5	-	2.5	350	0.2	-
Тэн Хун	Төв	12,960	424	13,384	5,730.4	456	30

6.11. ОУИТБС-ын тайлангийн задаргааны түвшин, хэлбэр (шаардлага 4.7)

Энэхүү тайланд хамрагдах төлбөр орлогын мэдээллийг компани, төрийн байгууллагууд болон орлогын урсгал төсөл нэг бүрээр дэлгэрүүлэн тайлагнасан ба төслийн түвшинээр мөн задалж харуулсан. Төслийн түвшнээр харуулсан дэлгэрэнгүйг Хавсралт 24-с үзнэ үү.

ОУИТБС-ын стандартад 2019 онд орсон өөрчлөлтөөр төсөл гэж юу болохыг тодорхойлсон ба стандартад өөрчлөлт орох болсон шалтгаан нь ЗГ төсөл тус бүрээс хэдий хэмжээний орлого авч байгаа талаар ил тод болгох, заавал ил тод болгох дүрэмд төсөл бүрээр, ОУИТБС-ын зөвлөл нь 2018 он болон түүнээс цааш орлогыг төслөөр нь задлан харуулах шаардлагыг 2017 онд баталсан.

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар сард хуралдсан 18 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу Ажлын албанаас ОУИТБС-ын Компанийн тайлагналын маягтыг шинэчлэх ажлыг хэрэгжүүлсэн ба төслийн түвшний тайлагналын маягтыг шинээр боловсруулж, Хараат бус хянагч-нэгтгэгч оролцож эхлэх үед компаниуд аль хэдийн тайлангаа тушаасан, цахим тайлагналын систем хаагдсан байсан тул тайлангийн маягтад бид саналаа тусгаагүй болно.

Төслийн тодорхойлолт

МОУИТБС-ын ОТАХ нь төслийг дараах байдлаар тодорхойлсон.

Төсөл гэдэг нь нэг гэрээ, лиценз, концесс эсвэл ижил төстэй эрх зүйн багц гэрээ хэлэлцээрээр зохицуулагдан, төртэй хамаарах төлбөрийн үүрэг хариуцлагын үндсийг бүрдүүлж буй үйл ажиллагааг хэлнэ.

Харилцан холбоотой гэрээ гэдэг нь үйл ажиллагаа болон газар зүйн хувьд уялдмал гэрээ, лиценз, концесс эсвэл ижил төстэй эрх зүйн багц гэрээ хэлэлцээрүүд эсвэл ЗГ-тай байгуулж, төлбөрийн үүргийг тусгасан, агуулгын хувьд ижил нөхцөл бүхий хамаарах гэрээнүүдийг хэлнэ. Ийм төрлийн гэрээ хэлэлцээрийг нэг гэрээ, хамтарсан аж ахуйн нэгж, бүтээгдэхүүн хуваах гэрээ эсвэл бусад нийтлэг зохицуулах эрх зүйн гэрээ зэргээр ерөнхийлөн зохицуулсан байна.

ОУИТБС-ын маягтаар авч буй төслийн төвшний мэдээлэл

ОУИТБС-ын цахим тайлангийн маягтыг бөглөхдөө тухайн хэрэгжүүлж буй төслийн талаарх дараах үндсэн мэдээллийг оруулахаар зааж өгсөн. Үүнд:

- Төслийн нэр
- Төслийн гэрээний огноо
- Техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийн огноо
- Техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийн дугаар
- Ашиглах хугацаа
- Техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан нийт хөрөнгө оруулалт
- Төсөл эхэлснээс хойших хөрөнгө оруулалтын нийт гүйцэтгэл
- Тайлант оны төлөвлөсөн хөрөнгө оруулалт
- Тайлант оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэл
- Техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан жилийн хүчин чадал
- Төсөл эхэлснээс хойших гаргасан бүтээгдэхүүний хэмжээ
- Тайлант онд гаргасан бүтээгдэхүүний хэмжээ
- Ирэх онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ

Компаниуд төсөл тус бүрийн хувьд дээр дурьдсан ТЗЭ компаниудын хувьд задарч болох дараах татварын төрлүүдээр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар болон нэрээр нь төслөө нэрлэж, төсөл тус бүрээр төлбөр, орлогоо ил тод болгохыг маягтаар зааж өгсөн. Үүнд:

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр
- Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

2019 оны тайланд зөвхөн хоёр татварын хувьд төслөөр тайлагнаж байгаа боловч цаашид компаниудын хувьд НББ-дээ сүүлийн үеийн мэдээллийн технологийн дэвшил, ERP систем ашиглан, мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулснаар төслөөр тайлагнаж болох төлбөр орлогын төрлүүдийг үе шаттайгаар нэмэгдүүлэх боломжтой юм.

7

ЗӨВЛӨМЖ



7. ЗӨВЛӨМЖ

7.1. ӨМНӨХ ЖИЛИЙН НЭГТГЭЛ ТАЙЛАНГААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2019 онд өгөгдсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийн байдлын талаарх дүгнэлтийг дор харуулав. Үүнд:

Хүснэгт 7.1 Зөвлөмжүүдийн хэрэгжилтийн байдал

Зөвлөмжүүд	2019 оны ОУИТБС тайлагналаар хэрэгжүүлсэн эсэх	
	Статус	Тайлбар
<p>1. Жендерийн тэгш байдал 2019 оны ОУИТБС-ын стандартын шаардлагын дагуу ОТОБ хүйсийн тэнцвэрт байдлыг хангахын тулд ОТОБ-ийн бүрэлдэхүүнд жендерийн тэнцвэрийг хангах зорилгоор оролцогч тал бүрийн төлөөлөлтэй хэлэлцүүлэг хийж, арга хэмжээ авах.</p>	Цаашид арга хэмжээ авах шаардлагатай	Ажлын төлөвлөгөөнд Жендерийн тэнцвэртэй байдлыг хангахад талууд нэгдмэл ойлголттой болсон байх үйл ажиллагааг оруулсан.
<p>2. Дэд зөвлөлийн идэвхгүй байдал Нийт 22 дэд зөвлөл байна. Дэд зөвлөлүүд нь ямар нэгэн хурал, үйл ажиллагаа зохион байгуулаагүй, идэвхгүй байна. ОУИТБС-ын дэд зөвлөлийн дүрмийг хэрэгжүүлэх боломжийг олгохын тулд илүү практикт тулгуурлан сайжруулах. ОТОБ нь дэд зөвлөлийн санхүүжилттэй холбоотой Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авах ёстой.</p>	Цаашид арга хэмжээ авах шаардлагатай	Орон нутагт мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа тусгасан. ЭБСИТБ-ын хуулийн төсөлд дараах заалтыг тусгасан. <i>26.3.Салбар зөвлөлийн төсвийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төсөвт тусган санхүүжүүлнэ.</i>
<p>3. Мэдээллийн ил тод байдал Газрын тосны БХГ-ний мэдээлэл ил тод байгаа боловч зарим компаниудын гэрээний мэдээлэл байхгүй байна. Иймд БХГ болон зарим зүйл заалт хараахан олон нийтэд ил тод болоогүй байна. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ийн гишүүдийн нэр, ажил албан тушаал, ажлын хаяг зэрэг мэдээллийг Эрдэнэс МГЛ ХК болон бусад компани гэсэн ангиллаар гаргаж, тайланд тусгах. Төрийн болон орон нутгийн өмчит Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал, үзүүлсэн хөнгөлөлт, томилолтын зардлыг охин компани тус бүрээр гаргаж, тайланд тусгах.</p>	Хэрэгжиж байгаа	ТӨК-дын шинэ мэдээллийг шинэчилсэн маягтуудад тусгаж, ҮСХ-оор батлуулсан. Маягтын дагуу цахим сургалт зохион байгуулсан.
<p>4. Бенефициар эздийн мэдээлэл Бенефициар эздийн мэдээллийг жил бүр зөвхөн тохируулгын хүрээнд хамрагдсан компаниудын хувьд ил тод болгодог. Энэхүү үйл явцыг тус салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх компаниудыг оролцуулан илүү өргөн хүрээнд авч үзэх ёстой. ОУИТБС-ын стандартын 2.5-д заасны дагуу ОУИТБС-ын хэрэгжүүлэгч орнууд хайгуул, олборлолт, газрын тос, байгалийн хийн олборлолт эрхлэх тусгай зөвшөөрөл, гэрээнд оролцох эрх бүхий өргөдөл гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудын бенефициар эздийн бүртгэлийг олон нийтэд нээлттэй байлгах ёстой.</p>	Хэрэгжүүлсэн	Өргөдөлд тусгагдах мэдээллийг АМГТГ анхаарч ажиллахаа илэрхийлсэн. ЭБСИТБ-ын хуулийн төсөлд холбогдох заалтыг тусгасан.
<p>5. Засгийн газрын байгууллагуудын хоорондын мэдээллийн зөрүүтэй байдал ОУИТБС-ын тайланд тусгах үндсэн мэдээллийг цуглуулах явцад хэд хэдэн ЗГ-ын агентлагуудын цахим хуудсанд нийтэлсэн статистик тоо баримтууд хоорондоо нийцэхгүй байсан. Уул уурхайн салбарын тусгай зөвшөөрөл, үйлдвэрлэл, экспортын орлого,</p>	Цаашид арга хэмжээ авах шаардлагатай	ЗГ-ын тогтоолын төслийг УУХҮЯ-д өргөн барина.

Зөвлөмжүүд	2019 оны ОУИТБС тайлагналаар хэрэгжүүлсэн эсэх	
	Статус	Тайлбар
орлоготой холбоотой статистик жишээ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ҮСХ болон СЯ нарын хоорондын мэдээлэл ялгаатай байна. Олборлох салбартай холбоотой статистик мэдээллийг эхлээд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд төвлөрүүлэх хэрэгтэй. Эдгээр статистик мэдээллийг хянаж, шалгасны дараа бусад засгийн газрын байгууллагуудад өгөх ёстой. Мөн Бичил уул уурхайн нэгдсэн дээвэр холбоо болон Ашигт малтмал газрын тосны газраас гаргасан бичил уурхайчдын тоо хэмжээ, тушаасан алтны хэмжээ зэргийг мэдээлэл нь хоорондоо зөрүүтэй байна.		
<p>6. Засгийн газрын байгууллагууд болон компаниудын мэдээллийн иж бүрэн, гүйцэд тайлагнах</p> <p>Төрийн байгууллагууд нийтэд мэдээлж буй мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг хянаж байх. Аймаг, орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд нь ОУИТБС-ын цахим системд мэдээллээ хугацаанд нь, иж бүрэн тайлагнадаг болох хэрэгтэй. ОУИТБС-ын ажлын алба нь цахим системд тайлагнах үүрэг бүхий бүх төрийн байгууллагууд бүрэн тайлагнаж буй эсэхийг хянах тогтолцоо бүрдүүлэх.</p>	Цаашид арга хэмжээ авах шаардлагатай	Аймгууд руу УУХҮЯ-наас албан тоот явуулах – хүлээгдэж байна.
<p>7. Тайлангийн маягт сайжруулах</p> <p>Тайланд хамрагдаж байгаа орлогын урсгалуудыг төсөл (тусгай зөвшөөрөл) тус бүрээр ялган тайлагнах. Ажилчдын мэдээллийг дэлгэрэнгүй болгох (ажилчдын насны талаарх мэдээлэл нэмэлтээр оруулах). Баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн маягтад тусгаж оруулах. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллах гэрээ байгуулсан оператор, туслан гүйцэтгэгч болон ханган нийлүүлэгч компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг оруулах.</p>	Хэрэгжүүлсэн	Эдгээр мэдээллүүдийг шинэчилсэн маягтуудад оруулж, ҮСХ-оор батлуулсан.
<p>8. Цахим тайлангийн систем</p> <p>ЗГ-ын болон компаниудаас үндсэн болон нэмэлт мэдээллийн маягтыг цахим системд оруулах. Ингэснээр нэгтгэл тайлангийн ажлын мэдээлэл цуглуулах болон нэгтгэх ажилд цаг хугацаа бага зарцуулна. Ил тод нээлттэй байх мэдээллийг цахим тайлагналын систем болон, албан ёсны веб сайтдаа байршуулаагүйгээс хамаарч тухайн албан газрууд руу албан бичиг бичиж мэдээлэл хүсэх, хариу ирэхгүй байх зэрэг хүндрэлүүд гарч байна. ОУИТБС-ын цахим системд оруулах мэдээллийг ЗГ-ын холбогдох байгууллагуудын гаргаж буй мэдээлэлтэй ижил байдлаар оруулж байх.</p>	Хэрэгжүүлсэн	Мэдээллийг цахим системд 2020 оны 5-р сарын 24-ний дотор оруулсан хэдий ч, систем ажиллахгүй байсан. Иймд системийг хөгжүүлэгч Интерактив ХХК-тай хамтарч ажилласны үр дүнд 8-р сарын 17-ноос идэвхжүүлсэн. Ингэснээр нийт 511 компани тайлангаа шинэ маягтаар гаргаж, системд оруулсан.
<p>9. Ил тод гэрээ сайтад гэрээний мэдээллийг бүрэн оруулах</p> <p>iltodgerее.mn сайтад байршуулсан гэрээнүүдийн хувьд зарим үнийн дүнгээр илэрхийлсэн зүйл заалтуудыг харагдахгүй байдлаар оруулсан байгаа нь гэрээ 100 хувь ил тод болсон гэж үзэх нөхцөл бүрдэхгүй байна. Иймээс iltodgerее.mn сайтад гэрээний бүх нөхцөлийг иж бүрэн, ямар нэгэн зүйл заалт хасахгүй оруулж байх</p>	Хэрэгжиж байгаа	Аймаг, нийслэл, дүүргүүд гэрээнүүдээ оруулж байна. 2020 оны 12-р сарын 22-ний байдлаар 796 гэрээ оруулаад байна. Гэрээний бүх нөхцөлийг нийтэд ил тод болгох эсэх талаар мэдээлэл алга байна.

7.2. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТАЙЛАНГААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол улс дахь ОУИТБС-ын хоёр дахь удаагийн буюу 2018 оны 1 дүгээр сард хийгдсэн баталгаажуулалтын үнэлгээний үр дүнд засан залруулах арга хэмжээний хэрэгжилт

ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны зүгээс хүсэмжилсэн анхны баталгаажуулалтаар өгсөн засан залруулах 8 үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн Монгол улсын алхмуудыг судлан үзсэний үндсэн дээр бүхий л засан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж, хамаарах шаардлагуудыг ханган биелүүлэхэд Монгол улс нь “хангалттай хэмжээнд” ахиц гаргасан хэмээн үзсэн байна.

Хоёр дахь удаагийн баталгаажуулалтаар 8 зөвлөмжөөс нэмж сайжруулах талаар 4 шаардлагад зөвлөмж өгсөн бөгөөд тэдгээрийн хэрэгжилт доорх байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 7.2 Зөвлөмжүүдийн хэрэгжилтийн байдал

№	Анхны баталгаажуулалтаар өгсөн зөвлөмжид хамаарах ерөнхий шаардлага	ОУ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын (ОУНБДГ) үнэлгээ	Хоёр дахь баталгаажуулалтаар өгсөн засан залруулах арга хэмжээ	Хоёр дахь баталгаажуулалтаар санал болгосон зөвлөмжийн хэрэгжилт (ОУИТБС хариу)
1	Шаардлага 1.4.b.vi дээр заасныг баримтлан ОТОБ нь санаачилгын хэрэгжилтийн бүхий л явцад оролцогч бүх талыг түншлэгч хэмээн ижил хандаж оролцоот шийдвэр гаргаж байхыг баталгаажуулах үүрэг хүлээнэ. ОТОБ нь олон талт бүлэгт ажиллах бүлэг бүр нь өөрийн төлөөллийг нэр дэвшүүлэх болон солих журмыг хэлэлцэн баталж, хэвлэн нийтэлсэн байна. Шаардлага 1.4.b.iii дээр заасны дагуу ОТОБ-ын гишүүд нь өөрийн хамаарах, төлөөлж буй бүлэгтэй хамтран ажиллаж байх үүргийг хүлээнэ.	ОУНБДГ-ын зүгээс оролцогч талуудын хяналтын асуудлыг Монголын ОУИТБС анхааралдаа авсанд сэтгэл хангалуун буй бөгөөд 1.4 дүгээр шаардлагын хүрээнд Монгол улс нь хангалттай хэмжээнд амжилт гаргасан хэмээн үзэж байна.	Байхгүй.	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд “Үндэсний зөвлөлийн гишүүнээр оролцох хуулийн этгээд, иргэний нийгмийн төлөөллийг олон нийтэд ил тод зарлах, төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулах, оролцоог эрх тэгш бүрдүүлэх нөхцөлийг ажлын алба хангаж ажиллана” гэж зохицуулахаар зааж өгсөн.
2	Шаардлага 2.2.a дээр заасны дагуу ЗГ нь тухайн жилд ашигт малтмал, газрын тос болон байгалийн хийн салбарт олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлийг, тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн болон зохицуулалтын хэм хэмжээ зөрчигдсэн байдлын хамтаар ил тод болгох арга хэмжээг авна. 2.3 дугаар шаардлагын дагуу ЗГ нь ашигт малтмал, газрын тос болон байгалийн хийн тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан огноог олон нийтэд нээлттэй болгон, газрын тос болон байгалийн хийн тусгай зөвшөөрлийн талбайн солбилцлыг хэвлэн нийтэлнэ.	ОУНБДГ-ын зүгээс тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэхтэй холбоотой ил тод байдлыг хангах засан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж, 2.2, 2.3 дугаар шаардлагыг хангах чиглэлд хангалттай хэмжээнд ахиц гаргасан хэмээн үзэж байна.	Нарийн бичгийн дарга нарын газар нь тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн болон зохицуулалтын орчныг хэвийн бус байдлаар зөрчигдсөн, практикаас гажсан зөрчилтэй үйлдлийг үнэлэх чиглэлээр ихээхэн ажил хийсэн ч зөрчлийн талаар зөвлөмж хомс буй нь асуудал үүсгэж болно. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт болон шилжүүлэх үйл явцыг шалгахад ОТОБ оролцох боломжтой юм.	2018 оны нэгтгэл тайлангийн хүрээнд холбогдох зөрчлийн талаар хэд хэдэн тохиолдлыг судалж дүнг хэвлүүлсэн. http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/final-reports/Mongolia_2018_EITI_Report_MN-12.30.pdf , 26-р хуудас Тусгай зөвшөөрлийн өргөдлийн огноог хэвлэн нийтлэх талаар АМГТГ-аас арга хэмжээ авахаар хүлээгдэж байна. Түүнээс гадна ЭБСИТБтХуулийн төсөлд тсгалаа олсон байна. 16.1.1.e.тусгай зөвшөөрлийн төрлийн талаарх тайлбар, ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, гаж ахуйн нэгжид тавигдах техникийн болон санхүүгийн шалгуур, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, цуцлах үйл явц, холбогдох зохицуулалтын мэдээлэл, 16.1.1.ё.олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж болох газрын кадастрын мэдээлэл, талбайн солбицол, түүнийг тодорхойлох журам,

№	Анхны баталгаажуулалтаар өгсөн зөвлөмжид хамаарах ерөнхий шаардлага	ОУ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын (ОУНБДГ) үнэлгээ	Хоёр дахь баталгаажуулалтаар өгсөн засан залруулах арга хэмжээ	Хоёр дахь баталгаажуулалтаар санал болгосон зөвлөмжийн хэрэгжилт (ОУИТБС хариу)
				<p>холбогдох шийдвэр, тайлбар, өөрчлөлтийн мэдээлэл;</p> <p>Мөн 2020 онд батлагдсан шинэ маягтуудад холбогдох шаардлагыг оруулсан байна.</p>
3	<p>Шаардлага 2.6 дээр заасанчлан ОТОБ нь ТӨК-иудын хуримтлагдсан ашиг болон дахин хөрөнгө оруулалттай холбоотой хэрэгжүүлж буй журам дүрмүүд, практикийн талаар тайлбар гаргах ёстой.</p> <p>ЗГ нь мөн ТӨК болон тэдгээрийн охин компаниуд дахь төрийн өмчид тухайн жилд гарсан өөрчлөлтийг ил тод мэдээлэх, төр эсвэл ТӨК-ийн зүгээс уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниудад олгосон зээл, зээлийн баталгааны талаарх иж бүрэн мэдээллийг гаргах үүргийг хүлээнэ.</p> <p>6.2 дугаар шаардлагад заасны дагуу ОТОБ нь олборлох салбар дахь ТӨК болон тэдний охин компаниудын төсвийн шинжтэй зарцуулалт буй эсэх, (үүнд олгосон татаас мөн багтана) эдгээрийн материаллаг байдлын тухай судлан үзэж, материаллаг төсвийн шинжтэй ямар нэгэн шилжүүлгийг ил тод болгох үүрэгтэй.</p>	<p>ОУНБДГ-ын зүгээс олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ил тод байдлыг хангахтай холбоотой санал болгосон засан залруулах арга хэмжээнд Монгол улс хангалттай хэмжээнд анхаарал хандуулж, 2.6, 6.2 дугаар шаардлагыг биелүүлэх чиглэлд <u>хангалттай хэмжээнд ахиц гаргасан хэмээн дүгнэж байна.</u></p>	<p>ОТОБ нь Эрдэнэс Монгол болон Олон улсын санхүүгийн корпораци, Олон улсын валютын сан болон Азийн хөгжлийн банк зэрэг техникийн туслалцаа үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллаж 2.6 дугаар шаардлагад дурдсан мэдээллийг (жишээ нь ТӨК-ийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан) ил тод болгох чиглэлээр ажиллавал үр дүнтэй байх юм.</p> <p>Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд ОТОБ нь төсвийн шинжтэй зарцуулалтыг Сангийн яамны вебсайт эсвэл Монголын ОУИТБС-ын мэдээллийн портал зэрэг төрийн байгууллагуудын ашигладаг системд төлөвшүүлэн байнга мэдээлж байх зорилгоор төсвийн шинжтэй зардлын хамрах цар хүрээг илүү өргөн хүрээнд тогтоож болох юм.</p>	<p>Мөн хуулийн төслийн “12 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын чиг үүрэг”- д эдгээр асуудлыг оруулсан байна.</p> <p>Төсвийн шинжтэй зарцуулалтын тайлгнгалын маягыг Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар 2018 онд батлуулж мөрдөж байна.</p>
4	<p>4.5 дугаар шаардлагад заасанчлан ОТОБ нь тайлан гаргах үйл явц нь материаллаг байдлыг үнэлж, орон нутгийн төрийн байгууллагуудад хийгдсэн материаллаг төлбөрийг иж бүрнээр ил тод болгох шаардлагатай.</p>	<p>ОУНБДГ-ын зүгээс төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн шилжүүлэгтэй холбоотой ил тод байдлыг хангахын тулд авч хэрэгжүүлсэн засан залруулах арга хэмжээнд сэтгэл хангалуун буй бөгөөд Монгол улс нь 4.5 дугаар</p>	<p>Санаачилгын хэрэгжилтийг цаашид сайжруулахын тулд ОТОБ нь ТӨК-д хамаарах онцлог шилжүүлгийг төрийн байгууллагын түгээмэл систем эсвэл ОУИТБС-ын мэдээллийн порталаар дамжуулан ил тод болгож байх арга замыг эрэлхийлбэл зүйтэй болно.</p>	<p>Мөн хуулийн төсөлд орон нутгийн төлбөрийн холбогдолтой асуудлыг хамруулсан байна. 2020 онд батлагдсан шинэ маягтуудад эдгээр асуудлыг мөн хамруулсан байна.</p>

№	Анхны баталгаажуулалтаар өгсөн зөвлөмжид хамаарах ерөнхий шаардлага	ОУ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын (ОУНБДГ) үнэлгээ	Хоёр дахь баталгаажуулалтаар өгсөн засан залруулах арга хэмжээ	Хоёр дахь баталгаажуулалтаар санал болгосон зөвлөмжийн хэрэгжилт (ОУИТБС хариу)
		шаардлагыг ханган биелүүлэхэд <u>хангалттай хэмжээний ахиц гаргасан хэмээн үзэж</u> байна.		
5	<p>ОУИТБС-ын 4.9.b.iii дугаар шаардлага болон ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн баталсан Хараат бус нэгтгэгчийн Гүйцэтгэх ажлын стандарт даалгаварын дагуу ОТОБ болон Хараат бус нэгтгэгч нь доорх үүргийг хүлээнэ:</p> <p>а. ОУИТБС-ын тайлан гаргах үйл явцад оролцож буй компани болон төрийн байгууллагуудын аудитын болон баталгаажуулалтын журмыг шинжлэн шалгаж, үүн дээр үндэслэн гарган өгч буй мэдээлэл нь 4.9 дүгээр шаардлагын дагуу үнэн зөв, итгэл төрүүлэхүйц болохыг баталгаажуулах зорилгоор оролцогч компаниуд болон төрийн байгууллагууд ямар мэдээллийг Хараат бус нэгтгэгчид гарган өгөх шаардлагатай болохыг зөвшилцөн гаргасан байна.</p> <p>б. Хараат бус нэгтгэгч нь гарган өгсөн санхүүгийн мэдээллийн иж бүрэн болон найдвартай байдалд үнэлгээ хийж, үүнд Хараат бус нэгтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын талаар мэдээллийн чанартай тойм, тухайн хийсэн үнэлгээний хязгаарлалтуудыг багтаасан байна.</p> <p>в. Хараат бус нэгтгэгч нь ОУИТБС-ын тайлан гаргах үйл явцын харилцан зөвшилцөн тогтоосон цар хүрээнд хамаарах бүх компани болон төрийн байгууллага хүсэмжилсэн мэдээллийг гарган ирүүлсэн эсэхийг шалган баталгаажуулна. Хараат бус нэгтгэгчид тайлагнахад гарсан ямар нэгэн орхигдол, сул талуудыг ОУИТБС-ын тайланд ил тодоор мэдээлж, үүнд гаргасан журмыг даган мөрдөөгүй байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, энэ нь тайлангийн иж бүрэн байдалд материаллаг нөлөөлөл</p>	<p>ОУИТБС-ын тайлангийн нэгтгэлд хамрагдаж буй мэдээллийн найдвартай байдлын чиглэлд санал болгосон засан залруулах арга хэмжээнд анхаарал хандуулж, 4.9 дүгээр шаардлагыг биелүүлэхэд <u>хангалттай хэмжээний ахицыг</u> Монгол улс гаргаад байна хэмээн Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар үзэж байна.</p>	байхгүй	Хараат бус хянан нэгтгэгчийн ажлын даалгаврыг олон улсын стандартын зөвлөмжийн дагуу мөрдөхийн хамт Иргэний нийгмийн ТАН эвслээс өгсөн шаардлагуудыг нэмэлт байдлаар оруулан мөрдөж байна.

№	Анхны баталгаажуулалтаар өгсөн зөвлөмжид хамаарах ерөнхий шаардлага	ОУ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын (ОУНБДГ) үнэлгээ	Хоёр дахь баталгаажуулалтаар өгсөн засан залруулах арга хэмжээ	Хоёр дахь баталгаажуулалтаар санал болгосон зөвлөмжийн хэрэгжилт (ОУИТБС хариу)
	үзүүлж болох эсэхэд хийсэн үнэлгээ зэргийг багтаана.			
6	5.2.а шаардлагын дагуу ОТОБ нь ТӨК-иудын орон нутагт шууд төлж буй төлбөр болон орон нутгийн шилжүүлгийн ялгааг мэдээлэл цуглуулж эхлэхээс өмнө урьдчилан тодорхой болгосон байх үүрэгтэй. ОТОБ нь ОУИТБС-ын тайлан нь аймаг болон сумдад хийгдсэн шилжүүлгийн орлого хуваалцах томьёог харуулж, орон нутгийн шилжүүлгийн төсөвлөсөн дүн болон гүйцэтгэлд гарч буй зөрүүг ил тод болгосон байна.	ОУНБДГ нь орон нутгийн шилжүүлэгтэй хамаарах засан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэмээн тооцож, Монгол улс нь 5.2 дугаар шаардлагыг ханган биелүүлэх чиглэлд <u>хангалттай ахиц гаргасан</u> хэмээн үзэж байна	байхгүй	2018 оны Нэгтгэл тайланд тусгалаа олсон байгаа. Хуудас 99.
7	Шаардлага 6.1.а дээр заасны дагуу ОТОБ нь мэдээлэл цуглуулж эхлэхээс өмнө заавал тайлагнах болон сайн дурын үндсэн дээр тайлагнах нийгмийн зарцуулалтууд хоорондыг ялгаа заагийг тодорхойлон гаргасан байх үүргийг хүлээнэ. Заавал тайлагнах нийгмийн зарцуулалт мөнгөн бус хэлбэрээр хийгдсэн бол ОТОБ нь тухайн зарцуулалтын зориулалт, мөнгөн дүнгээр илэрхийлсэн үр дүнг ил тод болгосон байна. Хэрэв заавал тайлагнах нийгмийн зарцуулалтын хүлээн авагч нь төрийн байгууллага бус харин гуравдагч тал бол ОТОБ нь тухайн хүлээн авагчийн нэр болон үндсэн чиг үүргийг ил тод мэдээлнэ.	ОУНБДГ нь нийгмийн зарцуулалтыг ил тод болгохтой засан залруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэнд сэтгэл ханамжтай буйн зэрэгцээ 6.1 дүгээр шаардлагыг хангахад <u>хангалттай хэмжээний, үүнээс ч илүү хэмжээний ахиц гаргасан</u> хэмээн дүгнэж байна	байхгүй	2020 онд батлагдсан шинэ маягтын хүрээнд сайн дураар тайлагнах хэсгийг заавал тайлагнахаар өөрчилсөн болно.
8	Шаардлага 7.4.а.iii, 7.4.а.iv болон 7.4.б дээр заасны дагуу ОТОБ нь дараа жилийн ажлын явцын тайланг бэлтгэхэд ОУИТБС-ын зөвлөмжүүдийн хэрэгжилт, хэрэгжилтээс үзүүлж буй нөлөөлөл дээр үнэлгээг өргөн хүрээний оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр хийх шаардлагатай байна.	Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар нь жилийн явцын тайланд дурдсан засан залруулах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлжсэн хэмээн үзэж, Монгол улс нь 7.4 дүгээр шаардлагыг хангахад <u>хангалттай хэмжээнд ахиц гаргасан</u> хэмээн үзэж байна.	Оролцогч талууд ОУИТБС-ын жил тутмын үйл ажиллагааны тайланг бэлтгэхэд оролцох болон ОУИТБС-ын үзүүлж буй нөлөөллийг судлан үзэх үйл явцыг цаашид хэрхэн сайжруулах талаар ОТОБ дээр хэлэлцэхийг зөвлөмж болгож байна.	2020 оны Ажлын төлөвлөгөөнд 2018 оны нэгтгэлийн тайлангаар өгсөн бараг зөвлөмжүүдийг оруулж, шийдвэрлэж ирсэн. Хэд хэдэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэх шатандаа байгаа гэж үзэж болно.

7.3. ОУИТБС-ЫН ТАЙЛАГНАЛ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Монгол улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлыг улам сайжруулах талаар 2019 оны ОУИТБС-ын тайланг бэлтгэх явцад үүссэн асуудлаар дараах зөвлөмжүүдийг өгч байна.

7.3.1. Боловсруулах компаниудыг тайланд хамруулахад үүсч буй хүндрэл

Олборлох салбараас Монгол улсад оруулж буй орлогын хувьд зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшдэг компаниудаас гадна боловсруулах үйлдвэр, уул уурхайн туслан гүйцэтгэгчийн чиглэлээр томоохон хувь нэмрийг оруулж байдаг. Эхлэлийн семинарийн үед боловсруулах салбарын 6 компанийн нэгтгэлд нэмж хамруулахаар шийдвэрлэсэн. Гэвч эдгээр компаниуд нь тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй тул цахим тайлангийн системд мэдээлэл нь ороогүй, ОУИТБС-ын талаар ямар ч ойлголтгүй, мэдээллээ гаргаж өгөхийг хүсэхэд хууль эрх зүйн ямар шаардлага байгааг асууж байна. Тухайлбал:

- ОТАХ-ээс “Ачит ихт” ХХК-ийг боловсруулах үйлдвэрлэлийн салбараас нэгтгэлд хамруулахаар шийдвэрлэсэн. Тус компаниас “манай компанийг eitimongolia.mn-д тайлагнах үүрэг хүлээсэн гэдгийг нотлох албан ёсны бичиг баримт, хуулийн заалт байгаа эсэх, нэгтгэгч нь төрийн байгууллага биш тул ААН-ээс шаардах эрхгүй, санаачилга гэхээр сайн дурын гэж ойлгогдож байна, хуулийн заалт болон эрх бүхий холбогдох байгууллагын шийдвэр ирүүлбэл мэдээллээ нууцлалын гэрээ байгуулсны үндсэн дээр өгнө” гэсэн хариу ирүүлсэн.
- Эрдмин ХХК-ийн хувьд мэдээллээ гаргаж өгөх боломжтой боловч энэ талын ойлголт сул учраас цаг хугацаа ихээхэн алдсан байна.
- ОТАХ-ийн саналаар жишээ нь Арева компанийг сонгосон ба энэ компани нь ураны чиглэлийн хайгуулын Компанийн толгой компани бөгөөд тус компани нь идэвхитэй үйл ажиллагаа явуулдаггүй, зөвхөн төлөөлөгчийн газрын шинжтэй тул улсад маш бага хэмжээний татвар төлбөр төлдөг байна.

Зөвлөмж

Боловсруулах салбарын томоохон үйлдвэрлэгч болон туслан гүйцэтгэгч нарыг ОТАХ судалж, улсын төсөвт томоохон хувь нэмэр оруулж буй компаниудыг урьдчилан сонгож, тэдэнд албан ёсоор мэдэгдэж, цахим тайлангийн системд үндсэн мэдээллийг оруулснаар, ил тодын тайланг тушаах нөхцлийг бүрдүүлж, улмаар ОУИТБС-ын нэгтгэлд хамруулж байх нь зүйтэй байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх байгууллагууд:

Олон талт ажлын хэсэг, ОУИТБС-ын Ажлын алба

7.3.2. Тайланг тушаалт, хариу ирүүлэлтийн байдал

ОУИТБС-ын 2019 оны тайланг нийт 2,093 компани илгээх ёстой боловч 1,472 компани тайлангаа илгээж, 621 компани тайлангаа илгээгээгүй байна. Төрийн байгууллагуудаас БОАЖЯ нь Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээг тайлагнаагүй бол ХНХЯ нь Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийн мэдээг оруулаагүй байна.

Нэгтгэлийн явцад тайланд хамрагдсан төрийн байгууллагууд болон компаниудын хариу ирүүлэлт дараах байдалтай байна. Тухайлбал:

- Нийт сонгогдсон 171 компаниас Ачит Ихт ХХК, Баян айраг эксплорэйшн ХХК гэсэн 2 компани хариу ирүүлэхээс татгалзсан бол Мэжик бридж, Империаал гоулд Майнинг, Монголчех металл зэрэг компаниудтай огт холбогдож чадаагүй.
- Төрийн нийт 14 байгууллага руу албан бичиг явуулснаас УУХҮЯ албан ёсоор хариу ирүүлээгүй, СЯ-ны хувьд ирүүлсэн мэдээлэл нь албан ёсоор баталгаажаагүй байна.

- Зөрүү үүссэн 20 аймаг, 8 дүүрэг рүү зөрүүг тодруулах албан бичиг явуулснаас Сүхбаатар дүүрэг, Сонгино хайрхан дүүрэг, Орхон аймаг, хариу огт ирүүлээгүй бол Ховд, Дорнод, Дорноговь, Баянхонгор аймгууд, Чингэлтэй дүүрэг мэдээллээ дутуу ирүүлсэн.

Зөвлөмж

Компаниуд болон төрийн байгууллагуудын ОУИТБС-ын тайланг тушааж хэвшүүлэх, тушаасан тайлангийн үнэн зөв байдлыг хангуулах талаар жил жилийн нэгтгэлийн тайлангаар зөвлөмж өгдөг боловч энэ тал дээр томоохон ахиц харагдахгүй байгаа нь Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг баталж мөрдүүлэх нь чухал болохыг харуулж байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх байгууллагууд:

Үндэсний зөвлөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

7.3.3. Төрийн байгууллагын тайлан мэдээний үнэн зөв байдал

Нэгтгэлийн явцад ТЕГ 28 алтны компаниас хүлээн авсан 18.1 тэрбум төгрөгийн АМНАТ-ийг анхны тайландаа орхигдуулан тайлагнасан, нэгтгэлийн явцад нэмэлт мэдээлэл гаргаж ирүүлээгүй. Учир нь 2019 оны 3 сарын 26-нд Ашигт малтмалын тухай хуулийн 47.12-д “Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 47.3.2-т заасан хувь хэмжээгээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тушаасан алтны борлуулалтын үнэлгээнээс суутган авч, улсын төсөвт шилжүүлнэ” гэсэн өөрчлөлт орсноор Монгол банк алтны компаниудын тушаасан алтнаас АМНАТ-ыг шууд ногдуулан, бөөн дүнгээр нь ТЕГ-т шилжүүлдэг болсон байна.

Зөвлөмж

Хуулийн өөрчлөлт нь ТЕГ-ын алтны компаниудын АМНАТ-ын ногдуулалт, төлөлтийн горимд нөлөөлсөн боловч ОУИТБС-ын тайлангаа зөв дүнгээр тайлагнах, АМНАТ-ын ногдуулалт, төлөлтийн байдалд тавих хяналтад нөлөөлөхгүй тул ТЕГ нь мэдээллийн системээ сайжруулж, ОУИТБС-ын тайлангаа үнэн зөв тайлагнах тал дээр цаашид анхаарч ажиллана гэж найдаж байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх байгууллагууд:

Татварын ерөнхий газар

7.3.4. Цахим тайлангийн иж бүрдэл

2019 оны ОУИТБС-ын тайлан тушаалтыг 2020 оны 4 дүгээр сарын 30-наар хаасан ба энэ өдрөөрх өгөгдөлд үндэслэн мэдээллийн иж бүрэн байдлыг шалгасан.

Цахим тайлангийн системд ЗГ нь 2,422 компаниас хүлээн авсан орлогоо тайлагнасан ба Хараат бус хянагч-нэгтгэгч нь эдгээр компаниудын жагсаалтыг АМГТГ-ын систем дэх ТЗЭ компаниудын жагсаалттай тулган шалгахад 329 компани илүү тайлагнасан гэж харагдаж байна.

Хүснэгт 7.3 Цахим тайлангийн систем

Утга	Компанийн тоо	ЗГ-ын орлогын дүн (сая төгрөгөөр)
Цахим тайлангийн системд бүртгэлтэй нийт Компанийн тоо	2,422	3,452,974
Үүнээс: АМГТГ-аас оруулсан ТЗЭ Компанийн тоо	2,093	3,405,508
Зөрүү	329	47,466
Цахим тайлагналын системд адилхан нэртэй мөртлөө өөр регистрийн дугаартай бүртгүүлж, тайлан тушаасан компаниуд	70	25,991
Бусад компаниуд	259	21,475

Зөрүүгийн шалтгааныг тодруулахад дараах асуудлаас үүдэлтэй байна. Үүнд:

- Орон нутгийн засаг захиргаанаас цахим тайланд мэдээлэл шивэхдээ шинэ нэр оруулах эрхтэй байдаг. Гэвч орон нутаг дахь төрийн байгууллагын хариуцсан ажилтан компаниудаас хүлээн авсан орон нутгийн татварыг цахим тайланд оруулахдаа уг системд

нэгэнт бүртгэгдсэн Компанийн нэр, регистрийн дугаар дээр оруулаагүй, өөрсдөө шинээр нэр, регистр оруулж, 70 Компанийн хувьд давхардуулан тайлагнасан байна.

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын лицензийг орон нутгаас бие даан олгодог ба эдгээр компаниудын мэдээллийг орон нутгийн засаг захиргаа өөрсдөө нэмж оруулсан байх магадлалтай 259 компани байна.
- 1-6 оронтой тоо бүхий алдаатай регистрийн дугаар бүхий 106 компани бүртгэлтэй байна.
- АМГТГ-ын кадастрын системд Голден грэвэл, Даян эрчис, Дүүрэн-Ёндой, Сова, Хишигтхөндий, Эрдэсплазм, Эрдэс плазм, Эрдэс плазм ХХК гэсэн 8 компани 2-6 орон бүхий буруу регистрийн дугаартай бүртгэгдсэн байна.

Зөвлөмж

АМГТГ-ын кадастрын систем, ОУИТБС-ын цахим систем дэх мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгаж, нэг эх үүсвэртэй мэдээлэл дээр цахим тайлангийн системийг ажиллуулах, хөдөө орон нутагт олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийг кадастрын системд цаг алдалгүй оруулж, олон нийтэд мэдээлж байх нь зүйтэй.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх байгууллагууд:

Ашигт малтмал, газрын тосны газар, ОУИТБС-ын Ажлын алба

7.3.5. ОУИТБС-ын шинэ маягтаар цуглуулсан мэдээллийн чанар байдал

2019 оны ил тод байдлын тайланг компаниудаас цахим тайлангийн системээр шинэ, хуучин 2 маягтаар авсан байна. Хуучин маягтаар 2020 оны 4 дүгээр сарын 30-ныг хүртэл, шинэ маягтаар 10 дугаар сарын 30-ныг хүртэл тайлан авсан гэж Ажлын албанаас мэдэгдсэн.

Хуучин маягтаар нийт 1472 компани тайлан илгээсэн бол, 881 компани тайлангаа илгээгээгүй, харин 633 компани шинэ маягтаар тайлангаа гаргажээ. Төрийн 2 яам, 4 агентлаг болон орон нутгийн 19 аймаг, 8 дүүргийн засаг захиргаа хүлээн авсан төлбөр, орлогоо цахимаар тайлагнасан байна.

Шинэ маягтуудыг гараар байршуулж байгаа бөгөөд програм хоорондын нийлэмжийг шинэчлэх ажил хийгдэж дуусаагүйн улмаас шинэчилсэн маягтаар ирүүлсэн мэдээллүүдэд доорх алдаанууд илэрч байна. Үүнд:

- Мэдээллүүд давхардсан,
- Олон сонголтод мэдээллүүдийг тодорхойлох боломжгүй,
- Компаниудын ирүүлсэн мэдээлэл хоосон

гэх мэт дутуу боловсруулагдсан мэдээллийг олон нийтэд ил тод болгох, цаашлаад тайлан хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах эрсдэлтэй байна.

Зөвлөмж

Цахимаар авч байгаа мэдээллийг оролцогч талууд баталгаажуулах, бүгдийг олон нийтэд ил тод болгох, эсвэл сонгогдсон компаниудын мэдээллийг хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс үнэлж, сайжруулан олон нийтэд ил тод болгох талаар хэлэлцэх нь зүйтэй.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх байгууллагууд:

ОУИТБС-ын Ажлын алба

7.3.6. ТӨААН-ийн санхүүгийн тайланг ил тод болгох

ҮАГ-ын цахим хуудас, шилэн дансны цахим хуудас болон ТӨААН-үүдийн өөрсдийн цахим хуудас дээр ТӨААН-үүдийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дараах мэдээллүүд нийтлэгдсэн байна.

- Санхүүгийн байдлын тайлан
- Дэлгэрэнгүй орлогын тайлан

- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Аудитын дүгнэлт

ТӨААН-үүдийн аудитлагдсан санхүүгийн тайлангууд нь УСНББОУС болон НББОУС/СТОУС-ын шаардлага хангасан хавсралт тодруулгуудыг иж бүрнээр нь ил тод болгож, бүрэн нийтлэхгүй байгаа нь олон нийтийн зүгээс ТӨААН-үүдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны талаар цогц мэдээллийг авч чадахгүйд хүрч байна.

Зөвлөмж

Олборлох салбарын бүх ТӨААН-ийн аудитлагдсан иж бүрэн санхүүгийн тайланг цахимаар нийтэд мэдээлэх буюу тодруулбал тухайн ТӨААН-ийн вэб хуудсанд болон УАГ, ОУИТБС буюу АМГТГ-ын вэб хуудсанд тус тус нийтлэхийг зөвлөж байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх байгууллагууд:

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар

7.3.7. Төрийн оролцоо шаардлагыг ил тод болгохтой холбоотой асуудал

ОУИТБС-ын нарийн бичгийн дарга нарын 2018 оны баталгаажуулалтын тайлан, Мэдээллийг системтэйгээр ил тод болгоход Монгол улс бэлэн эсэхэд хийсэн үнэлгээний тайлан зэрэгт нийтлэг тусгагдсан асуудал нь төрийн оролцоог стандартын шаардлагын дагуу ил тод болгоход хангалттай бус ахиц дэвшилтэй байгаа тухай асуудал байна.

Ялангуяа ТӨААН-ийн хуримтлагдсан ашиг, дахин хийсэн хөрөнгө оруулалт, гуравдагч талын санхүүжилт, зээл, ТӨААН-с төрийн байгууллагууд, төрийн байгууллагаас ТӨААН хоорондын гүйлгээ зэрэгт хамаарах мэдээллийг нийтэд ил тод болгох нь дутагдалтай байна. Түүнчлэн ОУИТБС-ын шинэ 2019 оны стандартаар ТӨААН-д өөрийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаа ил болгох, хөрөнгийн болон урсгал зардал, худалдан авалт, туслан гүйцэтгэгч ажиллуулах болон Компанийн засаглалтай холбоотой дүрэм журам болон практик үйл ажиллагааг ил тод болгох асуудал хангалтгүй байна.

Хэрэв ТӨААН-үүд шилэн дансны мэдээллийг иж бүрэн бөглөвөл дээрх шаардлагуудаас зарим шаардлагыг ил тод болгох боломж нь нээлттэй байна. Үүнд:

- хуримтлагдсан ашиг (шилэн дансны цахим хуудас санхүүгийн тайлан мэдээллээс харж болно),
- дахин хийсэн хөрөнгө оруулалт (Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр)
- хөрөнгийн болон урсгал зардал (шилэн дансны цахим хуудасны Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр), Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр))
- худалдан авалт (шилэн дансны цахим хуудасны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр), Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр), Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн).

Гэвч ТӨААН нь шилэн дансны цахим хуудсанд 2019 оны худалдан авалтын холбогдох маягтуудыг бөглөж оруулсан боловч бусад маягтуудыг Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет, Эрдэнэс тавантолгой ХК-иудаас бусад ТӨААН шилэн дансандаа дутуу, хангалтгүй байршуулсан байна.

ОТӨБ нь өөрийн жил тутам гаргаж буй ОУИТБС-ын тайлан дээр төрийн өмчит компаниудын ЗГ-тай хамаарах санхүүгийн харилцааны журам дүрэм болон бодит практик хоорондын ялгаатай/зөрүүтэй байдалд үнэлэлт хийж байхад төвлөрөх шаардлагатай. Илүү тогтвортой болгохын тулд ОУИТБС нь мөн ЗГХЭГ, Эрдэнэс Монгол болон Төрийн өмчийн бодлого,

зохицуулалтын газартай хамтран ажиллаж уул уурхайн салбарт ажиллаж буй төрийн өмчит компаниудын санхүүгийн мэдээллийг ил тод болгох системийг боловсруулан гаргах шаардлагатай.

Зөвлөмж

ТӨААН-үүдийг шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ ил тод оруулах, ТӨБЗГ-ын цахим хуудсаар ТӨААН-с хүлээн авсан ногдол ашиг, хамаарах төрийн байгууллагын вебсайтаар дамжуулан ил тод болгон нийтэлж байх тогтолцоог бий болгох хэрэгтэй.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх байгууллагууд:

Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд

7.3.8. ЗГ-ын орлого, Компанийн төлбөрийн зөрүүтэй холбоотой асуудал

Засгийн газар болон компаниудын цахим тайлагналын системд оруулсан төлбөр, орлогын анхны нэгтгэлийг хийхэд нэлээдгүй зөрүүтэй байгаа бөгөөд зөрүүгийн шалтгаан нь мэдээллийг тайлагнасан Засгийн газар эсвэл компаниудын аль алинд байна. Хараат бус хянагч-нэгтгэгч нь зөрүүгийн шалтгааныг тодорхойлж, оролцогч байгууллагуудаас тайлбар авч, санхүүгийн тохируулга хийж, зөрүүг багасгаж байна. Гэвч энэ алдаа давтагдсаар байна.

Зөвлөмж

Иймд ОТАХ-ийн зүгээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, цаашид Хараат бус хянагч нэгтгэгчийн оролцоо багасах үед тоо мэдээний чанар, үнэн зөв байдал улам илүү тавигдах болно гэдгийн үйл ажиллагаанда анхаарч ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

- Хамгийн их зөрүү гаргаж буй, мэдээллээ ил тод нийтлэхгүй, тайлагналын хариуцлага хүлээхгүй байгаа байгууллагад сургалт зааварчилгаа өгөх, нөлөөллийн арга хэмжээнүүд авах.
- Монголын ОУИТБС-ын 2019 оны нэгтгэлийн тайланг албан бичгийн хамт хүргүүлж, цаашид хэрхэн хамтарч ажиллахыг зөвлөх.
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын албаны вэбсайт дахь мэдээ, мэдээллийг байнга шинэчлэх. Зарим мэдээлэл, 2013 оны байдлаар хүртэл байх тохиолдол байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх байгууллагууд:

Олон талт ажлын хэсэг, ОУИТБС-ын Ажлын алба

7.3.9. Хараат бус нэгтгэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой асуудал

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хараат бус хянагч-нэгтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт сүүлийн жилүүдэд сунжирч, нэгтгэлийн ажиллагаанд хүндрэл учруулж байна. Өөрөөр хэлбэл Хараат бус хянагч нэгтгэгч нэгтгэлийн ажлыг гүйцэтгэх хангалттай цаг хугацаа байхгүй тул стандартаар шаардсан мэдээллүүдийг цаг хугацааны хавчигдмал байдлаас шалтгаалан ил тод болгож чадахгүйд хүрч байна.

Зөвлөмж

ОТАХ-ийн зүгээс тендер зарлах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа төрийн хууль тогтоомжийг чанд мөрдөж, төлөвлөгөөт цаг хугацаандаа гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байхад хяналт тавьж, дүрэм журмыг чанд мөрдөж ажиллахыг шаардаж ажиллахыг зөвлөж байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх байгууллагууд:

Олон талт ажлын хэсэг, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам

8

ХАВСРАЛТУУД



8. ХАВСРАЛТУУД

№	Хавсралтын нэр
Хавсралт 1	МОУИТБС-ын 2019 оны тайланд хамрагдсан компаниудын мэдээлэл
Хавсралт 2	Нэгтгэлийн ажилд мэдээлэл өгсөн ЗГ-ын байгууллагуудын албан тушаалтан
Хавсралт 3	Нэгтгэлийн ажилд мэдээлэл өгсөн орон нутгийн засаг захиргааны байгууллагын албан тушаалтан
Хавсралт 4	Компаниудад илгээсэн тайлангийн маягтуудын бүтэц
Хавсралт 5	Төрийн байгууллагуудад илгээсэн тайлангийн маягтуудын бүтэц
Хавсралт 6	Гол орлогын урсгал (Засгийн газрын тайлагнаснаар, нийт ОУ-ийн урсгал)
Хавсралт 7	Компаниудын ирүүлсэн мэдээлэл
Хавсралт 8	ЗГ-ын байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл
Хавсралт 9	Тайлбарлагдаагүй зөрүү (компаниудаар)
Хавсралт 10	Анхны нэгтгэл, залруулга болон залруулгын дараах нэгтгэл (Компаниудаар)
Хавсралт 11.а	Нэгтгэлийн дараах төрийн байгууллагуудад олгосон хандив, тусламжийн дэлгэрэнгүй мэдээлэл
Хавсралт 11.б	Төрийн бус байгууллага, иргэн, компаниудад өгсөн хандив, тусламжийн дэлгэрэнгүй мэдээлэл /компаниудын тайлагнаснаар/
Хавсралт 12	Тохируулгын дараах улсын хэмжээний гол орлогын урсгалууд, ЗГ-ын дүнгээр
Хавсралт 13	Тохируулгын дараах орон нутгийн хэмжээний гол урсгалууд, ЗГ-ын дүнгээр
Хавсралт 14	Нэгтгэлд хамрагдсан компаниудын санхүүгийн тайлангийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эх сурвалжууд
Хавсралт 15	Ажилчдын мэдээлэл
Хавсралт 16.а	Хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт (2019 оны 12 сарын 31-ний байдлаар)
Хавсралт 16.б	Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт (2019 оны 12 сарын 31-ний байдлаар)
Хавсралт 16.б-1	2018 оны 12 сарын 31-ний байдлаар хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн жагсаалт
Хавсралт 16.в	Шинээр олгосон хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт
Хавсралт 16.г	Шинээр олгосон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт
Хавсралт 16.д	Шилжүүлсэн хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт
Хавсралт 16.е	Шилжүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт
Хавсралт 16.ё	2019 онд шилжүүлсэн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт
Хавсралт 16.ж	2019 онд хасагдсан буюу хүчингүй болсон ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл
Хавсралт 16.з	ЭБМЗ-ийн ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх хуралдаанаар 2017 онд хэлэлцэгдсэн тайлангууд
Хавсралт 16.и	Хүчин төгөлдөр ураны тусгай зөвшөөрлийн жагсаалт (2019.12.31-ний байдлаар)
Хавсралт 16.к	Түгээмэл тархацтай ашигт малтмалын лиценз
Хавсралт 16.л	Хүчин төгөлдөр ураны тусгай зөвшөөрлийн солбилцлын цэгүүд
Хавсралт 16.м	Хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн сонгон шалгаруулалтын шийдвэрийн жагсаалт
Хавсралт 16.м-1	Сонгон шалгаруулалтаар улсын төсөвт орсон орлого
Хавсралт 16.н	Газрын тосны тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт
Хавсралт 16.о	Хүчин төгөлдөр БХГ-үүдийн солбилцлын цэгүүд
Хавсралт 16.ө	2019 онд сонгон шалгаруулалтын бус замаар (шууд гэрээ, хэлэлцээр хийх замаар) олгосон тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл, ямар процетур хэрэглэж байгаа талаарх мэдээлэл
Хавсралт 17	Нийгмийн зарцуулалт /компаниудын ирүүлсэн мэдээлэл/
Хавсралт 18 а	Нүүрсний олборлолт
Хавсралт 18 б	2019 оны дотоод болон экспортын борлуулалт
Хавсралт 18 в	Нүүрсний нөөц
Хавсралт 19	Санхүүгийн тайландаа аудит хийлгэсэн байдал

Хавсралт 20.а	Уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл (Нүүрсний салбараас бусад)
Хавсралт 20.б	Уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл - Нүүрс
Хавсралт 21	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүн
Хавсралт 21.а	Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл
Хавсралт 21.б	Ашиг хүртэгч эзэд (хувь хүн)
Хавсралт 21.в	Бенефициар өмчлөгчид (хуулийн этгээд)
Хавсралт 21.г	Ногдол ашиг
Хавсралт 22	Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хийсэн гэрээний мэдээлэл
Хавсралт 23	Компаниудын байгаль орчныг хамгаалах тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгө
Хавсралт 24	Төслийн түвшний мэдээлэл
Хавсралт 25	Компаниудын ирүүлсэн нөхөн сэргээлтийн мэдээлэл
Хавсралт 26.а	2019 оны нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниудын жагсаалт
Хавсралт 26.б	2018-2019 онд эрх нь цуцлагдсан газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагын мэдээлэл
Хавсралт 27.а	Нэгтгэлд хамрагдсан компаниудын ОУИТБС-д оролцооны үнэлгээ
Хавсралт 27.б	ЗГ, Төрийн байгууллагуудын ОУИТБС-д оролцооны үнэлгээ
Хавсралт 28.а	Орон нутаг дахь бичил уурхайн ГТББ-уудын гишүүдийн мэдээлэл
Хавсралт 28.б	Бичил уурхайн байгууллагуудын нөхөн сэргээлт хийсэн мэдээлэл-2020-5-р сарын байдлаар
Хавсралт 29	АМГТГ-аас ирүүлсэн БУУ-н үйл ажиллагааны мэдээлэл
Хавсралт 30а	Ашигласан усны мэдээлэл
Хавсралт 30б	ЗГ-т төлсөн ус ашигласны төлбөр (компаниудаар)
Хавсралт 31	Хог хаягдлын мэдээлэл
Хавсралт 32.а	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй, цахим тайлангийн системд ороогүй компаниудын жагсаалт
Хавсралт 32.б	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй, цахим тайлангийн систем дээр ЗГ-ын тайланд орсон компаниудын жагсаалт
Хавсралт 33	Ашигласан эрчим хүч, түлш шатахуун, бүтээгдэхүүн
Хавсралт 34	Туслан гүйцэтгэгчийн мэдээлэл
Хавсралт 35	Төрийн Өмчит Аж Ахуйн Нэгжүүдийн зээлийн мэдээлэл
Хавсралт 36	Нөөцийн мэдээлэл
Хавсралт 37	Нөлөөллийн бүсийн мэдээлэл
Хавсралт 38	Баяжуулах үйлдвэрлэл эрхлэгч Тэн Хун ХХК-ийн ашигласан химийн бодисын мэдээлэл
Хавсралт 39	Ашигт малтмал, газрын тосны газраас 2019 онд зохион байгуулсан тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын урилга
Хавсралт 40	Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хайгуулын ажлын мэдээ
Хавсралт 41	Монгол орны цацраг идэвхт ашигт малтмал болох ураны ордуудын нөөцийн нэгтгэсэн мэдээлэл
Хавсралт 42	Тайланд тусгагдсан байх шаардлагатай ОУИТБС-ын стандарт болон ажлын даалгаврын шаардлагууд

